

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2022 № 1, 2 (100)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ:

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал

ГИШҮҮД:

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Ч.ХОСБАЯР

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн

Г.БАНЗРАГЧ

Улсын Дээд шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/,

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Д.ЯНЖИНХОРЛОО

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Судалгааны төвийн дарга

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Дээд Шүүх 1995 оноос эхлэн “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийг санаачлан гаргаснаас хойш өнөөг хүртэл 27 дахь жилдээ нийт 99 дугаар эрхлэн гаргаж, төр, эрх зүйн онол, шүүхийн практик, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр нийт 987 өгүүлэл, нийтлэл хэвлэжээ.

Сэтгүүлийн зөвлөлийн анхны эрхлэгчээр Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дэмбэрэлцэрэн ажилласан бол, гишүүдээр гавьяат хуульч Б.Чимид, хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор, академич Ж.Амарсанаа, Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор /Sc.D/, профессор Ц.Сарантуяа, хууль зүйн доктор /Ph.D/, профессор Ж.Бямбаа, хууль зүйн ухааны доктор /Ph.D/, профессор Ч.Нямсүрэн зэрэг эрдэмтэд ажиллаж байсныг дурдахад таатай байна.

Өнгөрсөн хугацаанд үндэсний эрдэмтдийн 110 бүтээл хэвлэгдсэн бол гадаадын судлаачдын бүтээл бас олонтаа нийтлэгдэж, нийтийн хүртээл болж байлаа. Тухайлбал, Регенсбургийн Их сургуулийн Эрүүгийн эрх зүй, Дорно дахины эрх зүйн тэнхимийн багш Фридрих Кристиан Шрёдер, Байгалийн эдийн засаг, эрх зүйн Улсын Их сургуулийн эрүүгийн эрх зүй, гэмт явдал судлалын тэнхимийн доцент, хууль зүйн ухааны доктор Владимир Валерьевич Агильдин, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант Ли Сяньжи /Rhee Sand Gi/, Финлянд улсын

Захиргааны дээд шүүхийн ерөнхийлөгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор Пекка Халлберг, Байгалийн эдийн засаг, эрх зүйн Улсын Их сургуулийн эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Репецкая А.Л., Япон улсын Нагоягийн Их сургуулийн профессор Кодама Шигэрү, Оросын бүх ард түмний найрамдлын их сургуулийн шүүх эрх мэдэл, хуулийн байгууллагууд ба хууль хамгаалах үйл ажиллагааны тэнхимийн эрхлэгч, хууль зүйн ухааны дэд доктор, доцент Сангаджиев Бадма Владимирович, ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгч асан доктор Диетер Хёмиг, Бавари муж улсын Захиргааны сургуулийн захирал асан, МУИС-ийн ХЗС-ийн хүндэт доктор Юрген Харбих нарын бүтээл багтсан байдаг.

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Нийгмийн ухааны салбарын бага чуулган, академийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монголын төр, эрх зүй сэтгүүлийг шинжлэх ухааны бүтээл нийтлэх эрх бүхий мэргэжлийн сэтгүүлийн нэгдсэн жагсаалт буюу “Дотоодын мэргэжлийн, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт”-д бүртгэлээ.

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 36 дугаар захирамжаар Монголын төр, эрх зүй сэтгүүлийг эрхлэн гаргах журам, сэтгүүлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, цаашид Монгол Улсын дээд шүүхийн

дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гаргахаар шийдвэрлээд байна.

Монголын төр, эрх зүй сэтгүүл маань үе үеийн хуульчдын оюуны хэрэгцээг хангасан хууль зүйн шинжлэх ухааны

шилдэг бүтээлүүдийг хэвлэн нийтлэх, түгээн дэлгэрүүлэх шинэлэг талбар байж, сан хөмрөг нь арвидан тэлж, Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулсаар байх болно гэдэгт итгэлтэй байна.

Шударга ёс бэхжих болтугай.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ

АГУУЛГА

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

Ж.Батбаатар

Авлигын гэмт хэргийн өнөөгийн байдал, түүнтэй тэмцэх зарим асуудал 6

Б.Энхтайван

Итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, эсхүл оролцогч өөрөө давж заалдах шатны шүүх болон улсын дээд шүүхэд гомдол гаргасан тоон судалгаа, дүгнэлт, шийдлийн санал 17

Ц.Мөнх-Эрдэнэ

Корпорацын авлигын хэрэг ба siemens corruption case 39

Б.Ганболд

Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал 48

С.Жансая

Оросын Холбооны Улсын шүүхийн практикийн нэгдмэл байдал Иргэний хуулийн жишээн дээр 59

С.Номынбаясгалан

Хууль зүйн нэр томъёоны асуудлууд 71

Т.Бадрах

Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын детерминизмийн асуудал 83

Б.Арманбек

Эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчим 97

ҮЗЭЛ БОДОЛ /СЭДЭМЖ, ЯРИЛЦЛАГА, ШҮҮМЖ/ СЭДЭМЖ

Т.Мөнх-Эрдэнэ

Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналт: Төв банкны шийдвэрийг захиргааны эрх зүйн үүднээс авч үзэх нь 111

О.Бадмаараг

Шүүгчид хүлээлгэх сахилгын хариуцлагын процессын зарим асуудал 123

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ /ЭХ СУРВАЛЖ, ОРЧУУЛГА/ БУЛАН: ОРЧУУЛГА

С.Цэрэндолгор

Гэм хорын эрх зүй дэх дуализм 131

**АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ЗАРИМ АСУУДАЛ**

**CURRENT SITUATION OF CORRUPTION CRIMES AND
MATTERS RELATED TO CORRUPTION COMBATING**

Жанчивдоржийн БАТБААТАР¹

- I. Удиртгал
- II. Судалгааны үндсэн хэсэг
- III. Авлигын гэмт хэргийн илэрч буй байдал
- IV. Дүгнэлт
- V. Санал
- VI. Ном зүй

¹ МУИС-ийн магистрант

LL.M. candidate, School of Law, the National University of Mongolia

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Ж.БАТБААТАР. МУИС-ийн магистрант

Товчлол

Авлигын гэмт хэргийн өнөөгийн байдал, түүний шалтгаан, нөхцөлийг судлан, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зарим асуудлыг энэхүү өгүүллээр хөндөж гаргасан болно.

Түлхүүр үгс: Авлига, хэлбэр, шалтгаан, албан тушаалтан, гэмт хэрэг.

Summary: Research of the current situation of corruption crimes, its causes and approach matters related to corruption combating

Keywords: Corruption, form, cause, public official, crime

I. Удиртгал

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд авлига, албан тушаалтын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоохоос гадна авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ойлгуулах, таниулах, соён гэгээрүүлэх ажил чухал байр суурийг эзэлдэг.

Монгол Улсад Авлигатай тэмцэх газар /цаашид АТГ гэх/ 2007 оны 9 дүгээр сарын 07-ны өдрөөс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар 10 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байсан. Харин 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар

авлигын 11 төрлийн гэмт хэргийг харьяалан шалгаж эхэлсэн.

Дотоодын болон гадаадын судалгааны байгууллагууд, мөн Авлигатай тэмцэх газраас явуулдаг төсөөллийн болон эрсдэлийн судалгаа, үнэлгээнүүдийн дүнгээс үзэхэд Монгол Улсад авлига нийтлэг тархсан гэсэн үзүүлэлт хэвээр байна. Монгол Улсад авлигатай тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэг нь энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгаж, шийдвэрлэх ажиллагаа юм. Монгол Улсын Эрүүгийн хуульд 11 төрлийн авлигын гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих, хянан шийдвэрлэх ажиллагааг АТГ-ын мөрдөгч, прокурор, шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмын дагуу явуулж байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны тайланд дурдсанаар 2019 онд 523 авлигын гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд энэ нь улсын хэмжээний нийт гэмт хэргийн 1.7%-ийг эзэлж байна. АТГ 2013-2019 онд буюу сүүлийн 7 жилийн дунджаар жилд ойролцоогоор 269 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулснаас дунджаар 41 буюу 17%-ийг нь шүүхэд шилжүүлсэн байна. Мөн сүүлийн 3 жилийн дунджаар бүртгэгдсэн нийт



авлигын гэмт хэргийн ойролцоогоор 80 орчим хувь нь гэмт хэргийн шинжгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан болон бусад үндэслэлээр хаагдсан буюу хэрэгсэхгүй болгосон¹ байна .

Иймд Монгол Улсад авлигын гэмт хэргийн шалтгаан нөхцөл, илэрч буй байдал түүнтэй тэмцэх арга зам түүний эрх зүйн зохицуулалтын талаар гүнзгийрүүлэн судлахад оршино.

II. Судалгааны үндсэн хэсэг

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын төслийн эцсийн найруулгыг боловсруулсан. Ерөнхий Ассамблей 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор Конвенцыг баталсан юм².

Монгол Улс тус конвенцод 2005 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр нэгдэн орж, 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурал соёрхон баталсан³. Ингэснээр манай улс тухайн олон улсын гэрээг даган мөрдөх, түүний хэрэгжилтийг хангахад хүчин чармайлт тавих үүргийг олон улсын өмнө албан ёсоор хүлээсэн.

Эрт үед Монгол Улсад хээл хахууль нь төрийн харилцаанд ёс заншил болон тогтож, уг заншил хамгийн ихээр дэлгэрсэн үе нь 15-р зуунаас 19-р зууны эхэн үе бөгөөд энэ үед нь ард иргэд нь баяр ёслол, зэрэг дэв авах эсвэл бусад ажлаа бүтээхийн тулд ямар нэг байдлаар гар цайлгах мөнгө, эд зүйл өгдөг байсан ч хээл хахууль гэж тооцож байсангүй.

Тэр нь идэх хоол, хүнс түүнчлэн ялимгүй зүйлээс эхлээд их хэмжээний үнэ бүхий ембүү, мөнгө, эд зүйлүүдийг хээл хахуульд өгч авалцан шашны цол, хэргэм, төрийн албан тушаал, эрх мэдэл байр суурийг мөнгөөр худалддаг байсан

¹ https://www.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L23

² <https://www.legalinfo.mn/law/details/10269>

³ <https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>

нь ердийн үзэгдэл мэт байсан⁴.

1990-ээд он хүртэлх хугацаанд төрийн ил тод байдал байхгүй байсан учраас авлигын тухай асуудал барагтай л хэлэлцэгдэхгүй, зөвхөн тодорхой хүрээнд нууцлагдмал байсан.

Түүнчлэн улс төрд авлигын тухай ойлголт ил гарч байсангүй. Үнэндээ төрийн дээд давхаргад хувийн ашиг сонирхлын төлөө нийгэм дэх байр суурь ба эрх мэдлийг хэтрүүлэх зэргээр авлига нь хязгаарлагдмал хүрээнд тархаж байсан бөгөөд хэвлэн нийтлэх эрх чөлөөгүй байсан учраас нийгэм, иргэдийн дунд авлигын тухай ойлголт түүний талаарх мэдээлэлгүй байснаас энэ талаар мэдэж чаддаггүй байсан юм.

Солонгос Улсад авлигын гэмт хэргийг эрүүгийн хуулийн бүрэлдэхүүнээс хамаараад “төрийн албан хаагч болон эвлэрүүлэгч нь албан тушаалаа ашигласны төлбөрт ашиг хонжоо хүртэх эсвэл төрийн албан хаагч болон эвлэрүүлэгчид ашиг хонжоо өгөхийг гэмт хэрэг” гэж үзэхээр заасан байдаг. Эвлэрүүлэх үйлдэл авлига өгөх, авлига хүлээн авсантай адилтган үзэхгүй бөгөөд харин холбож өгөх, зуучлах үүрэгтэй ба өдөөн хатгах, ятгах болон туслах мөн чанартай бие даасан гэмт хэрэг болно.

Түүнчлэн, хандив авсан авлига өгч буй хүн ба хүлээн авагчийн хүсэлтээр төрийн албан хаагчийн үүргийг биелүүлэхгүй байх эсвэл үүрэгт нь хамааралгүй ажлыг хийхэд эвлэрүүлэгчийн оролцоо мөн хамаардаг⁵.

Монгол Улс дахь авлига нь улс төр, зах зээлийн эдийн засгийн өөрчлөлт, ардчилсан чөлөөт үзэл, хувийн хэвшил бий болж эдгээрээс үүдэн гарсан нийгмийн харилцааны өөрчлөлт болон

⁴ Ц.Энхбат. Авлига ба Иргэний нийгэм өгүүлэл. 2012 он., 65 дахь тал

⁵ БНСУ-ын Эрүүгийн хууль. 2016 он., 23 дахь тал



түүхийн тодорхой үе шатуудад авлигын төрөл, түүний шинжүүд, төр, нийгэм, соёлын харилцаанд хэвшин тогтож уламжлагдан ирсэн нь нийгмийн тодорхой харилцаанд одоо ч илэрсээр байна.

Академич Т.Намжин: авлига гэдэг нь ёсон бусаар өгч авалцаж байгаа мөнгө төгрөг, эд зүйл бөгөөд тэрхүү өгч авалцаж буй үйлдлийг илэрхийлж буй гаж үзэгдлийн нэр⁶ гэсэн бол **Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь бичиг"-т Авлига гэдэг нь** ёсон бусаар шунаж авсан эд гэж тайлбарласан байна⁷. **Бидний үзэж байгаагаар авлига гэдэг нь** Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ.

Авлигын гэмт хэрэг гарахад дараах шалтгаанууд нөлөөлдөг гэж үзэж болохоор байна. Тухайлбал:

- Төр, захиргааны байгууллагын хүнд суртал, олон шат дамжлага,
- Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй бус байдал
- Тодорхой бус хууль, тогтоомж, дүрэм, журам,
- Ядуурал, цалин хөлс бага, амьжиргааны өртөг өндөр,
- Төрийн алба хаагчийн ёс зүйн доройтол,
- Шийдвэр гаргах түвшинд албан тушаалтны хувийн ашиг

сонирхлын үүднээс нөлөөлөх орон зай их байгаа зэргийг нэрлэж болно.

Авлигыг голдуу далд хэлбэрээр хуйвалдан үйлддэг ба Монгол улсын Эрүүгийн хуульд авлига авсан, өгсөн, зуучилсан хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг

Авлига өгсөн, авсан хүмүүс нэг нь нөгөөгийнхөө эсрэг тэр бүр өргөдөл, гомдол гаргадаггүй бөгөөд аль нэг тал нь албан тушаалын байдлаа ашиглаад ашиг олсон, нөгөө тал нь авлига өгч өөрийн ажил хэргийг шийдвэрлүүлсэн байдагтай холбоотой.

III. Авлигын гэмт хэргийн илэрч буй байдал:

Хуулиар хээл хахууль авах, өгөх, зуучлах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан нь бусад орны эрүүгийн хуулийн зохицуулалтаас онцын ялгаа байхгүй бөгөөд хээл хахуулийн гэмт хэргийг зохицуулсан эрүүгийн эрх зүйн ойлголт, хуулийн заалтад өнгөрсөн болон одоо үйлчилж байгаа хууль тогтоомжид зарчмын өөрчлөлт байхгүй боловч тухайн хэргийг үйлдэх арга хэлбэр, төрөл нь нэмэгдэж, илрэх хэлбэрээрээ өөрчлөгдөн, учруулах хохирол нь өсөн нэмэгдсээр байна.

Монгол Улсад хээл хахууль болон авлигын гэмт хэрэг олон төрлөөр илэрч байгаа бөгөөд дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Жижиг буюу бага хэмжээний авлига болох төрийн дунд шатны албан хаагчийн авлига /Petty Corruption/. Ихэвчлэн зориудаар, илрүүлж баривчлахад харьцангуй амархан, төрийн албан хаагч нараас голчлон илэрдэг төдийгүй хээл хахуулийн мөнгөн дүн нь бусад салбаруудтай харьцуулахад

⁶ <https://police.gov.mn/resource/policegovmn/media/>

⁷ Я.Цэвэл. Монгол хэлний эх тайлбар толь. УБ. 1960 он., 112 дахь тал



бага байдгаараа онцлогтой байна⁸.

Дийлэнх нь төрийн албан хаагч нараас бусдад мөнгө зээлэхтэй холбогдуулан банкны зээлийн өр төлбөрийг хүчингүй болгох, согтууруулах ундааны хууль бус арилжаа наймаа, нууцаар хил давуулсан автомашинтай холбогдуулан гаалийн албан татварын төрийн албан хаагчийг хэрэгт татан оролцуулах гэх мэт давтагдаж байна. Нөгөө талаар, "шан харамж" гэж нэрлэгдээд байгаа баярласан сэтгэлээ илэрхийлсэн жирийн иргэн төрийн албан хаагчид өгдөг мөнгөн хэлбэрээр өдөр тутмын амьдралд илэрч байдаг, хийх ёстой ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлын төлөө шан харамж авах, хийх шаардлагагүй албан ажлыг оронд нь хийж гүйцэтгэсэн гэж талархлаа илэрхийлэл болгож авдаг ч тохиолдол байна.

Мөн төрийн албан хаагч нар нь эрх мэдлээ хууль бусаар хэтрүүлэн бусдыг сүрдүүлэх түүнчлэн заналхийлсний дараа хээл хахууль авдаг "шахалт дарамт үзүүлэх" байдлаар илэрдэг байна. Бусдаар, улсын хөрөнгийг хувьдаа ашиглах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, төрийн албан хаагчийн эрх мэдлийг хэтрүүлэн бусдад ашигтай байдлаар давуу эрх олгох тохиолдол нь давтагддаг гэж хэлж болно.

2. Их хэмжээний авлига болох эрх мэдэлтний давхаргын улс төрийн салбар дахь авлига /Grand Corruption/ юм. Энэ нь Засгийн газар ба Олон Улсын байгууллагын тусгай өндөр албан тушаалтан том аж ахуйн нэгжүүд /компани, корпорац/-ийн хооронд ихээхэн ашиг орлого олох боломжтой бизнесийг хууль буслоббигоор дамжуулан нууцаар удирдах зорилготойгоор үүсдэг байна. Үүнд: хувьцаа, хөрөнгө оруулалт,

⁸ Д.Зүмбэрэлхам. Авлига гэмт явдал. УБ. 2011 он., 23 дахь тал

онцгой эрх гэх мэт багтдаг бөгөөд хээл хахууль авч тэдгээрийн эрх мэдлээр онцгой эрх зөвшөөрлийг өгснөөр, хууль бус орлогыг эдийн засагт оруулж мөнгө угаах ажиллагаа давхар явагддаг байна.

Түүнчлэн, аж ахуйн нэгж нь бизнесийн хүрээгээ өргөтгөх, ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд улс төрийн нам буюу удирдагч нарт авлига өгдөг нь хэвшсэн ёс болоод байгаа энэхүү байдал нь түр зуурынх биш харьцангуй урт хугацааны үргэлжилсэн үйлдэлтэй байдгаараа онцлог юм.

"Сонгуулийн авлига" гэж сонгуульд ялах зорилгоор сонгогчдод материаллаг эд зүйлээр хээл хахууль өгөх эсвэл сонгуульд ялсны дараа хөрөнгө оруулагч, зөвлөгч нарт онцгой албан тушаал амлах зэрэг нь үүнд хамаарна.

3. Шүүх байгууллагын авлига. Монгол Улс 1992 онд шинээр батлагдсан Үндсэн хуульд тусгаар тогтносон, шударга шүүх байгууллагаар дамжуулан социалист нийгмийн үеийн байдлаас бүтэц, зохион байгуулалтыг өөрөөр тогтоосон билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлээс 51 дүгээр зүйл хүртэлх заалтыг авч үзвэл "Шүүхийн байгууллагын тусгаар тогтнол, бие даасан байдал, хуулийн ноёрхол, хэн ч байсан шүүх байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй гэж хуульчилсан байна.

Харин энэхүү шүүх байгууллагын тогтолцооны шинэчлэлээс үл хамааран хуучин нийгмийн үеийн хандлага, зарчмаар шийдвэр гаргадаг шүүгч нар одоог хүртэл байхыг үгүйсгэхгүйгээс гадна тэдгээрийн нарын цалин хөлс бага байсан нь хээл хахуульд өртөхөөс аргагүй байдалд хүргэх магадлал өндөр байсныг хэлэх нь зүйтэй юм.



Түүнчлэн Цагдаагийн байгууллага нь авлигад хамгийн ихээр өртдөг болох нь судалгааны дүнгээс харагддаг байна. Учир нь цагдаагийн албан хаагч нь хээл хахууль авч хэргийг мөрдөн шалгахгүй байх эсхүл мөрдөн шалгахдаа хэрэг нь өөрийнх хүсэл зоригийн дагуу шийдвэрлэснийхээ хариуд талархал болгож буюу албан үүргээ гүйцэтгэснийхээ хариуд болон хийж гүйцэтгээгүйнхээ төлөө талархал болгож мөнгөн шан харамж өгөхийг шаарддаг ойлголт нь хэвийн үзэгдэл болсон байна.


4. Хэвлэл мэдээллийн авлига. Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 16 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн, хэвлэх, нийтлэх эрх чөлөөг хамгаалахаар хуульчилсан боловч бодит байдал нь Үндэсний радио, телевиз нь урьдын адил засгийн газрын хяналтад байдаг, үндэсний радио телевиз улсаас санхүүжилт авдаг бөгөөд

хариуцлага хүлээх хүний томилгоонд Засгийн газар оролцдог нь хэвлэл мэдээллийн авлига нь тархах нөхцөлийг бүрдүүлж байна.

Дээрх байдлаар авлигын гэмт хэрэг илэрч гардаг байна. Тэгвэл 2017-2019 оны байдлаар хүлээн авсан гомдол, мэдээлэл, шалгаж шийдвэрлэсэн гэмт хэргийн тоог харьцуулах шаардлага үүнээс үүдэн гарч байна.

Тоон судалгааны үзүүлэлтээс харахад Авлигатай тэмцэх газар (АТГ) нь 2017-2019 оны дунджаар жилд ойролцоогоор 1500 гомдол мэдээлэл хүлээн авчээ. Үүнээс дунджаар 51.3% буюу 791 гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс үргэлжлүүлэн шалгажээ. Өөрөөр хэлбэл жилд 700 орчим гомдол, мэдээлэл гэмт хэргийн шинжгүй, эсхүл АТГ-ын бусад хэлтэст шилжсэн байна.


График 1. Авлигатай тэмцэх газрын 110 дугаарын утсанд ирсэн гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтэд хийсэн судалгаа, дүгнэлт



АТГ-ын гомдол мэдээлэл шийдвэрлэлт, сүүлийн 3 жилээр



График 2. Шалгаж шийдвэрлэсэн хэрэг



2013-2019 оны статистикаас үзэхэд АТГ-ын хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл болон мөрдөн шалгасан хэргийн тоо 2017 он хүртэл тогтвортой буюу их өөрчлөлтгүй байсан. Харин хүлээн авсан гомдол мэдээлэлд эзлэх мөрдөн шалгасан хэргийн тоо 2018 онд өмнөх оноос 17%-аар, 2019 онд 22%-аар өсөн нэмэгдсэн.

Энэ нь 2015 оны Эрүүгийн хууль (ЭХ) 2017 оноос мөрдөгдөж эхэлсэн. Өөрөөр хэлбэл эрүүгийн хуульд хэрэг бүртгэлтийн

шат нэмэгдэж улмаар 5 хоногт гомдол мэдээллийг бүрэн шалгаж амжилгүй хэрэг бүртгэлтийн хэрэг олноор нээсэн мөн авлигын гэмт хэрэг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсонтой холбоотой.

АТГ-ын мөрдөгч нэг хэрэг бүртгэлтийн хэрэгт дунджаар 147 хоног зарцуулсан байна. Тодруулбал, судлагдсан хэргүүдийн 49%-д нь 90 хоног хүртэл, 21%-д нь 91-183 хоног, 15% хувьд нь 184-273 хоног хэрэг бүртгэлт явуулсан байна.

Хүснэгт 1. Мөрдөн байцаалтын хэргийг шийдвэрлэсэн байдал

	Авлигатай тэмцэх газраас прокурорт шилжүүлсэн хэргийн судалгаа	Нийт	2018	2019
1	Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн тоо (АТГ-ын тоо)	263	115	148
2	Хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн хэрэг (АТГ-ын тоо)	9	3	6
3	Яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн (Прокурор)	124	41	83
	Хэрэгсэхгүй болгосон (Прокурор)	44	16	28
4	Нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан	88	-	-
5	Харьяаллын дагуу шилжүүлсэн	7	3	4

Судалгаанд 2017-2019 онд эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгосон прокурорын 28 тогтоолыг судалсан. Эдгээр эрүүгийн хэргийн 22 буюу 78.6%-ийг гэмт хэргийн

шинжгүй, 6 буюу 21.4%-ийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.




Хүснэгт 2. Хаасан, хэрэгсэхгүй болгосон хэрэгт эзлэх гэмт хэргийн зүйл

д/д	Хэргийг хэрэгсэхгүй болгосон хэргийн зүйл	Хаасан хэрэг бүртгэлтийн хэрэгт эзлэх хувь	Хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэрэгт эзлэх хувь
1	22.1/263 Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	73%	63%
2	22.4/268 Хээл хахууль авах	13.3%	17%
3	22.5/269 Хээл хахууль өгөх	5.9%	12%
4	22.8. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах	2.8%	3%
5	22.10/270 Үндэслэлгүйгээр хөрөнгөжих	2.5%	3%
6	22.11 Дураараа аашлах	0.6%	-
7	22.12 Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах	-	3%

Ийнхүү ажиллагааг дутуу, хангалтгүй хийж байгаа нь: 1) мөрдөгч, прокурорын ажлын ачаалал их, 2) хэрэг мөрдөн шалгах стратеги, арга аргачлал, зохион

байгуулалт уламжлалт хэлбэрээр явагддаг, 3) мөрдөгч, прокуроруудад хэргийн талаар хөндлөнгөөс нөлөөлдөгтэй холбоотой байж болзошгүй байна.

Авлигын гэмт хэргийг амжилттай мөрдөн шалгахад сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс




Ажлын ачаалал их байгаа нь АТГ-ын хүлээн авч шалгаж буй гомдол мэдээлэл, хэргийн тоо их, ялангуяа авлигын гэмт хэргийн онцлог, түүний ээдрээ төвөгтэй байдалтай холбоотой. Түүнчлэн авлигын

хэрэгт хамааралтай мэдээлэл, нотлох баримт цуглуулах, судлах, холбогдох дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл авах зэрэг нь ихээхэн цаг хугацаа, ажиллагаа шаардаж байна.



Мөрдөн шалгах ажиллагааны арга техник, ашигладаг давтамж



Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагаа үндсэндээ уламжлалт арга ажиллагаанд тулгуурлаж байна. Харин энэхүү уламжлалт арга ажиллагаа нь удаан хугацааны дараа илэрдэг, зохион байгуулалттай үйлдэгддэг авлигын, тэр дундаа эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг илрүүлэхэд үр дүн багатай байна

Тиймээс, ажиглалт хийх, өгөөш тавих, нууц мөрдөн шалгах ажиллагааг зарим төрлийн авлигын гэмт хэргийг илрүүлэхэд түлхүү ашиглах шаардлагатай байна. Ялангуяа, 22.8, 22.9, 22.10 зэрэг авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл цөөн ирж байгаа нь эдгээр төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шалгах шинэлэг арга ажиллагаа хэрэгтэйг харуулж байна. Дээр дурдсан ажиллагааны төрлүүд нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад үр дүнгээ өгдөг, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн арга техник юм.

IV. Дүгнэлт

Авлигын гэмт хэрэг нь нийгэм, эдийн

засгийг хүндрэлд оруулахаас гадна, хувь хүний ёс зүйд нөлөө үзүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Иймд төр ба хувь хүний оролцоо маш чухал байдаг. Монгол Улс 1990 онд зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжин орсноор авлигын гэмт хэрэг нь ихээр гарах болсон байна. Энэхүү илтгэлд авлигыг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, илрэн гарч буй хэлбэрийг судалж, түүнтэй тэмцэх арга зам түүний эрх зүйн зохицуулалтын гадаад орны эрх зүйн зохицуулалтын талаар дурдахыг зорьсон.

Мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлгийн шатанд эрүүгийн хууль тогтоомжийг оновчтой зөв хэрэглэхийн тулд авлигын гэмт хэргийн ойлголт ба цар хүрээ, бэлэг ба авлигын ялгаа, төрийн албан хаагчийн цар хүрээ хувь хүн хоорондын авлигын талаар эрүүгийн хуульд хуульчилж өгөх, эрүүгийн хууль дахь эрүүгийн хариуцлага ба зөрчлийн хуулин дахь хариуцлагын хэм хэмжээ хоорондын



ялгаатай талыг тодорхой болгох хэрэгтэй бөгөөд үүний талаар эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг дурдаж, үүнээс гадна Дээд шүүхийн оновчтой бөгөөд ойлгомжтой тайлбар хэрэгтэй юм. Хөгжингүй улс орнуудын хууль тогтоомжийн нэгэн адил хээл хахуульд үг хэллэгээс хамаарахгүйгээр шан харамж авч олсон орлогод тохирсон ял шийтгэл оногдуулах журмыг зүйлчилж өгөх зүйтэй.

Авлигын эсрэг хууль нь тухай бүр үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байгаа тухай дүгнэлт гарсан төдийгүй Авлигын тухай хуулийг бүхэлд нь нэмэлт өөрчлөлт оруулах санал дэвшүүлсэн ба уг хуулийн зорилгыг тодорхой болгон хуулийн үйлчлэх хүрээг өргөн болгох, нөгөөтээгүүр урьдчилан сэргийлэх зорилгыг хангалттай биелүүлэхэд иргэдэд ойлгогдохуйц нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй бөгөөд улс төр, эдийн засаг, аж ахуйн нэгж, цагдаагийн байгууллага, шүүх, прокурор, бусад албан байгууллагуудыг хамруулсан өргөн хүрээнд авлигыг зогсоож чадах хууль хэрэгтэй байна.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын бие даасан байдлыг хангахын тулд Авлигатай тэмцэх газрын даргыг сонгох эрхийг намын харьяаллаас татгалзсан субъектэд олгох шаардлагатай.

Төрийн албан хаагчид хангалттай цалин олгохгүй мөн амьдралын түвшин сайжраагүй нөхцөлд Монгол Улсын авлигын гэмт хэрэг нь хэзээ ч зогсохгүй бөгөөд төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, бараан бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах нь зүйтэй юм.

Авлигатай тэмцэх газарт ажиллаж буй мөрдөгчдийн ажлын ачаалал их байгаа нь АТГ-ын хүлээн авч шалгаж буй гомдол

мэдээлэл, хэргийн тоо их, ялангуяа авлигын гэмт хэргийн онцлог, түүний ээдрээ төвөгтэй байдалтай холбоотой юм. Мөн авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа үндсэндээ уламжлалт арга ажиллагаанд тулгуурлаж байна. Харин энэхүү уламжлалт арга ажиллагаа нь удаан хугацааны дараа илэрдэг, зохион байгуулалттай үйлдэгддэг авлигын, тэр дундаа эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэргийг илрүүлэхэд үр дүн багатай байгаа нь судалгаанаас харагдсан.

Эцэст нь Монголчуудын хувьд хээл хахуулийн гэмт хэрэг нь ердийн өдөр тутмын байх ёстой үзэгдэл мэт сэтгэхүйн ойлголтыг өөрчилж, сэтгэхүйд нь өөрчлөлт хийх, нөгөөтэйгүүр улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт шударга ёсны, ардчилсан тогтолцоотой нийгмийг цогцлоохын тулд иргэн, хувь хүн, төр, засгийн байгууллагууд хүсэл зорилгоо нэгтгэж, хамтарч ажиллах нь зүйтэй юм.

V. Санал

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Авлигын гэмт хэргийн онцлог тохирсон эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг албан тушаалын ангилал, зэрэглэл, гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэмжээ зэргийг харгалзан Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлд өөрчлөлт оруулж нэмэх,

2. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийтийн албан тушаалтан хийх ёстой үйлдэл хийсний үр дүнд бий болсон давуу байдлын үр өгөөжийг өөрөө болон хамаарал бүхий этгээд нь хүртсэн, ашигласан бол гэмт хэрэгт тооцохоор өөрчлөлтийг оруулах;

3. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан нийтийн албан тушаалтны жагсаалтыг Авлигын



эсрэг конвенцод нийцүүлэн өргөжүүлэх. Тухайлбал Авлигын эсрэг хуулийн 4.1.2-т “мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадалгаа гаргах, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий төрийн үйлчилгээний албаны ажилтан” гэж өөрчлөлт оруулж нэмэх,

Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах стратеги, шийдвэрлэх зохион байгуулалтыг сайжруулах талаар:

1. Нэг мөрдөгч, прокурорт ногдох ажлын ачааллыг бууруулж, хуваарилагдсан хэрэгт төвлөрч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2. Хэргийн онцлогоос хамаарч мөрдөн шалгах ямар ажиллагааг ямар дарааллаар, аль шатнаас эхлэх, мэдүүлгийг хэзээ авах уу гэх зэрэг аргачилсан заавар, хэрэг шалгах хувилбарууд, загвар стратеги боловсруулж ашиглах;

3. Хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан мөрдөгч, прокурор багаар ажиллах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох журамд оруулж, Мөрдөгч, прокурорууд багаар ажиллах зохицуулалтыг нэвтрүүлэх. Ингэхдээ, мөрдөх багийн гишүүд чиг үүрэг, оролцооны хувьд дагнан мэргэшиж мөрдөн шалгах ажиллагаанд оролцдог болгох;

АТГ-ын өргөдөл гомдол хүлээж авах ажиллагааг сайжруулах чиглэлээр.

1. Мэдээлэх системийг хэрэглэгчид ээлтэй болгох. Өргөдөл, гомдол хүлээн авах ажлыг хөнгөвчлөх зорилгоор өргөдөл, гомдлын маягт ашигладаг болох, мөн con1ac1@1aac.tn гэх байгууллагын мэдээлэл хүлээн авах сувгаас гадна авлигын гомдол, мэдээлэл авах тусгай мэйл хаяг нээх;

2. Иргэн АТГ-ын цахим хуудсаар нэр хаяггүйгээр гомдол, мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэх, талбарыг нотлох баримт (зураг, файл, дүрс бичлэг) хавсаргах боломжтой болгох зэрэг болно.

НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж:

Ц.Энхбат. Авлига ба Иргэний нийгэм өгүүлэл. 2012 он

С.Гантулга., Б.Энхболд. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ. 2018 он

Я.Цэвэл. Монгол хэлний эх тайлбар толь. УБ. 1960 он

Д.Зүмбэрэллхам. Авлига гэмт явдал. УБ. 2011 он

II. Эрх зүйн эх сурвалж:

Эрүүгийн хууль/шинэчилсэн найруулга/. УБ хот. 2015 он

Авлигын эсрэг хууль. УБ. 2006 он

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ хот. 2017 он

БНСУ-ын Эрүүгийн хууль. 2016 он

III. Бусад эх сурвалж:

<https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>

<https://police.gov.mn/resource/policegovmn/media>

**ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ, ӨМГӨӨЛӨГЧ, ЭСХҮЛ ОРОЛЦОГЧ
ӨӨРӨӨ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ БОЛОН УЛСЫН ДЭЭД
ШҮҮХЭД ГОМДОЛ ГАРГАСАН ТООН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ,
ШИЙДЛИЙН САНАЛ**

**FINDINGS OF QUANTITATIVE ANALYSES ON APPEALS
TO THE SUPREME COURT BY LEGAL PERSONS AND REPRESENTATIVES,
AND ITS RECOMMENDATIONS ABOUT SOLUTIONS**

Баатарын ЭНХТАЙВАН¹

- I. Тоон судалгааны үр дүн
- II. Итгэмжлэл гэгч нь юу болох, нэг талын хэлцэл болох тухайд
- III. Итгэмжлэлийг зөв тайлбарлаж хэрэглэх боломж
- IV. ХБНГУ-ын сайн жишээ
- V. Улсын дээд шүүхийн зөвлөмжийн агуулга
- VI. Дүгнэлт
- VII. Ном зүй

¹ Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш



**ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ, ӨМГӨӨЛӨГЧ,
ЭСХҮЛ ОРОЛЦОГЧ ӨӨРӨӨ ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХ БОЛОН УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД
ГОМДОЛ ГАРГАСАН ТООН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ,
ШИЙДЛИЙН САНАЛ**

Б.ЭНХТАЙВАН. /LL.M/ Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш

Товчлол

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга үйлчилж эхэлснээс хойш буюу 2021 оны 3-р сарын 1-нээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд давж заалдах шатны шүүхүүд болон Улсын Дээд Шүүхэд хандан хуульд заасан үндэслэлээр, түүнчлэн хууль хэрэглээний зөрүүтэй байдлын талаар хяналтын гомдол гаргасан эрүү, иргэн, захиргааны тодорхой тооны хэргээс субъектынх нь тухайд хэн гомдол гаргаж байгаа талаар тоон судалгааг гаргаж¹ өгүүлэл бичихэд дэмжлэг үзүүлсэн УДШ-ийн Шүүхийн Сургалт, Судалгаа, Мэдээллийн Хүрээлэнгийн Судалгааны Төвийн хамт олонд юуны өмнө гүнээ талархал илэрхийлье.

Тоон судалгааны үр дүнгээс харахад, хамгийн олон тоогоор хяналтын шатны гомдол гаргаж байгаа субъект нь **ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ** нар гэж гарсан тоо нь /иргэн, захиргааны хэрэгт/ анхаарал татаж байна. Нөгөө утгаараа, энэ нь бодит байдал дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож

байгаа дийлэнх оролцогч нь ямар эрх зүйн статустай ямар субъект байна вэ гэдгийг ялангуяа иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хэлж байгаа тоо гэж хэлж болно. /Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хэдэн хувь нь өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй этгээд байгаа, хэд нь энгийн иргэд, хэд нь эрх зүйч, хэд нь хуульч, хэд нь хуульчийн, эсхүл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь хүчингүй болсон байгааг гаргах боломжгүй байсан гэдгийг зориуд дурдаж байна/

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохих зүйл, заалтыг зөв тайлбарлаж хэрэглэвэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч л шүүхэд төлөөлөх эрхтэй байх ёстой гэсэн ойлголт зүй ёсоор уг нь гарч байна. Гэтэл манайд өмгөөлөгч нар биш, итгэмжлэгдсэн төлөөлөгч нар энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарт нөлөөлөх, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зохих ёсоор хангагдахгүйд хүрэх, үүгээр Үндсэн хуульд тунхагласан өмгөөлөгч авах эрх нь хөндөгдөх, цаашлаад шүүхэд итгэх иргэдийн итгэл багасах бас нэг хүчин зүйл болж байх шиг. Энэ байдлыг даван туулах гарцыг тус өгүүллээр санал болгож байна.

¹ 21 аймаг, нийслэлийн хэмжээнд улсын дээд шүүхэд хууль хэрэглээний зөрүүтэй байдал гэсэн үндэслэлээр ирүүлсэн гомдлуудын тодорхой хувьд /2022.03.01.-2022.12.31-нийг хүртэлх хугацааны/ гомдлыг хэн гаргасан байгаа тоон судалгааг гаргаж дэмжлэг үзүүлсэн УДШ-ийн Шүүхийн Сургалт Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн судлаачдад талархал илэрхийлж байна.



Түлхүүр үг: нэг талын хэлцэл, итгэмжлэл, бүрэн эрх, нэг удаагийн ба ерөнхий итгэмжлэл, процессын бүрэн эрх, өмгөөлөгч, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

I. Тоон судалгааны үр дүн

2021.03.01-2021.12.31 хугацаанд Давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдол, тухайн хэрэг дээрээ Улсын Дээд Шүүхийн иргэн, эрүү, захиргааны хэргийн танхимд ирүүлсэн хяналтын гомдлыг гаргасан субъектыг ангилсан тоон судалгаа, харьцуулалт /тоон судалгаанд энэ хугацааны бүхий л давж заалдах гомдол гаргасан хэрэг хараахан

хамрагдаагүй, гэхдээ тодорхой хэсэг буюу 50 хувиас дээш хувь нь хамрагдсан, иргэний хэргийн хувьд хяналтын шатны гомдолтой хэргийн 50 хувиас дээш хувь хамрагдсан болохыг дурдаж байна/


I ИРГЭНИЙ ХЭРЭГТ ГАРСАН ГОМДОЛ /давж заалдах ба хяналтын журмаар/

1. Аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхэд гаргасан нийт 814 гомдлоос 494 буюу 60.6 хувь нь давж заалдах журмаар, 320 буюу 39.3 хувь нь хяналтын шатны журмаар гомдол гаргасан байна. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар харуулбал,

Оролцогч	Давж заалдах шатны шүүх						Улсын дээд шүүх	
	Нийслэл		Орон нутаг		Нийт			
Нэхэмжлэгч	46	9.3%	23	4.6%	69	13.96%	38	11.8%
Хариуцагч	57	11.5%	38	7.6%	95	19.23%	66	20.6%
Гуравдагч этгээд	1	0.2%	2	0.4%	3	0.6%	3	0.93%
Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	70	14.17%	8	1.6%	78	15.78%	37	11.56%
Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	103	20.8%	34	6.8%	137	27.73%	77	24.06%
Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	1	0.2%	1	0.2%	2	0.4%	1	0.31%
Нэхэмжлэгчийн өмгөөлөгч	20	4.04%	24	4.8%	44	8.9%	23	7.18%
Хариуцагчийн өмгөөлөгч	13	2.63%	15	3.03%	28	5.66%	19	5.93%
Гуравдагч этгээдийн өмгөөлөгч	0	0%	0	0%	0	0	0	0
Хамтарч гаргасан	7	1.4%	18	3.6%	25	5.06%	54	16.87%
Хэргийн оролцогчид аль аль нь гаргасан	5	1.01%	8	1.6%	13	2.63%	2	0.62%
	323	65.3%	171	34.6%	494	100%	320	100%

2. Судалгаанд хамрагдсан нийт гомдлын хичнээн хувийг хэргийн оролцогч, түүний эрх хууль ёсны ашиг

сонирхлыг хамгаалж буй этгээдээс дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасныг дараах байдлаар авч үзвэл:



Судалгаанд хамрагдсан нийт 814 гомдлоос авч үзэхэд хэргийн оролцогчдоос 107 буюу 13 хувийг нэхэмжлэгч, 161 буюу 20 хувийг хариуцагч, 6 буюу 1 хувийг гуравдагч этгээдээс гаргасан. Хэргийн оролцогчдын эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж буй этгээд болох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 332 буюу 41 хувийг, өмгөөлөгчөөс 114 буюу 14 хувийг дангаараа гаргасан байна. Харин 79 буюу 9 хувийг хамтран, 15 буюу 2 хувь нь хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан гомдол тус тус эзэлж байна.

3. Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхэд болон хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлын харьцуулалт:

- Давж заалдах журмаар 69 нэхэмжлэгч гомдол гаргасан нь нийт гомдлын 13.9 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 38 нэхэмжлэгч гомдол гаргасан нь нийт гомдлын 11.8 хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар 95 хариуцагч гомдол гаргасан нь нийт гомдлын 19.23 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 66 нэхэмжлэгч гомдол гаргасан нь нийт гомдлын 20.6 хувийг эзэлж байна.

- Давж заалдах журмаар 3 гуравдагч этгээд гомдол гаргасан нь нийт гомдлын 0.6 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 3 гуравдагч этгээд гомдол гаргасан нийт гомдлын 0.93 хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар 217 итгэмжлэгдсэн төлөөлөгч² гомдол гаргасан нь нийт гомдлын 43.9 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 115 **ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ ГОМДОЛ ГАРГАСАН НЬ НИЙТ ГОМДЛЫН 35.9 ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА.**
- Давж заалдах журмаар 72 өмгөөлөгч³ гомдол гаргасан нь нийт гомдлын 14.5 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 42 өмгөөлөгч гомдол гаргасан нь нийт гомдлын 13.1 хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар 25 хамтран⁴ гомдол гаргасан нь нийт гомдлын 5.06 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 54 хамтран гомдол гаргасан нь

² Нэхэмжлэгч болон хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

³ Нэхэмжлэгч болон хариуцагчийн өмгөөлөгч


⁴ Нэхэмжлэгч, хариуцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өмгөөлөгчтэйгээ хамтран гомдол гаргасан



нийт гомдлын 16.87 хувийг эзэлж байна.

- Давж заалдах журмаар 13 хэргийн оролцогчдын аль аль нь⁵ гаргасан нь нийт гомдлын 2.63 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар 2 хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан нийт гомдлын 0.62 хувийг эзэлж байна.

Аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд болон улсын дээд шүүхэд хэргийн оролцогчид, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нараас дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан гомдлыг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал,




⁵ Нэхэмжлэгч болон хариуцагч талаас гомдол гаргасан



4. Аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлын тоон үзүүлэлт /2022.03.01-2022.12.31 хугацааны бүхий л гомдол гаргасан хэрэг хараахан хамрагдаагүй, гэхдээ тодорхой хэсэг буюу 50 хувиас дээш хувь нь хамрагдсан/

Судалгаанд хамрагдсан нийт гомдлын 494 буюу 60.6 хувь нь аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан байна. Үүнийг хэргийн оролцогчид, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нараас дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан байдлыг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал,



Дээрх хүснэгтээс үзвэл аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан нийт 494 гомдлоос аймаг болон нийслэлд гаргасан гомдлыг хувиар авч үзвэл:

- Нийслэлд давж заалдах журмаар **46 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь давж заалдах журмаар гаргасан нийт гомдлын **9.3**

хувийг эзэлж байгаа бол аймагт **23 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **4.6** хувийг эзэлж байна.

- Нийслэлд давж заалдах журмаар **57 хариуцагч** гомдол гаргасан нь нийт гомдлын 11.5 хувийг эзэлж байгаа бол аймагт **38 хариуцагч** гомдол гаргасан нь



- Нийт гомдлын **7.6** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **174 итгэмжлэгдсэн төлөөлөгч⁶** гомдол гаргасан нь нийт гомдлын **35.2** хувийг эзэлж байгаа бол аймагт **43 итгэмжлэгдсэн төлөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **8.7** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **33 өмгөөлөгч⁷** гомдол гаргасан нь нийт гомдлын **6.6** хувийг эзэлж байгаа бол аймагт **39 өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **7.8** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **хамтран⁸ 7** гомдол гаргасан нь нийт гомдлын **1.4** хувийг эзэлж байгаа бол аймагт давж хамтран 18 гомдол гаргасан нь нийт гомдлын **3.6** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **5 хэргийн оролцогчдын аль аль нь⁹** гаргасан гомдлын нийт гомдлын 1 хувийг эзэлж байгаа бол аймагт давж заалдах журмаар **8 хэргийн оролцогчдын аль аль нь** гаргасан нийт гомдлын **1.6** хувийг тус тус эзэлж байна.

II ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ГАРГАСАН, УЛМААР ХЯНАЛТЫН ГОМДЛЫГ ГАРГАСАН СУБЪЕКТЫН ТООН СУДАЛГАА ГОМДОЛ

Оролцогч	Давж заалдах шатны шүүх				Давж заалдах шатны шүүх		Улсын дээд шүүх	
	Нийслэл		Орон нутаг		Нийт			
Хохирогч	4	2%	4	2%	8	4.50%	7	4%
Шүүгдэгч	6	3%	8	4.50%	14	8%	32	18%
Хохирогчийн өмгөөлөгч	2	1%	1	0.50%	3	2%	3	2%
Шүүгдэгчийн өмгөөлөгч	28	16%	32	19%	60	34%	85	48%
хамтран гаргасан	24	14%	8	5%	32	18.50%	23	13%
Прокурор	21	12%	18	10%	39	22%	19	11%
Хэргийн оролцогчид аль аль нь гаргасан	13	7%	7	4%	20	11%	6	3.50%
Иргэний нэхэмжлэгч, хариуцагч	0	0	0	0	0	0	1	0.50%
НИЙТ	98	55%	78	45%	176	100%	176	100%

⁶ Нэхэмжлэгч болон хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч

⁷ Нэхэмжлэгч болон хариуцагчийн өмгөөлөгч


⁸ Нэхэмжлэгч, хариуцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нь өмгөөлөгчтэйгээ хамтран гомдол гаргасан

⁹ Нэхэмжлэгч болон хариуцагч талаас гомдол гаргасан



Хяналтын журмаар гаргасан 176 гомдлын 98 гомдол буюу 56%-ийг нийслэлээс, 78 гомдол буюу 44%-ийг орон нутгаас гаргасан байна.

Хяналтын шатны журмаар гаргасан гомдол




■ Нийслэл ■ Орон нутаг

2. Хохирогч шүүгдэгч дангаараа / хуульч биш хүн/ гомдол гаргаж байгаа нь нийт гомдлын хэдэн хувьд байгаа, харин өмгөөлөгч дангаараа гаргаж байгаа нь хэдэн хувь, хамтран гаргаж байгаа нь хэдэн хувь

Судалгаанд хамрагдсан нийт 352 гомдлоос авч үзэхэд 4.2%-ийг хохирогч, 13%-ийг шүүгдэгч, 42.8%-ийг өмгөөлөгч, 16%-ийг хамтран гомдол гаргасан бол 16.4%-ийг прокурорын эсэргүүцлээр, 7.3%-ийг хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан гомдол тус тус эзэлж байна.


Нийт гомдлыг харьцуулсан байдал



■ Хохирогч
■ Өмгөөлөгч
■ Прокурорын эсэргүүцэл
■ Шүүгдэгч
■ Хамтран
■ Хэргийг оролцогчдын аль аль нь


3. Давахын гомдлоос хяналтын гомдол гаргахад дээрх харьцаа яаж өөрчлөгдөж байна

Давж заалдах журмаар **8 хохирогч** гомдол гаргасан нь нийт гомдлын 4.5%-ийг эзэлж байгаа бол хяналтын шатны журмаар 7 хохирогч гомдол гаргасан нь нийт гомдлын 4%-ийг тус тус эзэлж байна.







Давж заалдах журмаар **14 шүүгдэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын 8%-ийг эзэлж байгаа бол хяналтын шатны журмаар 32 шүүгдэгч гомдол гаргасан нь нийт гомдлын 18%-ийг тус тус эзэлж байна.



Давж заалдах журмаар 32 **хамтран**¹¹ гомдол гаргасан нь нийт гомдлын 18.5%-ийг эзэлж байгаа бол 23 хохирогч эсхүл шүүгдэгч өмгөөлөгчтэйгөө хамтран хяналтын шатны журмаар гомдол гаргасан нь нийт гомдлын 13%-ийг тус тус эзэлж байна.



Давж заалдах журмаар **63 өмгөөлөгч**¹⁰ гомдол гаргасан нь нийт гомдлын 36%-ийг эзэлж байгаа бол 88 өмгөөлөгч хяналтын шатны журмаар гомдол гаргасан нь нийт гомдлын 50%-ийг тус тус эзэлж байна.




4. Нийслэлийн шүүх болон орон нутгийн шүүхэд давж заалдах журмаар **хохилогч** гомдол гаргасан нь нийт гомдлын 2%, 2%-ийг тус тус эзэлж байна.

¹⁰ хохирогч болон шүүгдэгчийн өмгөөлөгч нар.

¹¹ хохирогч эсхүл шүүгдэгч өмгөөлөгчтэйгөө хамтран гомдол гаргасан.




Хохирогч гомдол гаргасан




Нийслэлд давж заалдах журмаар 6 **шүүгдэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын 3%-ийг эзэлж байгаа бол орон нутагт 8 шүүгдэгч гомдол гаргасан нь нийт гомдлын 4.5%-ийг тус тус эзэлж байна.

Шүүгдэгч гомдол гаргасан



Нийслэлд давж заалдах журмаар 30 **өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын 17%-ийг эзэлж байгаа бол орон нутагт 33 өмгөөлөгч гаргасан нь нийт гомдлын 19.5%-ийг тус тус эзэлж байна.


Өмгөөлөгч гомдол гаргасан



Нийслэлд давж заалдах журмаар **хамтран** 24 гомдол гаргасан нь нийт гомдлын 14%-ийг эзэлж байгаа бол орон нутагт хамтран 8 гомдол гаргасан нь нийт гомдлын 5%-ийг тус тус эзэлж байна.



Хамтран гомдол гаргасан



**III ЗАХИРГААНЫ ХЭРЭГТ ДАВЖ
ЗААЛДАХ БОЛОН ХЯНАЛТЫН
ЖУРМААР ГАРГАСАН ГОМДЛЫН ТООН
СУДАЛГАА /2021.03.01-2021.12.31**


хугацаанд Давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлын тодорхой хэсэг буюу улсын дээд шүүхэд хянагдсан хэргийн хүрээнд/

1. Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхэд гаргасан нийт 308 гомдол байна. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй байдлаар харуулбал,

Оролцогч	Давж заалдах шатны шүүх						Улсын дээд шүүх	
	Нийслэл		Орон нутаг		Нийт			
Нэхэмжлэгч	15	13.76%	12	26.66%	27	17.53%	33	21.42%
Хариуцагч	8	7.33%	9	20%	17	11.03%	10	6.49%
Гуравдагч этгээд			1	2.22%	1	0.64%	3	1.94%
Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	27	24.77%	7	15.55%	34	22.07%	27	17.53%
Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	24	22.01%	6	13.33%	30	19.48%	21	13.63%
Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч	2	1.83%			2	1.29%	3	1.94%
Нэхэмжлэгчийн өмгөөлөгч	5	4.58%	5	11.11%	10	6.49%	19	12.33%
Хариуцагчийн өмгөөлөгч			2	4.44%	2	1.29%	6	3.89%
Гуравдагч этгээдийн өмгөөлөгч							5	3.24%
Хамтарч гаргасан	16	14.67%	1	2.22%	17	11.03%	19	12.33%
Хэргийн оролцогчид аль аль нь гаргасан	12	11%	2	4.44%	14	9.09%	8	5.19%
	109	100%	45	100%	154	100%	154	100%



2. Судалгаанд хамрагдсан нийт гомдлын хичнээн хувийг хэргийн оролцогч, түүний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж буй этгээдээс дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасныг дараах байдлаар авч үзвэл:



- Нэхэмжлэгч
- Хариуцагч
- Гуравдагч этгээд
- Төлөөлөгч
- Өмгөөлөгч
- Хамтран гаргасан
- Хэргийн оролцогчид аль аль нь

Судалгаанд хамрагдсан нийт 308 гомдлоос авч үзэхэд хэргийн оролцогчдоос 60 буюу 19 хувийг нэхэмжлэгч, 27 буюу 9 хувийг хариуцагч, 4 буюу 1 хувийг гуравдагч этгээдээс гаргасан. Хэргийн оролцогчдын эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж буй этгээд болох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс 117 буюу 38 хувийг, өмгөөлөгчөөс 42 буюу 14 хувийг дангаараа гаргасан байна. Харин 36 буюу 12 хувийг хамтран, 22 буюу 7 хувь нь хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан гомдол тус тус эзэлж байна.

3. Аймаг, нийслэлийн давж заалдах шатны шүүхэд болон хяналтын шатны


шүүхэд гаргасан гомдлын харьцуулалт:

- Давж заалдах журмаар **27 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **17.53** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **33 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **21.42** хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар **17 хариуцагч** гомдол гаргасан нь нийт гомдлын **11.03** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **10 хариуцагч** гомдол гаргасан нь нийт гомдлын **6.49** хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар **1 гуравдагч** этгээд гомдол гаргасан нь нийт гомдлын **0.64** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **3 гуравдагч** этгээд гомдол гаргасан нь нийт гомдлын **1.94** хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар **66 итгэмжлэгдсэн** төлөөлөгч гомдол гаргасан нь нийт гомдлын **42.85** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **51 итгэмжлэгдсэн** төлөөлөгч гомдол гаргасан нь нийт гомдлын **33.11** хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар **12 өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **7.79** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **30 өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **19.48** хувийг эзэлж байна.
- Давж заалдах журмаар **17 хамтран** гомдол гаргасан нь нийт гомдлын **11.03** хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **19 хамтран** гомдол гаргасан нь нийт гомдлын **12.33** хувийг эзэлж



- байна.
- Давж заалдах журмаар **14 хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан нь** нийт гомдлын 9.09 хувийг эзэлж байгаа бол хяналтын журмаар **8 хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан** нийт гомдлын **5.19** хувийг эзэлж байна.


Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд болон улсын дээд шүүхэд хэргийн оролцогчид, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нараас дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан гомдлыг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал



4. Аймаг, нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдлын тоон үзүүлэлт:

Судалгаанд хамрагдсан нийт гомдлын 154 нь аймаг, нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах

шатны шүүхэд гаргасан байна. Үүнийг хэргийн оролцогчид, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нараас дангаараа болон хамтран гаргасан, хэргийн оролцогчдын аль аль нь гаргасан байдлыг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал,



Дээрх хүснэгтээс үзвэл аймаг, нийслэлийн захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан нийт 154 гомдлоос аймаг болон нийслэлд гаргасан гомдлыг хувиар авч үзвэл:

- Нийслэлд давж заалдах журмаар **15 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь давж заалдах журмаар гаргасан нийт гомдлын **9.74** хувийг эзэлж байгаа бол аймагт **12 нэхэмжлэгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **7.79** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **8 хариуцагч** гомдол гаргасан нь нийт гомдлын **5.19** хувийг эзэлж байгаа бол аймагт **9 хариуцагч** гомдол гаргасан нь нийт гомдлын **5.84** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар

53 итгэмжлэгдсэн төлөөлөгч гомдол гаргасан нь нийт гомдлын **34.41** хувийг эзэлж байгаа бол аймагт **13 итгэмжлэгдсэн** төлөөлөгч гомдол гаргасан нь нийт гомдлын **8.44** хувийг эзэлж байна.


- Нийслэлд давж заалдах журмаар **5 өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **3.24** хувийг эзэлж байгаа бол аймагт **7 өмгөөлөгч** гомдол гаргасан нь нийт гомдлын **4.54** хувийг эзэлж байна.
- Нийслэлд давж заалдах журмаар **хамтран 16** гомдол гаргасан нь нийт гомдлын 10.38 хувийг эзэлж байгаа бол аймагт давж **хамтран 1** гомдол гаргасан нь нийт гомдлын **0.64** хувийг эзэлж байна.



- Нийслэлд давж заалдах журмаар **12 хэргийн оролцогчдын аль аль нь** гаргасан гомдлын нийт гомдлын **7.79** хувийг эзэлж байгаа бол аймагт давж заалдах журмаар **2 хэргийн оролцогчдын аль аль нь** гаргасан нийт гомдлын **1.29** хувийг тус тус эзэлж байна.

ЭРҮҮ, ИРГЭН, ЗАХИРГААНЫ ШҮҮХҮҮДЭД ХАМТРАН ГАРГАСАН, НЭХЭМЖЛЭГЧ, ХАРИУЦАГЧ, ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАРГАСАН ГОМДЛЫГ НИЙТ ГОМДЛЫН ТООНД ХАРЬЦУУЛБАЛ:

	Өмгөөлөгч		Нэхэмжлэгч		Хариуцагч		Итгэмжлэгдсэн төлөөлөгч		Хамтран гаргасан		Нийт гомдлын тоо	
	Давах	Дээд	Давах	Дээд	Давах	Дээд	Давах	Дээд	Давах	Дээд	Давах	Дээд
Эрүү	63 36%	88 50%	8 4.5%	7 4%	14 8%	32 18%			32 18%	23 13%	176	176
Иргэн	72 14.56%	42 13.11%	69 13.96%	38 11.8%	95 19.23%	66 20.6%	217 43.92%	115 35.93%	25 5.06%	54 16.87%	494	320
Захиргаа	12 7.78%	30 19.46%	27 17.53%	33 21.42%	17 11.03%	10 6.49%	66 42.85%	51 33.11%	17 11.03%	19 12.33%	154	154



II. Итгэмжлэл гэгч нь юу болох, нэг талын хэлцэл болох тухайд

Хэлцлийг хувийн эрх зүйд хувь этгээд зөвхөн өөрөө хийх шаардлагатай, хувийн байдалтай нь салшгүй холбоотой

хэлцэл, бусдаар төлөөлүүлэн хийж болох хэлцэл гэж ангилдаг. Хувийн байдалтай нь салшгүй холбоотой хэлцэлд тухайлбал гэрлэх, хүүхэд үрчлэн авах зэрэг орох бол, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхтэй холбоотой бараг бүх хэлцлийг бусдаар



төлөөлүүлэн хийж болох юм. Яагаад хэлцлийг төлөөлөгчөөр дамжуулан хийх тухай асуудлыг хөндөх болов гэхээр, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх итгэмжлэл нь нэг удаагийн биш, ерөнхий мэргэжлийн үйл ажиллагааны буюу процессын шинжтэй байхад, хэлцэл байгуулахад олгодог нэг удаагийн итгэмжлэлтэй хольж хутгаж ойлгож хэрэглээд байгааг эргэж нэг авч үзэх цаг болсон үзэж байна. Хэлцэл гэдэгт нэг ба түүнээс дээш этгээдийн илэрхийлсэн, нөгөө тал нь хүлээн зөвшөөрөх шаардлагатай, эсхүл шаардлагагүй, эрх зүйн үр дагавар үүсгэхэд чиглэсэн хүсэл зоригийн илэрхийллийн нэгдлийг хэлцэл гэнэ. Нэг талын хэлцэл нь зөвхөн нэг этгээдийн хүсэл зоригийн илэрхийллийг агуулна¹². Тиймээс итгэмжлэлээр төлөөлөх төлөөлөл нь дараах шинжээрээ нэг талын хэлцэл билээ. Төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, хязгаарлагдмал чадамжтай иргэн байж болохоор Иргэний Хуульд заасан байгаа нь төлөөлөгчийг төлөөлүүлэгчийн “уртасгасан гар”¹³ төдий үзэх, төлөөлөгчөөр дамжуулан хийсэн хэлцлийн бүхий л эрх зүйн үр дагавар гагцхүү **төлөөлүүлэгчид л** үүсдэг учраас нэг талын хэлцэл болдог байна. Тиймээс ч, итгэмжлэлийг гэрчилж буй нотариатчид, гадаад оронд байгаа иргэний хүсэл зоригийг гэрчилж буй нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нь гагцхүү итгэмжлэл олгож буй этгээдийн гарын үсгийг зуруулж, харин итгэмжлэл авч буй буюу итгэмжлэлээр олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэх /өөр орон нутагт буюу Монгол улсад байгаа/ этгээдийн гарын үсгийг заавал зуруулах шаардлагагүйгээр,

¹² Б.Буянхшиг, Д.Энхзул, Б.Тэмүүлэн нар “Иргэний эрх зүй Ерөнхий анги”, 2010 он, 39 дэх тал

¹³ Д.Янжинхорлоо “Иргэний эрх зүйн үндсэн асуудал, үүргийн гүйцэтгэлийг хангах арга”, 2019, удиртгал хэсэг

хоосон чигт нь ГХЯ руу илгээдэг байна.

Манайд хуулийн товчоогоор үйлчлүүлж буй иргэн, эсхүл хуулийн этгээд өмгөөллийн үйлчилгээ авч байгаа тэрхүү фирмийн аль нэг ажилтан, магадгүй туслах, өмгөөлөгчид иргэн, эсхүл захиргааны хэрэгт төлөөлүүлэхээр итгэмжлэл олгож байна. Ингэж итгэмжлэл авсан өмгөөлөгч/ажилтан, хамт ажилладаг өөр нэг өмгөөлөгчтэйгээ Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээг байгуулж, шүүхэд гаргаж өгч хэвшжээ. Зүй нь, процесст төлөөлөх итгэмжлэлийг өмгөөлөгч өөрөө л авах ёстой гэж онолын хувьд үздэг байна. Үйлчлүүлэгч нь хувь өмгөөлөгчтэйгээ, эсхүл өмгөөллийн нөхөрлөлтэй Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг хоёр талаасаа бодитоор байгуулах нь зөв болох юм. Хэрэв нэг товчооны 2 өмгөөлөгч хоорондоо Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаад, түүнийгээ шүүхэд гаргаж өгөөд байгаа энэ практикийг зөвтгөхгүй бол, ашиг сонирхлын тогтолцооныхоо үүднээс энэ гэрээ Иргэний хуулийн 70 дугаар зүйлд зааснаар хүчин төгөлдөр бус болно¹⁴. Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээг нэг талаас туслалцаа авагч иргэн, нөгөө талаас өмгөөлөгч/төлөөлөгч байгуулж, ийм утгын алдаагүй гэрээг шүүх хэрэгт авч байвал илүү утга төгөлдөр болно, гэтэл одоогийн манай практикт 2 өмгөөлөгчийн хоорондын гэрээг нэг ижил ашиг сонирхолтой, нэг товчооны хоёр өмгөөлөгч хоорондоо байгуулчихаад байхад, хэдийгээр нэг өмгөөлөгч нь итгэмжлэгдсэн төлөөлөгч гээд гэрээнд зурсан ч, утга төгөлдөр гэж үзэж хэрэгт авч хавсаргаж байгаа нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Үйлчлүүлэгч буюу хэргийн оролцогч

¹⁴ Б.Буянхшиг “Иргэний эрх зүйн бодлогын хураамж” I, 2010 он, 101 дэх тал “дэд итгэмжлэлийн агуулга хуульд нийцэх эсэх тухай абзац”



өөрөө өмгөөлөгч, түүний товчоотой ямар гэрээ, итгэмжлэл байгуулж оролцохоо шийдээд, энэ гэрээ итгэмжлэл дээрээ маргаагүй цагт шүүхийн асуудал биш гэдэг нь нэг талаас үнэн. Гэхдээ шүүхэд төлөөлж оролцох бүрэн эрх хууль зүйн хувьд утга төгөлдөр үүсэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ нэг ижил ашиг сонирхол бүхий талуудын хооронд байгуулагдахгүй байх нь эргээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдах, субъектын эрх зүйн байдал алдаа мадаггүй тодорхойлогдох үр дагаврыг үүсгэнэ гэж харж байна.

III. Итгэмжлэлийг зөв тайлбарлаж хэрэглэх боломж

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны 4 төрөл заасны нэг нь “шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, өмгөөлөгчөөр оролцох” гэж заасан. Энэ үйл ажиллагааг явуулахдаа шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байх шаардлага тавигдана¹⁵. Өмгөөлөгчид олгож байгаа итгэмжлэл нь Иргэний хууль төдийгүй, тусгайлсан хууль болох Өмгөөллийн тухай хуулийг хамтад нь үндэслэж олгогдох ёстой гэж товчхондоо хэлэх гээд байна. Иргэд хоорондын нэг удаагийн хэлцэлд олгогдох итгэмжлэлтэй мэргэжлийн үйл ажиллагааг хольж ойлгох нь зүйд нийцэхгүй байна. Тоон судалгааны үр дүнгээр иргэн, захиргааны хэрэгт дийлэнх гомдлыг итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргаад, үлдэх хэсгийг өмгөөлөгч, эсхүл хэргийн оролцогч өөрөө биечлэн гаргаж байна. Иргэд

¹⁵ 24.2.Хуульч нь энэ хуулийн 24.1.5-д заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа энэ хуулийн 30, 31 дүгээр зүйлд заасны дагуу шүүхэд төлөөлөх эрхээ нээлгэсэн байна. Төрийн мэдээлэл, 2013

үнэндээ бол өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, цаашлаад эрх зүйч, хуульч гэх ялгаа заагийг нарийн мэдэхгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дууссаны дараа, эсхүл энэ ажиллагааны явцад хүссэн үр дүн нь бий болж өгөхгүй үед л Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоонд итгэмжлэгдсэн төлөөлөгчийнхөө мэргэжлийн ёс зүйн талаар ямар нэг гомдол санал гаргах эрхгүй, тэдгээр байгууллагад хамааралгүй, ямар нэг мэргэжлийн ёс зүйд баригдахгүй хүнтэй гэрээ байгуулсан гэдгээ хожимдсон хойноо олж мэдэхэд хүрч байна.

Хуульчийн мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд хэргийн оролцогч нарын итгэмжлэлийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь асуудал үүсгэж байгаа тухай зарим судлаачид асуудал дэвшүүлсэн тавьжээ. Судлаачид 1. Иргэдийн эрх зөрчигдөх, 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад тотгор учруулах, 3. Хуульчийн мэргэжлийн эрхэд сөргөөр нөлөөлж буй байдалд дүгнэлт хийсэн байна¹⁶. Иргэдийн эрх зөрчигдөж буй тухайд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд бусдыг төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдолд мэргэжлийн байх шинж алдагдаж, мэдлэг чадвар дутагдах асуудал үүсдэг. Тухайлбал төлөөлүүлж буй этгээдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөв таньж мэдэхгүй байх, цаашлаад зөв оновчтой хууль зүйн зөвлөгөө өгч чадахгүй байх, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсний улмаас төлөөлүүлэгч нь хохирох явдал

¹⁶ Н.Норовсамбуу нар Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд шүүхэд итгэмжлэлээр төлөөлөхтэй холбогдсон эрх зүйн асуудал, Нээлттэй нийгэм форумаас эрхлэн гаргаж буй цуврал, дугаар 25



тохиолддог тухай дурджээ¹⁷.

Өмгөөллийн холбоо зөвхөн эрүүгийн хэрэгтажилладаг өмгөөлөгчдийг бүртгэдэг байгууллага болж хязгаарлагджээ. Зүй нь, иргэн, захиргааны хэрэгт ч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй этгээд л төлөөллөөр ажиллах нь Үндсэн хуульд заасан зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжийг нь хангах юм. Одоо манайд хуульчийн эрхээ аваагүй эрх зүйчид, эсхүл хуульчийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь хүчингүй болсон, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхээ хасуулсан өмгөөлөгчид өмгөөллийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь тоон судалгаагаар баталгаажлаа.

Нотариатчид ч мөн тодорхой үүрэг байгаа гэж үзлээ. Шүүхэд төлөөлөх итгэмжлэлийг гэрчлэхдээ, Иргэний хууль биш, Өмгөөллийн тухай хуулийг үндэслэж байгаа эсэхийг нягталж байх шаардлага байна. Нэгэнт өмгөөлөгч төлөөллөөр оролцож байгаа тохиолдолд энэ нь өөр нэг өмгөөлөгч итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, өөрөө өмгөөлөгч атлаа өмгөөлөгч авах ёстой гэдэг шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах замаар хугацаа хожиж процессыг хортойгоор ашигладгийг болиулна.

Хуульчийн гэрчилгээтэй хуульчид нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан 24.1.5-аас бусад төрлийн үйл ажиллагааг эрхлэх тухай заагдсан тул шүүхийн процесст оролцохоос бусад үйл ажиллагааг эрхлэх нь зүйтэй байна. Хуулийг ийм байдлаар тайлбарлаж хэрэглэж заншвал өмгөөллийн үйл ажиллагаан дахь гажуудал багасаж, үүгээрээ шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх

¹⁷ Н.Норовсамбуу нар Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд шүүхэд итгэмжлэлээр төлөөлөхтэй холбогдсон эрх зүйн асуудал, Нээлттэй нийгэм форумас эрхлэн гаргаж буй цуврал, дугаар 25

ажиллагаанд эергээр нөлөөлөх, процесс чанаржих, шүүхэд итгэх иргэдийн итгэл дээшлэх үр нөлөөтэй юм.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт эрх, үүргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 95¹⁸ дугаар зүйлд зааснаар тайлбарлахаар зохицуулсан нь төлөөлөх эрхийн тухайд мөн хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлийг Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллагын төлөөлөх эрх, үүргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч төлөөлөгчийн эрхээс төдийлэн зарчмын ялгаагүй байдлаар зохицуулагдсан нь харагдаж байна.

Өмгөөллийн тухай хуульд заахдаа, **өмгөөлөгч шүүхэд төлөөлөх зарчмаар** оролцохыг үгчлэн заасан байна. Контекстийн утга буюу ямар харилцаанд өмгөөллийн хууль үйлчлэхийг заасан доорх хэсэг нь өмгөөлөгчийн эрхлэх ажил, хуульчийн эрхлэх ажлыг маш тодорхой зааглаж өгсөн хамгийн тусгай хэм хэмжээ байна:

Өмгөөллийн тухай хуульд

3.1. Үйлчлүүлэгчийг шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгчтэй холбогдсон харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2. Хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх, зөвлөмж, дүгнэлт гаргах, хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиох, төрийн болон бусад байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх, түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг **үйлчлүүлэгчийг**

¹⁸ Г.Банзрагч “Захиргааны процессын эрх зүй”, 2019 он, 280 дугаар тал



шүүхэд төлөөлөхөөс бусад хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуульчид энэ хууль хамаарахгүй.- / хуульчийн эрх авсан хуульчдын эрхлэх үйл ажиллагаа/

13.2. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, арбитрын маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн эрхийг энэ хууль болон холбогдох хуулиар тогтооно.

21 дүгээр зүйл. Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах

21.1. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийг **итгэмжлэл, хүсэлт, гэрээ**, эсхүл нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүрээнд томилолтын үндсэн дээр төлөөлнө.

Өмгөөллийн эрхгүй хуульчид нь дараах үйл ажиллагааг эрхлэхээр зохицуулагдсан:

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль

4 дүгээр зүйл. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөл

24.1. хуульч нь дараах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулна:

24.1.1. хууль зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх;

24.1.2. хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянах, батлах;

24.1.3. иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх;

24.1.4. нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах;

IV. ХБНГУ-ын сайн жишээ

ХБНГУ-д хүн бүр шүүх, албан байгууллагад **өмгөөлөгчөөр**

төлөөлүүлэх эрхтэй. Зарим хэрэгт бүр заавал өмгөөлөгч оролцох хуулийн шаардлага тавигдсан. Тодруулбал, давж заалдах болон хяналтын шатны шүүхүүдэд зөвхөн өмгөөлөгчөөр төлөөлүүлэх, гэр бүлийн хэргийн шүүх дэх гэрлэлт цуцлах, гэрлэлт цуцалсны үр дагаврыг шийдвэрлэх хэргүүд болох хүүхдийн асран хамгаалалт, асран тэтгэх үүрэг, гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн хуваарилалт, цаашилбал илүү чухал эрүүгийн хэргүүд, өндөр үнийн дүнгээр торгууль хүлээх зөрчлийн хэргүүдэд өмгөөлөгчийг эрх хамгаалах гэдэг утгаар заавал оролцуулна. Өмгөөлүүлэгч өөрөө даалгавар өгөх, эсхүл шүүхээс захиалах гэсэн хоёр төрөлтэй¹⁹.

Холбооны Дээд шүүх, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн дээд шүүхэд өмгөөлөгч заавал оролцох ёстой. Хөдөлмөрийн маргаанд давж заалдах шатны шүүхээс эхлэн, Үндсэн хуулийн шүүхэд өмгөөлөгч заавал оролцоно. Харин нийгмийн халамжийн талаарх маргаанд өмгөөлөгчийн оронд үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчид, ажил олгогчдын, ажилтнуудын холбоодыг процессын эрх бүхий төлөөлөгч этгээдээр оролцуулах жишээтэй. Санхүү, татварын маргаанд татварын зөвлөхүүд, эдийн засгийн шинжээчид төлөөлөн оролцож бас болно.

Хуульчийн эрхтэй мэт, цаашлаад өмгөөллийн үйл ажиллагаа эрхтэй мэт ойлголт төрүүлж итгэмжлэл аваад, өмгөөлөгчтэй адил үйл ажиллагаа явуулаад байхыг нь шүүх дуугүй харж суудаг ийм зохисгүй байдал ХБНГУ-д лав байдаггүй юм байна гэж ойлголоо.

¹⁹ Prozessvollmacht, - URL: [https://www.wikiwand.com/de/Zivilprozessrecht_\(Deutschland\)](https://www.wikiwand.com/de/Zivilprozessrecht_(Deutschland)).



V. Улсын дээд шүүхийн зөвлөмжийн агуулга

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх нь нэг этгээд нөгөө этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлыг хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогоороо /тухайлбал, нотлох баримт цуглуулах, шүүх хуралдаанд оролцох/ иргэний эрх үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох зорилго бүхий иргэний эрх зүйн харилцаан дахь төлөөллөөс ялгаатай²⁰.

Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно.

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 2002.07.24-ний өдрийн 263 тоот тогтоолд "сайн дурын төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлээр, гэрээгээр төлөөлөгчийн төлөөлөх эрх нь төлөөлүүлэгч төлөөлөгчийн хооронд хийгдсэн бичгийн гэрээгээр тодорхойлогдоно" гэж заасан байх тул энэ тухай баримтыг зайлшгүй гаргуулан авч хэрэгт хавсаргана.

Түүнээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийн төлөөлөх эрх нь эрх зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогддог бол өмгөөлөгчийн эрх нь өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй болохыг нотолж эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичгээр /өмгөөлөгчийн үнэмлэх/ батлагддаг байна.

Эндээс сайн дурын төлөөлөл буюу

²⁰ Монгол Улсын Дээд Шүүхийн Зөвлөмж. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх зарим асуудлын тухай. 2004 он. - URL: <https://legalinfo.mn/mn/detail/11136>.

гэр бүлийн гишүүнээрээ, эсхүл төрөл садангийн хүнээрээ л төлөөлүүлэх нь ашиг сонирхлын тогтолцооны үүднээс зөв гэж улсын дээд шүүх дүгнэж зөвлөж байсантай санал нийлж байна. Энд гол анхаарах зүйл нь, өмгөөлөгч нь гэрээ, хүсэлтийн үндсэн дээр төлөөлж оролцох ёстой болохоос итгэмжлэлээр төлөөлөх нь утгагүй гэсэн агуулгаар гарч, шүүхийн практик тогтоохоор зорьж байжээ.

VI. Дүгнэлт

Анхан шатаар зогсохгүй, давж заалдах журмаар хянуулах, улсын дээд шүүхэд хяналтын гомдол гаргахад хууль хэрэглээний нэгдмэл байдлын талаар өргөн хэмжээний мэргэшсэн мэдлэгтэй байж байж л хууль хэрэглээний зөрүү байгаа эсэхийг дүгнэх чадвар, боломж зөвхөн өмгөөллийн эрхтэй хуульчдын хүрээнд л байгаа, байх ёстой гэж шаардах нь зүйтэй. Үүгээрээ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хэрэгжүүлэх боломжгүй, өмгөөлөгчийн хэрэгжүүлэх шаардлагатай чиг үүрэг гэж харагдаж байна. Хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд онол ба практик хамтдаа хөгжих шаардлагатай, харин яг шүүхийн практикийн хөгжилд өмгөөлөгчийн үүрэг асар их билээ. Учир нь өмгөөлөгчийн хууль хэрэглээ, нөгөө талын өмгөөлөгчийн хариу эсэргүүцэл, үндэслэж буй хууль хэрэглээний оновчтой байдал, талуудын хууль хэрэглээнд шүүх хөндлөнгөөс үнэлэлт дүгнэлт өгч өөрийн хууль хэрэглээг толилуулах ёстой. Эндээс өмгөөлөгчийн хууль хэрэглээний стандартын тухай ярих шаардлагатай болж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг утга агуулгаар нь зөв тайлбарлаж хэрэглэж хэвшвэл, мэргэжлийн мэргэшсэн хуульч, тухайн салбарын мэргэжилтэн-өмгөөлөгч



л эрүү, иргэн, захиргааны хэрэгт процессын итгэмжлэлийн үндсэн дээр бүрэн төлөөлж, өмгөөлөгч нар энэ явцдаа бичмэл ёс зүйн стандарт хэм хэмжээнд захирагддаг, заавал дагаж мөрдөх хуульчлагдсан үйл ажиллагааны журамтай учраас үйлчлүүлэгч нь өмгөөлөгчтэйгээ хариуцлага тооцох боломж нээгдэхээр байна.

Харин бидний гаргасан судалгаагаар, Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дугаар зүйлд заасан иргэд хоорондын төлөөллийн харилцаа гэж ойлгож, итгэмжлэлээр олгосон бүрэн эрхийг л хэрэгжүүлж байна, бүх үр дагавар нь үйлчлүүлэгчид оногдох байдлаар тайлбарлах нь хэр шударга байх вэ?

Энэ итгэмжлэлийн харилцааг буруугаар хэвшүүлснээс болж, үйлчлүүлэгч буюу өмгөөлүүлэгч нь өмгөөлөгчийн туслахад итгэмжлэл олгож, тэр товчооны туслах нь өмгөөлөгчтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулдаг болсон байна. Уг нь үйлчлүүлэгч бол өмгөөлөгчид найдаж итгэж эрхээ хамгаалуулахаар хандсанаас биш, бүрэн эрхээ туслахад нь шилжүүлээд, үр дагаврыг нь өөрөө бүрэн хүлээе гэсэн хүсэл зориг байдаггүй. Сонирхлын зөрчилтэй буюу нэг товчооны ажилтан, эсхүл өмгөөлөгч итгэмжлэл аваад, тэр нь цаашаа хамт ажилладаг өмгөөлөгчтэйгээ гэрээ байгуулах нь өмгөөллийн нөхөрлөлийн хувьд хууль зөрчөөгүй, өөрсдийн ачааллыг тэнцвэржүүлж байгаа мэт боловч, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаас нь авч үзвэл утгагүй юм. Зүй нь, өмгөөлөгч, төлөөлөгч нь нэг талдаа, нөгөө талд үйлчлүүлэгч байж Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах нь хэлцлийн агуулгадаа нийцэх юм.

НОМ ЗҮЙ

I. Эрх зүйн эх сурвалж:

Иргэний хууль, 2002 он
 Захиргааны ерөнхий хууль, 2015 он
 Эрүүгийн хууль, 2015 он
 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
 Хуульчийн эрх зүйн байдлын тухай, 2012 он
 Өмгөөллийн тухай, 2019 он хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх зарим асуудлын тухай, Улсын дээд шүүхийн зөвлөмж, 2004

II. Монгол эх сурвалж:

Б.Буянхишиг, Д.Энхзул, Б.Тэмүүлэн нар “Иргэний эрх зүй Ерөнхий анги”, 2010 он,
 Д.Янжинхорлоо “Иргэний эрх зүйн үндсэн асуудал, үүргийн гүйцэтгэлийг хангах арга”, 2019
 Б.Буянхишиг “Иргэний эрх зүйн бодлогын хураамж” I, 2010 он,
 Г.Банзрагч “Захиргааны процессын эрх зүй”, 2019 он,
 Н.Норовсамбуу нар “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй этгээд шүүхэд итгэмжлэлээр төлөөлөхтэй холбогдсон эрх зүйн асуудал”, Нээлттэй нийгэм форумаас эрхлэн гаргаж буй цуврал, дугаар 25

III. Бусад эх сурвалж

<https://legalinfo.mn/mn/detail/14859>
<http://www.supremecourt.mn/>
<https://bzd.civilcourt.gov.mn/>
<https://sbd.civilcourt.gov.mn/>
<https://www.admincourt.gov.mn/>
<https://legaldata.mn/buteel/pdf?id=794>



Abstract

FINDINGS OF QUANTITATIVE ANALYSES ON APPEALS TO THE SUPREME COURT BY LEGAL PERSONS AND REPRESENTATIVES, AND ITS RECOMMENDATIONS ABOUT SOLUTIONS

B.ENKHTAIVAN

Lecturer, School of Law, the National University of Mongolia

First of all, I would like to extend my thanks for the support of my co-workers at the Judicial Training, Research and Information Institute under the Supreme Court of Mongolia for helping me on the part of statistics of the article by assessing the data from 1 March 2021 to 31 December 2021 on representative subjects who are appealing to the Appellate as well as Supreme courts according to the newly adopted Mongolian law, *Law on Courts*.

According to the findings of statistical data, the largest number of persons who have appealed to the Supreme Court were the representatives based on warranty or representation, which seems interesting. On the other hand, it can be seen which type of legal status of the parties involved in judicial proceedings in practice are, particularly when it comes to civil as well as administrative proceedings. /It should be mentioned that it was impossible to determine what were the percentage of attorneys, lawyers, people who have not been admitted to practice law, those

whose licenses of practising law have been suspended or disbarred, or regular public among the representatives/.

If the relevant regulations of the *Law on Legal Status of Lawyers* are applied and interpreted in an adequate way, it should be seen that attorneys only shall represent the clients in judicial proceedings. Nonetheless, the representatives based on warranty or representation have such rights, not attorneys at all in Mongolia, which may cause declines in levels of public confidence in the judiciary, affect the efficiency of the proceedings, as well as the right to receive legal assistance by the Constitution, may be limited, legal interests and rights of clients may not be properly served.

Keywords

Unilateral agreement, representation, warranty, one-time or general representation, warranty at the court, attorney, practising law, judicial proceedings.

КОРПОРАЦЫН АВЛИГЫН ХЭРЭГ
ба
SIEMENS CORRUPTION CASE

Цэнд-Очирын МӨНХ-ЭРДЭНЭ¹

- I. Удиртгал
- II. Compliance Committee мөрдөн шалгах талаарх хамтын ажиллагаа
- III. Дотоод хяналт шалгалтыг хэрхэн гүйцэтгэсэн тухай
- IV. Дотоод хяналтын мөрдлөгийг шударгаар хуулийн дагуу явуулсан талаар
- V. Санал дүгнэлт
- VI. Ном зүй

¹ Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, судлаач (LL.M)



КОРПОРАЦЫН АВЛИГЫН ХЭРЭГ ба SIEMENS CORRUPTION CASE

Ц.МӨНХ-ЭРДЭНЭ. Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, судлаач (LL.M)

Удиртгал

Сүүлийн үед үндэстэн дамнасан корпорацийн авлигын хэргүүд нэмэгдэж байгаатай холбогдуулан олон улсын байгууллагуудаас корпорациудын авлигын хэргийн талаарх судалгаа хийх шаардлага байгаа талаарх нийтлэл premarket.org гэх цахим хуудсанд нийтлэгджээ. Учир нь корпорацийн авлига нь бизнесийн шударга өрсөлдөөнд итгэх итгэлийг бууруулж зах зээлийн шударга хэвийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй юм. Тодорхой жишээ дурдвал "...Айрбас (Airbus), Голдман Сакс (Goldman Sachs), Мак Кинсий (McKinsey), Новартис (Novartis), Сийменс (Siemens), Ролс Ройс (Rolls Royce) зэрэг корпорацийн удирдлагын холбогдсон авлигын хэргийг илрүүлсэн явдал юм. Олон улсын түвшинд корпорацийн авлигын хэргийг мөрдөн шалгаж шийдвэрлэхэд ахиц дэвшил илүү сайн гарсан байна. Ковид-19 цар тахлаас үүдсэн эдийн засгийн хямралтай холбоотойгоор авлигын хэргүүд цаашид илэрч, томоохон дуулиан дэгдэж болзошгүй гэж бид үзэж байна. Уоррен Буффет 2001 онд Беркшир Хэтэуэй корпорацийн хувьцаа эзэмшигчдэд зориулан илгээсэн захидалдаа дурдсанаар "Далайн түрлэг татрах үед л хэн нүцгэн сэлж байгааг олж мэдэж болно". Эдийн засгийн өсөлттэй

нөхцөл байдал нь авлигач удирдлага өөрсдийн ёс зүйгүй үйлдлээ нуухад нь дэм болж байдаг. Харин эдийн засгийн уналт, эдийн засгийн удаашрал зэрэг нь уг зохисгүй үйлдлийг илрүүлэн гаргах боломжийг олгож байдаг..."¹ Иймд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Корпорацийн авлигын хэргийг шалган шийдвэрлэсэн олон улсын сайн туршлагыг судлах цаг үеийн хэрэгцээ шаардлага бий болсон тул судлаачийн зүгээс Siemens corruption case-г ХБНГУ болон АНУ-ын хамтран мөрдөн шалгаж шийдвэрлэсэн туршлагад анализ хийж дэлгэрэнгүй танилцуулахыг зорилоо. Учир нь энэхүү хэрэгтэй холбоотойгоор ХБНГУ болон АНУ-ын хууль хяналтын байгууллага Siemens Корпорацийн хамтын ажиллагааг өндрөөр үнэлсэн байдаг.

Товчлол

Цар тахалтай холбоотой эдийн засгийн хямралын үеэр үндэстэн дамнасан зохион байгуулалтай эдийн засгийн гэмт хэргүүд илрэх магадлалтай байна. Үндэстэн дамнасан корпораци нь бизнесийн үйл ажиллагаагаа дэмжих зорилгоор хууль бус төлбөр тооцоог хэрхэн хөгжиж буй орны төрийн өндөр албан тушаалтнуудад өгдөг түүнийг нь хэрхэн мөрдөн шалгасан олон улсын

¹"We need more research on corporate corruption" by Armando Castro, Nelson Phillips



сайн туршлагыг өгүүлэх болно.

Дэлгэрэнгүй дурдвал Siemens корпорацийн удирдах зөвлөл болон Compliance Committee-н хяналтан дор Debevoise & Plimpton LLP хуулийн фирм нь дотоод хяналт шалгалтыг ХБНГУ болон АНУ-ын хууль сахиулагчдын Siemens корпорацийг буруутгаж буй нөхцөл байдалд хүрээнд явуулж, дүгнэлт хийж, яллах талын нотлох баримтыг цулглуулж хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан сайн туршлага юм.

Энэхүү сайн туршлагыг тодорхой жишээн дээр тухайн улсын хууль хяналтын байгууллагаас зөвшөөрөгдсөн хэмжээнд танилцуулах ба манай улсын эрүүгийн эрх зүйн системд нэвтрүүлж болох зохих саналыг дэвшүүлж бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжих болно.

Siemens Корпорацийн авлигын гэмт хэргийг АНУ болон Мюнхен хотын хууль хяналтын байгууллагын шалгасан мөрдөн шалгах ажиллагааны тайлангийн талаар

Түлхүүр үг

Авлига, Siemens корпораци, прокурорын газар, дотоод хяналт шалгалт, гэмт хэрэг, хууль сахиулагч, хууль хяналтын байгууллага.

2006 оны 11 дүгээр сард Siemens корпорацийг авлигын гэмт хэрэгт буруутган Мюнхен хотын прокурорын газраас тус Корпорацийн байрыг битүүмжилж мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхэлжээ. Корпорацийн зүгээс мөрдөн шалгалтыг бие даан явуулж ХБНГУ-ын болон гадаад улсуудын хууль хяналтын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээ нэн даруй илэрхийлжээ. Энэхүү оролдого нь амжилттай хэрэгжсэн бөгөөд зарим тохиолдолд хууль хяналтын эрх бүхий байгууллагын оролцоо зайлшгүй

шаардагдсан байна. Корпорацийн бие даасан мөрдлөг нь хууль сахиулах эрх бүхий байгууллагаас олгосон хэмжээ хязгаарын хүрээнд явагдсан хуулийн этгээдийг мөрдөн шалгах хамтын ажиллагааны шинэ хэлбэр байлаа.

Compliance Committee мөрдөн шалгах талаарх хамтын ажиллагаа

Мюнхений прокурорын газраас Siemens корпорацид мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхлэхтэй зэрэгцэн Siemens Корпорацийн удирдах зөвлөл, дотоод хяналт шалгалтын хороо хуралдаж тус корпорацид болсон асуудлыг олж тодорхойлох зорилгоор гадны бие даасан компаниудыг ажиллуулж дотоод шалгалт хийх хэрэгтэй гэж үзжээ. Ингээд Мюнхений прокурорын газар, АНУ-ын Хууль зүйн яам болон өөр бусад орнуудад Siemens Корпорацийн эсрэг эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явагдах нь тодорхой тул корпораци хуулийн эрх бүхий байгууллагуудтай бүрэн хэмжээнд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан, дотоод хяналт шалгалт хийх шийдвэрийг Корпорацийн удирдах зөвлөл гаргажээ.

Хөндлөнгийн шинжээчид

ОУ-ын хуулийн фирмүүдээс сонгож хамтран ажиллахдаа ажлын туршлага боловсон хүчний чадавхийг харгалзан үзэхийн зэрэгцээ бие даасан байж гадны ямар нэгэн нөлөөнд авталгүй дотоод хяналт шалгалтыг хийлгэх зорилгоор урьд нь Siemens корпорацитай ямар нэг байдлаар хамтарч ажиллаж байгаагүй Debevoise & Plimpton LLP хуулийн фирмийг сонгож гэрээ байгуулан ажиллуулахаар болж дотоод хяналт шалгалт хийж, зөвлөмж боловсруулан корпорацийн хяналт шалгалтын хороонд тайлагнаж байхаар тохиролцжээ. Хуулийн фирмийн зүгээс хяналт шалгалтыг хийхдээ



корпорац нь Авлигын эсрэг ямар хууль зөрчсөн, авлигын гэмт хэрэг корпорацын бүх салбаруудыг хамарч байгаа эсэхэд үнэлгээ хийж тус корпорацыг буруутгаж буй нотлох баримтыг цуглуулжээ.

Дотоод хяналт шалгалтыг хэрхэн гүйцэтгэсэн тухай

Үндсэндээ мөрдөгч нар Корпорацын баримт бичгүүд, санхүүгийн мэдээллийг хянан шалгаж, гэрчүүдтэй ярилцлага хийж эцэст нь эдгээр ажлын үр дүнд цуглуулсан баримтуудыг үндэслэн асуудлыг тодорхойлон шалтгаан нөхцөлыг тогтоожээ. Корпорацын хэмжээ том олон улсуудад олон тооны салбар группүүд байдаг нь хууль хяналтын байгууллага болон дотоод хяналтын мөрдлөгийг явуулахад төвөгтэй байдлыг учруулж байлаа. Жишээ дурдахад 2006 оны байдлаар Siemens корпорацын орлого 87 тэрбум евро байсан бол ойролцоогоор 475,000 ажилтантай 190 орчим оронд олон төрлийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг зэргээс дүгнэхэд ямар хэмжээний үндэстэн дамнасан корпорац болох нь харагдана. Siemens корпорацын зүгээс ХБНГУ болон АНУ-ын хууль хяналтын байгууллага ийм томоохон корпорацын олон төрлийн бизнесийн санхүүгийн гүйлгээ бүрийг шалгах нь боломжгүй зүйл байлаа. Дотоод хяналтын мөрдөн шалгах ажиллагаа

нь Siemens корпорацын авлигад өртөх өндөр эрсдэл бүхий дэд бүтцийн төслүүдийг нарийвчлан шалгажээ. Тодруулбал Siemens корпорацын хамгийн өндөр орлоготой 11 группээс Siemens корпорацын жилийн орлогын 60 хувийг бүрдүүлдэг Communications, Power Generations, Power Transmission and Distribution, Transportation Systems, Industrial Solutions and Services and Medical Solutions зэрэг группүүдийг нарийвчлан шалгасан. Хэдийгээр мөрдөн шалгах ажиллагааны хүрээг нарийвчлан тогтоох гэж оролдсон боловч энэ нь тухайн үедээ хамгийн том мөрдөн шалгах ажиллагаа байлаа. Дотоод мөрдөн шалгах ажиллагааны явцад хийсэн ажлын хүрээг тодорхойлбол;

Siemens корпорацын 1750 ажилтантай хийсэн ярилцлага, ажилтнуудын талаарх 800 орчим мэдээлэл цуглуулсан, хэрэгт хамааралтай 82 сая электрон баримтуудыг илрүүлсэн, 14 сая баримтыг цуглуулж шалгасан, 38 сая санхүүгийн баримтуудад дүгнэлт хийсэн, 10 сая банкны дансны хуулгыг шалгаад Debevoise&Plimpton LLP хуулийн фирм нь Siemens корпорацын сул талуудыг тодорхойлж үнэлгээ хийн хэрхэн сайжруулах талаар 850 мэдээлэл зөвлөмж, дүгнэлт² бэлджээ.

² Siemens Aktiengesellschaft Investigation and summary of findings with respect the proceedings in Munich and the US,



Дотоод хяналтын мөрдлөгийг шударгаар хуулийн дагуу явуулсан талаар

Siemens корпорац нь мөрдлөгийн ажиллагааг ХБНГУ болон бусад улсын хуулийн дагуу хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, гадаад тагнуулын үйл ажиллагаанд хамаарах нөхцөл байдал бий болгохгүй байх зохих арга хэмжээг онцгой анхаарч ажиллажээ. Өөр улс орнуудад ажилчидтай ярилцлага хийхдээ тухайн орны хэлний орчуулагч шаардлагатай тохиолдолд хууль зүйн зөвлөгөө авах боломжийг ажилчдад бүрэн олгож хуульд заасан эрхийг бүрэн хангах арга хэмжээг авчээ. Мөн баримт бичиг, мэдээ мэдээллийг авч тээвэрлэхдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түгжээтэй төмөр хайрцгийг ашиглаж баримт бичиг, мэдээлэл үрэгдэх, хуулбарлагдахаас сэргийлж чаджээ. Мөн ажилчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлж хэрэгтэй мэдээлэл олж авахын тулд сайн дураар өөрийн бурууг хүлээсэн тохиолдолд корпорацийн зүгээс тэдний буруутай үйлдэлтэй холбоотой ямар нэг иргэний нэхэмжлэл гаргахгүй байх, ажлаас халахгүй байх баталгааг гаргасан нь мөрдөн шалгах ажиллагаанд эерэг нөлөө үзүүлжээ. Үүний үр дүнд Siemens корпорацийн 171 ажилтан сайн дураар өөрсдийн бурууг хүлээн, хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл, нотлох баримтыг гаргаж өгч хамтран ажилласан.

Төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажилласан талаар

Siemens корпорацийн удирдлагууд болон Debevoise & Plimpton LLP хуулийн фирм дотоод хяналт шалгалтыг явуулж хамтран ажиллах талаар саналаа Мюнхен хотын прокурортой танилцуулан прокурорын байгууллагаас явуулж

буй мөрдөн шалгах ажиллагаатай зөрчилдөх нөхцөл үүсгэхгүй байх талаар зөвшилцөж зөвшөөрөл авсан байна. АНУ-ын хувьд хуулийн этгээд хууль сахиулах байгууллагатай зэрэгцэн бие даасан дотоод хяналт шалгалт явуулж мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллаж байсан туршлага байдаг боловч ХБНГУ-ын хувьд ийм туршлага өмнө нь байгаагүй юм. Энэхүү хамтын ажиллагааны эцэст Мюнхен хотын прокурорын газраас “Siemens корпорацийн дотоод хяналт шалгалтын үр дүнд гэм буруутайг баталгаажуулсан нотлох баримт олоход чухал дэмжлэг болсон гэж үнэлсэн байна.” Хамтарсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд дараах асуудлуудыг нэг мөр шийдвэрлэж чаджээ;

- ХБНГУ-д тус тусдаа шадлагдаж байсан Siemens корпорацийн бүх хэргүүдийг нэг мөр шийдвэрлэжээ.
- ХБНГУ болон АНУ-ын хуулийн эрх бүхий байгууллагатай хамтран ажилласнаар Siemens корпорац нэг гэмт хэрэгт давхар шийтгэгдэхээс сэргийлж чаджээ.
- Хамтын ажиллагааны үр дүнд авлигын хэргийг түргэн шуурхай шийдвэрлүүлжээ.
- Үр дүнтэй хамтран ажилласныг харгалзан үзэж АНУ-ын Хууль зүйн яамнаас хамгийн бага торгуул, шийтгэлийг санал болгожээ.

АНУ-ын Хууль зүйн яамны дүгнэлтээр Siemens корпорацид бизнесийн давуу байдал олж авахын тулд шаардлагатай үед авлигыг хүлээн зөвшөөрдөг байжээ. Жишээ нь тус Корпорацийн ажлын байранд шаардлагатай үед хэрэглэх их хэмжээний бэлэн мөнгийг тогтмол



хадгалдаг зарим тохиолдолд ажилчид нь сая, тэрбум еврог авлигын зориулалтаар авч байжээ. Түүнчлэн Siemens корпорац нь бизнесийн үйл ажиллагаа дэмжүүлэх зорилгоор бизнесийн зөвлөх компаниудаар дамжуулан гадаад улсын төрийн өндөр албан тушаалтнуудад олон удаа авлига өгч байсныг тогтоожээ. 1999 оноос өмнө ХБНГУ-ын хуулиар гадаад улсад хориглосон төлбөрийг зөвшөөрдөг бөгөөд татвар оногдуулдаггүй байжээ. ХБНГУ 1999 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн конвенцод нэгдэн орж соёрхон баталснаар гадаад улсын албаны хүмүүст төлж буй хууль бус төлбөр тооцоог эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх болжээ. Улмаар Нью Йоркийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй Siemens Корпорацийн салбарыг 2001 оны 3-р сарын 12-нд АНУ-ын Гадаад авлигын эсрэг хуулийг зөрчсөн гэж үзжээ.

Мюнхенийн прокурорын газрын үзсэнээр Siemens корпорац нь шаардлагатай тохиолдолд хэрэглэх тусгай сан (slush fund) үүсгэж зөвлөх компаниар дамжуулан хилийн чанадад авлигын гэмт хэрэг үйлддэг байжээ.

АНУ-ын Хууль зүйн яамнаас Siemens корпорацийг дараах авлигын хэрэгт буруутгажээ.

- 2001 оны сүүлээс эхлэн 2006 хүртэл Венесуэль улсын томоохон 2 хотод хэрэгжүүлэх төслийг авахын тулд хэд хэдэн зөвлөх компани буюу гуравдагч этгээдээр дамжуулан засгийн газрын өндөр албан тушаалтнуудад 18.7 сая ам долларын авлига болгон өгчээ.
- Мөн 2001-2006 онд тус корпорац нь Бангладешийн төрийн өмчит Bangladesh Telegraph and Telephone Board гэх үүрэн телефоны сүлжээг барьж

байгуулах төслийн тендэрийг хууль бусаар авах зорилгоор гуравдагч зөвлөх компаниар дамжуулан ойролцоогоор 5 сая гаран ам долларын авлигыг төрийн албан тушаалтнуудад олон удаагийн үйлдлээр өгсөн. Зарим тохиолдолд Кипр, Швейцар зэрэг улсаар дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэдэг байжээ.

- Мөн тус корпорац нь 1998 онд Аргентин улсад үйл ажиллагаа явуулж байхдаа Аргентин улсын Дотоод хэргийн яамны иргэний үнэмлэх шинэчлэх 1 тэрбум ам долларын төслийг авахын тулд 15 сая ам.долларын авлигыг Аргентин улсын засгийн газрын гишүүний хамаарал бүхий хуулийн этгээд шууд шилжүүлсэн гуравдагч этгээд болох зөвлөх компаниар дамжуулан 85 сая ам долларыг шал өөр төслийн нэрээр олон удаагийн үйлдлээр авлигал болгон шилжүүлсэн гэжээ³.

Тус Корпорацийн авлигын шинжтэй хууль бус төлбөр тооцоо нь санхүүгийн бүртгэлд тэмдэглэгддэггүй заримдаа зөвлөх компанийн төлбөр гэж бүртгэгддэг байжээ. Мюнхений шүүхийн тогтоосноор худалдааны дээд түвшиний менежерүүд хууль бус төлбөр тооцоо буюу авлигын системийг үүсгэж мөнгөний урсгалыг бий болгосон гэжээ. Хууль бус төлбөр тооцоо буюу авлигын шинжтэй төлбөрүүдийн талаарх баримтуудаас харахад маш өндөр дүнтэй гүйлгээнүүд тусгагджээ. Жишээ нь

- 66.6 сая ам долларыг АНУ-д үйл ажиллагаа явуулж байсан

³ Siemens Aktiengesellschaft Investigation and summary of findings with respect the proceedings in Munich and the US,



салбарын ажилтан бэлэн мөнгөөр авчээ.

- Ойролцоогоор 85 сая ам долларыг компаний менежер чекээр авч цааш нь сэжигтэй гүйлгээ хийсэн.
- 183 сая ам.долларыг бизнесийн зөвлөх үйлчилгээнд төлсөн гэх боловч энэ нь гадаад улсын төрийн өндөр албан тушаалтнуудад авлига болж очсон гэх мэтчилэн олон авлигын шинжтэй санхүүгийн баримтууд авагдсан бөгөөд 2001-2007 оны хооронд нийтдээ 1,360,000,000 ам.долларыг янз бүрийн хэлбэрээр авлигалд ашиглажээ.

Мюнхен болон АНУ-ын Хууль зүйн яамны буруутгаж буй баримт бичгүүдэд яагаад энэ хэрэг гарах болсон талаар дүгнэхдээ Siemens корпорац нь дараах арга хэмжээ аваагүй гэжээ. Үүнд;

- Авлигын эсрэг бодлогыг үйл ажиллагаандаа баримтлаагүй,
- Авлигын шинжтэй төлбөр тооцоог тохиромжтой хэлбэр шалгаж тогтоогоогүй,
- Ажилчдын дунд авлигын талаар ёс зүйн хэм хэмжээг тогтоогоогүй,
- Хууль дүрэм журам дагаж мөрдөх албыг үр дүнтэй байгуулж, ажиллуулаагүй,
- Дотоод хяналт шалгалтад гомдол мэдээлэл хүлээж авах систем бүрдээгүй гэж дүгнэжээ.

Мюнхений прокурорын газрын тогтоолд дурдсанаар дотоод хяналт шалгалт сул байсан мөн ажилчдад авлигын талаар үр дүнтэй сургалт явуулж байгаагүй. Түүнчлэн бизнесийн зөвлөх үйлчилгээ нэрийн дор маш олон сэжигтэй гүйлгээ хийгдсэний дараа Siemens

ямар нэг эрсдэлийн үнэлгээ, хууль зүйн дүгнэлтгүйгээр томоохон төслүүдэд ажиллах эрхийг авч байсан. Мөн ямар нэг баримтгүй бэлэн мөнгөний гүйлгээнд хяналт тавьдаггүй байжээ. Гуравдагч этгээдэд төлөх төлбөрийг 2 хүний гарын үсгээр зөвшөөрөгдөх атал нэг хүний зөвшөөрлөөр авдаг байсан. Өөрөөр хэлбэл эхлээд санхүүгийн ажилтан гарын үсэг зураад дараа нь худалдааны ажилтан гарын үсэг зурах ёстой байтал ихэнх сэжигтэй төлбөр тооцоо нь нэг хүний гарын үсгээр зөвшөөрөгдөж байсан нь Four eyes principle буюу санхүүгийн хяналтын зарчмыг алдагдуулжээ.

Мюнхений прокурорын газраас дүгнэхдээ Siemens корпорац нь дэлхийн хэмжээний том компани атлаа хууль, дүрэм журам сахиулах буюу Compliance бүтэц муу энэ талаар сайжруулах арга хэмжээ аваагүй. Дэлхийн олон улс дахь Siemens Корпорацийн салбаруудад авлигын хэрэгтэй холбоотой хууль сахиулах байгууллагын мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байхад дээд тушаалын удирдах ажилтнууд нь дотоод аудитын хороондоо мэдэгдэж зохих арга хэмжээг тэр дор нь авч анхааруулаагүй гэж дүгнэжээ. Эцсийн дүндээ Siemens корпорацийн удирдлагууд АНУ, ХБНГУ-ын хууль сахиулах байгууллагуудын хамтарсан мөрдөн шалгалтын дүнд 1.6 тэрбум ам.долларын торгууль төлөх ёстой байснаас, АНУ-д 800 сая ам.долларын торгууль төлж 1977 онд АНУ-д Гадаадын авлигын хууль баталснаас хойш хамгийн их хэмжээний торгууль ногдуулсан хэрэг болжээ⁴.

⁴ Siemens Aktiengesellschaft Investigation and summary of findings with respect the proceedings in Munich and the US,



Санал дүгнэлт

Siemens корпорацийн энэхүү хэрэг нь хуулийн этгээдүүд тодорхой Compliance хөтөлбөртэй болж чадсанаар хууль сахиулагчид хуулийн этгээдтэй хамтран ажиллаж мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгох боломжтой юм. Цаашид хуулийн этгээдийн Compliance алба эсхүл хяналтын дотоод шалгалтын хүрээнд цуглуулсан нотлох баримтыг хуулийн байгууллагууд хууль ёсны нотлох баримт болгон сонгон бэхжүүлж хэргийг нотлох ажиллагаанд ашиглах нь үр дүнтэй бйаж болох юм. Үүний тулд Corporate prosecution гэх ойлголтыг хуулийн этгээдийг мөрдөн шалгах ажиллагаанд хууль сахиулах байгууллагууд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Corporate prosecution-ний талаар АНУ-ын Хууль зүйн яамнаас зохих хууль эрх зүйн зохицуулалтыг гарган амжилттай хэрэгжүүлж байдаг тул энэ талаар цаашид судлах шаардлагатай гэж үзэж байна. Үндэстэн дамнасан корпорацийн авлигын хэргүүдийг амжилттай мөрдөн шалгаж чадсанаар улс орон бүрийн төрийн өндөр албан тушаалтнууд авлига авах ёсгүйг ойлгуулж зохих ял шийтгэлийг нь оногдуулж, шударга ёсыг тогтоох боломжтой.

НОМ ЗҮЙ

I. Гадаад эх сурвалж:

Siemens Aktiengesellschaft
Investigation and summary of findings with respect the proceedings in Munich and the US,

“We need more research on corporate corruption” by Armando Castro, Nelson Phillips

II. Бусад эх сурвалж:

https://promarket.org/2020/11/05/need-research-corporate-corruption-firms-entrepreneurship/?fbclid=IwAR2Mz-ZGrI3MqLTvbV_x2v1hSHei4gUmb5-Umpq_380ocqDGRbl-BKu3gFs

**Abstract****SIEMENS CORRUPTION CASE****TS.MUNKH-ERDENE***Researcher (LL.M.), Judge, Bayangol Criminal Court of First Instance*

There is higher chance of multinational organized economic crimes would be determined during the economic crisis caused by the pandemic. This article introduces how Multinational Corporation used illegal payment for high-level government officials in developing countries due to support businesses and international best practices of law enforcement investigation process.

Moreover, Siemens corporation board committee decided to chose Debevoise & Plimpton LLP to conduct internal independent investigation over accusation of US and Germany law enforcements in order to obtai acusation evidences for

law enforcements and the whole process controlled under Compliance Committee of Siemens. It is best cooperation practice between Siemens Corporation and US and Germany law enforcement on the Multinational Corporation investigation.

This article presents only endorsed information of the intenation best practice by the multijurisdictional law enforcements and it suggests certain ideas for criminal law system due to support business fair competition.

Keywords

Corruption, Siemens Corporation, prosecutor office, internal investigation, crime, law enforcement.

**МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛД
АНХААРАХ АСУУДАЛ**

**SIGNIFICANT ISSUES OF MONEY LAUNDERING AS ONE
OF THE CLASSIFICATIONS OF CRIME**

Бадамдоогийн ГАНБОЛД¹

- I. Оршил
- II. Сэдвийн судлагдсан байдлын тойм
- III. Үндсэн хэсэг
- IV. Дэд хэсэг
- V. Бодомж
- VI. Дүгнэлт
- VII. Санал зөвлөмж
- VIII. Ном зүй

¹ Монголын Хуульчдын болон Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛД АНХААРАХ АСУУДАЛ

Б.ГАНБОЛД. Монголын Хуульчдын болон Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч

Товчлол

Сонгон судалсан сэдэв “хууль зүйн зохицуулалт, амьдрал практик, шинжлэх ухааны онол зүйн хувьдаа ч агуулга нь өргөн хүрээний, олон талт шалтгаан, нөхцөлтэй судалгааны ажил” ажээ.

Тухайлбал:

- гэмт явдал судлалын хүрээнд мөнгө угаах үзэгдлийг 1994 оны АНУ-ын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Ерөнхийлөгчийн комиссоос гаргасан хувилбар ёсоор “орлогын хууль бус эх сурвалжийг нууж, дараа нь хууль ёсны мэт болгон хувиргах” гэж тодорхойлж голдуу иш татсан байдаг.¹
- тив дэлхийн хэмжээнд НҮБ-ийн Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг /Палермогийн 2000 оны/ конвенцын 6 дугаар зүйл, Авилгалын эсрэг /2003 оны/ конвенцын 23 дугаар зүйлд заасан “гэмт хэргээс олсон орлогыг угаах” гэсэн агуулгаар “мөнгө угаах” гэмт хэргийг томъёолон үзэж тодорхойлсон нь бий.

- Азийн сан, Үндэсний авлигын индексийн судалгаа, Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо /ФАТФ/-ны тайлан зэрэгт дурдсанаар бол, манай улсад “авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх, хүний болон ан амьтдын наймаа, оффшор данс, хууль бус үнэт цаас, хар тамхи, валютын арилжаа, бэлэн мөнгө эдийн засагт зонхилж буй байдал, хил хязгаар нь мөнгө тээвэрлэгчдэд илт боломж олгож байгаа зэрэг” ноцтой эрсдэлийг үүсгэж байгаа талаар дүгнэжээ.

Учир иймд өгүүлэгч явцуу утгаар “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал” хэмээх сэдвийг ончлон сонгож, энэхүү гэмт хэргийн зүйлчлэлийн хууль зүйн үндэс буюу эрүүгийн хуулийн хэрэглээ ба томъёололд “хууль зүйн задлан шинжилгээ” хийж, улмаар зарим нэг санааг дүгнэн гаргахыг зорилоо.

Судлаачийн зүгээс цаг хугацаа хэмнэх, өгүүллийн гол санааг шууд илэрхийлэх, өдөөлт үүсгэх, үйлчлэн хэрэгжиж буй шинэчлэн найруулсан эрүүгийн хуультай, Олон улсын гэрээ, конвенцыг уялдуулах, тэдгээрийн хэрэглээг хангах, шинжлэх ухааны эргэлтэд оруулах, хууль зүйн практикт ашиглах үүднээс “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах

¹ Монгол Улсын дээд шүүх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010., 429 дэх тал.



асуудал” сэдэвт энэхүү өгүүллийг бичсэн болохыг та бүхэн гэгээнээр тольдоно буй за.

Түлхүүр үг. Энэхүү өгүүлэлдээ “мөнгө угаах”, “гэмт хэрэг зүйлчлэл”, “суурь гэмт хэрэг”, “гэмт хэргээс олсон орлогыг угаах” гэсэн нэр томъёонуудыг ашиглав.

Мөнгө угаах /money laundering/. XX зууны 20-оод оны эхэн үед АНУ-ын цуутай дээрэмчдийн толгойлогч Алфонс **Капоне** /1899-1947/ мөрийтэй тоглоом, архины хууль бус наймаа, янхны газрын үйл ажиллагаа зэргээс олсон бохир мөнгөний орлогоо нуун далдлахын тулд уг мөнгөөрөө угаалгын газар нээн ажиллуулж байсан энэ үеэс эхэлж “мөнгө угаах” гэдэг нэр томъёо албан ёсоор хэрэглэгдэх болсон гэдэг.²

Энэхүү Чикагогийн мафийн толгойлогч хууль бус үйлдлээр олсон орлогоо угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг L'expresssee сонинд хувцас биш мөнгө угааж байна гэж бичсэнээр анх гарч ирсэн боловч 1973-1974 оны Watergate-ийн дуулианы үеэр энэ нэр дахин сөхөгдөж дэлхий нийтэд танигдсан билээ.

Гэмт хэрэг зүйлчлэл /qualification of crimes/. Онол зүйн хувьд “эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг эрүүгийн хуулийн ямар хэм хэмжээнд заагдсан гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоох ажиллагааг” гэмт хэрэг зүйлчлэл хэмээн ойлгодог.³

Гэмт хэрэг зүйлчлэлийн асуудлыг онолын үндэслэлтэй байдлаар үл ойлговоос эрүүгийн хуулийг буруу

хэрэглэх, өөрийн үзэмж аятай хандах зэрэг сөрөг байдлыг бий болгох аюултай агаад эрүүгийн хуулийн төсөөтэй хэрэглэхийг хориглодог учир илүү нарийвчлан авч үздэг болно.

Суурь гэмт хэрэг /designated categories of crimes/. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд зайлшгүй гарч ирэх нэг ойлголт нь энэ бөгөөд энэ ойлголтын талаар Олон улсын гэрээ, конвенцод авч үзсэн байдаг нь бидэнд ч нэгэн адил хамаарна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003.10.31-ний өдрийн 58/4 дугаартай тогтоолоор баталсан Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцын 2 дугаар зүйлд “суурь гэмт хэрэг” гэж “энэхүү конвенцын 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн зүйл болж болох орлогыг бий болгосон гэмт хэргийг хэлнэ” гэж тодорхойлсон байна.⁴

Гэмт хэргээс олсон орлогыг угаах. Авилгалын эсрэг уг конвенцын 23 дугаар зүйлд энэ талаар ийнхүү заажээ, үүнд:

i/ тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний хууль бус гарлыг нуун далдлах буюу өөрчлөн хувиргах, эсхүл суурь гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд үйлдсэн хэргийнхээ хууль зүйн үр дагавраас зайлсхийхэд туслах зорилгоор уг эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх,

ii/ тухайн эд хөрөнгө нь гэмт хэргээс олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулалт, хөдөлгөөн, өмчлөл түүн дэх эрхийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах” гэжээ.⁵

² Europäische Anwaltsvereinigung. Bekämpfung der Geldwaesche 2002., s-111 /Европын өмгөөлөгчдийн холбоо. Мөнгө угаахтай тэмцэх нь. 2002., 111 дэх тал/.

³ Б.Ганболд. Гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2005., 54-55 дахь тал.

⁴ Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцыг батлах тухай Монгол Улсын хууль /2005.10.27/.

⁵ Уг конвенцод манай улс Зөвлөмжийн 36-р заалтын хүрээнд нэгдэн орсон. FATF www.fatf-gafi.org.



I. Оршил

Энэ өгүүллийн үндсэн сэдэв болох мөнгө угаах гэх гэмт хэргийн зүйлчлэлийн талаар оршихын өмнө “мөнгө угаах” гэмт хэргийн талаар гол ойлголт өгөх үүднээс энэ гэмт хэргийн олон улсын стандарт гэж нэрлэгддэг НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцын заалтыг танилцуулга болголоо. Үүнд “мөнгө угаах” үйлдлийг дараах байдлаар тодорхойлжээ:

- тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;
- тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;
- тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;
- мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөх гэж тодорхойлсон байдаг.

II. Сэдвийн судлагдсан байдлын тойм

Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн

асуудал нь манай улсын хувьд тусгайлан судлагдаагүй байна. Харин мөнгө угаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжийн талаар эрүүгийн эрх зүйн чиглэлийн ном, сурах бичигт авч үзсэн явдал байх ба зарим нэг судлаач, эрдэмтэд өгүүлэл бичсэн зэрэг мэр сэр тохиолдлууд байна.

Жишээ нь: “мөнгө угаах гэмт хэргийн хор аюул нь улс орны хараат бус, тогтвортой оршин тогтнох үндсийг үгүй хийж, эдийн засгийн аюулгүй байдал, чөлөөт зах зээлийн зөв хөгжих боломжийг хааж улмаар нийгмийн эрүүл тогтолцоо буюу хууль эрх зүйн цэвэр орчинг бохирдуулж тухайн улс оронд хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодис, зэвсгийн худалдаа, авлига хээл хахууль цэцэглэн хөгжих нөхцөлийг бүрдүүлж байдаг оршино. Уг гэмт хэргийн шууд бус хохирогч нь жирийн шударга татвар төлөгч, зохион байгуулалттай гэмт хэргийн золиос болгогчид юм” гэжээ.⁶

Хууль зүйн их, дээд сургуулиудад мөнгө угаах асуудлыг судлан үзэж хууль зүйн ухааны магистрын зэрэг горилсон дипломны ажил бичигдсэнээс өөрөөр шинжлэх ухааны эргэлтэд орсон нэг сэдэвт бүтээл, докторын зэрэг хамгаалсан судлаач хүн одоогоор /манай улсад/ байхгүй байна.

III. Үндсэн хэсэг

Судлагдаж байгаа сэдвийн хувьд “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал”-ын гол цөм хэсэг нь одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл буюу түүний үндсэн томъёолол нь юм.

Иймд дараах хууль зүйн зохицуулалт буюу эрүүгийн хуулийн эх бичвэрээр уг гэмт хэргийг хэрхэн томъёолж ирсэн

⁶ Б.Өнөрмаа. Монголд мөнгө угаасаар л байх уу? Шударга ёс., 2010., №2/3/, 45-48 дахь тал.



түүхийг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

2002 оны Эрүүгийн хуулийн **163** дугаар зүйл. Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах. Илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан бол.⁷

2002 оны Эрүүгийн хуулийн **268**¹ дүгээр зүйл. **Мөнгө угаах.** Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулсан бол.⁸

2002 оны Эрүүгийн хуулийн **166**¹ дүгээр /нэмэлт/ зүйл. **Мөнгө угаах.** Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол.⁹

2015/17 оны Эрүүгийн хуулийн **18.6** дугаар зүйл. **Мөнгө угаах.** Гэмт хэргийн

улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол.¹⁰

“Мөнгө угаах” гэмт хэргийн талаарх **Хууль зүй, дотоод хэргийн яам, ажлын хэсгийн байр суурь** /хуулийн төслийн үндсэн концепц/.

- 2002 оны Эрүүгийн хуулийн **155** дугаар зүйлд заасан “гэмт хэрэг үйлдэж олсон **эд хөрөнгийг авах, борлуулах**” гэмт хэргийг “**өмчлөх эрхийн эсрэг**” гэмт хэрэгт хамааруулж байсныг нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар Эдийн засгийн гэмт хэргийн бүлгийн 18.6 дугаар зүйлд заасан “мөнгө угаах” гэмт хэрэгт хамаарах үйлдлүүд гэж үзсэн.
- НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000.11.15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцод заасан агуулгаар гэмт хэргийн шинжийг нь тодорхойлсон” аж.¹¹

Дээрх байдлаас үзэхэд “мөнгө угаах” гэмт хэргийн эрүүгийн эрх /хууль/ зүйн зохицуулалт олон дахин өөрчлөгдөж иржээ. Ер нь бол “аливаа хуулийг эрэмдэг

⁷ Анх удаагийн хууль зүйн зохицуулалт бөгөөд энэ зүйлийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008.02.01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

⁸ Энэ зүйлийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2008.02.01-ний өдрийн хуулиар нэмсэн /1 дүгээр зүйлийн 12 дахь заалт/. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=102787&showType=1>.

⁹ Энэ зүйлийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2009.12.24-ний өдрийн хуулиар /1 дүгээр зүйл/ нэмж, Эрүүгийн хуулийн 268¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсон /2 дугаар зүйл/. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=102789&showType=1>.

¹⁰ Энэ зүйлд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2017.05.11/ хуулиар өөрчлөлт орсон.

¹¹ ХЗДХЯ. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2017., 175 дахь тал.



ээрэмдэг болгохыг зорьж муутгая” гэвэл түүнийг зогсоо зайгүй сайжруулах нэрийн дор олон удаа нэмэлт, өөрчлөлт хийх хэрэгтэй гэдгийг ч мартаж учиргүй.

Үүнийг “ОХУ-ын эрүүгийн хуульд 1500 орчим нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд ихэнх нь шинжлэх ухааны ямар нэгэн үндэслэл байхгүй” гэсэн нь¹² яг батлаад байх шиг тул эрүүгийн хуульд хамаагүй гар дүрээд байх нь зохимжгүй гэлтэй.

IV. Дэд хэсэг

Харьцуулалт, өнөөгийн практик, хууль зүйн ялгаварлал, бодит кейс, бодомжийг дэд сэдэв болгон авч үзэв. Үүнд:

Харьцуулалт. Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /2013.05.31/ хуулийн 3 дугаар зүйлд зааснаар, “**мөнгө угаах**” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг” хэлнэ.

ОХУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх /1999 оны/ тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “нийгэмд аюултай хууль бус ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгө болон бусад эд хөрөнгийг хууль ёсны мэт болгон харагдуулах, түүнийг эзэмших, ашиглах, эргэлтэд оруулах явдал” хэмээн тодорхойлжээ.

¹² Репецкая А.Л. ОХУ-ын эрүүгийн эрх зүйн орчин үеийн хөгжилд криминологийн судалгааны гүйцэтгэх үүрэг. Монголын төр, эрх зүй. УБ., 2011., №4/66/., 9 дэх тал.

Муу үр дагавартай хуулийг муугаар нь байлгавал түүнээс муу үр дагавар үүсгэх учир онол ба практикийн олон талт хандлагаар нь авч үзэх нь зүйтэй.

Өнөөгийн практик. Д.Х нь ... баарны ариун цэврийн өрөөнд иргэн А-гийн гэсэн гар утсыг олж, улмаар өөрийн төрсөн дүүдээ “гар утас олсон талаараа хэлэхэд” уг гар утсыг дүү нь ирж авч яваад, улмаар өөр хүнд зарчихсан байна.

Шүүх дүүг нь Эрүүгийн хуулийн **18.6** дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар буюу “гээгдэл эд зүйл олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, шилжүүлэн **мөнгө угаах** гэмт хэргийг үйлдсэн” гэж, харин өөрийг нь Эрүүгийн хуулийн **17.5** дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар буюу “гээгдэл эд хөрөнгө завших гэмт хэрэг” үйлдсэн хэмээн гэм буруутайд тооцжээ.¹³

Энэ мэт байдлаар маш олон хэргүүд, ялангуяа мөнгө угаах үйлдэл дангаараа бус, бусад хэргийн дагалдах сүрэн дор шүүхээр шийдвэрлэгдсэн болох нь шүүхийн цахим санд байгаа шийтгэх тогтоол, магадлал зэргээс тод ажиглагдана.¹⁴

Хууль зүйн ялгаварлал. Шүүн таслах ажиллагааны бодит практикийг судлан үзэхэд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, нотлох, зүйлчлэх ажиллагаанд үл анзаарагдах хэдий боловч гүн гүнзгий хууль зүйн адил биш хэрэглээ ба зүйлчлэл /ноёрхол/ явагдаж байна.

“Хүн нь байвал зүйл анги нь олдож л таарна” гэж **Сталины** хэлсэнчлэн буруу ишилсэн сүх шиг байх, нөгөө талдаа хэн нэгний дур зорго, мэдлэг боловсрол дутуу байдлаас хамаарч хууль завхрах ёсгүй юм.

¹³ Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх. Шийтгэх тогтоол. УБ., №604., 2018.07.20.

¹⁴ Үзнэ үү. Эх сурвалж. <http://new.shuukh.mn/>.



Бодит кейс. УИХ-ын гишүүн “С” өөрийн хамаарал бүхий компанид Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 950 сая төгрөгийн зээлийг нэр хүнд, эрх мэдлээ урвуулан ашиглах замаар эдийн засгийн давуу байдлыг бий болгож буюу нөлөөлж авч өгсөн учир түүнийг гэм буруутайд тооцож, шүүх 3 жил хорих ял оноожээ.

Энэ мөнгөнөөс түүний эхнэр “А” нь 850 сая төгрөгийг нь Худалдаа хөгжлийн гэх банканд “хадгаламжийн данс” нээлгэн, гэрээ хийж, улмаар 7.880.547.95 төгрөгний **хүү** бодогдсон нь тогтоогджээ.

Гэтэл мөрдөн байцаалтын шатанд энэ үйлдлийг мөнгө угаах гэмт хэргийн шинж байгаа эсэх талаар нь огт шалгаагүй, анхан шатны шүүх хохиролгүй гэж дүгнэсэн, харин давж заалдах шатны шүүх “гэмт хэргийн улмаас олсон орлого” хэмээн үзэж улсын орлого болгохоор шийдвэрлэх төдийгөөр өнгөрч байгааг яалтай.¹⁵

V. Бодомж

Хүн өөрийнхөө өмчийг хамгаалах үүрэгтэй. Гэтэл ийм үүрэггүй этгээд гэмт хэрэгтэн боддог тохиолдлыг юу гэх вэ?. Өмнөх гар утасны хэрэг дээр гэхэд л шүүх “хоширогчийн буруутай буюу эд хөрөнгөндөө хайхрамжгүй хандсан байдал нь энэ гэмт хэрэг гарахад нөлөөлсөн” гэж дүгнэсэн байдаг. Гэвч хууль зүйн хувьд олж авсан хүний “шууд буруу” болж байгаа юм. Практикт андуурсан илгээмж, банкны гүйлгээ гэхэд шуудан хүргэгч, банкны теллерийн хариуцлагагүй ажиллагаа байхад бас л “өөр бусдын буруу” л болж хувирдаг. Ийнхүү дам дамаа бусдыг буруутгах нь ял халдаан хэрэглэх явдал гэж харагдахаар атал бүр эсрэгээрээ мөнгө угаасан гэх үр дагаврыг үүсгэж эрүүгийн гэмт хэрэг гэж

¹⁵ Улсын дээд шүүхийн тогтоол. 2020.12.18., №685., Г.С-д холбогдох эрүүгийн хэргийн тухай.

үзэх нь хэр зохистойг бодох учиртай.

VI. Дүгнэлт

Миний бие “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлд анхаарах асуудал” гэсэн өгүүллийнхээ хүрээнд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Нэгдмэл нэг ойлголтод бид огт хүрээгүй байна. Ойлголтын зөрүүг арилгах явдал нь хуулийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөнгө угаах гэдгийг жирийн иргэдээс асуугаад үз л дээ. Тэрч бүү хэл хуульч хүн бүхэн ч бас мэдэхгүй асуудал.

Тагнуулын ерөнхий газрын сайтад ... “ХХ зууны эхэнд АНУ-ын Сан Франциско хотын нэгэн зочид буудлын эзэн халтар мөнгө үйлчлүүлэгчдийн ганган бээлийг бохирдуулж байгааг анзааран угаасан мөнгөөр үйлчилж эхэлснээр “мөнгө угаах” гэдэг үг хэллэг анх үүссэн байдаг” гэжээ.¹⁶

Гэхдээ одоо бид энд дээрхийн адил халтар болсон мөнгийг вок савангаар угааж цэвэрлэх зүйл яриагүй, мөнгийг ингэж угаадаг угаалгын газар байдгийг ч би мэдэх юм алга байна. Харин эрүүгийн эрх зүйн үр дагаварт ялын харилцаанд бохир буюу хар мөнгийг хэрхэн угаахыг яаж эрүүжүүлэх тухай л асуудлыг хөндөж буй юм.

Угтаа “мөнгө угаах нь олон үе шат бүх дамжлагатай, бохир мөнгөний хэмжээ нь их үнийн дүнтэй, гол төлөв үндэстэн дамнасан буюу “зохион байгуулалттай” гэмт хэргийн ертөнцийнхөн байх нь элбэг, төөрөгдүүлэхэд чиглэсэн, ойлгоход төвөгтэй, илрүүлэхэд маш хүнд, бэрхшээлтэй, нууц далд аргатай, тохиолдлын буюу ахуйн хүрээний шинжтэй гэмт хэрэг биш юм” гэдгийг

¹⁶ Мөнгө угаах гэмт хэрэгт тооцогддог түгээмэл 30 хэлбэр. <https://gia.gov.mn/49/item/611>.



ойлгох шаардлагатай байна.

2. Эрх зүйн зөв, тогтвортой орчин бүрэн хангагдаагүй байна.

Ойлголтынхоо зөрүүг арилгалаа гэхэд хууль - эрх зүйн орчин нь өөрчлөгдөхгүй бол үр нөлөөгүй учир бүх гэмт хэргийн орлогыг мөнгө угаасан гэмт хэрэг гэж зүйлчлэхэд хүрчээ.

VII. Санал зөвлөмж

Дээрх ерөнхий дүгнэлтийнхээ хүрээнд дараах 3 саналыг судлаачийн хувьд /энэхүү сэдэвт хамааруулан үзэж/ дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Мөнгө угаах гэмт хэргийн гэм буруугийн хэлбэр ба зорилгыг маш тодорхой заах, ингэхдээ “бохир мөнгө гэдгийг мэдсэн байх, түүнийг цэвэршүүлж хууль ёсны болгох үүднээс” гэдэг агуулгыг заавал “диспозицид” тусгах.

Энэ нь “хууль бус эх үүсвэрээс олж авсан бохир буюу хар мөнгийг юуны өмнө өрөөл бусдын нэрээр хадгаламж нээлгэх, чек авах, алт үнэт зүйлс хадгалуулах нэрийдлээр зохих арга хэрэглэж байршуулна, хууль ёсны бизнест хөрөнгө болгож оруулна, **дараа нь** анхны эх сурвалж бүдгэрч замхартал дахин эргэлдүүлж ул мөрийг арилгана /жишээ нь: худалдан авсан газраа зарах, түрээслүүлэх, банкнаас хүү авах гэх мэт/ ингэснээр эдийн засгийн /банк, санхүү, үйлдвэрлэл, хөрөнгийн арилжааны зэрэг/ хэлбэрт шилжиж цоо шинэ эх үүсвэртэй болж хууль ёсны болно” гэх утга нь мөнгө угаах гэмт хэрэг учир тэр.¹⁷

Тухайлбал: санамсаргүй олсон гар утсаа найздаа хэрэглүүлсэн нь мөнгө угаах биш, харин хар тамхи зарж олсон мөнгөө найзынхаа картанд шилжүүлж хувиргах үйлдэл нь мөнгө угаах гэмт хэрэгт тооцогдоно.

¹⁷ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012., 722 дахь тал.

Хоёр. Гэмт хэргийн улмаас олсон ямар орлого, мөнгө, эд хөрөнгийг мөнгө угаах гэмт хэрэгт хамааруулахыг “нарийвчилан” томъёолох, ингэхдээ эрүүгийн хуулийн зохих зүйлийн дор “хуульчилсан” тайлбарын хэлбэрээр оруулах.

Ингэх нь **жишээлбэл:** жижиг дунд үйлдвэрлэлийн сангаас “хууль бусаар авсан” зээлийн мөнгөө банкинд хадгалуулж, хүү авч байгаа нь мөнгө угаах болох эсэхийг нэг мөр ойлгож, зөв зүйлчлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Гурав. Мөнгө угаах гэмт хэргийн “суурь гэмт хэргийг тодорхой нэрлэн заах” нь зохистой, ингэхдээ “бүх гэмт хэргийн жагсаалтыг хийх бус харин Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуулиар жагсаалтыг батлах нь” оновчтой.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны “Авилгалын эсрэг НҮБ-ийн конвенцын 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “оролцогч улс суурь гэмт хэргийг аль болох өргөн хүрээнд хэрэглэхийг эрмэлзэнэ, суурь гэмт хэрэгт наад зах нь энэхүү конвенцын дагуу тогтоосон бүх эрүүгийн гэмт хэргийг оруулсан байна” гэж заасныг манай улс хэт хавтгайруулж, бүх гэмт хэргийг суурь гэмт хэрэг гэж үзсэн явдал нь “эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх” зарчмыг зөрчөөд зогсохгүй мөнгө угаах гэмт хэргийн утгыг алдагдуулж, хүний эрхийг ноцтойгоор зөрчиж, хууль зүйн системд гажуудал хийгээд хийдэл үүсгэж байгааг анхаарах цаг нэгэнтээ болжээ.

Иймд цаашид өнөөдрийн эрүүгийн хуулийн хууль зүйн зохицуулалтыг нэн даруй өөрчлөх, практикт гарч буй “мөнгө угаасан” гэх зохиомол хэргүүдийг хэлмэгдүүлэн зүйлчлэх явдлаа таслан зогсоохыг зөвлөмжилж байна.



НОМ ЗҮЙ:

I. Монгол эх сурвалж:

- Б.Ганболд. Гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2005.
- Шударга ёс., 2010., №2/3/.
- Монголын төр, эрх зүй. УБ., 2011.
- Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012.
- ХЗДХЯ. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. Сургагч багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2017.

II. Гадаад эх сурвалж:

Europäische Anwaltsvereinigung.
Bekaempfung der Geldwaesche 2002.

III. Эрх зүйн эх сурвалж:

- ОХУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль. 1999.
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц. 2000.

- Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002 /2008, 2009/, 2015/17.
- Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц. 2003.
- Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцыг батлах тухай Монгол Улсын хууль. 2005.
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. 2013.
- Шийтгэх тогтоол. УБ., №604., 2018.07.20.
- Улсын дээд шүүхийн тогтоол. УБ., №685., 2020.12.18.
- Монгол Улсын Дээд шүүх. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2010.

IV. Бусад эх сурвалж:

- www.fatf-gafi.org.
- <https://legalinfo.mn>.
- <http://new.shuukh.mn>.
- <https://gia.gov.mn>.



Abstract

SIGNIFICANT ISSUES OF MONEY LAUNDERING AS ONE OF THE CLASSIFICATIONS OF CRIME

B.GANBOLD

*Lawyer, Mongolian Bar Association, Advocate,
Association of Mongolian Advocates*

Due to its sever consequences to human beings in the world, institutional and legal solutions are devised to avert money laundering. There are many national, regional and international laws, which are designed to fight money laundering.

The research is based on the premises that human beings have an inherent right to be free from money laundering and setting the fight against money laundering within a human rights discourse be elevating money laundering-free service.

- In the field of criminology, money laundering is often referred to as "concealing an illegal source of income and then making it legal" according to The President's Commission on Organized Crime in 1994.
- Throughout the world, "Laundering of proceeds of crime" is to be defined by according to article 6 of The United Nations Convention against Transnational Organized Crime, article 23 of The United Nations Convention against Corruption.
- In Mongolia, according to the report of Asian Foundation, Study of Corruption perceptions index, and report of international co-

operation in the fight against financial crimes are mentioned that "Corruption, bribe, to avoid a tax, human and animal trafficking, offshore account, illegal bond, drug, exchange of value, the dominance of cash in the economy, as borders provide a clear opportunity for money smuggle so on, which are providing serious risk.

The objective of the research is to show the apparent lack of concern for victims of money laundering by analyzing the measures adopted by the international conventions and instruments.

Keywords

Money laundering, designated categories of crimes, laundering of proceeds of crime.

Money laundering. Laws against money laundering were created to use against organized crime during the period of United States during the 1920s. Organized crime received a major boost from Prohibition and a large source of new funds that were obtained from illegal sales of alcohol.

The successful prosecution of **Al Capone** on tax evasion brought in a new emphasis by the state and law enforcement



agencies to track and confiscate money, but existing laws against tax evasion could not be used once gangsters started paying their taxes.

Designated categories of crimes.

United Nations Convention Against Corruption /Adopted by the General Assembly, by its resolution 58/4 of 31 October 2003/. Article 2. "Predicate offence" shall mean any offence as a result of which proceeds have been generated that may become the subject of an offence as defined in article 23 of this Convention.

Laundering of proceeds of crime.

Each State Party shall adopt, in accordance with fundamental principles of its domestic law, such legislative and other measures as may be necessary to establish as criminal offences, when committed intentionally:

- (i) The conversion or transfer of property, knowing that such property is the proceeds of crime, for the purpose of concealing or disguising the illicit origin of the property or of helping any person who is involved in the commission of the predicate offence to evade the legal consequences of his or her action;
- (ii) The concealment or disguise of the true nature, source, location, disposition, movement or ownership of or rights with respect to property, knowing that such property is the proceeds of crime / United Nations Convention Against Corruption. Article 23/.

**ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН
НЭГДМЭЛ БАЙДАЛ ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР**

**UNITY OF JUDICIAL PRACTICE IN THE RUSSIAN
FEDERATION ON THE EXAMPLE OF THE CIVIL CODE
OF THE RUSSIAN FEDERATION**

Советханы ЖАНСАЯ¹

- I. Оршил
- II. Үндсэн хэсэг
- III. Санал
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач, Москвагийн (ОХУ) Улсын Удирдлагын Их Сургуулийн магистр



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН НЭГДМЭЛ БАЙДАЛ ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР

С.ЖАНСАЯ. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач Москвагийн (ОХУ) Улсын Удирдлагын Их Сургуулийн магистр

Товчлол

Тус эрдэм шинжилгээний өгүүлэлд Оросын Холбооны Улсын шүүхийн практикийн нэгдмэл байдлын талаар болон иргэний хуулийн тодорхой нэгэн заалтыг тодорхойлон, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, шийдвэрлэх арга замуудыг илэрхийлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: Оросын Холбооны Улс, Иргэний хууль, гэрээний тайлбар, шүүхийн практик, нэгдмэл байдал

I. Оршил

Шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хангах нь эрх зүйн тогтолцоонд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг ОХУ-ын Үндсэн хуульд хамаарна. ОХУ-ын Үндсэн хуульд хууль тогтоомжийг хэрэглэх нэгдмэл байдал, ОХУ-ын Дээд шүүхийн шүүхийн практикийг тайлбарласан тодруулга өгөх эрхийн талаар заасан байдаг. Тус зохицуулалтад "ОХУ-ын нутаг дэвсгэрт хуулийн хэм хэмжээг нэгэн адил тайлбарлаж хэрэглэх ёстой гэсэн зарчим агуулагдаж байдгийг анзаарч болно" гэж бодож байна. Дээрх Улсын Дээд шүүхийн эрх мэдэл нь ОХУ-ын Үндсэн хуулийн 126-р заалтаар¹ болон

¹ Конституция Российской Федерации от 12 декабря 1993 года // 1993 оны 12-р сарын 12-ны өдрийн ОХУ-ын Үндсэн хууль [Сүүлд үзсэн: 2021.03.17].

"ОХУ-ын Дээд шүүхийн тухай" хуулиар зохицуулагддаг. "ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай" хуулийн 3-р зүйлд шүүхийн тогтолцооны нэгдмэл байдлын талаар зохицуулагдсан байдаг² ба "ОХУ-ын Дээд шүүхийн тухай" хуулийн 7-р зүйлд зааснаар хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрүүдийг хяналтын журмаар хянан шалгадаг хяналтын дээд байгууллагаар ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг тогтоосон байна.³ Тус зохицуулалтыг шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хангаж буй явдал хэмээн ойлгож болно. Материаллаг эсвэл процессын хууль зөрчсөн аливаа нэгэн зөрчил нь шүүхийн практикийн нэгдмэл байдалд шууд халдаж байдаг. Шүүх хуулийг буруу хэрэглэсэн нь хууль дээдлэх ёсыг зөрчихөд хүргэж, улмаар шүүхийн практикийн нэгдмэл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй тул шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэл болдог. Үүнийг үндэслэн Оросын Холбооны Улсын иргэний хуулийн тодорхой нэгэн заалтыг янз бүрийн түвшний шүүхүүд өөрөөр

² Федеральный конституционный закон от 31 декабря 1996 г. № 1-ФКЗ "О судебной системе Российской Федерации" // 1996 оны 12-р сарын 31-ний өдрийн № 1 "ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай хууль".

³ Федеральный конституционный закон от 5 февраля 2014 г. № 3-ФКЗ "О Верховном Суде Российской Федерации" // 2014 оны 2-р сарын 5-ны № 3 "ОХУ-ын Дээд шүүхийн тухай хууль" [Сүүлд үзсэн: 2021.03.17].



тайлбарласан маргааны тухай өгүүлэл бичих болов.

II. Үндсэн

ОХУ-ын Иргэний хуулийн 431 буюу “Гэрээний тайлбар” гэсэн заалтад шүүх гэрээний нөхцөлийг тайлбарлахдаа түүнд агуулагдах үг, хэллэгийн шууд утгыг харгалзан үзнэ. Гэрээний нөхцөлийн шууд утга нь ойлгомжгүй байгаа тохиолдолд гэрээний бусад нөхцөлүүд болон гэрээний утгыг бүхэлд нь харьцуулан гэрээний нөхцөлийг тогтооно.

Энэ зүйлийн 1-р хэсэгт заасны дагуу гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй тохиолдолд гэрээний зорилгыг харгалзан талуудын нийтлэг хүсэл зоригийг тодруулах шаардлагатай. Энэ тохиолдолд “гэрээ байгуулахаас өмнөх хэлэлцээр, захидал, практик, талуудын харилцан тогтоосон гэрээний нөхцөлүүд, ёс заншил, талуудын дараагийн зан байдал зэрэг холбогдох бүх нөхцөл байдлыг харгалзан үзнэ” хэмээн заасан байна.

ОХУ-ын Иргэний хуулийн 431-р зүйл заалт нь олон сул талтай. Ялангуяа гэрээний нөхцөлийг тайлбарлахад эргэцүүлэн бодох, сэтгэх чадвар, өөрийн гэсэн бодол (аргумент) их чухал. Үүний зэрэгцээ гэрээний нөхцөл нь хэд хэдэн өгүүлбэр, зүйл заалтуудад агуулагдаж болох тул нөхцөл байдлын “хязгаарыг” харах нь маш чухал юм. Маргаан үүсгэж болзошгүй нөхцөл байдал яг юу болохыг ойлгох нь гэрээг буруу тайлбарлахаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

ОХУ-ын Иргэний хуулийн 431-ийн 2-д дурдсан бусад холбогдох нөхцөл байдал нь гэрээнд нэмэлт тайлбар гаргахад болон тодорхой бус бичвэрийг (текстийг) тайлбарлахад, мөн бичвэр (текст) үнэхээр ойлгомжгүй эсэхийг

үнэлэхэд чухал ач холбогдолтой.⁴

ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 363 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд шийдвэрийг өөрчилнө эсвэл хүчингүй болгоно” гэж заасан байна. Буруу тайлбарын тухай ойлголт нь ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 364-р зүйлд зааснаар процессын хэм хэмжээнд ч гэсэн хамаардаг бөгөөд тус заалтын дагуу шүүх хэргийг буруу шийдвэрлэхэд хүргэж болзошгүй тохиолдолд л шийдвэрээ хүчингүй болгож болдог” хэмээн заасан байна.⁵

ОХУ-ын Иргэний хуулийн 431-р заалтын 1-д заасан бусад нөхцөл байдал нь “маргаантай нөхцөл байдал юунаас тогтсон байна? түүний агуулга үнэхээр тодорхойгүй байна уу?” гэсэн асуултад, харин ОХУ-ын Иргэний хуулийн 431-р зүйл заалтын 2-д заасан бусад нөхцөл байдал нь “талууд гэрээний утгыг өөрөөр ойлгосон тохиолдолд, талуудын гэрээг байгуулахад нийтлэг хүсэл, зорилго юу байсан вэ? гэсэн асуултад хариулт олсны үндсэн дээр шүүхээр хэрэглэгдэх ёстой.

Анхан ба давж заалдах шатны шүүхүүд тус заалтыг шүүхийн шийдвэртээ ижил утгатайгаар тайлбарлаж хэрэглэх, харин хяналтын шатны шүүх шүүхийн шийдвэртээ тус заалтыг (ОХУ-ын Иргэний хуулийн 431-р заалтыг) өөрөөр тайлбарлаж хэрэглэх тохиолдол ОХУ-ын шүүхийн практикт багагүй тохиолддог

⁴ Гражданский кодекс Российской Федерации часть первая от 30 ноября 1994 г. N 51-ФЗ//1994 оны 11-р сарын 30-ны №51 “ОХУ-ын Иргэний хуулийн” нэгдүгээр хэсэг. URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17]

⁵ Гражданский процессуальный кодекс Российской Федерации от 14 ноября 2002 г. N 138-ФЗ//ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].



байна. Тухайлбал, 2019 оны 11-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч баталсан №3 "ОХУ-ын Дээд шүүхийн практикийг хянан үзэх тухай" тогтоолын 6 дахь хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг жишээ болгон авч үзье.⁶ Гол асуудал нь: Ф. (худалдан авагч буюу нэхэмжлэгч) болон Ч. (худалдагч буюу хариуцагч)-ын хооронд оёдлын газрыг тоног төхөөрөмжийн хамт 2 сая рублийн үнээр худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байна.

Худалдагч, худалдан авагчад шилжүүлэн өгсөн тоног төхөөрөмж нь 73,000 рублийн үнэтэй (шүүхэд ирүүлсэн үнэлгээний тайлангийн дагуу). Оёдлын газар нь түрээсийн байранд байрладаг байсан тул гэрээний нөхцөлийн дагуу оёдлын газар болон тоног төхөөрөмжийг худалдан авагч нь худалдааны төвд байрлах байрны түрээсийн гэрээ байгуулах ёстой байв. Улмаар худалдан авагч нь гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцож, худалдагч шударга бусаар хэт өндөр үнээр тоног төхөөрөмж худалдаалах болсон хэмээн үзэж, худалдагчийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Анхан ба давж заалдах шатны шүүх: Үг хэллэгийн шууд утгыг харгалзан гэрээний нөхцөлийг шууд утгаар нь тайлбарлахад "худалдагчаас худалдан авагч руу шилжих", "оёдлын газар ашиглах эрх шилжүүлэх", "оёдлын газрыг эзэмших эрх", "хариуцагч оёдлын газрыг нэхэмжлэгчид шилжүүлэх үүрэг хүлээнэ" гэсэн үгсэд дүн шинжилгээ хийхэд уг гэрээний зүйл нь худалдагч

⁶ п. 6 "Обзора судебной практики Верховного Суда Российской Федерации N 3 (2019)", утв. Президиумом Верховного Суда РФ 27.11.2019.// 2019 оны 11-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч баталсан 2019 оны №3 "ОХУ-ын Дээд шүүхийн практикийг хянан үзэх тухай" тогтоолын 6 дахь хэсэг URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

Ч-гаас худалдан авагч Ф-д зөвхөн тоног төхөөрөмж төдийгүй худалдааны төвд байрлах байрыг өмчлөх эрхийг шилжүүлсэн байна.

Түрээсийн байрыг өмчлөлд шилжүүлэх боломжгүй гэдгийг хариуцагч мэдэхгүй байхын аргагүй. Гэрээг байгуулах зорилготой худалдагч санаатайгаар нэхэмжлэгчид гэрээний нөхцөлийн тухай худал мэдээлэл өгсөн нь худалдагчийн үйлдлээс батлагдаж байна. Энэ нь ОХУ-ын Иргэний хуулийн 179 дүгээр зүйлд заасан хууран мэхлэхийн тодорхойлолттой нийцэж байна.

Худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа хариуцагчийн зүгээс шударга бус үйлдэл гаргасан тул шүүхээс бодит нөхцөл байдлыг болон ОХУ-ын Иргэний хуулийн 168 дугаар зүйлийн 2-р хэсэг ба ОХУ-ын Иргэний хуулийн 10 дугаар зүйлд заасан үндэслэлээр дээрх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсугай" хэмээн анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, давж заалдах шатны шүүх хариуцагчийн давж заалдах гомдлыг хангахгүй, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх тухай магадлал гаргасан байна.

Харин ОХУ-ын Дээд шүүх хяналтын журмаар тус иргэний хэргийг хэлэлцэн, анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах үндэслэлээр алдаатай гаргасан байна гэж үзэв:

ОХУ-ын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд дурдсанаар ОХУ-ын Дээд шүүх гэрээний агуулгыг нийтээр хүлээн зөвшөөрсөн тайлбарын дагуу болон гэрээний нөхцөлийг талууд хэрхэн ойлгож байгаагаар тодорхойлно.⁷

⁷ Гражданский кодекс Российской Федерации часть первая от 30 ноября 1994 г. N 51-ФЗ//1994 оны 11-р сарын 30-ны №51 "ОХУ-ын Иргэний хуулийн" нэгдүгээр хэсэг URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].



Хэрэв гэрээ хэд хэдэн утгатайгаас болж гэрээний зарим заалтуудын утгыг тогтоох, тодорхойлох боломж олгохгүй байгаа тохиолдолд, шүүх талуудын бодит хүсэл, зоригийг тодорхойлох үүрэгтэй. Үүнийг тогтоох гол арга нь талуудын болон тэдгээрийн төлөөлөгчдийн гэрээний нөхцөл, хэргийн нөхцөл байдлын дагуу өгсөн мэдүүлэг юм.

Шүүх ямар ч эргэлзээгүйгээр талуудын бодит хүсэл зориг, зорилгыг тодорхойлохын тулд хавтаст хэрэгт цугалсан бүх нотлох баримтыг нэгтгэн харгалзан үзэх үүрэгтэй.

Нэхэмжлэгч өөрөө шүүхэд өгсөн тайлбартаа гэрээний шууд агуулгад үндэслэн түүний зүйлээр тоног төхөөрөмжийн багц, оёдлын газрыг дурджээ.

Гэрээний бичвэрт 6 метр квадрат талбай бүхий худалдааны төвд байрлах байрны өмчлөх эрхийг шилжүүлэх тухай заагаагүй байна.

Гэрээний агуулгад “уг байрыг худалдагч, худалдааны төвийн өмчлөгчөөс 2017 оны 2-р сарын 1-ний өдрийг хүртэл түрээслэн авах ба оёдлын газрын байр худалдагчийн түр өмчлөлд байх болно, худалдагчаас худалдан авагч оёдлын газрыг худалдан авсны дараа худалдан авагч өөрөө тусдаа худалдааны төвийн өмчлөгчтэй түрээсийн гэрээ байгуулна” гэж тодорхой бичигдсэн байна.

Байрны эзэмших эрх нь хэнийх гэдгийг болон түрээсийн гэрээ байгуулах шаардлагатай нөхцөл байдалтай гэдгийг талуудын байгуулсан гэрээнд тодорхой заасан тул Ф. (худалдан авагч) нь гэрээнд гарын үсэг зурхаасаа өмнө үүний талаар мэдэх ёстой байсан.

Худалдан авагч юуг, ямар үнээр худалдаж авч байгаагаа сайн мэдэж

байсан болохор худалдагчийг заль мэх хэрэглэн шударга бусаар оёдлын газар болон тоног төхөөрөмжүүдэд хэт өндөр үнэ тогтоосон гэсэн нь үндэслэлгүй бөгөөд худалдагчийг шударга бус, заль мэх хэрэглэсэн гэж дүгнэж болохгүй. Нэмж дурдахад гэрээний зүйл нь ганц ширхэг тоног төхөөрөмж биш, харин тэдгээр нь багц байв.

Анхан шатны шүүхийн шийдвэрт болон давж заалдах шатны шүүхийн магадлалд худалдан авагч Ф. болон худалдааны төвийн өмчлөгчийн түрээсийн гэрээ байгуулаагүйд нь худалдагч Ч. буруутай гэсэн дүгнэлт байгаагүй.

Худалдааны төвийн өмчлөгч (худалдааны төвийг түрээслүүлэгч) шүүх хуралд өгсөн тайлбартаа худалдан авагч Ф.-гийн зүгээс түрээсийн гэрээ байгуулна гэсэн хүсэлт ирээгүй учраас худалдан авагч Ф.-тэй түрээсийн гэрээ байгуулаагүй гэв.

Худалдан авах, худалдах объектын үнэ цэн нь хариуцагчийн хэлснээр захиалгаар хувцас оёх, засварлах чиглэлээр бизнес эрхлэх боломжийг олгож буй, өөрийн гэсэн тогтмол үйлчлүүлдэг үйлчлүүлэгчтэй бизнесийг оёдлын газар болон түүний дагалдах тоног төхөөрөмжүүдийн хамт худалдаалахад оршино гэв. Үүний зэрэгцээ, тоног төхөөрөмжүүдийг түрээсийн байранд хүлээлгэж өгсөн ба өмнөх оёдлын газрын эзэн оёдлын газраа маш сайн сурталчилсан бөгөөд тус оёдлын газар нь маш их эрэлттэй газар байсан байна.

Эдгээр нөхцөлүүдийн дагуу нэхэмжлэгч нь тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээнд заасан үнээр гэрээг байгуулахаар тохиролцсон” хэмээн үзэж ОХУ-ын Дээд шүүх хариуцагчийн хяналтын журмаар



гаргасан гомдлын шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.⁸

Дээрх иргэний хэргээс харахад анхан болон давж заалдах шатны шүүхүүд нөхцөл байдлын шууд бичвэрийг (оёдлын газрыг худалдах, худалдан авах гэрээний зүйл болгон өгөх, эзэмших эрхийг нь шилжүүлэх), талууд юуны тухай тохиролцсон (оёдлын газар зарна гэдэг нь тухайн байрны өмчлөлийг шилжүүлнэ гэсэн үг), үүний дараа ОХУ-ын Иргэний хуулийн 431-ийн 1-т заасныг үндэслэн “бодсон” нөхцөлийг шууд утгаар нь тайлбарлав.⁹ Талуудын тайлбар нь тодорхой хэргийн нөхцөл байдал болон маргаантай нөхцөлд анхаарлаа төвлөрүүлэхэд тусалдаг ба үгсийн бичвэрүүдийн (текстийн) тодорхой / тодорхой бус байдлыг үнэлэх шаардлагатай болгодог болохор гэрээний талаарх талуудын өгсөн тайлбарыг үнэлэхэд хүндрэлтэй байдаг байна.

III. Үндсэн хэсэг

В.В.Сорокин эрх зүйн номлолыг (доктринаг) хууль эрх зүйн тодорхой зөрчлийг шийдвэрлэх, хуулийн цоорхойг нөхөх “аюулгүй” арга зам гэж үзсэн байна. Энэ тохиолдолд эрх зүйн номлол нь хуулийн эх сурвалжийг акт хэлбэрээр илэрхийлж буй шүүхийн хууль хэрэглэх үйл явцад хамаарна. Үүний зэрэгцээ нийтээр заавал дагаж мөрдөх эрх зүйн номлол нь (доктрина) эрх зүйн тасралтгүй, тогтвортой удирдамжийн

⁸ п. 6 “Обзора судебной практики Верховного Суда Российской Федерации N 3 (2019)”, утв. Президиумом Верховного Суда РФ 27.11.2019.// 2019 оны 11-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч баталсан 2019 оны №3 “ОХУ-ын Дээд шүүхийн практикийг хянан үзэх тухай” тогтоолын 6 дахь хэсэг URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17]

⁹ Гражданский кодекс Российской Федерации часть первая от 30 ноября 1994 г. N 51-ФЗ//1994 оны 11-р сарын 30-ны №51 “ОХУ-ын Иргэний хуулийн” нэгдүгээр хэсэг URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17]

тогтолцооны зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг.¹⁰ Шүүхийн практикийн нэгдмэл байдлыг эрх зүйн номлолоор хангах талаар ярихдаа шүүгч зөвхөн хууль тогтоомжуудыг зөв иш татан хэрэглэхдээ анхааран, дотоод үзэл бодол, дотоод итгэл үнэмшилээ харгалзан үзэж үндэслэлтэйгээр шийдвэр гаргах нь зүйтэй. А.Ф.Галушкогийн хэлснээр “дотоод итгэл үнэмшил нь өөрийн мэдлэг (материаллаг болон процессын хуулийн мэдлэг), дүгнэлт, шийдвэрийн үнэн зөв гэдэгт итгэх итгэлийг агуулдаг”.¹¹ Шүүгчийн итгэл үнэмшил, материаллаг болон процессын эрх зүйн мэдлэгийн үндсэнд нь номлол (доктрина) болон түүний хэлбэр оршиж байдаг” гэж үзсэн. Тус аргументыг одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжуудад тусгаж өгсөн байна. Тухайлбал, ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67-р зүйлд “шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг иж бүрэн, бодитой, шууд шинжлэн судалсны үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэл үнэмшлээр үнэлдэг” хэмээн заасан байна.¹²

2018 оны 1-р сард ОХУ-ын Дээд шүүхийн 95 жилийн ойд зориулсан ёслолын арга хэмжээн дээр ОХУ-

¹⁰ Сорокин, В. В. Судебная практика или правовая доктрина? / В. В. Сорокин // Арбитражный и гражданский процесс. -2002. - № 8. - С.9.// Сорокин, В. В. Шүүхийн практик эсвэл эрх зүйн номлол уу? / В.В.Сорокин // Арбитр ба иргэний процесс. - 2002. -№ 8- 9x.

¹¹ Галушко, А. Ф. Влияние внутреннего убеждения судей на оценку доказательств / А. Ф. Галушко // Вестник Омского университета. Сер.: Право. -2011. - № 3 (28). - С. 146-148// Галушко, А. Ф. Нотлох баримтыг үнэлэхэд шүүгчдийн дотоод итгэл үнэмшлийн нөлөө /А. Ф. Галушко //Омскийн их сургуулийн мэдээллийн товхимол.Эрх зүй. - 2011. - No3 (28). - 146-148-х.

¹² “Гражданский процессуальный кодекс Российской Федерации” от 14.11.2002 N 138-ФЗ // 2002 оны 11-р сарын 14-ний өдрийн № 138-ФЗ “ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17]



ын Ерөнхийлөгч В.В.Путин шүүхүүд хууль тогтоомжуудыг зөв тайлбарлаж ашиглахын тулд шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хангах нь шүүхүүдийн үйл ажиллагаанд өндөр ач холбогдолтой хэмээн онцлон тэмдэглэж хэлэв. Шүүхийн практикийг нэгтгэн дүгнэвэл, Дээд шүүх нь эрх зүйн хэм хэмжээний нэгдмэл ойлголт, хэрэглээг хангадаг бөгөөд үнэн хэрэгтээ хууль тогтоомжуудыг албан ёсоор тайлбарладаг. Үүний ачаар хууль дээдлэх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчим хэрэгждэг.¹³

Шүүхийн практикийн нэгдмэл байдлын үзэл баримтлалын талаарх шинжлэх ухааны ойлголтууд нь янз бүр. Одоогийн байдлаар "шүүхийн практикийн нэгдмэл байдал" гэсэн ойлголтын эрх зүйн хүрээнд хараахан зохицуулагдаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй ба сүүлийн үед боловсруулсан шинжлэх ухааны онолууд нь тус ойлголтыг тодорхойлдог гэж үзэж болно. Тухайлбал, ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2005 оны 3-р сарын 23-ны өдрийн № 25-ПВ тоот тогтоолд шүүхийн практикийн нэгдмэл байдал гэдгийг "ОХУ-ын нутаг дэвсгэр дэх шүүхүүдийн ОХУ-ын хууль тогтоомжуудыг иргэний хэргүүдийг шийдвэрлэхэд адилхан, төстэйгөөр тайлбарлаж хэрэглэх явдал гэж ойлгож болно" хэмээн тэмдэглэсэн байна.¹⁴

Онолд "шүүхийн практикийн нэгдмэл байдлаар хэргийг шийдвэрлэхдээ шүүхийн дээд байгууллагуудаас

боловсруулсан хууль тогтоомжуудын тайлбаруудыг нэгдмэл байдлаар хэрэглэх зарчмыг хэлнэ" хэмээн тодорхойлсон байна.¹⁵

Г.А.Вишневский "шүүхийн тогтоомжуудын нэгдмэл байдлыг хангах нь дээд шүүхийн үндсэн зорилтуудын нэг гэж үзсэн байна.¹⁶

С.И.Князкин хэлснээр "шүүхийн практикийн нэгдмэл байдал нь процессын болон зохион байгуулалтын арга хэрэгслээр хангагддаг. Процессын арга хэрэгсэлд ОХУ-ын Дээд шүүх иргэний болон эдийн засгийн хэргүүдийг хяналтын журмаар шалгах, зохион байгуулалтын арга хэрэгсэлд ОХУ-ын Дээд шүүхээс эрхлэн гаргасан шүүхийн шийдвэрт тусгасан хууль тогтоомжуудыг зөв тайлбарлаж хэрэглэх талаарх ОХУ-ын Дээд шүүхийн тогтоол болон 3 сард нэг удаа гаргадаг хууль тогтоомжуудын эмхэтгэл хамаарна.¹⁷

В.А.Давыдов (зохиолч) "Хяналтын шатны шүүхээс баталсан шүүхийн практикийн асуудлуудыг тусгасан шийдвэрүүдийг хуулийн үндсэн дээр

¹⁵ Гук, П. А. Принцип единства судебной практики в российском судопроизводстве / П. А. Гук, Е. П. Гук // Известия высших учебных заведений. Поволжский регион. Общественные науки. – 2016. – № 3 (39). – С. 88. // Гук, П.А. Оросын хууль эрх зүйн байцаан шийтгэх ажиллагааны нэгдмэл байдлын зарчим / П. А. Гук, Е. П. Гук // Дээд боловсролын байгууллагуудын мэдээ. Поволжский бүс. Нийгмийн шинжлэх ухаан. - 2016. -№3 – 88-х.

¹⁶ Вишневский, Г. А. Единство судебного правоприменения как способ обеспечения верховенства права / Г. А. Вишневский // Право. Журнал Высшей школы экономики. – 2011. – № 2. – С. 13. // Вишневский, Г.А. Шүүхийн хууль тогтоомжуудыг хэрэглэх нэгдмэл байдал нь хууль дээдлэх ёсыг хангах арга зам болох нь / Г.А. Вишневский // Эрх зүй. Эдийн засгийн дээд сургуулийн сэтгүүл. - 2011. - № 2. – 13 х.

¹⁷ Князькин, С. И. Единство судебной практики и средства его обеспечения / С. И. Князькин // Журнал российского права. – 2015. – № 11 (227). – С. 161. // Князькин, С. И. Шүүхийн практикийн нэгдмэл байдал, түүнийг хангах арга хэрэгсэл / С.И.Князкин // Оросын хууль, эрх зүйн сэтгүүл. - 2015. -№11 (227). – 161-х.

¹³ Президент выступил на торжественном собрании, посвященном 95-летию Верховного Суда. // Улсын дээд шүүхийн 95 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн хурал дээр хэлсэн ОХУ-ын Ерөнхийлөгч үг – URL: <http://kremlin.ru/events/president/news/56688> [Сүүлд үзсэн: 2021.03.17]

¹⁴ Постановление Президиума Верховного Суда РФ от 23 марта 2005 г. № 25-ПВ // Бюллетень Верховного Суда РФ. – 2005. – № 9. // ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2005 оны 3-р сарын 23-ны өдрийн № 25-ПВ04 тоот тогтоол URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].



тайлбарлахын тулд ОХУ-ын Дээд шүүх тогтоол гаргадаг. Зохиогч шүүхийн практикийн нэгдмэл байдал ийм байдлаар хэрэгждэг болохоос, шүүхийн шийдвэрийг хяналтын журмаар дахин хэлэлцэх замаар хэрэгждэггүй. Учир нь хяналтын шүүхийн практик нь ОХУ-ын Дээд шүүхийн тогтоол шиг тогтвортой биш” гэж үздэг.¹⁸ Би В.А. Давыдов зохиолчын үзэл бодолтой санал нийлж байна.

IV. Санал

Орчин үед хууль тогтоомжуудыг нэгдмэл байдлаар тайлбарлах асуудал шүүхчдэд тулгамдсан ба тус асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй боловч харамсалтай нь тус асуудлын талаар тогтсон ойлголт байхгүй байгаа нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээний хүндрэл учруулж байгаа ба үүнтэй холбогдуулан шүүхийн практикийн нэгдмэл байдлын зарчмыг хэрэгжүүлэх механизмыг боловсруулж, хуульчлахыг санал болгож байна. Шүүхийн практикийн нэгдмэл байдал нь шүүгчдийн материаллаг болон процессын хэм хэмжээг нэгдмэл байдлаар тайлбарлаж, хэрэглэснээр илэрхийлэгддэг. Үүнтэй холбогдуулан “ОХУ-ын нутаг дэвсгэрт үйлчлэх, шүүхийн шийдвэрүүдэд ихэвчлэн хэрэглэгддэг Иргэний хуулийн зүйл заалтуудын тайлбарыг тусгасан шүүхийн практикийн эмхэтгэлүүдийг сард нэг удаа ОХУ-ын Дээд шүүхээс удирдамж болгон бүх шатны шүүгчдэд өгөхөөр гаргаж, өгвөл шүүгчдийн ижил хэргүүдийг төсөөтэйгөөр шийдвэрлэх

боломж үүсэж, улмаар анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдийн хууль хэрэглээний зөрүүг арилгах бүрэн нөхцөл үүснэ” гэж би бодож байна. ОХУ-ын Дээд шүүхээс хүчин төгөлдөр байгаа хуулиудын тайлбаруудыг эмхэтгэлд зааснаар тайлбарлахыг анхан болон давж заалдах шатны шүүхүүдэд удирдамж болговол ОХУ-ын Иргэний хуулийн тодорхой нэгэн заалтыг янз бүрийн түвшний шүүхүүд өөрөөр тайлбарласан талаар маргаан маш бага үүсэж магадгүй гэж бодож байна.

V. Дүгнэлт

Орчин үед хууль тогтоомжуудыг нэгдмэл байдлаар тайлбарлах асуудал шүүхчдэд тулгамдаж буй гол асуудлуудын нэг болсон бөгөөд тус асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь зүйтэй боловч харамсалтай нь тус асуудлын талаар тогтсон ойлголт байхгүй байгаа нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээний хүндрэл учруулж байгаа ба үүнтэй холбогдуулан шүүхийн практикийн нэгдмэл байдлын зарчмыг хэрэгжүүлэх механизмыг боловсруулж, хуульчилж, “ОХУ-ын нутаг дэвсгэрт үйлчлэх, шүүхийн шийдвэрүүдэд ихэвчлэн хэрэглэгддэг Иргэний хуулийн зүйл заалтуудын тайлбарыг тусгасан шүүхийн практикийн эмхэтгэлүүдийг сард нэг удаа ОХУ-ын Дээд шүүхээс удирдамж болгон бүх шатны шүүгчдэд өгөхөөр гаргаж, өгвөл шүүгчдийн ижил хэргүүдийг төсөөтэйгөөр шийдвэрлэх боломж үүсэж, улмаар анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүдийн хууль хэрэглээний зөрүүг арилгах бүрэн нөхцөл үүсэж, ОХУ-ын Дээд шүүхээс хүчин төгөлдөр байгаа хуулиудын тайлбаруудыг эмхэтгэлд зааснаар тайлбарлахыг анхан болон давж заалдах шатны шүүхүүдэд удирдамж болговол ОХУ-ын Иргэний хуулийн

¹⁸ Давыдов, В. А. Пересмотр в порядке надзора судебных решений по уголовным делам: производство в надзорной инстанции : науч.-практ. пособие / В. А. Давыдов. – Москва : Волтерс Клувер, 2006. – 7 с.// Давыдов, В. А. Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг хяналтын журмаар дахин хэлэлцэх: хяналтын шат./ шинжлэх ухааны хэвлэл – Москва : Волтерс Клувер, 2006. –7х.



тодорхой нэгэн заалтыг янз бүрийн түвшний шүүхүүд өөрөөр тайлбарласан талаар маргаан маш бага үүсэж магадгүй гэж би бодож байна.

2019 оны 11-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч баталсан №3 "ОХУ-ын Дээд шүүхийн шүүхийн практикийг хянан үзэх тухай" тогтоолын 6 дахь хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг нэгтгэн дүн шинжилгээ хийхэд хэрэв гэрээ хэд хэдэн утгатайгаас болж гэрээний зарим заалтуудын утгыг тогтоох, тодорхойлох боломжгүй байгаа тохиолдолд, шүүх талуудын бодит хүсэл, зоригийг тодорхойлох үүрэгтэй. Үүнийг тогтоох гол арга нь талуудын болон тэдгээрийн төлөөлөгчдийн гэрээний нөхцөл, хэргийн нөхцөл байдлын дагуу өгсөн мэдүүлгийг анхааралтай уншиж танилцаж, тодорхой дүн шинжилгээ хийх явдал хэмээн дүгнэж болно.

Одоогийн байдлаар "шүүхийн практикийн нэгдмэл байдал" гэсэн ойлголтын эрх зүйн хүрээнд зохицуулагдаагүйг тэмдэглэх нь зүйтэй ба сүүлийн үед боловсруулсан шинжлэх ухааны онолууд нь тус ойлголтыг тодорхойлдог гэж үзэж болно. Тухайлбал, ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2005 оны 3-р сарын 23-ны өдрийн № 25-ПВ тоот тогтоолд шүүхийн практикийн нэгдмэл байдал гэдгийг "ОХУ-ын нутаг дэвсгэр дэх шүүхүүдийн ОХУ-ын хууль тогтоомжуудыг иргэний хэргүүдийг шийдвэрлэхэд адилхан, төстэйгээр тайлбарлаж хэрэглэх явдал гэж ойлгож болно" хэмээн тэмдэглэсэн байна. Онолд "шүүхийн практикийн нэгдмэл байдлаар хэргийг шийдвэрлэхдээ шүүхийн дээд байгууллагуудаас боловсруулсан хууль тогтоомжуудын тайлбаруудыг нэгдмэл байдлаар хэрэглэх зарчмыг хэлнэ" хэмээн тодорхойлсон байна.

ОХУ-ын шүүх, эрх зүйн байдлыг сайжруулах тогтолцооны хүрээнд шүүхийн практикийн нэгдмэл байдлыг бүрдүүлэх асуудал онцгой үүрэг гүйцэтгэдэг. Шүүхийн практикийн нэгдмэл байдал нь шүүгчдийн материаллаг болон процессын хэм хэмжээг нэгдмэл байдлаар тайлбарлаж, хэрэглэснээр илэрхийлэгддэг. Оросын Холбооны улсад "шүүхийн практикийн нэгдмэл байдал" гэсэн ойлголт хангалттай судлагдаагүй байна. Шүүхийн практик нь хууль тогтоомж, шүүхийн шийдвэрүүдийн хэрэгжилтийг харуулах орчин үеийн эрх зүйн идэвхтэй хөдөлгүүр мөн. Шүүхийн практикийн нэгдмэл байдлыг эрх зүйн номлолоор хангах асуудлын талаар олон эрдэмтэн, судлаачид ном, сурах бичигтээ дурдсан байна. Тус эрдэмтэн, судлаачдын нэг нь В.В.Сорокин бөгөөд В.В.Сорокин нь номлолыг (доктринаг) хууль эрх зүйн тодорхой зөрчлийг шийдвэрлэх, хуулийн цоорхойг нөхөх "аюулгүй" арга зам гэж үзсэн байна. Шүүхийн практикийн нэгдмэл байдлыг хууль зүйн номлолоор хангах талаар ярихдаа шүүгч зөвхөн хууль тогтоомжуудыг зөв иш татан хэрэглэхдээ анхааран, дотоод үзэл бодол, дотоод итгэл үнэмшлээ харгалзан үзэж үндэслэлтэйгээр шийдвэр гаргах нь зүйтэй. Би В.В.Сорокин-тай бүрэн санал нийлж байна.



НОМ ЗҮЙ

I. Гадаад эх сурвалж:

1. Вишневский, Г.А. Единство судебного правоприменения как способ обеспечения верховенства права / Г. А. Вишневский // Право. Журнал Высшей школы экономики. – 2011. – № 2. – С. 13. // Вишневский, Г.А. Шүүхийн хууль тогтоомжуудыг хэрэглэх нэгдмэл байдал нь хууль дээдлэх ёсыг хангах арга зам болох нь / Г.А. Вишневский // Эрх зүй. Эдийн засгийн дээд сургуулийн сэтгүүл. - 2011. - № 2. – 13 х.

2. Галушко, А.Ф. Влияние внутреннего убеждения судей на оценку доказательств / А. Ф. Галушко // Вестник Омского университета. Сер.: Право. – 2011. – № 3 (28). – С. 146–148 // Галушко, А. Ф. Нотлох баримтыг үнэлэхэд шүүгчдийн дотоод итгэл үнэмшлийн нөлөө / А. Ф. Галушко // Омский их сургуулийн мэдээллийн товхимол. Эрх зүй. - 2011. - №3 (28). – 146–148-х.

3. Гук, П.А. Принцип единства судебной практики в российском судопроизводстве / П. А. Гук, Е. П. Гук // Известия высших учебных заведений. Поволжский регион. Общественные науки. – 2016. – № 3 (39). – С. 88. // Гук, П.А. Оросын хууль эрх зүйн байцаан шийтгэх ажиллагааны нэгдмэл байдлын зарчим / П.А.Гук, Е.П.Гук // Дээд боловсролын байгууллагуудын мэдээ. Поволжский бүс. Нийгмийн шинжлэх ухаан. - 2016. -№3 – 88-х.

4. Давыдов, В.А. Пересмотр в порядке надзора судебных решений по уголовным делам: производство в надзорной инстанции : науч.-практ. пособие / В.А.Давыдов. – Москва : Волтерс Клувер, 2006. – 7 с. // Давыдов, В. А. Эрүүгийн хэргийн шүүхийн

шийдвэрийг хяналтын журмаар дахин хэлэлцэх: хяналтын шат./ шинжлэх ухааны хэвлэл – Москва: Волтерс Клувер, 2006. –7х.

5. Князькин, С.И. Единство судебной практики и средства его обеспечения / С. И. Князькин // Журнал российского права. – 2015. – № 11 (227). – С. 161. // Князькин, С. И. Шүүхийн практикийн нэгдмэл байдал, түүнийг хангах арга хэрэгсэл / С.И.Князькин // Оросын хууль, эрх зүйн сэтгүүл. - 2015. -№11 (227). – 161-х.

6. Президент выступил на торжественном собрании, посвященном 95-летию Верховного Суда. // Улсын дээд шүүхийн 95 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн хурал дээр хэлсэн ОХУ-ын Ерөнхийлөгч үг – URL: <http://kremlin.ru/events/president/news/56688> [Сүүлд үзсэн: 2021.03.17]

7. Сорокин, В. В. Судебная практика или правовая доктрина? / В. В. Сорокин // Арбитражный и гражданский процесс. – 2002. – № 8. – С.9. // Сорокин, В. В. Шүүхийн практик эсвэл эрх зүйн номлол уу? / В.В.Сорокин // Арбитр ба иргэний процесс. - 2002. -№8- 9х.

II. Эрх зүйн эх сурвалж:

1. Конституция Российской Федерации от 12 декабря 1993 года // 1993 оны 12-р сарын 12-ны өдрийн ОХУ-ын Үндсэн хууль URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

Федеральный конституционный закон от 31 декабря 1996 г. № 1-ФКЗ "О судебной системе Российской Федерации" // 1996 оны 12-р сарын 31-ний өдрийн № 1 "ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай хууль" URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].



Федеральный конституционный закон от 5 февраля 2014 г. N 3-ФКЗ "О Верховном Суде Российской Федерации" // 2014 оны 2-р сарын 5-ны № 3 "ОХУ-ын Дээд шүүхийн тухай хууль" URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

Гражданский кодекс Российской Федерации часть первая от 30 ноября 1994 г. N 51-ФЗ // 1994 оны 11-р сарын 30-ны №51 "ОХУ-ын Иргэний хуулийн" нэгдүгээр хэсэг. URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

Гражданский процессуальный кодекс Российской Федерации от 14 ноября 2002 г. N 138-ФЗ // ОХУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

Постановление Президиума Верховного Суда РФ от 23 марта 2005 г. № 25-ПВ // Бюллетень Верховного Суда РФ. – 2005. – № 9. // ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2005 оны 3-р сарын 23-ны өдрийн № 25-ПВ04 тоот тогтоол URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].

"Обзор судебной практики Верховного Суда Российской Федерации N 3 (2019)", утв. Президиумом Верховного Суда РФ 27.11.2019. // 2019 оны 11-р сарын 27-ны өдөр ОХУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч баталсан 2019 оны №3 "ОХУ-ын Дээд шүүхийн практикийг хянан үзэх тухай" тогтоолын 6 дахь хэсэг URL:<http://www.pravo.gov.ru> [Сүүлд үзсэн: 2021.03.17].



Abstract

**UNITY OF JUDICIAL PRACTICE IN THE RUSSIAN
FEDERATION ON THE EXAMPLE OF THE CIVIL CODE OF THE
RUSSIAN FEDERATION**

S. ZHANSAYA

*Researcher at the Center for Judicial Training,
Research and Information of the
Supreme Court of Mongolia
Master of the State University of Management
(Russian Federation)*

The purpose of this scientific article is to describe the unity of judicial practice in the Russian Federation, to identify individual provisions of the Civil Code, to analyze legal norms, to consider the problems of

the legal sphere and to describe ways to solve them.

Keywords

Russian Federation, civil law, interpretation of the contract, judicial practice, unity.

**ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ АСУУДЛУУД
(Антропологи хэмээх нэр томьёоны хүрээнд)**

**LEGAL TERMINOLOGICAL ISSUES
(In anthropology)**

Сүлдийн НОМЫНБАЯСГАЛАН¹

- I. Оршил
- II. Нэр томьёонд тавигдах шаардлага
- III. Антропологийн судалгаа хийх хууль зүйн үндэслэл
- IV. Антропологийн үүднээс судлах хэрэгцээ шаардлага
- V. Антропологийн судалгааны аргын тухай
- VI. Антропологийг төрөлжүүлэх нь
- VII. Дүгнэлт, санал
- VIII. Ном зүй

¹ МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, Хууль зүйн магистр /LL.M./



ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁНЫ АСУУДЛУУД

(Антропологи хэмээх нэр томьёоны хүрээнд)

С.НОМЫНБАЯСГАЛАН. МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн докторант, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, Хууль зүйн магистр /LL.M/

Товчлол

Энэхүү нийтлэлийн сэдвийг “Хууль зүйн нэр томьёоны асуудлууд: Антропологи хэмээх нэр томьёоны хүрээнд” гэж нэрлэн, агуулгыг хууль зүйн нэр томьёоны орчуулгын асуудлаар хязгаарлав.

Түлхүүр үгс: Хүн судлал, антропологийн судалгаа, хууль зүйн антропологи, эрх зүйн антропологи, монголын эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн соёл, эрх зүйн заншил, оролцон ажиглах арга, орчуулга, хууль зүйн хэл, хууль зүйн нэр томьёо.

I.Оршил

Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан¹ болон Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны судалгааны эх сурвалжийн цахим сан² зэрэгт төр, эрх зүйн сэтгэлгээ, эрх зүйн түүхэн талаас хийгдсэн цөөнгүй судалгаанууд байна. Харин “хүн судлал”³ буюу антропологийн

онол, арга зүйд суурилсан, хууль зүйн антропологийн үүднээс хийгдсэн судалгаа хомс байна.⁴ Энэ салбар ухааны онол, арга зүйн үүднээс судалж үзсэн судалгаа хууль зүйн салбарт хэвлэгдээгүй байна. Харин “монголчуудын эрх зүйн соёлын сэтгэлгээ, уламжлалыг судлахад монгол зүйр цэцэн үгс чухал ач холбогдолтой” гэсэн санааг гаргасан цөөн хэдэн бүтээл байна. Академич С.Нарангэрэлийн Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо хэмээх бүтээлд монголын зүйр цэцэн үгэнд монголчуудын эрх зүй, хуульд хандах сэтгэлгээ тов тодорхой тусгалаа олсон байдлыг жишээ болгон авч үзсэн байна.⁵ Мөн түүнчлэн зүйр цэцэн үг нь эрх зүй, хууль гээч юу болох түүний зорилго, зориулалт, хэрэгцээ, шаардлагыг тодорхой харуулснаараа онцлог байна.⁶ Ийнхүү зүйр цэцэн үгэнд тусгагдсан монголчуудын эрх зүйн сэтгэлгээ соёлын уламжлал болохыг тодорхойлохыг оролдсон байна.⁷ Нэн ялангуяа монгол

¹ <https://legaldata.mn/> (Сүүлд үзсэн огноо: 2022.02.09)

² <https://nli.gov.mn/nom/index.php> (Сүүлд үзсэн огноо: 2022.02.09)

³ Хүн судлал буюу антропологи (англиар Anthropology; оросоор Антропология) гэдэг нь хүн, хүн төрөлхтнийг судлах байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан юм. 1501 онд Германы гүн ухаанч Магнус Хундт Антропологи (эртний Грек хэлний антропос хэмээх ἀνθρώπος, “хүн”, –логиа хэмээх λογία, “судлал”) гэдэг нэр томьёог анх хэрэглэсэн гэж үздэг.

https://mn.wikipedia.org/wiki/%D0%A5%D2%AF%D0%BD_%D1%81%D1%83

[%D0%B4%D0%BB%D0%B0%D0%BB](https://mn.wikipedia.org/wiki/%D0%B4%D0%BB%D0%B0%D0%BB) (Сүүлд үзсэн огноо: 2022.02.09)

⁴ Хууль зүйн салбарт биологийн антропологийн чиглэлээр хийгдсэн цөөнгүй судалгаа байна.

⁵ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 182 дахь тал

⁶ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 183 дахь тал

⁷ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 184 дэх тал



үндэстэн ястны аман зохиол, ёс, зан заншил, цээрийн ёс болон бэлгэдэл зүйг эрх зүйн сэтгэлгээний уг сурвалж болох талаас нь судалсангүй. Өөрөөр хэлбэл, монгол үндэстний ахуй, зан заншил, ёс суртахууныг судлахгүйгээр тэдгээрийн эрх зүйн болон эрх зүйн сэтгэлгээний уламжлалыг ойлгох, судлах боломжгүй.⁸

Энэ байдлыг харгалзан энэхүү нийтлэлээр хууль зүйн нэр томъёоны асуудлууд гэсэн сэдвийн хүрээнд “антропологи” хэмээх нэр томъёоны утга санаа, ойлголтын талаар танилцуулахыг гол зорилгоо болгов. Ийнхүү дурдан буй нэр томъёог сонгон хэрэглэхдээ хэлбэр талаас нь бус харин агуулга талаас нь авч үзэхийг антропологийн салбар ухааны онол болоод арга зүй талаасаа шаардаж байна. Энэ нь дараах бүтээлүүдийн агуулгаас тодорхой харагдаж байна.⁹ Энэхүү нэр томъёо нь хууль зүйн салбарт танил бус болох нь монголын эрх зүйн толь бичгүүдээс тодорхой харагдаж байна. Жишээлбэл, хууль зүйн зарим нэр бүхий тайлбар тольд дээрх нэр томъёоны талаар дурдаагүй байна.¹⁰

⁸ Баярсайхан Б., Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа, (Илтгэл, өгүүлэл), Уб., 2021, 365 дахь тал
⁹ Fernanda Pirie, The Anthropology of Law, Clarendon Law Series, Oxford university press, 2013

https://books.google.mn/books?id=SbbDAQAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false
 James M. Donovan, Legal Anthropology: An introduction, printed in the United States of America, AltaMira, 2008

https://books.google.mn/books?id=vRAfAAAAQBAJ&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false
 Norbert Rouland, Legal Anthropology, (Translated by Philippe G. Planel), The Athlone Press, London, 1994
https://books.google.mn/books?id=5gLNds-G_u8C&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0#v=onepage&q&f=false . . . etc. (Сүүлд үзсэн огноо: 2022.02.09)

¹⁰ Амарсанаа Ж., ба бусад, Хууль зүйн тайлбар толь, Уб., 2003, Баярсайхан Б., Хууль зүйн тайлбар толь, (Монгол Улсын төр, эрх зүйн түүх), Уб., 2003, . . . гэх мэт.

Харин академич С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичиг хэмээх бүтээлд “Эрх зүйн антропологи” - “Хууль зүйн антропологи” – аман (үлгэр, домог, туульс, зүйр цэцэн үгс, ардын аман зохиол, ардын уран бүтээл зэрэг) буюу түүхэн дурсгалт бичиг, нийгмийн практикийг задлан шинжлэх замаар нийгэм хэв маяг бүрт хэвшмэл буй хүн төрөлхтний ахуйг хуульчлах үйл явцыг судалж, тухайн тодорхой эрин үе болон нийгмийн тухайн хэв маягийг хүний эрх зүйн ахуйн үндэс болсон зүй тогтол ба логикийг тодорхойлоход чиглэгдсэн шинжлэх ухаан ба хичээлийн судлагдахуун” гэж тэмдэглэсэн байна.¹¹ Ингэхдээ эрх зүйн антропологи - хууль зүйн антропологи гэсэн нэр томъёо, хэллэгийг авч үзэхдээ адилтган бичжээ. Энэ нь уг нэр томъёог хууль зүйн салбарт зохих түвшинд нийтээр ойлгон хэрэглэж дадсан болохыг нотлон харуулах нэгэн жишээ юм. Иймд уг нэр томъёоны ойлголтын утга, санаа илүү өргөн агуулгатай эсэх, мөн түүнчлэн ийнхүү нэгдмэл байдлаар тодорхойлох боломжтой юу, цаашлаад монгол хэлэнд хэрхэн хөрвүүлэн буулгах вэ гэх мэт асуултауд нээлттэй төдийгүй хариултаа хүлээж байна.

II.Нэр томъёонд тавигдах шаардлага

Хууль зүйн шинжлэх ухаанд “нэр томъёо судлал” чухал байр суурь эзэлдэг¹² бөгөөд хуулийн хэлний онцлог нь нэр томъёотой шууд холбоотой.¹³ Энэ нь үг, өгүүлбэрээр дамжин илэрдэг. Нэр томъёо товч, оновчтой, утга санаа

¹¹ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Хоёр дахь хэвлэл, Уб., 2008, 529 болон 610 дахь тал, Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Гурав дахь хэвлэл, Уб., 2011, 563 болон 610 дахь тал

¹² Баярсайхан Б., Монгол Улсын Үндсэн хуульт ёсны уламжлал, (БНМАУ–ын 1949 оны Үндсэн хуулийн эрх зүйн шинжилгээ), Уб., 2017, 32 дахь тал

¹³ Амархүү О. “Эрх зүйн онолын арван таван сэдэв” Уб., 2008, 52 дахь тал



бүрэн төгс байх нэг гол үндэс нь үгийг зөв сонгож хэрэглэх явдал юм.¹⁴ Тиймээс хууль зүйн нэр томъёог гадаад хэлнээс гадаад нэр томъёонд нутагшуулан оноон хэрэглэх эсэх сонголтыг шинээр нэр томъёо бүтээхэд баримтлах зарчмын дагуу хийх ёстой. Гэхдээ нэгэнт тогтсон хууль зүйн нэр томъёог өөрчлөх гэхээсээ илүүтэй утга агуулга, үзэл санааг нь нэг мөр ойлгох нь чухал билээ.¹⁵ Чухамдаа *нэр томъёог нэр томъёогоор орчуулах*¹⁶ зарчмыг харгалзан үзэх шаардлагатай юм. Гэвч энэ зарчим хэрэгжсэн эсэх нь эргэлзээтэй, тодорхойгүй байна.

Нийтээр хэвшсэн нэр томъёог аль болох хэвээр нь хэрэглэхийн хамт *үг хэмнэх зарчмыг* баримтлахын¹⁷ зэрэгцээ шинжлэх ухааны үүднээс хүлээн зөвшөөрөгдөхүйц байх нь зохимжтой. Тиймээс энэхүү нийтлэлээр авч үзэж буй нэр томъёоны нэршил, ойлголтын судлагдахууныг **хуулийн антропологи** гэж нэрлэхийн оронд **эрх зүйн антропологи буюу хууль зүйн антропологи** гэсэн нэр томъёог ашиглав. Гэтэл хууль зүйн салбарт зээлдсэн антропологи гэх нэр томъёог зээлдсэн хууль зүйн антропологи гэсэн нэр томъёогоор орлуулан хэрэглэснээр эрх зүйн онол, философи, номлолын бүрдэл хэсэг болох *эрх зүйн антропологи* ойлголттой андуурагдан ойлгогдох боломжтой. Тиймээс нэр томъёог хэрхэн оноож өгснөөс шалтгаалан хоёрдмол утгаар ойлгогдох үр дагавартай. Хэдий тийм ч антропологи гэсэн нэршилээр хууль зүйн салбарт нэгэнт нийтээр хэрэглэж

¹⁴ Амарсанаа Ж. “Эрх зүй-нийгмийн харилцааг тохируулагч” УБ., 1988, 67 дахь тал

¹⁵ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” (Улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл) УБ., 2016, 73 болон 77 дахь тал

¹⁶ Сергей Влахов, Сидер Флорин. “Непереводимое в переводе” Москва, 1980, Стр. 285,

¹⁷ “Улсын нэр томъёоны комиссын мэдээ” Хууль зүйн нэр томъёо №107–108 (Тэргүүн дэвтэр) УБ., 1978, 5 дахь тал

дадсан гэж үзвэл салбар эрх зүй бүрт адил утгаар ойлгон хэрэглэгддэг нийтлэг нэр томъёо болгон хэвшүүлэх боломжтой гэж үзэж байна. Жишээлбэл, Үндсэн хуулийн эрх зүйн антропологи, эрүүгийн эрх зүйн антропологи, захиргааны эрх зүйн антропологи, иргэний эрх зүйн антропологи гэх мэт. Эндээс авч үзвэл хууль зүйн салбарт, тэр дундаа хууль зүйн практикт *хууль зүйн антропологи гэж нэрлэн хэрэглэх нь хууль зүйн нэр томъёонд зайлшгүй тавигддаг *нэгмдэл байх, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх, тогтвортой байх* гэсэн шинжүүдийг ханган илүү тохиромжтой байна.

III. Антропологийн судалгаа хийх хууль зүйн үндэслэл

Хуулийн амин сүнсийн тухай хамгийн даацтай, хүлээн зөвшөөрөгдсөн онолын судалгаа шинжилгээг Шарль Монтескюг [Charles de Montesquieu] (1689 – 1755) хийсэн хэмээн үздэг. Ш.Монтескюгийн 1748 онд хэвлүүлсэн “Хуулийн амин сүнс” хэмээх зохиол нь хуулийн амин сүнсийг судалсан хамгийн алдартай бүтээл хэмээгдэн дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн байна.¹⁸ Орчин цагийн бүхий л улс гүрнүүдийн хууль, түүний дотор “**Үндсэн хууль**” Ш.Монтескюгийн боловсруулсан онолыг эш үндэс болгож ирсэн байна.¹⁹ Тодруулбал, АНУ–ын 1878 оны Үндсэн хуулиас эхлээд 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал Ш.Монтескюгийн дэвшүүлсэн үзэл санаанд тулгуурлагдсан байна.²⁰ Энэхүү бүтээлд “*Хууль нь тухайн орныхоо газарзүйн шинж чанарт, хүйтэн, халуун эсвэл сэрүүн цаг агаарт нь, газрын хөрсний чанарт, уг орны байршилд,*

¹⁸ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 7 дахь тал

¹⁹ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 8 дахь тал

²⁰ Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), УБ., 2016, 10 дахь тал



нутаг дэвсгэрийнх нь хэмжээ дамжаанд, цаашилбал, тариачид, анчид, малчид болох ард түмнийх нь амьдралын хэв маягт, улсынх нь байгууллаар тодорхойлогддог эрх чөлөөнийх нь хэр хэмжээнд, оршин суугчдынх нь шашин шүтлэг, авьяас чадварт, мөнөөх ард түмний баялаг, тоо хэмжээнд, худалдаанд нь, зан төлөв, ёс заншилд нь нийцэж байх учиртай” хэмээсэн маш нухацтай үндэслэгээг дэвшүүлэн тавьсан байна.²¹

Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд “хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно”²² гэсэн нь антропологийн судалгаа хийх хууль зүйн үндэслэл нь болж байна. Энэ хүрээнд жишээлбэл, монголд хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт хэрхэн төлөвшиж, уламжлалт соёл, ахуй амьдрал, ёс заншил, итгэл үнэмшлийн онцлогтой хэрхэн холбогдож байгааг судлах боломжтой. Иймээс үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг бодит амьдрал дээр, нийгмийн харилцаанд хэрхэн хэрэгжиж, монголын түүх, нийгэм, соёл, аж байдал, итгэл үнэмшлийн онцлогтой уялдаж байгааг судлах нь антропологийн судалгаа хийх үндэс нь болж байна. Учир нь эрх зүйн соёлыг бүрэлдэхэд түүх – нийгэм, улс төр, эрх зүй, соёл, заншил зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг²³ болохыг санах ёстой.

²¹ Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, УБ., 2018, 8 дахь тал

²² Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 1992, №1

²³ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 181 дэх тал

Өмнөх хэсэгт антропологийн онол, арга зүйд суурилсан, тэр дундаа хууль зүйн антропологийн үүднээс хийгдсэн судалгаа хэвлэгдээгүй тухай дурдсан. Дэлхийн улс орон бүр “**өөрийн**” гэсэн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээр нь хүн амын амьдралын хэв маяг, зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээний хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай учраас энэхүү онцлог байдлыг харгалзан зохицуулах асуудал үндэсний эрх зүйн шинжлэх ухаан бүрийн өмнө зүй ёсоор тавигдаж ирсэн байна. Энэ байдлыг хууль зүйн антропологийн онол, арга зүйн үүднээс авч үзэх хэрэгцээ шаардлага монголын эрх зүйн тогтолцоонд үгүйлэгдэж байна. Нүүдлийн мал аж ахуйн өвөрмөц соёл иргэншилтэй, өдөр тутмын амьдрал ахуйдаа эдэлж хэрэглэдэг зарим зүйлс нь Европынхоос өөр учраас манай орны хувьд зарим хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд өвөг дээдсээс уламжилж ирсэн заншлын хэм хэмжээг баримтлах шаардлага үүсэх нь гарцаагүй.²⁴

Хууль зүйн антропологи буюу эрх зүйн антропологи нь XIX зууны дунд үеэс хөгжсөн бөгөөд нэг талаас нийгмийн олон талт харилцаа, соёл, ухамсарын ижилсэл, ондоошлыг, нөгөө талаас хүнийг эрх зүйн харилцааны объект болох талаас нь судалдаг “**антропологийн**” болон “**хууль зүйн**” шинжлэх ухааны салбар дундын бие даасан хавсарга ухаан²⁵ гэж тодорхойлдог. Энэ утгаараа антропологи бол бодит туршлагад суурилсан салбар ухаан бөгөөд антропологийн

²⁴ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 121 дэх тал

²⁵ Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), УБ., 2021, 5 дахь тал



судлагдахуун нь ихэнхдээ урт хугацааны турш зорилтот оролцогчид дээр ажиглалт хийх замаар бодит амьдрал дээрхи зүйлсийг шинжлэн авч үздэг. Өөрөөр хэлбэл, антропологичид эртний эсвэл төдийлөн авч үздэггүй зүйлсийг хамруулаад аливаа юмсын талаарх бодол санаа, бодит үйлдэл зэрэг олон төрлийн хэлбэрээр орших нийгмийн үзэгдлийг судалдаг.²⁶ Мөн түүнчлэн эрх зүйн антропологи нь эрх зүйн мөн чанарыг нийгмийн үзэгдэл талаас нь судалдаг болохыг анхаарах учиртай. Энэ салбар шинжлэх ухааны үүднээс өөрийн үндэсний эрх зүйн асуудлыг судалж үзсэн судалгаа өнөөг хүртэл хэвлэгдээгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөө бол хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйл билээ. Энэхүү хүн төрөлхтний түгээмэл (**эрх зүйн**) үнэт зүйлсийг үндэсний хууль тогтоомжид тусгахдаа монгол орны өвөрмөц онцлог, үндэсний хэв маяг, монгол хүний сэтгэлгээ, хандлагад нийцүүлэн **"монгол хөрсөнд"** буулгаж чадсан уу, монголчуудын төрт ёс, түүх соёлын үнэт зүйлс нь үндэсний эрх зүйн зохицуулалттай хэрхэн уялдаж эсвэл ондоошиж байна вэ, даяаршлын нөлөөгөөр монголд хурдан дэлгэрч байгаа орчин үеийн үзэл санаа, түүнийг илэрхийлсэн үнэт зүйлс болон нөгөө талд монголчуудын түүх, соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлс хэрхэн зэрэгцэн оршиж байна вэ гэх мэт асуулт түгээмэл тохиолдох боловч өнөөг хүртэл мэргэжлийн түвшинд хариултгүй байсаар байгаа нь **"антропологийн судалгаа хийх нийгмийн хэрэгцээ шаардлага"** үгүйлэгдэж байгааг харуулж байна. Энэ бол **"салбар дундын судалгааны**

²⁶ Fernanda Pirie, *The Anthropology of Law*, Clarendon Law Series, Oxford university press, 2013, 1–2 p

асуулт" бөгөөд тэр дундаа хууль зүйн антропологийн судалдаг сэдвүүдийн нэг болно. Дээрх асуултад антропологийн судалгааг хийснээр зохих хариултыг олно гэж үзэж байна.

IV. Антропологийн үүднээс судлах хэрэгцээ шаардлага

Монголчуудын эрх зүйд хандах сэтгэлгээ нь тэдний амьдралын хэв маяг ёс заншил, уламжлал, эдийн засаг, хүн амын нягтралт зэргээс шалтгаалан барууны орнуудынхтай харьцуулахад өвөрмөц байдалтай²⁷ гэж үздэг. Харин монголчуудын эрх зүйн соёлын уг сурвалж, үнэт зүйлийг тодруулахын тулд "tabula rasa" зарчим буюу урьд өмнө огт байгаагүй цоо шинэ зүйлээс аливаа эрх зүй үүсэж бий болдоггүй гэдгийг санууштай. Учир нь хүмүүсийн нийтлэг бүрт өдгөө үйлчилж буй хууль журмаас өмнө ямар нэгэн суурь хэм хэмжээ, хэв ёс үйлчилж ирсэн байдаг.²⁸ Энэ байдалд үндэслэн Монгол Улс ардчилал, хүний эрхийг дээдэлж, хүний жам ёсны эрхийг үндсэн хуулиараа бататган тунхагласан хэдий ч хүний эрх, эрх чөлөөний талаарх эрх зүйн зохицуулалт монголчуудын эрх зүйн соёл, ухамсар, сэтгэлгээний уламжлалт хандлагад нийцэж чадсан уу, ХХ зуунд даяаршлын нөлөөгөөр хүний эрх, эрх чөлөөний үзэл санаа, түүнийг илэрхийлсэн үнэт зүйлс болон монголчуудын түүх, соёлын онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлс хэрхэн зэрэгцэн оршиж байна вэ, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг иргэд хэрхэн ойлгож байна вэ, хууль хэрэглээнд хэрхэн хэвшүүлэх вэ зэрэг асуултуудад өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд нэгтгэн

²⁷ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 181–182 дахь тал

²⁸ Өнөрбаяр Ч., Үндсэн хууль ёсны хөгжил, түүний чиг хандлага, (Түүх, улс төр, эрх зүй), УБ., 2021, 263 дахь тал



судлаагүй байна.

Өнөөдөр дэлхийн улс орнууд хөгжлийн асуудлыг дан ганц эдийн засгийн талаас нь бус, харин түүх соёл, улс төр, нийгмийн болон улс төрийн философи, улс төрийн эдийн засаг, антропологийн талаас нь бүрэн гүйцэд судалж, өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн замналыг тодорхойлохыг оролдож байна. Монголчууд бид ч гэсэн хөгжлийн шинэ замналаа хайж байна.²⁹ Үүний нэг тод илрэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаас харж болно. Тодруулбал, (1992 оны) Үндсэн хууль нь социалист чиг баримжаа, тоталитар дэглэмд хамаарах өмнөх 3 үндсэн хуулиас мөн чанарын ялгаатай өөр буюу **"ардчилсан"** маягийнх гэж үздэг. Энэ нь түүний гол гол үзэл баримтлалаар тодорхойлогдох³⁰ бөгөөд антропологийн судалгааны агуулга ч дээрхи байдлаас хөндийрөх учиргүй гэж үзэж байна. Иймд хууль зүйн антропологийн тухай ойлголтын агуулгад юу хамаарах эсэхийг үндэслэлтэй тодорхойлох хууль зүйн хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Өмнө дурдсанчлан хүн төрөлхтний түгээмэл (эрх зүйн) үнэт зүйлс үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусгагдан, монголчуудын төрт ёс, түүх соёлын үнэт зүйлс, эрх зүйн соёл ухамсартай хэрхэн нийцэж байгаа эсэх, түүнчлэн үндэсний эрх зүйн зохицуулалт нь амьдралын хэв маяг, уламжлал, үндэстний онцлог үнэт зүйлстэй уялдан тохирч байгаа эсэхийг хууль зүйн антропологийн судалгаагаар илрүүлэн гаргаж болно. Тодруулбал, Өнөөгийн монголын эрх зүйн зохицуулалт нь монголчуудын төрт

ёс, түүх соёлын үнэт зүйлстэй хэрхэн нийцэн уялдаж байна вэ?, монголчуудын эрх зүйн соёл, ухамсар, сэтгэлгээний уламжлалт хандлагад нийцүүлж чадсан уу?, даяаршил түүнийг илэрхийлсэн үнэт зүйлс болон монголчуудын түүх, соёлын онцлогийг илэрхийлсэн үнэт зүйлс хэрхэн зэрэгцэн оршиж байна вэ?, эсвэл ижилсэн, ондоошиж байна уу? монголчуудын түүх, уламжлалт соёлыг илэрхийлсэн үнэт зүйл, нийгэм аж байдлын онцлогтой хэрхэн уялдаж байгаа эсэх, энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд нөлөөлдөг үү? хүний эрх, эрх чөлөөний талаарх үндэсний эрх зүйн зохицуулалт монголчуудын түүх, уламжлалт соёлыг илэрхийлсэн үнэт зүйл, нийгэм аж байдлын онцлогтой хэрхэн уялдаж байгаа эсэх, энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг тодруулах зэрэг асуултуудад антропологийн тэр дундаа хууль зүйн антропологийн судалгаа хийснээр зохих хариулыг өгөх боломжтой гэж үзэж байна.

Эрх зүйн түүхчид архивын материалд тэмдэглэгдэн үлдсэн эртний үеийн хууль зүйн туршлагыг тодорхойлох, хянан засварлах зорилгоор эрх зүйн соёлын үзэл санааг ашигладаг.³¹ Монголчуудад эрх зүйн соёл, ухамсар хэрхэн хөгжиж, төлөвшсөнийг нүүдэллэн аж төрөх ёс, ахуй, соёлын хэв шинж, сэтгэлгээний тусгал болох эрх зүйн түүхэн эх сурвалжид төдийгүй монголчуудын (Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн БНМАУ-ын Бага Хурал, Ардын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл зэргээс) үзэл бодол, сэтгэлгээний байдал буюу нийгэм, соёлын онцлог байдалд үндэслэн хууль зүйн антропологийн

²⁹ [https:// www.mongolbank.mn /documents/tovhimol/group14/01.pdf](https://www.mongolbank.mn/documents/tovhimol/group14/01.pdf) (Сүүлд үзсэн огноо: 2022.02.09)

³⁰ Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлт, (1924–1992), Эмхэтгэл, УБ., 1998, 122 дахь тал

³¹ Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001, 181 дэх тал



судалгаа хийж болох юм. Жишээлбэл, академич С.Нарангэрэлийн Чингис хааны сүр хүч хэмээх бүтээлд “Энд ёс суртахуунаас хууль урган гардаг хэмээсэн их чухал санаа байна гэж үзэж болно” гээд хуулийн язгуур ёс суртахуун³² гэсэн дүгнэлтийг нийгэм, хүмүүнлэгийн ухааны үүднээс хийсэн байна.

V. Антропологийн судалгааны аргын тухай

Бусад нийгмийн ухаанаас антропологийн ялгарах гол ялгааны нэг бол судалгааны арга зүй байдаг. Антропологичид судлах гэж буй нийгэм, соёлдоо урт хугацаагаар амьдардаг байна. Ийнхүү соёлын орчинд амьдарч байхдаа тэдгээр хүмүүсийнхээ амьдралыг ажиглаж, амьдралд нь оролцдог. Энэ аргыг **оролцон ажиглах** (participant observation) гэх бөгөөд ажигласан, оролцсон бүхнээ тэмдэглэхийг угсаатны зүйн тэмдэглэл хөтлөх гэнэ. Энэ арга зүй энгийн үгээр хэлбэл судлаач судалж буй тухайн судлагдахууныхаа дунд хамгийн багадаа арван хоёр сар суурин сууж, хамт амьдран, тэр нийгэмд уусан орсны үндсэн дээр мэдээлэл цуглуулах юм. Яагаад заавал тийм урт хугацаагаар суух хэрэгтэй гэж, судалгааг анкет бэлтгээд, түүвэрлэлт хийгээд иргэдээр бөглүүлээд үр дүнг нь гаргаж болох биш үү гэж зарим хүн асуудаг. Антропологид хүний соёл амьдрал гэдэг зүйл ямар нэгэн “тойрог” (жишээ нь монгол соёлд бол хавар – цагаан сар, мал төллөх, сургууль төгсөх; зун – хүмүүсийн амрах улирал, намар – хичээлийн шинэ жил, ургац хураалт гээд өвөл бол дулаан хувцас, зулын хорин таван, ес эхлэх зэрэг байнга давтагдаж байдаг соёлын чухал үйл явдлууд байна) байдаг тул тэр тойргийг бүрэн таньж мэдэх, уг соёлын мөн чанарт

³² Нарангэрэл С., Чингис хааны сүр хүч, Уб., 2013, 226 дахь тал

нэвтрэхийн тулд их хугацаа хэрэгтэй гэж үздэг. Мөн уг соёлд анх очиж судлах хүн эхэн үедээ ямар нэгэн байдлаар “зочин” байж тухайн соёл түүнээс өөрийн бодит амьдралын хэвшлийг далдалж байдаг байна.³³

Харин энэ мэт удаан хугацаа зарцуулснаараа судлаач уг соёлын гүнд орж тэр соёлын “нэг хэсэг” болдог аж. Ийнхүү бий болсон мэдээлэл нь илүү үнэнд ойр байж, бусад өнгөц оюун дүгнэлтээс ялгардаг гэдгийг хэлэх хэрэгтэй болов уу. Хамгийн гол нь тухайн соёлд Таныг ирэхээс өмнө ямар байсан яг тэр хэвээр нь тухайн соёлыг үлдээх ёстой. Түүнээс бус “та нарын энэ болохгүй байна, үүнийгээ ингэ, тэг” гэх мэтээр өөрийн юм уу бусад хүний санаа бодлыг тухайн соёлд суулгах гэж оролдох нь судалгааны ёс зүйгүй хэрэг юм. Антропологич хүн судалж буй соёлдоо өөрийнхөө соёлын нөлөөг тусгаж, хувирган өөрчилж болохгүй гэсэн ёс зүйг чанд мөрдөх хэрэгтэй байдаг. Ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн судалгааг хүлээн зөвшөөрөхгүй байх журамтай бөгөөд асуудал бүр хүндэрвэл судалгаа хийхийг нь ч хориглож болох юм.³⁴

Антропологийн үндсэн судалгааны арга нь сонгон авсан аль нэгэн газар орон болон бүлэг хүмүүсийн дунд тодорхой хугацаагаар сууж тухайн хүмүүсийн өдөр тутмын аж амьдралд оролцож, ажиглах болон энгийн байдлаар ярилцаж хээрийн буюу байршлын судалгааны ажил хийдэг

³³ Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021, 16 дахь тал

³⁴ Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021, 16 дахь тал



бөгөөд үүнийг этнографийн (**угсаатны зүйн**) судалгаа гэдэг. Этнографи гэдэг нь соёлын антропологи хэмээх салбар ухааны үндсэн судалгааны арга зүй бөгөөд судлах бүс нутгийн талаар бодит ойлголтыг чухалчилдаг судалгаа юм. Сүүлийн үед этнографи нь нийгмийн ухаан, сэтгэл судлал, менежмент зэрэг олон салбар ухаанд хэрэглэгдэх болсон байна.³⁵ Хууль зүйн антропологийн хээрийн судалгаанд ч мөн адил энэхүү судалгааны арга гол үүрэг гүйцэтгэдэг. Хууль зүйн антропологийн хээрийн судалгааны үндсэн судалгааны арга нь чанарын судалгааны арга буюу антропологийн оролцон ажиглах (**participant observation**) арга байна.³⁶ Мөн судалгааны бусад аргыг судалгаандаа өргөн ашиглана.

Иймд эрх зүйн сэтгэлгээний хөгжлийг судлахад юуны өмнө археологийн судалгааны үр дүн, эд өлгийн болон бичгийн эх сурвалжуудыг нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан судалж дүгнэлт хийх нь гарцаагүй. Түүнчлэн монголын эрх зүйн түүхэн эх сурвалжийг түүх, хэл шинжлэлийн ухааны аргад шинжлэх ухааны техник, технологийн дэвшлийг ашиглан судлах явдал түгээмэл болж сурвалж судлалын арга, арга зүйг оновчтой сонгох явдал нь өнгөрсөн цаг үеийн үйл явцыг хэл зүйн хувьд үндэслэлтэй тайлбарлах, тодруулах, тэрхүү судалгаанд үндэслэн эрх зүйн онол, арга зүйд тулгуурлан эрх зүйн сэтгэлгээний хэв шинжийг тодруулахаас

гадна энэ нь археологи, антропологи, этнографийн судалгаанд ч ач холбогдолтой байна³⁷.

VI. Антропологийг төрөлжүүлэх нь

Хууль зүйн салбарт антропологийг салбар эрх зүй бүрээр төрөлжүүлэн хөгжүүлж болно. Жишээ нь биологийн антропологийн чиглэл буюу эрүүгийн эрх зүйн антропологийн сургаал зэргийг дурдаж болох юм. Академич С.Нарангэрэлийн Эрх зүйн эх толь бичигт “*Эрүүгийн эрх зүйн антропологийн сургаал* (англ. *Anthropological school of criminal law*; ор. *Антропологическая школа уголовного права*) – эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны номлолын нэгэн үндсэн чиглэл. 1870–аад онд Италид үүссэн. Үндэслэгч нь италийн сэтгэц гэм судлаач – эмч Чезаре Ломброзо (1835 – 1909). Эрүүгийн эрх зүйн антропологийн сургаалын гол сэдэв нь гэмт явдал нийгэмшлийн биш харин цэвэр биологийн үзэгдэл учраас гэмт хэрэгтнийг антропологийн үүднээс судлах зайлшгүй шаардлагатай хэмээн үздэг. Энэ сургаалыг баримтлагчдын үзэж байгаагаар гэмт хэрэгтэн – гадаад хэвшмэл онцлог чанар бүхий биологийн өвөрмөц хэв шинж. Зарим хүмүүс гэмт хэрэгтэн болж төрдөг учраас тэднийг засан хүмүүжүүлэх ямар ч боломжгүй. Эрүүгийн эрх зүйн сонгодог сургаалын үндсэн зарчмыг үгүйсгэхдээ эрүүгийн эрх зүйн антропологийн сургаал нь эрүүгийн шүүхийг “гэмт хүн” субъектийн алив нэгэн төрөлх шинжийг тодорхойлох ба түүнд хэрэглэх шаардлагатай аюулгүй байдлын арга хэмжээний тухай асуудлыг шийдвэрлэх засаг захиргаа – эмнэлгийн байгууллагаар сольж өөрчлөх ёстой

³⁵ Сосорбурам А., Кишимото Саяака, Хөгжил, малчин ахуй, ирээдүй: Инженерүүдэд зориулсан этнографи, Уб., 2014, 8 дахь тал

³⁶ Номынбаясгалан С., Баатарцогт Б., Мөнх – Эрдэнэ Г., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа хийх судлаачдад зориулсан гарын авлага), Уб., 2021, 26 дахь тал

³⁷ Баярсайхан Б., Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа, Уб., 2021, 365 дахь тал



хэмээн үздэг” гэж тэмдэглэсэн байна³⁸.

VII. Дүгнэлт, санал

Дээрхи нэр томьёо нь гадаад хэлнээс монгол хэлэнд агуулгын хувьд зөрүүтэйгээр орчуулагдах боломжтой. Монголын эрх зүйн толь бичигт ***эрх зүйн антропологи буюу хууль зүйн антропологи** гэсэн хэллэгээр бичигдсэн байна. Энгийнээр уг нэр томьёо нь **“хуулийн хүн судлал”** гэсэн утга санааг илэрхийлдэг хэдий ч монгол хэлэнд хэрхэн оновчтой буулгах вэ гэсэн асуулт мэргэжлийн үүднээс хариултаа хүлээсээр өнөөг хүрсэн байна. Мэргэжлийн гэлтгүй мэргэжлийн бус хүмүүс хуулийн антропологи, хуулийн хүн судлал гэж танин мэдэхүйн хувьд нэрлэн хэрэглэх нь бий. Харин шинжлэх ухааны үүднээс авч үзвэл **“хуулийн антропологи”** гэж оноон нэрлэхээс илүүтэй **“эрх зүйн антропологи”**, эсвэл **“хууль зүйн антропологи”** гэсэн нэр томьёонд хэвшүүлэн хэрэглэх нь зүйтэй болов уу гэж үзэж байна. Учир нь хууль гэдгийг энгийнээр цагаан дээр хараар буулгасан буюу бичмэл зүйлээр л хязгаарлагддаг бол харин эрх зүй нь дан ганцхан бичмэл зүйлээр хязгаарлагдахгүй илүү өргөн хүрээний ойлголт болно. Энэ асуудлын зангилаа нь **“эрх зүйн антропологи буюу хууль зүйн антропологи хэмээх ойлголтуудыг хэрхэн ялган ойлгох вэ, агуулгыг нь хэрхэн тодорхойлох вэ гэдэгт байна”** гэж үзэн түүнд ач холбогдол өгч эргэцүүлж болохоор байна. Энэ үндсэн дээр эрх зүйн антропологи буюу хууль зүйн антропологи гэсэн нэр томьёог эрх зүйн зохицуулалтаас цааш өргөн утгаар нь хэрэглэх үед **“Anthropology of Law”** гэсэн агуулгаар нь ойлгох нь зүйтэй болов уу, харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд явцуу

утгаар хэрэглэх тохиолдолд **“Legal Anthropology”** гэж ялган зааглаж, уг нэр томьёоны агуулгын багтаамжаас // хэрэглэж байгаа хүрээнээс нь хамааран ийнхүү тодорхойлж болох юм.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсад өнөөг хүртэл хууль зүйн антропологийн үүднээс аливаа асуудлыг судалж үзсэн судалгаа хэвлэгдээгүй байна. Энэ нь **“Антропологийн салбар ухаан нь хууль зүйн шинжлэх ухаанд ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ”** гэсэн асуулт хариултаа хүлээсээр байгааг харуулж байна. Энэхүү салбар ухааны онол, арга зүйн үүднээс үндэсний эрх зүйн зохицуулалтыг судлах нь хууль зүйн антропологийг Монгол Улсад хөгжүүлэх нэн таатай боломж болох юм. Иймд антропологийн судалгааг эрүүгийн эрх зүй, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй зэргээр төрөлжүүлэн хийж болохоор байна. Ийнхүү антропологийн судалгааг хийхэд анхаарах цөөнгүй зүйлс байна. Үүнд: Антропологийн судалгааны үндсэн судалгааны арга нь чанарын судалгааны арга буюу оролцон ажиглах (**participant observation**) арга боловч хууль зүйн судалгаанд хэрэглэдэг бусад аргыг орхигдуулан ач холбогдлыг нь бууруулж болохгүй. Иймээс салбар дундын судалгааны онцлог байдлыг харгалзан дээрх аргуудыг уялдуулах нь нэн тэргүүний судалгааны арга зүйн тулгамдсан асуудал болж байна.

³⁸ Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, Гурав дахь хэвлэл, УБ., 2011, 409 дэх тал



НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж:

Нарангэрэл С., Эрх зүйн эх толь бичиг, (II, III хэвлэл), УБ., 2008, 2011

Нарангэрэл С., Хуулийн амин сүнс буюу Чингис хаан, монголчууд, 2018

Нарангэрэл С., Чингис хааны сүр хүч, УБ., 2013

Нарангэрэл С., Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, (Харьцуулсан эрх зүй), УБ., 2001

Нарангэрэл С., Хуулийн амин сүнсийн эрэлхийлэл, (Чингис хааны гэрээс), УБ., 2016

Баярсайхан Б., Монголын эрх зүйн түүх, соёлын судалгаа, (Илтгэл, өгүүлэл), УБ., 2021

Номынбаясгалан С., Мөнх-Эрдэнэ Г., Баатарцогт Б., Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа, (Хууль зүйн антропологийн судалгаа

хийх судлаачдад зориулсан гарын авлага), УБ., 2021

Номынбаясгалан С., Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд диспозитив зарчмыг хязгаарлах нь, магистрын дипломын ажил, УБ., 2017

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн БНМАУ-ын Бага Хурал, Ардын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл, (1991-1992), УБ., 2017, цахим ном

II. Гадаад эх сурвалж:

Fernanda Pirie., The Anthropology of Law, Oxford university press, 2013

James M. Donovan, Legal Anthropology: An introduction, printed in the United States of America, AltaMira, 2008

Norbert Rouland, Legal Anthropology, (Translated by Philippe G. Planel), The Athlone Press, London, 1994



Abstract

LEGAL TERMINOLOGICAL ISSUES

(In anthropology)

S.NOMYNBAYASGALAN

Master of Laws (LL.M),

Ph.D. candidate, National University of Mongolia

The article is named as the “Legal terminological issues (In anthropology)” and its content is conducted within legal issues on the translation of terminology.

Keywords

Anthropology, anthropological research, legal anthropology, law of anthropology, mongolian legal thoughts, legal culture, legal custom, participant observation, translation, legal language, legal terminology.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ЗААВАЛ БИЕЛЭГДЭХ ЗАРЧМЫН ДЕТЕРМИНИЗМИЙН АСУУДАЛ

THE ISSUE OF DETERMINISM PRINCIPLE OF BINDING THE JUDICIAL DECISIONS

Төмөрбаатарын БАДРАХ¹

- I. Удиртгал
- II. Нэр томьёо ба хуулийн зохицуулалт
- III. Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хэрэгжилтийн өнөөгийн байдал
- IV. Гадаад улсын жишиг
- V. Шаардлагатай шинэ зохицуулалтыг хүлээн авах онолын үндэслэл
- VI. Дүгнэлт
- VII. Ном зүй

¹ Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн магистр



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ЗААВАЛ БИЕЛЭГДЭХ ЗАРЧМЫН ДЕТЕРМИНИЗМИЙН АСУУДАЛ

*Т.БАДРАХ. Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны
шүүхийн шүүгч, Хууль зүйн магистр*

Товчлол

Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хүрээнд урьд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг эрх ашиг нь хөндөгдөж буй тохиолдолд өмнөх хэргийн оролцогч биш байсан эсэхээс үл хамааран дараагийн маргаанд шүүхээс нэгэнт нотлогдсон гэж үзэх шаардлага, түүнчлэн гэрээний стандарт нөхцөл хүчингүй болсон нь тухайн хэргээр хязгаарлагдахгүйгээр өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай болохыг онолын болон практик хууль хэрэглээний хүрээнд авч үзсэн судалгааны ажил.

Түлхүүр үгс: Шийдвэр биелүүлэх, гэрээний стандарт нөхцөл, эрх зүйн зайлшгүй процесс, хууль зүйн детерминизм, процессын зарчим, хууль зүйн техник, хэрэглэгчийн эрх зүй.

1. Удиртгал

Шүүх эрх мэдлийн нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдал нь шүүхээс гарч буй шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байхаас гадна заавал биелэгдэх легитим шинжтэйд оршино. Хэрэв шүүхээс гарч буй шийдвэр биелэгдэхгүй тохиолдолд нийгэм, олон нийтийн дунд шүүхийн нэр хүнд, итгэх итгэл алдарна. Иргэд, олон нийтийн итгэлийг алдсан шүүхийг judicial power/шүүх эрх мэдэл гэж үзэх боломжгүй билээ.

Иймд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим хэрхэн хангагдаж байгааг одоо үйлчилж буй хуулийн зохицуулалт, шүүхийн практикт тулгуурлан дүн шинжилгээ хийх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Зорилгодоо хүрэхийн тулд одоо мөрдөгдөж буй хуулийн орчин, шүүхийн практик, гадаад улсын туршлагыг судлах зорилтуудыг тавьсан болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд гарсан судалгааны бүтээлд “Шүүх шийдвэр заавал биелэгдэх зарчим”-ын хууль хэрэглээний асуудлыг зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх хүрээнд авч үзэж ирсэн. Мөн урьд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг дахин нотлохгүй гэх хуулийн зохицуулалт нь Монгол Улсын эрх зүйн номлол, шүүхийн практикт хэвшмэл болсон боловч энэ нь зөвхөн тухайн хэргийн оролцогч нарт хамааралтай буюу явцуу хүрээнд хэрэглэгддэг билээ.

“Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх” гэх ойлголтыг Монгол Улсын хууль зүйн судалгааны эргэлтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн үүднээс голчлон авч үздэг байсныг өөрчилж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд судалж байгаад



судалгааны шинэлэг тал оршино. Үүнтэй холбогдуулаад а/ гэрээний стандарт нөхцөлийг хүчингүй болгох тохиолдолд тухайн маргааны хүрээгээр хязгаарлахгүй байх ёстой, б/ шүүхийн шийдвэрээр нэгэнт тогтоосон үйл баримтыг эрх ашиг нь хөндөгдөж буй бүхий л этгээдэд хамааралтай байдлаар авч үзэх гэсэн 2 нөхцөлийг судлах замаар шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хууль хэрэглээг өргөтгөх ач холбогдлыг мөн агуулж байгаа болно.

2. Нэр томьёо ба хуулийн зохицуулалт.

“Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх” гэх ойлголтыг ихэвчлэн Enforcement of judgments¹ буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн хүрээнд авч үздэг олон улсын хандлага байдаг нь манай улсын хувьд ч адил билээ. Мөн нэр томьёоны хувьд Binding principle of Court Decisions гэсэн ойлголт байдаг боловч энэ нь шүүхийн прецедентийн хүрээнд дээд шатны шүүхийн шийдвэр, тогтоосон жишгийг доод шатны шүүхүүд заавал дагаж биелүүлнэ гэдэг утгыг илэрхийлдэг².

Манай улсын хувьд 2002 онд батлагдсан ИХШХШТХ-ийн 11.1-д “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ” гэдэг утгаар дээрх зохицуулалтыг хуульчилсан нь Enforcement of judgments буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйд хамаарах ойлголт болсон байна. Үүнтэй ижил зохицуулалтыг ОХУ-ын Иргэний процессын хуулийн 13.2-т “Шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг төрийн эрх мэдлийн бүх байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгжүүд,

олон нийтийн холбоо, аливаа албан тушаалтан, иргэн, байгууллага заавал биелүүлнэ”³ гэж хуульчилсан байдаг.

Харин ОХУ-ын Иргэний процессын хуулийн 13.4-т “Шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх шинж чанар нь тухайн хэрэгт оролцоогүй сонирхогч этгээдийн шүүхэд хандах эрхийг хязгаарлахгүй”⁴ гэж хуульчилж өгснөөр Обязательность судебных постановлений буюу шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх шинж чанар гэх ойлголт нь зөвхөн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд биш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамаарах болохыг илэрхийлсэн байна. ИХШХШТХ-ийн 40.4-т “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй” гэж тусгасан нь дээрх шүүхийн шийдвэрийн заавал биелэгдэх шинж чанарыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас ангид байдлаар иргэний процессын хүрээнд тусгайлан авч үзсэн гэж үзэх үндэстэй. Мөн зарим судлаачид шийдвэр гүйцэтгэх ажиллагааг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг гэж үздэг⁵.

Анхаарах нэгэн асуудал бол Монгол улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дагаж мөрдөх зарчмыг дийлэнх тохиолдолд:

- талуудын бүрэн эрхийн /диспозитив, мэтгэлцэх/,
- шүүхэд мэдүүлэх эрхийн,
- хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударгаар явуулах,
- шүүх хуралдааныг нээлттэй

¹ <https://thelawdictionary.org/enforce/>. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

² <https://cgc.law.stanford.edu/commentaries>. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

³ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

⁴ Мөн тэнд.

⁵ Ц.Амарсайхан нар, Процессын эрх зүй, УБ, 2014 он, 269 дэх тал.



- явуулах,
- шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх,
- шүүх хуралдааныг тасралтгүй явуулах,
- шүүх хуралдааныг амаар явуулах,
- хууль ёсны шүүх, шүүгчээр хэрэгээ шийдвэрлүүлэх,
- шүүхэд чөлөөтэй хандах эрхийн гэж ангилдаг.⁶

Эндээс ИХШХШТХ-ийн 11.1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэр заавал биелэгдэх гэх зохицуулалт нь зарчим уу, эсхүл тодорхой харилцааг /шүүхээс гарсан шийдвэрийг гүйцэтгэх/ зохицуулсан хэм хэмжээ юу гэдэг анхаарал татна. Хэрэв өмнө дурдсанчлан уг зохицуулалтыг зөвхөн шийдвэр гүйцэтгэх гэдэг утгаар биш иргэний процессын бүх үе шатанд дагаж мөрдөх ёстой гэдэг байр суурийг онцолбол зарчмын хүрээнд авч үзэхээс өөр аргагүй. 2014 онд Монгол Улсын Дээд шүүхээс гаргасан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”⁷ болон 2021 онд судлаач Б.Буянхишигийн зүгээс “шүүхийн шийдвэр заавал биелэгдэх” гэх ойлголтыг зарчмын хүрээнд⁸ авч үзсэн нь ИХШХШТХ-ийн Нэгдүгээр бүлгийн Нийтлэг үндэслэлийн зохицуулалттай нийцэж байна.

Ерөнхий суурь зарчмын хувьд шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд үйлчлэх ёстой билээ.

⁶ Й.Кают, Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2015 он, 17-29 дэх тал.

⁷ Монгол Улсын Дээд Шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ, 2014 он, 54-55 дахь тал.

⁸ Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2021 он, 20 дахь тал.

Чухамхүү уг зарчмыг детерминизмийн үүднээс авч үзэх шаардлагын үндэслэлийн тухайд бол детерминизм нь бүх үйл явдал, үзэгдэл, түүний дотор ёс суртахуун, хууль эрхийн бодол санаа, үйл ажиллагаа, шийдвэрийг урьд бүрдсэн нөхцөл шалтгаанд үндэслэж тодорхойлдог философийн сургаал юм⁹. Харин legal determinism/хууль зүйн детерминизм нь Аристотель, эртний Стоикуудын үзэл баримтлалаас улбаалсан онтологи суурьтай эрх зүйн номлол бөгөөд өмнөх үеийн үзэл баримтлал, туршлага, өөрчлөлтүүд нь одоо буй хууль, эрх зүйн тогтолцоонд зайлшгүй хадгалагдах ёстой гэж үздэг консерватив байр суурийг илэрхийлдэг¹⁰.

Одоо шүүхийн практикт тулгамдсан гэж судлаачийн үзэж буй шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмыг хэрэгжүүлэхэд урьд тогтсон шүүхийн практик, хуулийн зүйлчлэлийн асуудал зайлшгүй хөндөгдөх тул детерминизмийн арга зүйн хүрээнд судалгаа явуулах нь оновчтой гэж үзэв.

3. Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хэрэгжилтийн өнөөгийн байдал.

ИХШХШТХ-ийн 11.1, 40.4 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын зохицуулалтыг иргэний процесс, шүүхийн практикт хэрэгжүүлж байгаа байдал хангалтгүй, үүнээс шалтгаалж иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал дутмаг гэж үзэж судлаачийн зүгээс үзэхдээ дараах судалгааны үр дүнд үндэслэв.

А. М.Мөнхнаран “Хэрэглэгчийн гэрээний эрх зүйн зохицуулалт ба хэрэглэгч гэрээг уншилгүйгээр гарын үсэг

⁹ <https://bletoncouncil.org/determinismo-filosofico-12857>. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

¹⁰ Maciej Chmieliński, The Philosophy of Legal Change, 2019, p19.



зурах явдал”¹¹ сэдэвт 2015 оны нийтлэлд авагдсанаар: Судалгаанд хамрагдсан 124 хэрэглэгчийн 79% нь гэрээний стандарт нөхцөлийг уншилгүйгээр гарын үсэг зурдаг бол эдгээр хэрэглэгчдийн 48%-д нь үүнээс болж тодорхой хэмжээгээр хохирол учирсан. Хохирол учирсан хэрэглэгчдийн ердөө 4% нь энэ асуудлаар холбогдох хуулийн байгууллагад хандсан байна.

Б. Шүүхийн шийдвэр гарахдаа маргааны гэм буруутай үйл баримт болсон эсэх, хохирлыг хэрхэн барагдуулах асуудлыг шийдвэрлэх бөгөөд хуулийн хүчин төгөлдөр болсноор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т заасан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй гэх зохицуулалтын үр дагаврыг үүсгэдэг.

Шүүхийн практикийн жишээг авч үзвэл,

- Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 187 дугаар шийдвэрээр даатгалын нөхөн төлбөрийн маргааныг шийдвэрлэхдээ 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдөр байгуулагдсан “Орон сууц, зээлийн тасалдлын даатгалын гэрээ”-ний 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт даатгуулагч даатгалын гэрээ байгуулахаас өмнө архаг хууч өвчтэй байсан, тухайн өвчний улмаас эмчлэгдэж байсан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд даатгалд хамрагдахгүй нөхцөл болно гэж заасан нь үүргээс өргөн хүрээтэйгээр

өөрийн байр сууринаас тайлбарлах замаар татгалзах эрхийг “МД” ХК-д олгосон, даатгуулагчийн ашиг сонирхлыг зөрчсөн, гэрээ байгуулсан хүсэлт зоригт нь үл нийцэж байх тул Иргэний хуулийн 202 дугаар зүйлийн 202.2.4 дэх хэсэгт зааснаар хүчин төгөлдөр бусад тооцож, улмаар зохих нөхөн төлбөрийг гаргуулж шийдвэрлэсэн.

Дээрх шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 388 дугаар шийдвэрээр “МЖД” ХК-нд мөн л гэрээний стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус гэх үндэслэлээр даатгагчаас нөхөн төлбөрийг гаргуулж шийдвэрлэсэн байна¹².

В. 2011 онд ШӨХТГ-ын зүгээс банкуудын иргэдийн болон ипотекийн зээлд авч буй шимтгэл, хураамж нь Иргэний хуулийг зөрчсөн хууль бус үйлдэл гэж үзсэн. Хууль зөрчсөн эсэхийг Захиргааны шүүхээр хэлэлцсэн ба давж заалдах шатанд банкууд ийм шимтгэл хураамж төлөх эрхтэй гэсэн шүүхийн шийдвэр гарсан¹³. Энэхүү банкуудын зээл олгохдоо авч буй шимтгэл, хураамж гэх төлбөрийг давхардуулж авдаг, шимтгэлийг бодит зардалтай уялдуулаагүй буюу өндрөөр тооцдог гэсэн маргаан юм. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын зүгээс “... банкуудын зээл олгохдоо авч буй шимтгэл, хураамж гэх төлбөрийг давхардуулж авдаг, шимтгэлийг бодит зардалтай уялдуулаагүй буюу өндрөөр тооцдог, эдгээр шимтгэл, хураамжийн талаар төөрөгдүүлсэн мэдээллийг харилцагч нартаа өгдөг” гэх зөрчлийг тогтоон нэр бүхий 9 банканд улсын байцаагчийн дүгнэлт, “...өөрийн банкны зээлийн үйлчилгээний шимтгэл, хураамжийн талаар мэдээллийг зээлдэгчдэд бүрэн,

¹¹ М.Мөнхнаран, Хэрэглэгчийн гэрээний эрх зүйн зохицуулалт ба хэрэглэгч гэрээг уншилгүйгээр гарын үсэг зурах явдал, <https://legaldata.mn/b/1038> [Сүүлд үзсэн: 2022.02.28]

¹² https://shuukh.mn/single_case/49217. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

¹³ <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy> [Сүүлд үзсэн: 2022.02.28]



үнэн зөв өгч байх, зээлийн шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй байх, зээл олгосны шимтгэлийг гарч буй зардалтай уялдуулан үндэслэлтэй тогтоох” албан шаардлага хүргүүлснийг илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлагыг нэр бүхий 9 банк шүүхэд гаргаж, шүүх ШӨХТГ-ын улсын байцаагчийн “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагууд, “Хяналт шалгалтын тухай” дүгнэлтүүдийг хүчингүй болгосон байдаг. Энэ тохиолдолд шимтгэл авах нь зөв эсэх талаар бус, шимтгэлийг хэрхэн авах талаар маргаж буй нь зохицуулалт тодорхой бус байгааг харуулдаг. Маргааны гол агуулга нь зээлийн шимтгэл буюу гэрээ байгуулах зардлыг хэн хариуцах талаар болон зээлийн шимтгэлийн хэмжээ үндэслэлгүй байгаа талаар юм¹⁴.

Хэдийгээр Захиргааны шүүхийн журмаар дээрх нэхэмжлэл хэрэгсэхгүй болсон боловч судлаач Д.Энхзулын зүгээс энэ асуудлаар “Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмын зээлийн шимтгэлтэй холбогдох хэсэг нь эрх зүйн хэм хэмжээний акт нь хуульднийцсэнбайхшаардлагыгхангаагүй ба арилжааны банк энэхүү журмыг үндэслэн хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагааг хариу төлбөртэйгөөр эрхэлж зээлдэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчиж байна. Манай улсын Иргэний хуулийн 202 дугаар зүйлийн 202.1, 200 дугаар зүйлийн 200.1 дэх хэсэгт заасны дагуу хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон нөхцөл нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус

¹⁴ Хансс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, “Арилжаа /худалдаа/-ны хуулийн хэрэглээ, шаардлагыг урьдчилан тандах судлах судалгааны тайлан”, УБ, 2019 он.

байхаар байна. Тиймээс зээлийн шимтгэл авах тухай гэрээний заалт нь хуулиар тодорхойлоогүй буюу хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон нөхцөлд агуулгын шалгалт хийх нөхцөлд хамаарах юм. Банк зээлийн шимтгэлийн талаарх стандарт нөхцөлөөрөө хуулиар тодорхойлоогүй журмыг тогтоосон тул энэ нь агуулгын шалгалтад хамрагдах нөхцөл гэж үзэж байна.”¹⁵ байр суурийг илэрхийлсэн байдаг.

Г. Гэрээний стандарт нөхцөл ихээр хэрэглэгддэг арилжааны явцад хэрэглэгчдэд хохирол учирч байсан эсэх, хэрэв хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага хэмжээний хохирол учирсан бол тухайн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлж байсан эсэх, мөн ямар төрлийн үйлчилгээний улмаас хэрэглэгчдийн ихэнх хэсэг хохирдог талаарх асуулыг 2021 оны 3 дугаар улиралд Улаанбаатар хот болон орон нутагт түүврийн аргаар 93 хэрэглэгчээс авахад:

- Нийт судалгаанд оролцогчийн 70.6% нь бараа, үйлчилгээ худалдан авах явцдаа аливаа байдлаар хохирол хүлээж байсан боловч тухайн хохирол нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага байсан тохиолдолд шүүхэд огт хандаж байгаагүй гэжээ. Хэрэв эрх бүхий байгууллага шүүхэд хандан хохирол барагдуулсан тохиолдолд шүүхэд хандахгүйгээр уг байгууллагад хандаж хохирлоо барагдуулах зохицуулалтыг сонирхож байгаа болохоо судалгаанд оролцогчдын 83.4% илэрхийлсэн байна.

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага хэмжээний хохирол учирсан тохиолдолд ямар шалтгааны улмаас шүүхэд хандахгүйгээр хохирсон хэвээр үлддэг болохыг судалбал:

¹⁵ <http://elbpartners.mn/post/57185>. [Сүүлд үзсэн:2022.02.28]



Энэхүү судалгааны үр дүнгээс нийт зах зээлийг хамарсан үйлчилгээ явуулдаг аж ахуй нэгжүүдэд холбогдуулан бага үнийн дүнтэй хохирлын талаарх маргааныг хэрэглэгчид өрнүүлдэггүй шалтгаан нь хэдийгээр өөрсдийн хохирч байгааг мэдэж байгаа боловч одоо байгаа хуулийн хүрээнд маргааныг шийдвэрлэхэд цаг хугацаа их шаардагдахаас шалтгаалжээ¹⁶.

Дээрх судалгааны ажлуудын үр дүнгээр гэрээний стандарт нөхцөл, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанаас болж иргэд хохирох асуудал түгээмэл болох нь харагдаж байна. Мөн гэрээний стандарт нөхцөлөөс болж иргэд хохирч байгаа тохиолдолд зөвхөн дангаар нэхэмжлэлийн шаардлага гаргах замаар эрхээ шүүхээр хамгаалуулж байгаа боловч энэ нь зөвхөн тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд холбогдох гэрээний заалт хүчингүй болж, нийт хэрэглэгчдэд хандан тавьж буй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрээний стандарт нөхцөл хэвээр үлдэж байгаа нь due process-ийн зөрчил юм. Түүнчлэн гэрээний стандарт нөхцөл, хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээнээс хамаарсан маргааныг шүүх шийдвэрлэсэн бол эрх ашиг нь хөндөгдөж буй сонирхогч этгээдийн зүгээс гэм бурууг тогтоосон шүүхийн шийдвэрт үндэслэн маргах боломж байгаа нь судалгааны үр дүнгээр илэрч байна.

¹⁶ Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021, №4 .

4. Гадаад улсын жишиг.

2021 оны 4 дүгээр сард Германы холбооны Дээд шүүхийн шийдвэрээр Германы арилжааны банкуудын 2 сарын өмнө нийт хэрэглэгчдэд урьдчилж мэдэгдэх замаар гэрээний нөхцөлийг нэг талын санаачилгаар өөрчлөх эрхийг хүчингүй болгосон. Энэ шийдвэр нь банкны гэрээнд шударга бус замаар өөрчлөлт оруулсан гэж Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагаас гаргасан гомдлын хүрээнд гарсан юм¹⁷.

Герман улсын шүүхийн шийдвэрийн үйлчлэл нь дараах үр дагавар үзүүлж болохыг харуулж байна. Үүнд:

1/ Арилжаа эрхлэх явцдаа хэрэглэгчид хохирол учруулсан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн гэм бурууг урьдчилж тогтоосон шийдвэрийг шүүх гаргадаг. Ийнхүү гаргасан шийдвэрт үндэслэж хэрэглэгчид өөрт учирсан хохирлоо дахин шүүхэд хандан шийдвэрлүүлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т заасан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй гэх зохицуулалттай нийцэх юм. Гэхдээ хариуцагч байгууллагын үйл ажиллагаанаас болж хохирсон этгээд өөрийн оролцоогүй үйл баримтад үндэслэн дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд нэхэмжлэлээ шийдвэрлүүлэх

¹⁷ [https:// www.dentons.com /en /insights/ articles/2021](https://www.dentons.com/en/insights/articles/2021) [Сүүлд үзсэн:2022.02.28]



боломж шүүхийн практикт байхгүй билээ.

2/ Гэрээний стандарт нөхцөл хуульд нийцэж буй эсэхийг сонирхогч бүлэг, этгээдийн хүсэлтээр шүүх хянах. Өмнөх хэсэгт жишээ болгон авсан банкны зээлийн шимтгэл, даатгалын гэрээний нөхцөл хүчин төгөлдөр бус байх тохиолдол нь тухайн маргааны хүрээнд шийдвэрлэгдээд дуусгавар болдог бол Герман улсын хувьд тухайн аж ахуй хэрэглэгчийн ашиглаж байсан гэрээний стандарт нөхцөл цаашид нийт хэрэглэгчдийг хамарсан хэмжээнд хүчин төгөлдөр бус болох ёстой.

Монгол Улсын эрх зүйн орчинд хэрэглэгчийн эрх ашгийг хамгийн ихээр хөнддөг гэрээний стандарт нөхцөл нь зөвхөн тухайн хэрэг маргааны хүрээнд хүчин төгөлдөр бус болдог нь хууль зүйн техникийн хувьд эргэлзээ үүсгэж байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120, 183 дугаар зүйлд зааснаар хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр заавал биелэгдэх шинжийг агуулдаг. Тийм байтал нэгэнт шүүхийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийн нийт хэрэглэгчид санал болгодог гэрээний стандарт нөхцөлийг хүчин төгөлдөр бусад тооцсон шийдвэр гаргасан нь зөвхөн тухайн маргааны хүрээнд үйлчилж, харин шүүхээс хүчин төгөлдөр бус гэж үзсэн гэрээг хэрэглэж буй бусад иргэд дахин шүүхэд хандахгүй бол хохирсон хэвээр үлдэж байна.

Өөрөөр хэлбэл, гэрээний стандарт нөхцөлийг шүүхээс хүчингүй болгосон тохиолдолд тухайн гэрээг байгуулсан бүх хүнд хамааралтай байдлаар авч үзэх шаардлага, шүүхийн зүгээс хариуцагчийн гэм бурууг тогтоосон тохиолдолд тухайн маргааны нэхэмжлэгчээр оролцоогүй ч дараагийн маргаанд нэхэмжлэгчээр оролцох тохиолдолд өмнөх гэм буруу

тогтоосон шүүхийн шийдвэрийг нэгэнт нотлогдсон гэж үзэх нөхцөлийг шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим бүрдүүлэх боломжтой байна.

5. Шаардлагатай шинэ зохицуулалтыг хүлээн авах онолын үндэслэл.

Legal transplant хэмээх ухагдахуун нь тодорхой эрх зүйн хэм хэмжээ, эсвэл институтийг аль нэг эрх зүйн тогтолцооноос нөгөөд шилжүүлэх үйл явцыг илтгэдэг¹⁸. Энэ рецепцийн үр нөлөөг судлах онолын хүрээнд Герман улсын жишигтэй харьцуулсан байдлаар шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хэрэгжилтийг хангахтай холбоотой асуудлыг хүлээн авах асуудлыг судалж үзвэл:

А. АНУ-ын Үндсэн хуулийн тав дахь нэмэлт өөрчлөлтөд “due process” буюу “эрх зүйн зайлшгүй процесс”-ыг заасан. Ингэснээр “шударга ёс” гэх ойлголтыг тунхаглалаас илүүтэйгээр процедурын хувьд бэхжүүлж, шүүхийн шийдвэр нь урьдчилан тогтоосон журмын хүрээнд шударгаар үйлчлэх үйл ажиллагааг хуульчилж өгсөн. Түүхийн хувьд уг заалт нь Их Британийн Магна Картад зааснаар буюу XIII зуунд хаан Жон язгууртнуудад хандан зөвхөн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах, бүгд хуулийг дагаж мөрдөх ёстой гэж амласнаар үүссэн билээ. Энэхүү үйл ажиллагаагаа хууль ёсонд захируулах амлалт нь бүхий л дэвшилтэт хууль эрх зүйн тогтолцооны гол цөм байдаг бөгөөд шүүхийн шийдвэр гаргах тухай ажиллагаа нь энэхүү амлалтыг биелүүлэхэд чиглэгдсэн юм¹⁹.

Үүнээс үзэхэд төрийн зүгээс иргэнд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, дагаж

¹⁸ Б.Буянхишиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ, 2021 он, 61 дэх тал.

¹⁹ https://www.law.cornell.edu/wex/due_process [Сүүлд үзсэн: 2022.02.28]



мөрдүүлж байгаа хэм хэмжээндээ шударга ёсыг баримтлах ёстой. УИХ, Засгийн газраас батлагдаж буй хууль, хэм хэмжээний актыг туйлын шударга хэм хэмжээ гэж үзэхэд үргэлж хангалттай байдаггүй учир иргэд төрийн үйл ажиллагаа явуулж буй хууль тогтоомжид тусгагдсан эсэхээс үл хамааран шударга ёс, журмыг шаардах эрхтэй байх нь "due process" билээ. Иймд шүүхийн аливаа маргаан эхлэхэд процесс хэрхэн эхлэх, хэзээ дуусгавар болох, ямар журам баримтлах ёстойг иргэд мэдэх эрхтэй.

Тэгвэл ИХШХШТХ-ийн 11, 40-р зүйлд заасан зохицуулалтын хүрээнд иргэдийн процессын эрхийг бүрэн эдлүүлэх үүднээс шүүхийн шийдвэрээр тогтоосон үйл баримтыг тухайн хариуцагчид холбогдох дараагийн маргаанд нэгэнт тогтоогдсон гэж үзэх, гэрээний стандарт нөхцөлийг хүчингүй болгох тохиолдолд тухайн маргаанаар хязгаарлахгүйгээр нийт зах зээлийн хүрээнд нь авч үзэх нь due process-ын зайлшгүй шаардлага болжээ. Хуулийн зохицуулалтыг зарчмын үүднээс авч үзэж тайлбарлахгүй байгаагаас шалтгаалан хохирч байгаа иргэд уг хийдлийг арилгахыг Засгийн газар болон хууль тогтоогчоос шаардах нь зүй ёсны асуудал болох нь эрх зүйн зайлшгүй процессын ойлголтоор илэрч байна.

Б. Шүүхийн үйл ажиллагаа нь зайлшгүй public purpose буюу нийтийн зорилгын төлөө байдаг гэж үзэх хандлага байдаг. Энэ нь хувийн эрх ашгийг нийтийн эрх ашигтай уялдуулсан шийдвэрийг гаргахыг шүүхээс шаарддаг. Анхлан төрийн аливаа шийдвэрийг шүүх дэмжих хэрэгтэй гэж ойлгож болохоор байсан боловч хөгжлийн явцдаа нийтийн ашиг сонирхлыг аливаа буруутай үйл ажиллагаанаас хамгаалах /үүнд төрийн үйл ажиллагаа ч мөн хамаарна/ чиглэлд

хөгжиж иржээ²⁰.

Уг байр сууриас үзвэл шүүх хувь хүний болон нийтийн зорилгын аль нэгийг эн тэргүүнд тавьж шийдвэр гаргана гэхээс илүүтэйгээр шүүхийн гаргасан шийдвэр нь хэрэв нийтийн ашиг сонирхолд нийцэж байвал түүнийг зайлшгүй биелүүлэх шаардлагатай болж байна. Өмнө дурдсанчлан гэрээний стандарт нөхцөлийн маргааныг шийдвэрлэхдээ зөвхөн тэр маргааны хүрээнд биш хариуцагч байгууллагын нийт зах зээлд санал болгож буй гэрээний стандарт нөхцөл нь хуульд нийцээгүй тохиолдолд бүхэлд нь хүчингүй болгож, үйл ажиллагаандаа дахин хэрэглэхийг хориглох нь шүүхийн public purpose буюу нийтийн зорилготой сая нэг нийцэх юм.

В. ИХШХШТХ-ын 11.1, 40.4 дэх хэсэгт зохиогчийн санал болгож буй шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим агуулгын хувьд хуульд туссан байгаа нь бидэнд бэлээхэн уншигдахуйц байгаа. Гэхдээ шүүхийн практик, 2002 оноос уг хуулийг хэрэг маргаанд хэрэглэж ирсэн туршлага, шүүхийн шийдвэрийн сангаас энэ судалгаагаар санал болгож буй шүүхийн шийдвэрээр тогтоосон үйл баримтыг дараагийн тухайн хариуцагчид холбогдох маргаанд нэгэнт тогтоогдсон гэж үзэх, гэрээний стандарт нөхцөлийг хүчингүй болгох тохиолдолд тухайн маргаанаар хязгаарлахгүйгээр нийт зах зээлийн хүрээнд нь авч үзэх асуудлыг хөндсөн тохиолдолд байхгүй билээ.

Хуулийн зохицуулалт агуулгаараа санал болгож буй зохицуулалтыг зохицуулсан гэж хууль зүйн техник, тайлбарын хувьд авч үзэж болохуйц байгаа боловч бодит үр дүн байхгүй

²⁰ Harry N.Scheiber, Public purpose doctrine, 1986, <https://www.encyclopedia.com/politics/encyclopedias-almanacs-transcripts-and-maps/public-purpose-doctrine> [Сүүлд үзсэн: 2022.02.28]



байна. Энэ тохиолдолд шүүгч ИХШХШТХ-ийн 40.1-д заасан дотоод итгэлийг удирдлага болгон өөрийн эрх хэмжээний хүрээнд²¹ хөндөж буй асуудлыг шийдвэрлэх гаргалгаа байж болно.

Ийнхүү шүүгч өөрийн дотоод итгэлээр хуулийн үзэл санааг өртгөтгөсөн байдлаар тайлбарлах нь зөв эсэх нь маргаан дагуулах магадлалтай. Judicial activism буюу шүүгчийн идэвхтэй оролцооны ойлголтыг манай улсад ихэвчлэн шүүгч хуулиас давсан шийдвэр гаргах нь дур зоргын асуудал үүсгэнэ гэж тайлбарладаг. Уг нэр томъёоны үүсэл, бүрэн утгыг мөшгөвөл ямар тохиолдолд ямар утгыг авч үзэж байгаагаа тодорхой илэрхийлэхгүй бол утгын төөрөгдөлд оруулах²² ба шүүгчийн дур зорго гэж мушгин гуйвуулахыг зогсоож, шүүгч өөрийн эрх хэмжээ, дотоод итгэл үнэмшлийн хүрээнд хууль тайлбарлан хэрэглэх арга замын эрэлхийлэл гэж авч үзэх боломжтой.

Үүний дагуу эрх зүйн хэм хэмжээнд илэрхийлэгдсэн хууль тогтоогчийн хуульчилсан заавал биелүүлэх хүсэл зоригийн утга санаа, агуулгыг тодорхой болгоход чиглэгдсэн²³ тайлбарыг шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ өгөх эрхтэй. Тухайлбал, өмнө жишээ болгож авсан даатгалын маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг дараагийн маргаанд шүүх нэхэмжлэгч

²¹ Judicial discretion томъёоллыг шүүгчийн эрх хэмжээ, бүрэн эрх, үзэмж гэж шууд орчуулдаг боловч судлаач С.Цэрэндолгор "Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурын үзэл баримтлал ба Улсын дээд шүүхийн чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах арга хэрэгсэл болох нь" Б.Чимидийн нэрэмжит ЭШБХ (УБ: 2022) илтгэлдээ "шүүгчийн дотоод итгэл" гэх утга хэрэглэсэн нь оновчтой бөгөөд хуулийн үзэл санаатай нийцэж байна.

²² <https://www.britannica.com/topic/judicial-activism> [Сүүлд үзсэн: 2022.02.28]

²³ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он, 469 дэх тал.

этгээд өөр байгаа эсэхээс үл хамаараад тухайн гэрээний стандарт нөхцөл хүчингүй болохыг урьд шүүх тогтоосон байна гэж ИХШХШТХ-ын 40.4-д зааснаар авч үзэх асуудал онолын хувьд ч, хууль тогтоогчийн тухайн хэсэгт илэрхийлсэн үзэл баримтлалын хувьд ч нээлттэй харагдаж байна. Энэ жишээгээр шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин төгөлдөр байдал нь зөвхөн шүүхийн шийдвэр гарсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид даган мөрдөх ёстой²⁴ гэх гол агуулга нь хариуцагч этгээд хэвээр байгаа тохиолдолд алдагдахгүй юм.

Шүүгч өөрийн эрх хэмжээ, дотоод итгэл үнэмшлийн хүрээнд хууль тайлбарлан хэрэглэх замаар эрх зүйг хөгжүүлэх нь Rule of law зарчмыг зөрчихгүй бөгөөд түүнд нийцэх болно.

Г. Хэрэв шүүхүүд ИХШХШТХ-ын 40.4-д заасныг баримтлан өмнөх хэрэг маргаанд одоо буй маргааны бүх талууд оролцоогүй байхад тухайн шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг хэрэг шийдвэрлэхэд дахин нотлохгүйгээр хүлээн авах гэж байгаа нь шүүхийн жишиг буюу прецедент тогтоох юм биш биз гэсэн хардлага байж болно.

Үүнтэй төстэй харилцаанд судлаач С.Цэрэндолгор өөрийн илтгэлд -Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өмнөх шүүхийн шийдвэрийг дурдах нь жишгийн эрх зүй бий болгохоор шууд санаархах, манай эрх зүйн тогтолцооны соёл, уламжлалтай харшилдах хэрэг огт биш бөгөөд харин хууль хэрэглээний нэгдмэл байдлыг боловсронгуй болгох, шүүхийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх

²⁴ И.Кают, Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2015 он, 216 дахь тал.



хүрээнд хийгдэх зайлшгүй ажиллагаа²⁵ гэж авч үзсэн байдаг. Тийм учраас өмнөх шүүхийн шийдвэрт тулгуурлан шийдвэр гаргах нь stare decisis буюу шүүхийн жишгийн хүрээнд хэргийг шийдвэрлэх зарчим биш, харин хуульд заасан хэм хэмжээг баримталж буй хэрэг юм.

Нөгөө талдаа хууль тогтоогчийн ИХШХШТХ-ын 40.4-т “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй” гэж тогтоож өгсөн хэм хэмжээг зөрчихгүйгээр шүүгч урьд гарсан шүүхийн шийдвэрээр тогтоосон үйл баримтыг үндэслэж хэрэг хянан шийдвэрлэх нь хууль зүйн детерминизм буюу хүчин төгөлдөр хуулийн орчинтой шалтгаант холбоо, зүй тогтолтойгоор үүсэх харилцаа болж байна.

Д. Урьд гарсан шүүхийн шийдвэрт үндэслэх, гэрээний стандарт нөхцөлийг нийт байгуулсан бүх гэрээнд нь хамруулан авч үзэх нь нэг талдаа Class action зохицуулалтыг хэв шинжийг өөртөө агуулдаг.

Class action буюу ангийн, хамтын үйл ажиллагаа гэх ойлголт нь гарвалын хувьд викингчүүдээс улбаалан Англо-Саксоны эрх зүйгээр дамжин эрх зүйд XIII зууны үеэс бий болсон. Тухайн үедээ эзэн хааны болон сүм хийдийн тогтоосон журмыг иргэд хэсэг бүлгээрээ зөрчих асуудал их гарч байсан тул тэдгээрт тэгшитгэх зарчмаар ижил үйлдэлд ижил хариуцлага ногдуулж байсан²⁶. XVIII зууны үед эрх зүйн хөгжлийн

явцад Англид бүлгийн шүүх ажиллагаа дуусгавар болж, нарийвчилсан хуулийн зохицуулалтаар ялгамжтай байдлаар асуудалд хандах болсон. Энэ үетэй зэрэгцэн Америкт “Class action” талаарх ойлголт шүүхийн практикт бий болсон²⁷.

Одоо цагт “Class action” гэх ойлголтыг нэг буюу хэд хэдэн нэхэмжлэгч нь хамтран тодорхой нийгэм, хэрэглэгчийн бүлгийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж, нэхэмжлэлийн дагуу гарсан шүүхийн шийдвэр, эвлэрлээр хариуцагчийн төлсөн төлбөрийг бүлгийн гишүүдийн дунд хуваарилах хууль ёсны ажиллагаа гэж томъёолж байна²⁸.

Тэгвэл Class action зохицуулалтын хүрээнд тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нэг хэлбэр нь аж ахуй эрхлэгчийн нийтэд санал болгосон гэрээний стандарт нөхцөл хүчингүй болсон тохиолдолд тухайн гэрээнд хамаарах бүх хэрэглэгчийн хувьд дээрх зохицуулалт нэгэн адил үйлчилдэг байна. Мөн шүүхээс арилжаа эрхлэгчийн арилжааны явцад гаргасан буруутай үйлдлийг тогтоосон бол уг асуудлаар дараа нь маргаж буй хэрэглэгчдийн хувьд урьд гарсан шүүхийн шийдвэрт дурдагдсан үйл баримтыг дахин нотлох шаардлагагүй байдаг²⁹.

Дэлхийн жишгээс харахад шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хэрэгжилтийн нэгэн жишээ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах class action буюу хэрэглэгчийн бүлгийн, тодорхойгүй тооны хэрэглэгчийн эрх

²⁷ Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021 он, №4.

²⁸ <https://www.investopedia.com/terms/c/classaction.asp>. [Сүүлд үзсэн: 2022.02.28]

²⁹ Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021 он, №4.

²⁵ С.Цэрэндолгор “Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурын үзэл баримтлал ба Улсын дээд шүүхийн чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах арга хэрэгсэл болох нь” Б.Чимидийн нэрэмжит ЭШБХ (УБ: 2022)

²⁶ <https://classactionlawsuitcenter.com/history-of-class-action-lawsuits/>. [Сүүлд үзсэн: 2022.02.28]



ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт гэж үзэж болох талтай байна.

6. Дүгнэлт

“Шүүхийн шийдвэр заавал биелэгдэнэ” гэж ИХШХШТХ-ын 11.1-д заасан зохицуулалтыг зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад биш нийт иргэний процессын хүрээнд авч үзэх шаардлагатай болжээ.

Үүнтэй холбогдуулаад шүүхээс гэрээний стандарт нөхцөлийг хүчингүй болгосон шийдвэр гаргасан тохиолдолд тухайн маргааны хүрээгээр хязгаарлан орхиж буйг анхаарах цаг болсон байна. Иймд гэрээний стандарт нөхцөлийг нийтэд санал болгож буй аж ахуй эрхлэгчийн байгуулсан нийт гэрээний хэмжээнд тухайн стандарт нөхцөл хүчингүй байхаар шийдвэрлэх нь одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийг зөрчихгүй, шүүх нэгэнт шийдвэрлэсэн асуудлаар иргэд давхардсан байдлаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргаж буйг залруулах боломж буйг онолын үндэслэл болон гадаад улсын жишиг харуулж байна.

Түүнчлэн шүүхээр аливаа асуудлыг нэг удаа шийдвэрлэх онол болон хуулийн шаардлагыг хангах үүднээс шүүхээр

шийдвэрлэж тогтоосон үйл баримтыг дараагийн хэрэг маргаанд ашиглах үйл явцыг одоо буй хуулийн зохицуулалтын хүрээнд өргөжүүлэх боломж байгаа нь харагдаж байна. Ялангуяа хэрэглэгчийн эрх зүйн хүрээнд үүсдэг маргаанд энэхүү зохицуулалт нэн тулгамдсан асуудал болж байгаа нь сонгон авсан судалгаа, гадаад улсын жишгээр харагдана.

Хууль тогтоогчоос баталж өгсөн хэм хэмжээний зааг хүрээнээс халихгүйгээр, хууль зүйн детерминизмийн үүднээс гэрээний стандарт нөхцөлийг шийдвэрлэсэн байдал, шүүхээр урьд тогтоосон үйл баримтын асуудалд хандах шаардлага хуулийн зохицуулалт, онолын үндэслэл, гадаад улсын жишгийн хүрээнд тогтоогдож байна гэсэн дүгнэлтэд хүрэв.

Харин хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд тусгайлан санал өгөхийг уг судалгааны ажлаар зориогүй тул хөндөлгүй орхиж байна. Цаашид шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчмын хүрээнд энэ сэдвээр хөндсөн асуудалд хуулийн шинэчлэл хийх, нэгдсэн хууль хэрэглээ үүсгэх шаардлагатай тохиолдолд хууль зүйн детерминизмийн үүднээс хандах нь зүйтэйг дурдаж байна.



НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж:

Ц.Амарсайхан нар, Процессын эрх зүй, УБ, 2014 он, 269 дэх тал.

Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2015 он, 17-29 дэх тал.

Монгол Улсын Дээд Шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ, 2014 он, 54-55 дахь тал.

Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2021 он, 20 дахь тал.

М.Мөнхнаран, Хэрэглэгчийн гэрээний эрх зүйн зохицуулалт ба хэрэглэгч гэрээг уншилгүйгээр гарын үсэг зурах явдал, <https://legaldata.mn/b/1038>

Хансс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, "Арилжаа / худалдаа/-ны хуулийн хэрэглээ, шаардлагыг урьдчилан тандах судлах судалгааны тайлан", УБ, 2019 он.

Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021, №4 .

Б.Буянхишиг, Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, УБ, 2021 он, 61 дэх тал.

С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, УБ, 2007 он, 469 дэх тал.

Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ, 2015 он, 216 дахь тал.

С.Цэрэндолгор "Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурын үзэл баримтлал ба Улсын дээд шүүхийн чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах арга хэрэгсэл болох нь" Б.Чимидийн нэрэмжит ЭШБХ (УБ: 2022)

Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021 он, №4.

Т.Бадрах, Тодорхойгүй тооны буюу олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2021 он, №4.

II. Гадаад эх сурвалж:

Maciej Chmieliński, The Philosophy of Legal Change, 2019, p19.

Harry N.Scheiber, Public purpose doctrine, 1986,

III. Бусад эх сурвалж:

<https://thelawdictionary.org/enforce/>.

<https://cgc.law.stanford.edu/commentaries>.

http://www.consultant.ru/document/cons_doc_LAW.

<https://bletoncouncil.org/determinismo-filosofico-12857>.

https://shuukh.mn/single_case/49217.

<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy>

<http://elbpartners.mn/post/57185>.

<https://www.dentons.com/en/insights/articles/2021>

https://www.law.cornell.edu/wex/du_process

<https://www.encyclopedia.com/politics/encyclopedias-almanacs-transcripts-and-maps/public-purpose-doctrine>

<https://www.britannica.com/topic/judicial-activism>

<https://classactionlawsuitcenter.com/history-of-class-action-lawsuits/>.

<https://www.investopedia.com/terms/c/classaction.asp>.



Abstract

**THE ISSUE OF DETERMINISM PRINCIPLE OF
BINDING THE JUDICIAL DECISIONS**

T.Badrakh /LL.M/

Judge of the first instance Civil court in Nalaikh district

In the scope of principle to bind the judicial decisions related to the facts that registered by the judicial decisions previously, in the case of raised interests, regardless of previous involvement in the case, the demand of considering that is proven by the court, and an invalidate of the standard term of the contract is not limited by that case, it requires to deal

with widely in the field of theoretical and practical use of legislation is mirrored in the research work.

Keywords

Binding the decisions, standard terms of the contract, due process, legal determinism, principle of the process, legal technic, consumer law.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЭНЭРЭНГҮЙ ЁСНЫ ЗАРЧИМ

PRINCIPLES OF HUMANITY IN CRIMINAL LAW

Болатханы АРМАНБЕК¹

Удиртгал

Эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчим

I. Эрх зүйн зарчим

II. Эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчим

III. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж дахь энэрэнгүй ёсны зарчмын илрэл

IV. Энэрэнгүй ёсны зарчим ба эрүүгийн эрх зүйн орчин үеийн хандлага

V. Дүгнэлт

VI. Ном зүй

¹ Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн дарга



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЭНЭРЭНГҮЙ ЁСНЫ ЗАРЧИМ

Б.АРМАНБЕК. Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газрын шүүх хуралдааны нарийн бичгийн дарга.

Товчлол

Энэхүү нийтлэлд энэрэнгүй ёсны зарчмыг эрх зарчмын хүрээнд авч үзэн, түүний мөн чанар, агуулга, хэлбэрийг судалж, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдлийг олохыг эрмэлзэв. МУ-ын хууль тогтоомж, хууль сахиулах ажиллагаанд энэ зарчмыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж, энэ нь дэлхийн нийтийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн орчин үеийн хандлагын хүрээнд явагдаж байгаа эсэхэд дүгнэлт хийж үзэв.

Түлхүүр үгс: эрүүгийн эрх зүй, эрх зүйн зарчим, энэрэнгүй ёс, энэрэнгүй ёсны зарчим, эрүүгийн хариуцлага

Удиртгал

Эрх зүйн энэрэнгүй, хүмүүнлэг шинж чанар нь тухайн салбар эрх зүйн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь үнэлэмж болох гол шалгуур болдог. Эрүүгийн эрх зүй нь хууль зөрчигчдийн хамгийн аюултайд нь тооцогдох гэмт этгээдүүдэд албадлагын арга хэмжээ хэрэглэж, ял шийтгэл оногдуулж тэдгээрийг нийгэмшүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онцлогтой. Ихэнх судлаачид эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчим нь гэмт хэрэгтэн буюу ял эдэлж буй этгээдийн ял эдлэх дэглэм, амьдралын нөхцөл байдлыг хөнгөрүүлэх байдлаар илэрдэг гэж үздэг. Тухайлбал өршөөл үзүүлэх, гэмт

этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх хуулийн хэм хэмжээг буцаан хэрэглэх, тодорхой гэмт хэргүүдийн санкцийг хөнгөрүүлэх зэрэг арга хэмжээнүүд эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчимд нийцдэг, гэмт этгээдэд хүнлэг байдлаар хандсан тохиолдол байж болох юм. Гэвч “энэрэнгүй ёс” гэдэг нь гэмт этгээдийг өрөвдөх сэтгэл биш харин ч нийтийн болон хувийн ашиг сонирхлыг хамгаалж нийгмийн тогтвортой аюулгүй байдлыг хангахад баримтлах гол үзэл баримтлал болдог юм. Эрүүгийн эрх зүй нь хуулийн харанхуй, гэсгээл хүлээлгэдэг салбар нь биш, нийгмийн амьдралын сөрөг үзэгдлийг зохицуулах хүмүүнлэг ёсны хэрэгсэл болох шаардлагатай. Иймээс гэмт этгээдийг хамгийн түрүүнд хүн гэдэг утгаар нь хүндлэх хэрэгтэй гэсэн хандлага дэлхий дахинд түгээмэл дэлгэрч байна. Энэ үүднээс Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжууд дахь энэрэнгүй ёсны тусгал, уламжлал, хөгжил, цаашид анхаарах асуудал зэрэг асуудлуудын хүрээнд судалгааны ажлаа хийхээр эрмэлзлээ. Энэрэнгүй ёсны зарчмын мөн чанарыг таньж олохын тулд юуны өмнө “зарчим” болон “энэрэнгүй ёс”-ны тухай нэр томьёог түс бүрээр нь авч үзэн дэлгэрэнгүй ойлголттой болсны үндсэн дээр судалгааны ажлаа үргэлжлүүлэх нь зүйтэй.



“ЗАРЧИМ” ба “ЭНЭРЭНГҮЙ ЁС”-ны тухай ойлголтын судлагдсан байдал

Зарчим нь латин хэлний principium, грек хэлний **архэ** буюу анхдагч гэсэн үгнээс гаралтай. Энэ нэр томъёог Исаак Ньютон “Philosophiæ Naturalis Principia Mathematica – Байгалийн философийн математик эхлэл” бүтээлээрээ анх шинжлэх ухааны эргэлтэд оруулсан. И.Ньютон “зарчим”-ыг дараах хоёр шалгуурт нийцсэн үзэл баримтлал гэж тодорхойлсон¹.

1. Аливаа үзэгдлийн туршилт, ажиглалтын үр дүнд бий болсон үзэл баримтлал
2. Ирээдүйд дүгнэлт хийхэд анхдагч үзэл баримтлал болно

Иймд И.Ньютон “зарчим” гэдэг нь ирээдүйд үзэл баримтлал бий болоход суурь болох туршлагын үр дүнд бий болсон анхдагч үзэл баримтлал гэж үзсэн бол Томас Бландевиль 1617 оны The Arte of Logick номдоо зарчим гэсэн ойлголтын олон утга санааг нь нэгтгэж “нотолгоо шаардахгүй тодорхой туйлын үнэн” хэмээн тодорхойлсон. Ньютон “зарчим” хэмээх ойлголтыг өөрийнхөөрөө ашиглаж байсныг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд энэ нь эртний сэтгэгчид болон орчин үеийн тэдгээрийн дагагчдын “зарчим”-ыг хэрэглэснээс огт өөр байсан. Орчин үеийн физик дэх “зарчим” гэдэг үгийн утга бага зэрэг өөрчлөгдсөн бөгөөд одоо “Ньютоны зарчмууд”-ийг “Ньютоны хууль” гэж нэрлэх болжээ. Өнөө үеийн эрдэмтэд “зарчим” гэсэн нэр томъёог “Зарчим бол байгалийн хэлээр илэрхийлэгдэх ерөнхий шинж чанартай урьдчилсан нөхцөл гэж тодорхойлж байна. Ерөнхий ойлголтыг ихэвчлэн “нөхцөлийг хангасан бүх Х-ийн хувьд Y

үнэн байна гэх мэт тохирох хэмжигдэхүүн ашиглан тодорхойлдог”² гэсэн байдлаар тодорхойлсон болно. Харин эрх зүйн зарчмын тухай хуульч Пол Шолтен “эрх зүйн зарчим бол бидний хувьд (тодорхой нэг улсын иргэд, цаг хугацаа, эрх зүйн тогтолцоонд хамаарч буй хүмүүс) удирдамж болох ердийн ойлголт гэж томъёолжээ³.

Монгол хэлний их тайлбар толиос харахад хүмүүнлэг ёс, энэрэнгүй ёс зэрэг үгс адилхан утга санааг агуулдаг байна. Олон улсын шинжлэх ухааны эргэлтэд энэ үг нь гуманизм /humanity.анг/ гэдэг үгээр орсон ба олон судлаач, сэтгэгчдийн бүтээлд дээрх байдлаар тусгагджээ. Хүмүүнлэг ёс нь юуны түрүүнд хувь хүний дотоод итгэл үнэмшлээс үүдэлтэй, өөрийгөө таньж мэдэх хамгийн дээд түвшинд орших ертөнцийг харах өнцөг нь байдаг. Харин үүнийг үгүйсгэх оролдлого бүрийг хүнлэг бус гэж үздэг бөгөөд энэ нь “төгс хүн” орших тухай үзэл санааг үгүйсгэдэг⁴. АНУ-ын хүмүүнлэг ухааны судлаачдын холбоо нь “Хүмүүнлэг үзэл бол ер бусын зүйлд итгэх итгэлгүйгээр өөрийгөө ухамсарлах, хүн төрөлхтөнд илүү их ашиг тус хүртээх зорилгоор ёс суртахууны амьдралын хэв маягийг удирдан чиглүүлэх чадвар, үүрэг хариуцлагаа баталгаажуулдаг амьдралын дэвшилтэт байр суурь” гэж тодорхойлсон⁵. Эртний Ромын сэтгэгч Цицерон “хүмүүнлэг ёс бол хүний чадварын соёл, ёс суртахууны хамгийн өндөр хөгжил нь бөгөөд зөөлөн, хүнлэг

² Christian List и Laura Valentini. The Methodology of Political Theory (англ.) // Oxford Handbook of Philosophical Methodology

³ Scholten, Paul. Algemeen Deel / Mr. C. Asser's Handleiding. - Zwolle: Tjeenk Willink, 1931. 251-259 дэх талууд

⁴ Новейший философский словарь. Минск, 2003. 2.

⁵ Humanism and its aspirations / http://americanhumanist.org/wp-content/uploads/2018/08/HumanismanditsAspirations_jefferson1.pdf/.

¹ Kirsten Walsh. The Idea of Principles in Early Modern Thought: Interdisciplinary Perspectives / Peter R. Anstey. - Routledge, 2017. - 304 дэх тал.



сэтгэлтэй хослуулан ёс суртахууны боловсронгуй хэлбэрт хүргэх явдал” хэмээн үзсэн. Хүмүүнлэг ёс нь хүний чадварыг ашиглан хүний болон бусад байгалийн үнэт зүйлсэд суурилсан ёс зүйтэй, ухамсартай, чөлөөт сэтгэлгээний үндсэн дээр илүү хүмүүнлэг нийгмийг цогцлоохыг уриалдаг. Хүмүүнлэг үзэл нь шашны үзэл баримтлал биш бөгөөд бодит ертөнцийн “ер бусын далд хүчний” тухай төсөөллийг хүлээн зөвшөөрөхгүй.

1. Эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчим

1.1. Эрх зүйн зарчим

Эрх зүйн зарчим нь үндсэн хуулиар тунхагласан суурь зорилгын хүрээнд бий болж, эрх зүйн ухамсраас үүдэн гардаг юм. Эрх зүйн нийтлэг зарчимд нийцсэний үр дүнд аливаа хэм хэмжээ хууль ёсны болох учиртай. Харин тухайн оронд үндсэн хуулиар тунхагласан суурь зорилго нь эрх зүйн салбар бүрд өвөрмөц агуулгаар тусгагддаг ч энэ нь нийтлэг эрх зүйн зарчимд нийцсэн байх ёстой. Иймээс эрх зүйн зарчим гэдэг нь үндсэн хуулийн үзэл санаанаас эхтэй, эрх зүйн ухамсраас урган гардаг ба хууль бүтээх, хуулийг хэрэглэх ажиллагаанд эрх бүхий субъектүүдээс үйл ажиллагаандаа мөрдлөг болговол зохих үзэл санааны нийлбэр цогц юм. Энэхүү тодорхойлолтыг үндэслээд ерөнхийгөөс тусгай руу орох зарчмын хүрээнд тодорхойлбол эрүүгийн эрх зүйн зарчим нь эрүүгийн хууль тогтоомжийг бүтээх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлдэл, эс үйлдэхүйг шинээр гэмт хэрэгт тооцох, гэмт хэргийг илрүүлж гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх бүхий л ажиллагаанд удирдлага болгох, түүнийг хэрэглэх тохиолдол бүрд баримтлах үзэл баримтлал юм. Эрүүгийн эрх зүйн зарчим нь тус хуулийн ерөнхий

ангийн тулгуур ойлголт нь бөгөөд тусгай ангийн бүх хэм хэмжээнд тусгалаа олсон байвал зохино. Г.Совд “Эрүүгийн эрхийн үндсэн зарчмуудыг эрүүгийн эрхийн утга агуулгыг тодорхойлж, түүний үйлчилгээнд удирдамж болдог гол үзэл санааны нийлбэр”⁶ гэж тодорхойлсон бол академич С.Нарангэрэл “Эрүүгийн эрхийн зарчмуудыг хууль тогтоох болон хэрэглэх үйл ажиллагаанд заавал хэрэглэгдэх гол суурь болсон эрх зүйн үзэл баримтлал”⁷ гэж тодорхойлсон байна.

1.2. Эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчим

Эрүүгийн эрх зүйгээр шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг хэрэглэх талаар асуудал шинэ үеийн сэтгэгчид Чезаре Бекариа, Шарль Луи Монтескье нарын бүтээлүүдэд анх хөндөгдсөн⁸. Хэн бугай ч эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бус, түүний нэр хүндийг гутаан доромжилсон шинжтэй хариуцлага хүлээх ёсгүй гэх зарчим Хүний эрхийн түгээмэл тунхаглалд⁹ анх тусгагдаж, олон улсын хууль тогтоомжуудад хэрэглэгдэж эхэлсэн. Эрүүгийн хуулийн үндсэн зорилго нь Үндсэн хуулиар хамгаалсан хүний үндсэн эрхийг гэмт халдлагаас хамгаалах явдал бөгөөд энэ утгаараа хүний жам ёсны эрхийг гэмт халдлагаас хамгаалж байгаа нь энэрэнгүй ёсны зарчмын цөм нь болно. Энэрэнгүй ёсны зарчим нь нэн түрүүнд гэмт хэргийн улмаас хохирогчийн эрх ашгийг хамгаалахад чиглэдэг боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ч хохирогчтой нэн

⁶ БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ.,1973, 10 дахь тал

⁷ Монгол Улсын эрүүгийн эрх зүй. /ерөнхий анги/. УБ.,1999, 15 дахь тал

⁸ Уголовное право России. Практический курс / Ерөнхий редактор. А.И.Бастрыкин; эрдэм шинжилгээний редактор. А.В.Наумов. Нэмж засварласан 3 дахь хэвлэл. М., 2007. 18 дахь тал

⁹ ХЭТТ-ын 5 дугаар зүйл



адил хүн гэдэг утгаар нь авч үзэн хуулиар хамгаалсан эрх ашгийг нь хамгаалах учиртай. Энэхүү зарчмын гол агуулга нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд ч нийгмийн бүрэн эрхт гишүүн гэдэг утгаар нь хандаж, түүний үндсэн эрх ашгийг нь хүндлэх явдал юм. Эрүүгийн хариуцлага гэмт этгээдийн хуулийн хэм хэмжээг зөрчсөнийхөө төлөө өш авч байгаа арга хэрэгсэл биш, эсрэгээрээ Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын зорилгод¹⁰ хүрч, нийгэмд шударга ёсыг тогтоож, гэмт этгээдийг засан хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ болох ёстой. Иймээс үүнийг эрх зүйн онолын хүрээнд хувийн ба нийтийн урьдчилан сэргийлэлт гэж авч үздэг. Энэрэнгүй ёсны зарчим нь хүний жам ёсны эрхийн ойлголтой холбоотой гарч ирсэн ойлголт. Харин эрүүгийн хууль тогтоомжуудаар хүний жам ёсны эрхэд төр, нийгмийн зүгээс хууль ёсоор халдах ганцхан арга зам билээ. Энэрэнгүй ёсны зарчмаар ял шийтгэл нь залхаан цээрлэх зорилгыг агуулдгийг үгүйсгэхгүй ч цээрлэх зорилгыг туйлын баримтлал болгох нь эрүүгийн эрх зүйн зорилгын ач холбогдлыг багасгах сөрөг үр дагавартай гэдгийг сануулж байдаг. Карл Маркс түүх болон статистикийн шинжлэх ухааны судалгааны үр дүнгээс “Каины үеэс хойш дэлхий хэзээ ч ял шийтгэлээр нийгмийг засаж залруулж, гэмт хэргээс айлган сүрдүүлгийн замаар сэргийлж чадаагүйг баталгаатай нотолж байна” хэмээн хэлж байв. Энэ нь яг эсрэгээрээ хэрэгжиж байдаг¹¹ гэж ялын нийгмийг айлган сүрдүүлэх зорилгыг үгүйсгэсэн байдаг. Уламжлалт эрүүгийн хариуцлагын тогтолцооноос өөр төрлийн арга хэмжээг хэрэглэснээр гэмт хэрэгтэй

тэмцэх үйл ажиллагаанд томоохон ахиц гарна гэсэн хандлага сүүлийн үеийн улс орнуудын туршлага харуулж байна.¹² Ч.Беккариа “Эрүүгийн хуулийг үгчлэн дагаж мөрдсөнөөс учрах хохирол нь түүнийг тайлбарласнаас үүдэн гарах хохирлоос хавьгүй бага” хэмээн тайлбарлаж, хуулийг тайлбарлах нэрийн дор түүний агуулгыг өөртөө болон бусдад ашигтай байдлаар гуйвуулан ашиглах явдлаас сэргийлэх мессеж өгчээ.

1.3. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомж дахь энэрэнгүй ёсны зарчмын илрэл

Анхны кодексжуулсан эрүүгийн хууль болох 1926, 1929 оны БНМАУ-ын шүүх цаазын бичигт энэрэнгүй ёсны зарчмын талаар ерөнхий заалт тусгагдаагүй ч 1926 оны Шүүх цаазын бичиг нь тухайн үедээ хүнлэг хандлагын шинжтэй хэм хэмжээнүүдийг агуулснаараа онцлог болсон. Уг хуульд 18 насанд хүрээгүй байсан хүн, жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эмэгтэйд цаазаар авах ялыг хориглосон агуулга орж ирээд, энэ нь сүүлд 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулиар бүх насны эмэгтэйчүүд болон 60-аас дээш насны эрэгтэйчүүдэд ялын дээд хэмжээг хэрэглэхийг хориглосон хэм хэмжээ болтлоо өргөжсөн. Энэ нь нэг талаас дэлхийн дайны дараа социалист хувьсгал нийгмийн бүх түвшинд хүрч бэхэжсэнтэй холбоотой юм. Ял шийтгэл нь хэрцгий, хүний нэр төрийг гутаан доромжилсон шинж агуулсан байхыг хориглосон агуулга бүхий заалт нь 1934 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн ерөнхий ангид анх хэлбэрийн хувьд хуульчлагдсан. Үүнд тус хуулийн 5 дугаар зүйлд заасан “Ял шийтгэх явдлыг хэрэглэх зорилго”-ын тайлбар хэсэгт “ял шийтгэх явдал нь

¹⁰ МУ-ын Эрүүгийн хууль.2015 §5.1

¹¹ Маркс К., Энгельс Ф. Сочинения. 2-е изд. Т. 8. 530 дахь тал.

¹² Уголовное право. Общая часть / ред. И.Я.Козаченко, З.А.Незнамова. Нэмж засварласан 3 дахь хэвлэл. М., 2001. 51-52 дахь тал



хүний бие махбодыг зовоох буюу хүн гэсэн нэр зэргийг доромжлох зорилготой байж үл болно” гэж хуульчилсан. Энэ зохицуулалт нь БНМАУ-ын 1942, 1961, 1987 онуудын Эрүүгийн хуульд¹³ тус тус адилхан агуулгаар батлагдсан.

Шинэ Үндсэн хууль батлагдаж, ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 19 дүгээр зүйлд “ял нь хүнлэг бус, хүнд хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох зорилго агуулж болохгүй” гэж хуульчилсан нь өмнөх эрүүгийн хуулиуд дахь энэ зарчмын зохицуулалттай ижилхэн болжээ. Харин 2002 оны Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлд “Энэрэнгүй ёсны зарчим”-ын тухай “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй” гэж заасан нь Монгол Улсын хууль тогтоомжид анх энэрэнгүй ёсны зарчим нь тустай зохицуулалтаар зохицуулагдсан тохиолдол байв. Гэвч 2015 оны Эрүүгийн хуулийн зарчмуудаас энэрэнгүй ёсны зарчмын агуулгыг тус хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлд багтаажээ.

1.4. Энэрэнгүй ёсны зарчим ба эрүүгийн эрх зүйн орчин үеийн хандлага

Орчин үеийн эрүүгийн эрх зүй нь 1980-аад онд дэлхий даяар эхэлсэн нийгэм, эдийн засаг, улс төрийн өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд болсон эрүүгийн эрх зүйн үндсэн институцуудын хөгжлийн хүрээнд 1990-ээд оноос эхэлж дэлхийн 50 гаруй улсад шинээр эрүүгийн хууль батлагдаж, социалист

блокт хамаардаг улсуудын эрүүгийн хууль тогтоомж бүтцээрээ өөрчлөгдсөн. В.Н.Додонов орчин үеийн эрүүгийн эрх зүйд нийтлэг 3 шинж тэмдгийг тодорхойлохдоо эрүүгийн эрх зүй нь хүмүүнлэг хандлагатай болох, үйлдэл, эс үйлдэхгүйг шинээр гэмт хэрэгт тооцож хуульчлах, эрүүгийн эрх зүйн харилцаа олон улсыг хамаарсан шинжтэй болох гэсэн нийтлэг 3 чиг хандлага байгааг онцолсон.¹⁴ Эрүүгийн эрх зүйн өнөөгийн чиг хандлага бий болоход 19 дүгээр зуунд Европ, Америкийн олон орнуудад болсон хөрөнгөтний хувьсгалууд нөлөөлсөн ба орчин үеийн эрх зүйн тогтолцооны гол суурь болсон либерализм, эрх зүйт төр зэрэг ойлголтууд гарч ирсэн. Эрүүгийн эрх зүйн 19 дүгээр зууны сүүл үеийн 20 дугаар зууны эхэн үеийн сонгодог зохиолуудад (Н.С.Таганцевын) дурдагдсан үзэл санаанууд хожим 20 дугаар зууны сүүл үеийн улс орнуудын хууль тогтоомжуудад тусгалаа олж эхэлсэн. Цаазаар авах ял оногдуулахын үр нөлөө, албадан хөрөнгө хураах ял нь эрх зүйн нийтлэг зарчмуудад нийцэх эсэх, хорих ялыг орлуулах өөр төрлийн арга хэмжээ хэрэглэх, насанд хүрээгүй этгээдүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг тусгайлсан тогтолцоог бий болгох, олон этгээд (зохион байгуулалттай гэмт хэрэг) оролцсон гэмт хэрэгт хариуцлага оногдуулах г.м өнөөгийн эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудлуудыг XIX зууны сүүл, XX эхэн үед шинжлэх ухааны хэлэлцүүлгийн эргэлтэд оруулсан нь XX зууны эхний хагаст хөгжлийн либерал-хөрөнгөтний хэв маягийн хямрал эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага эрс өөрчлөгдөхөд хүргэсэн.

¹³ Баярсайхан.Б нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/. УБ., 2011, 359-506 талаас түүвэрлэн хэрэглэв

¹⁴ Додонов В. Н. Сравнительное уголовное право. Общая часть. Монография / М.: Юрлитинформ, 2009, 11-12 дахь тал



Цаазаар авах ялыг халах: Эрүүгийн эрх зүйг хүмүүнлэг, энэрэнгүй хандлагатай болгох нь тус салбар эрх зүйн хөгжлийн хамгийн удаан үргэлжилсэн үйл явц нь юм. XVIII зуунаас цаазаар авах ялыг халах, хязгаарлагдмал хүрээнд хэрэглэх тухай санаачилгууд гарч эхэлсэн бөгөөд Англид 1826-1861 оны хооронд цаазаар авах санкцтай гэмт хэргийн тоо 200-аас 4 болтлоо багассан¹⁵. XX зууны эхний хагаст энэхүү чиг хандлагаас ухрах хандлага ажиглагдсан ч 1950-аад оны дунд үеэс улс төрийн дэглэм харгалзахгүй барууны болон социалист орнуудад эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгож хүмүүнлэг болгох үйл явц эхэлсэн. Эртний Грект Диодот ба Клеоны хоорондын цаазаар авах ялын үр дүнгийн тухай маргааны агуулга гэгээрлийн үеийн нэрт төлөөлөгч Ч.Беккариагийн бүтээлүүдэд тусгалаа олсон¹⁶. Цаазаар авах ялыг халах, хязгаартай хэрэглэх чиг хандлага XX зууны эхэнд эхэлсэн ч 1920-1940 онуудад цаазаар авах ялыг хэрэглэх хэм хэмжээг сэргээн хуульчилсан нь дээр дурдсанчлан нийгэм, улс төр, эдийн засгийн ухралтай холбоотой билээ. Гэсэн хэдий ч XX зууны төгсгөлд цаазаар авах ялаас татгалзах хөдөлгөөн дэлхий даяр эрчимтэй явагдаж 1980-аад оны сүүлд дэлхийн 30 гаруй улс оронд цаазаар авах ялыг халсан. Цаазаар авах ялыг халахыг дэмжигчид дараах 3 төрлийн аргументыг түгээмэл удирдлага болгодог. Үүнд:

а. Шүүхийн алдаа: Дэлхийн хаана ч алдаагүй, бүрэн төгс хэрэгжих эрх зүйн тогтолцоог бий болгож чадаагүй. Иймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа, хуулийн хийдэл, зохицуулалтын дутмаг байдал зэрэг нөхцөл байдлаас

хамаараад гэм буруугүй хүнийг цаазаар авах магадлал маш их гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийдвэрүүд алдаатай байх тохиолдлууд түгээмэл тохиолддог бөгөөд 1987 онд АНУ-д гарсан цаазаар авах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолуудын дундаас 349 шийдвэр алдаатай байсан ба үүний 23 нь гүйцэтгэгдсэн байжээ.¹⁷ Мөн 1978-2007 онуудад АНУ-д өмнө нь цаазаар авах ялаар шийтгүүлж байсан 126 хүнийг цагаатгасан байдаг. Энэ ангиллын ялтай хэргийн 2/3-ийг дахин хянан хэлэлцэхэд анх цаазаар авах ял оногдуулсан шийдвэрийн 82% -д нь ялын дээд хэмжээг хөнгөн ялаар сольжээ.¹⁸ 1949 онд Их Британид жирэмсэн эхнэрээ болон 2 настай охиноо алсан хэрэгт буруутгагдсан Тимоти Эвонсын алдартай кейст шүүгдэгч дүүжлэх ялаар шийтгүүлсэн боловч 4 жилийн дараа Тимоти Эвонсын тус хэрэгт гэрчээр мэдүүлэг өгсөн цуврал алагч Жон Кристи гэгч дээрх хэргийг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн ч хэлмэгдсэн этгээд Тимоти Эвонс нь цагаатгагдаж хэргийн жинхэнэ эзэн нь цаазаар авагдсан. Энэхүү Тимоти Эвансын хэрэг нь цаазаар авах ялыг халахыг дэмжигчдийн маргааны хамгийн том жишээнүүдийн нэг болжээ.

б. Гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадахгүй: Эртний Грекийн үеэс Диодот тэргүүтэй сэтгэгчид цаазаар авах ялын гэмт этгээдийг айлган сүрдүүлэх үр нөлөө нь тун бага хэмээн үзэж байв. Ихэнх тохиолдолд гэмт хэрэг үйлдэж буй хүн хариуцлагаас мултарч чадна гэж тооцоолдог тул цаазаар авах ял нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг туйлд нь хүргэж чадахгүй. Онц

¹⁵ Всемирная история государства и права. Энциклопедический словарь. - М.: Инфра-М, 2001. 312 дахь тал

¹⁶ Курс уголовного права. Т. 2. Общая часть. Учение о наказании. М.: Зерцало, 2002

¹⁷ Курс уголовного права. М.: Зерцало, 2002. - Т.

2. Общая часть. Учение о наказании. 508 дахь тал
¹⁸ Иванова Н. Г., Никулина С. И., Яцеленко Б. В. Курс российского уголовного права. Общая часть. - Экономика, 2010. 666 дахь тал



хүнд гэмт хэрэг үйлдсэн хүн ирээдүйд алдах зүйлгүй гэж үзэн дахин гэмт хэрэг үйлдэхэд бэлэн байдаг. Орчин үед шинээр бий болсон алан хядах террорист халдлага үйлдэх гэмт хэргийн төрлүүдэд цаазаар авах ял оногдуулах нь төдийлөн амжилтад хүрэхгүй. Учир нь алан хядагчид нийгмийн тогтвортой байдлыг бусниулж, айлган сүрдүүлэх гэмт хэрэг үйлдэхэд шашны экстремист үзэл баримтлалын үүднээс хандаж өөрийгөө золиослоход бэлэн байдаг¹⁹. Шинжлэх ухаанаар батлагдсан цаазаар авах ялыг хуульчилснаар гэмт хэргийн гаралтын тоо буурах талаар баталгаатай судалгааны үр дүн байдаггүй. 2002 онд НҮБ-ын захиалгаар хийгдсэн цаазаар авах ял болон хүн алах гэмт хэргийн гаралтын тоонд хийсэн судалгаагаар²⁰ “цаазаар авах ял нь харьцангуй хөнгөн ял болох бүх насаар нь хорих ялтай харьцуулбал хүн амины хэргийн гаралтад нөлөөлөх чадвар нь бага” гэсэн дүгнэлтэд хүрчээ.

в. Нийгмийг хүмүүнлэг бус болгодог: Дэлхийн бүх шашнууд хүн төрөлхтөн хүмүүнлэг, энэрэнгүй байх тухай номлодог. Христийн шашинтай орнууд хууль болон шашны хэм хэмжээг зөрчсөн этгээдүүдэд болон тэрс үзэлтнүүдийг олон нийтийн өмнө галлан шатаах зэрэг хүнд ялыг түгээмэл хэрэглэж ирсэн. Ийнхүү онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд цаазаар авах ял оногдуулах нь таллионы зарчим буюу нүдийг нүдээр гэсэн хуучны харгис зарчим болох бөгөөд орчин үеийн нийгмийн сэтгэхүй, эрүүгийн эрх зүйн зорилгод харш үзэгдэл юм. Хүний амь нас бүхэлдээ халдашгүй байдаг ба төрийн зүгээс хууль ёсоор хүний амь насыг егүүтгэхийг зөвшөөрснөөрөө хүний амь насны үнэ цэнийг үгүйсгэж

нийгмийн дунд харгис үзэгдлийг дэлгэрүүлэн өөхшүүлж байгаа хэрэг болно гэж А.Сахаров цаазаар авах ялын хор уршгийн талаар өөрийн үзэл бодлоо хэлсэн²¹.

2019 оны Эмнести Интернэшнл байгууллагаас эрхлэн гаргасан судалгаагаар 106 улс де-юре цаазаар авах ялыг бүрэн халсан, 7 улс дайны болон онц байдал тогтоосон үед зарим төрлийн гэмт хэргүүдэд хэрэглэх тухай хуульчилсан, 30 улс уг ялыг де-юре хуульчилсан ч де-факто хэрэглэхгүй түдгэлзүүлсэн бол 48 улс одоо хүртэл хэрэглэж байна²². Хамгийн сүүлд 2021.01.02-ны өдөр Казахстан улс цаазаар авах ялыг бүрмөсөн халжээ²³. Монгол Улсын хувьд 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад 1968 гарын үсэг зурж, 1974 онд соёрхон баталсан бөгөөд 2012 онд уг пактын хоёрдугаар нэмэлт протоколд гарын үсэг зурж цаазаар авах ялыг халахыг дэмжсэн. Манай улсад хамгийн сүүлд 2008 онд цаазаар авах ялыг хэрэгжүүлж, үүнээс хойш цаазаар авах ялаар шийтгүүлсэн этгээдүүдэд МУ-ын Ерөнхийлөгчөөс уучлалт хүссэн тохиолдолд уг ялаас чөлөөлж де-факто хэрэглээгүй. 2015 оны Эрүүгийн хуулиар Монгол Улс цаазаар авах ялыг бүх төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялаас хасаж уг ялыг бүрмөсөн халснаар Үндсэн хуулийн хүмүүнлэг нийгмийг байгуулах зорилгод хүрэх томоохон алхам болсон ч Үндсэн хуульд хүний амь насыг онц хүнд гэмт хэрэг үйлдсэн шалтгаанаар егүүтгэхийг зөвшөөрсөн заалт одоо хүртэл оршсоор байгаа нь ирээдүйд дахин цаазаар авах ялыг хуульчилж хэрэглэх боломж

²¹ Сахаров А. Д. Письмо в организационный комитет симпозиума по проблеме смертной казни

²² AMNESTY INTERNATIONAL GLOBAL REPORT. DEATH SENTENCES AND EXECUTIONS. 2019

²³ <https://deathpenaltyinfo.org/news/kazakhstan-signs-global-treaty-to-abolish-death-penalty>

¹⁹ Учение о наказании, 2002, 510 дахь тал

²⁰ Hood, Roger. The Death Penalty: A World-Wide Perspective. - 3rd ed. - Oxford: Clarendon Press, 2002. - P. 230.



оршоор байгааг илтгэж байна.

Хорихоос өөр төрлийн ял хэрэглэх: Улс орнуудын эрүүгийн хууль тогтоомж эрүүгийн хариуцлагын хувьд хүнд тогтолцоотой, олон төрлийн ял шийтгэлтэй байгаа ч түгээмэл оногдуулах ялын төрөл нь хорих ял байсаар байна. XIX зууны сүүлээс эрдэмтэд, криминологичид энэ байдлыг өөрчилж, хорих ялыг орлуулах ялын төрлийг бий болгохыг эрмэлзэж эхэлжээ. Гэвч олон нөхцөл байдлын улмаас эрдэмтдийн бүтээлүүдэд тусгагдсан санал дэвшлүүд өргөн хүрээнд бодит биелээ олж чадаагүй л байна. XX зууны сүүл үеэс эхлээд улс орнууд эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хорихоос өөр төрлийн ялыг нэмж зохицуулсан явдалд НҮБ-д болсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчигчтэй харьцах тухай конгрессууд багагүй хувь нэмэр оруулсан. 1985 онд болсон 8 дугаар конгресст торгууль, хорих ял оногдуулахгүйгээр албадан хөдөлмөр эрхлүүлэх, тэнсэн харгалзах ял зэрэг ялын төрлүүдийг нэмж хуульчлах тухай санал дэвшүүлжээ. Албадан ажил хийлгэх ял нь уламжлалт ялын тогтолцоонд байдаг ч шүүхээс тогтоосон ажлыг үндсэн ажилтайгаа зэрэг хийх боломжоор хангах, тодорхой хугацаа, дэглэмийн дагуу хийж гүйцэтгэх нийтийн ажил нь дэлхий нийтийн эрүүгийн эрх зүйн практикт шинэ зохицуулалт болсон. Нийтэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх шийтгэлийн төрөл орчин үеийн агуулгаараа анх Их Британид 1973 оноос бий болж хэрэглэгдэж байгаа. Монгол Улсын хууль тогтоомжид энэ төрлийн ял нь хүнд хүчир ажил хийлгэх, засан хүмүүжүүлэх жил хийлгэх, албадан ажил хийлгэх гэсэн нэрээр хуульчлагдаж ирсэн. 2015 оны Эрүүгийн хуулиар “нийтэд тустай ажил хийлгэх ял”-ын зохицуулалтаар гэмт хэрэг үйлдсэн

этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр түүний жам ёсны эрхэд халдахгүйгээр учруулсан хор уршгаа арилгах боломж олгосон юм. Мөн хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, жирэмсэн эмэгтэй, хүний насны онцлогийг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулж болохгүй этгээдийг тусгайлан заасан нь энэрэнгүй ёсны зарчмын агуулгын хүрээнд байгаа юм.

Хорих ял оногдуулахгүйгээр гэмт этгээдэд тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд зорчихыг даалгах, түүний зорчих эрхийг хязгаарлах ялын төрөл нь эрүүгийн эрх зүйн эрхийн актуудад бий болоод удаагүй байгаа. Энэ ялын хорих ялаас гол ялгаа нь ялтны ажил хөдөлмөр эрхэлж гэр бүлээ асран хамгаалах, гэр бүлийн гишүүдтэйгээ чөлөөтэй харилцах зэрэг суурь эрхийг нь зөрчихгүйгээр түүнийг дахин хүмүүжүүлж давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд хорих ялтай харьцуулахад өндөр үр дүнтэйд нь оршино. XX зууны сүүл, XXI зууны эхэн үеэс Аргентин, Их Британи, АНУ, Турк, Испани зэрэг улс орнуудын хууль тогтоомжид гэрийн хорио гэсэн ялын шинэ төрөл бий болсон. Оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг оногдуулдаг ялын төрөл болох “зорчих эрхийг хязгаарлах” ялыг 2015 оны Эрүүгийн хуулиар шинээр бий болгосон. Энэ зохицуулалт нь шүүхээс оногдуулж буй биечлэн хорих ял оногдуулдаг практикийг өөрчлөх зорилгоор гарч ирсэн ч уг ялыг хэрэглэхийг 2021 он хүртэл бэлтгэл ажлыг хангах зорилгоор түдгэлзүүлжээ. 2021 он гараад зорчих ялыг хэрэглэх хууль зүйн бүрэн боломж бүрдсэн ч зарим шүүхүүдийн практикт



энэ төрлийн ялыг улсын яллагчийн зүгээс санал болгосон ч хэрэглэх тохиолдол тун бага байгаа нь уламжлалт эрүүгийн хариуцлагын тогтолцооны ойлголтын хүрээнээс гарч чадаагүйг харуулаад байна. Энэ төрлийн ялыг практикт хэрэгжүүлэхэд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгслийн боломж, хүртээмж, хүн амын тархалт суурьшил, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг тулгарах бэрхшээлүүдийг байхыг үгүйсгэхгүй.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх: Эрүүгийн эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны бие даасан салбар болж хөгжихөд хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хохирогчийн оролцоо багасаж, гэмт хэргийн бодит байдлыг тогтоох үйл ажиллагааг зөвхөн төрийн байгууллагууд хэрэгжүүлж гэм буруутай этгээдийг тухайн улсын нэрийн өмнөөс ялаж, хариуцлага хүлээлгэдэг зохицуулалт давамгайлсан нийтийн эрх зүйн шинжтэй болох үйл явц нөлөөлсөн. Гэтэл сүүлийн үед эрүүгийн эрх зүйд хувийн эрх зүйн диспозитив хэм хэмжээний агууламж өсөж, ял оногдуулахад хохирогчийн нөлөө ихсэх хандлагатай байна. Өмнө нь эрүүгийн хариуцлагын гол зорилго нь гэмт этгээдийг залхаан цээрлүүлэх байсан бол орчин үед нийгэмд шударга ёсыг тогтоож, нийгмийн сөргөлдөөнийг шийдвэрлэх нь ялын тэргүүний зорилго болжээ. Энэхүү концепц нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь ял шийтгэл хүлээлгэхээс гадна хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн, нийгмийн харилцаанд учирсан хохирлыг арилгаж “шударга ёсыг тогтоох” зорилготой гэсэн агуулгатай байна. Ийм зохицуулалт Австрали, Бельги, Герман зэрэг улс орнуудын хууль тогтоомжид

тусгагдсан²⁴. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйлд гэм буруугаа хүлээн зөвшөөрч, учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан эсхүл учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлж буй шүүгдэгчид хүлээлгэх хариуцлагыг хөнгөрүүлэх, хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн харгалзах зэрэг арга хэмжээнүүдийг тусгаж өгсөн нь 2002 оны Эрүүгийн хуульд хохирол, хор уршгийг арилгасан хүнээс гадна хохирол, хор уршгийг арилгахаа илэрхийлсэн этгээдэд ч энэ боломжийг олгох дэлгэрэнгүй, өргөн хүрээг хамарсан зохицуулалт болжээ.

Эмэгтэй хүний энэрэнгүй ёсны зарчмаар эдлэх давуу байдал нь: Эмэгтэй хүнийг хууль тогтоогч бусад субъектээс онцгойлон авч үзэн ял оногдуулдаг нь энэрэнгүй ёсны зарчимтай холбоотой гэдгийг тайлбарлах шаардлага ч байхгүй. 1929 оны Шүүх цаазын бичигт эмэгтэй хоригдлыг бусад хоригдлуудаас тусдаа хорьж, жирэмсэн байгаа бол төрөхөөс урьд болон хойно 6 сарын чөлөө олгож эмэгтэй хүнд бусдаас илүү боломж өгөх зохицуулалт Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжууд дахь энэрэнгүй ёсны анхны илрэлүүдийн нэгээр тооцогддог. Мөн цаазаар авах ялыг насанд хүрээгүй хүүхэд, 60 дээш насны эрэгтэйчүүд болон бүх насны эмэгтэйчүүдийн хувьд халдаан хэрэглэхийг хориглосон нь хүний физиологийн онцлогт тохируулан хийсэн, тус хуулийн энэрэнгүй байх зарчимд бүрэн нийцсэн зохицуулалт байсан. Хорих ялын хувьд 1961 оны Эрүүгийн хуулиар 18 насанд хүрээгүй этгээд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд, 50-аас дээш насны эмэгтэйчүүдэд хорих

²⁴ Додонов В. Н. Сравнительное уголовное право. Общая часть. М.: Юрлитинформ, 2009. 15 дахь тал



ялын дээд хэмжээг ялгамжтай байдлаар 10 жил, 1986 оны хуулиар 15 жил болгон тогтоосон нь бас л хүний нас, хүйс, бие хамгаалах чадвар зэргийг харгалзсан энэрэнгүй ёсны зарчмын илрэл юм. Үүнээс гадна 1961 оны Эрүүгийн хуулиар 8 нас хүрээгүй хүүхэдтэй эх болон жирэмсэн эмэгтэйн хувьд нутаг зааж суулгах, нутгаас зайлуулах, ялын төрлийг хэрэглэхийг хязгаарлаж ялгамжтай байдлаар ял оногдуулах нь эрүүгийн хариуцлагыг гэмт этгээдээс гадна түүний үр хүүхдэд халдаан хэрэглэхгүй, хүүхдийн эрхийг онцгойлон хамгаалах төрийн үүрэгт хамаарах асуудал болдог талтай. Энэ хэм хэмжээний агуулга 1986 оны хуульд 16 насны 4-өөс дээш хүүхэдтэй эмэгтэй хүнд дээрх төрлийн ялыг хэрэглэхгүй байх тухай зохицуулалт болж өргөжсөн. Ганц бие эцэг, бага насны хүүхэдтэй эхийн хувьд гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө хариуцлага заавал хүлээх ёстой боловч төрийн нийгмийн өмнө хүлээсэн хүмүүнлэг хандах, гэр бүлийг хамгаалах үүрэг нь нийгмийг гэмт халдлагаас хамгаалах үүргээсээ илүү жинтэй болохыг харуулж байгаа.

Насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудалд энэрэнгүй ёсны зарчмын илрэл: Хүний насны физиологи, сэтгэхүйн онцлогт тохируулан бусдаас хөнгөн ял оногдуулж, хариуцлагыг хөнгөрүүлж мөн үүнээс чөлөөлөх нь эрүүгийн эрх зүй дэх энэрэнгүй ёсны зарчмын гол илэрхийлэл болдог онцлогтой. XIX зууны дунд үе хүртэл ихэнх улс орнуудын хууль тогтоомжид насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгай журам зохицуулагдаагүй байсан. Ингэхдээ насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдэгсдэд насанд хүрсэн хүнтэй адил эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ цаазаар авах ял ч оногдуулдаг байжээ.

Гэвч хүмүүнлэг ёсны зарчмын хөгжлийг дагаад насанд хүрээгүй хүнд хариуцлага оногдуулахдаа түүнийг шийтгэхээс илүүтэйгээр хүмүүжүүлэх чиглэл давамгайлж эхэлсэн. Нидерланд, Унгар, Монгол Улс²⁵ зэрэг улс орнуудад эрүүгийн хуулийн тусгай бүлэг зохицуулалтаар насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага оногдуулдаг бол Испани, Швейцар гэсэн орнуудад эрүүгийн кодекжүүлсэн хуулиас гадна тусгай хэм хэмжээний актаар энэ харилцааг зохицуулдаг. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн нас, хэрэг хариуцах чадвар зэрэг ойлголтууд нийгмийн сэтгэхүй хөгжихийн хэрээр улам өргөжиж анх 1926 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичигт тогтоосон насны доод хязгаар 10 насыг 1929 оны хуулиар 14 нас болгож, 1934 оны хуулиар 16 нас болгосон. 1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулиар хулгай, хүний биед гэмтэл учруулах, хүн алах, алахыг завдах зэрэг хэргүүдэд эрүүгийн хариуцлагад татах насны доод хязгаарыг 14 нас болгон хуульчилсан шинэ зохицуулалт орж ирсэн. Энэхүү нийгэмд хор аюул ихтэй хүнд хэргүүдэд хэрэг хариуцах чадвартай гэж үзэх нийтлэг наснаас доогуур буюу 14-16 насны хүнд хариуцлага хүлээлгэж тусгай зохицуулалт одоогийн эрүүгийн хуульд ч уламжлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгээр насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тусгай зохицуулалтыг бий болгон, тэдгээрийн насны болон бие, сэтгэл санааны онцлогийг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг ялын төрлүүдийг хэрэглэхээс гадна хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, шийтгэх тогтоолын биелэлтийн хойшлуулж дээрх хугацаанд

²⁵ МУ-ын Эрүүгийн хууль.2015 §8 дугаар бүлэг



хүлээлгэсэн үүргээ зөрчөөгүй бол ялаас ч чөлөөлөх хууль зүйн боломж бий болгожээ. Мөн насны онцлогоос хамааран хүүхдэд энэрэнгүй хандах ёсны үүднээс ЭХ-ийн 5.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар 18 насанд хүрээгүй хүнд бүх насаар нь хорих ял оногдуулахгүй байх нь 2002 оны ЭХ болон социалист чиг баримжаатай үеийн эрүүгийн хууль тогтоомжуудад энэ насны хүмүүст цаазаар авах ял оногдуулахыг хориглосон заалттай зорилгын хувьд ижил гэж үзэж болно.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд хүний сэтгэхүйн хөгжил, нийгмийн хандлага, хөгжил асар хурдтай явагдаж байгаа энэ үед шинэ гэмт хэргүүдийн төрөл бий болохын зэрэгцээ гэмт хэрэгт холбогдох хүмүүсийн цар хүрээ тэлэгдэж, тэдгээр хүмүүсийн нийгмийн бүрэн эрхт гишүүний хувьд сурч боловсрох, шударгаар орлого олж ажил хөдөлмөр эрхлэх, гэр бүл үр хүүхдүүдээ асран хамгаалж хувийн харилцаа үүсгэх, нийгэмших зэрэг нэн тэргүүний эрхүүдийг зөрчихгүйгээр гэмт хэрэг үйлдсэн үйлдэлд нь хариуцлага хүлээлгэх боломжуудыг судалж, гарах гарцыг олох шаардлага тулгарсаар байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ эрүүгийн хариуцлагыг зөвхөн тухайн хүнд л хамаатуулж, яллагдагч хохирогч эвлэрсний үндсэн дээр яллагдагчийн нас, хүйс, гэр бүлийн байдал зэргийг харгалзан хариуцлагаас чөлөөлөхийг шударга ёсны зарчмыг зөрчихгүйгээр зохицуулах хэм хэмжээнүүдийг бий болгон, нийгмийн шаардлагатай нийцүүлэн боловсронгуй болгох нь эрүүгийн хуулийг хүнлэг ёсны хандлагатай хууль болгохын томоохон шалгуур үзүүлэлт учраас эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хүрээнд энэрэнгүй ёсны зарчмыг заавал хуульчилж, шүүх ял оногдуулахдаа хувь хүний нөхцөл

байдалтай уялдуулан шударга ёс, хүний жам ёсны эрх, хүнлэг хандлагын аль алинд нь нийцэх шийдвэр гаргах эрх зүйн орчин бүрдүүлж өгөх хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Мөн манай улсын хувьд шинэлэг зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэх хууль эрх зүйн орчныг дэлгэрэнгүй болгож, хэрэглэх хүрээг нь өргөжүүлэх асуудалд ач холбогдол өгвөл төрийн хүний жам ёсны эрхийн хүндэтгэх үүрэг болон нийгмийг гэмт халдлагаас хамгаалах үүргийн огтлолцлыг олоход томоохон алхам болж чадна гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж:

- Баярсайхан.Б нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/. УБ.,2011
- БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс. УБ.,1973
- Монгол Улсын эрүүгийн эрх зүй. /ерөнхий анги/. УБ.,1999

II. Гадаад эх сурвалж:

- Kirsten Walsh. The Idea of Principles in Early Modern Thought: Interdisciplinary Perspectives/ Peter R. Anstey. - Routledge, 2017
- Christian List и Laura Valentini. The Methodology of Political Theory (англ.) // Oxford Handbook of Philosophical Methodology
- Scholten, Paul. Algemeen Deel / Mr. C. Asser's Handleiding. - Zwolle: Tjeenk Willink, 1931.
- Hood, Roger. The Death Penalty: A World-Wide Perspective. - 3rd ed. - Oxford: Clarendon Press, 2002.
- AMNESTY INTERNATIONAL GLOBAL REPORT. DEATH SENTENCES AND EXECUTIONS.2019



- Новейший философский словарь. Минск, 2003.
- Курс уголовного общая часть. М., 1999
- Российское уголовное право. Общая часть / Под ред. В. С. Комиссарова. СПб., 2005
- Курс уголовного права. Общая часть. Том 1: Учение о преступлении. М., 2002.
- Уголовное право России. Практический курс. Нэмж засварласан 3 дахь хэвлэл. М., 2007.
- Маркс К., Энгельс Ф. Сочинения. 2-е изд. Т. 8.
- Уголовное право. Общая часть / ред. И. Я. Козаченко, З. А. Незнамова. Нэмж засварласан 3 дахь хэвлэл. М., 2001
- Додонов В. Н. Сравнительное уголовное право. Общая часть. Монография / М.: Юрлитинформ, 2009
- Всемирная история государства и права. Энциклопедический словарь. - М.: Инфра-М, 2001.
- Учение о наказании, 2002
- Иванова Н. Г., Никулина С. И., Яценко Б. В. Курс российского уголовного права. Общая часть. - Экономика, 2010

III. Эрх зүйн эх сурвалж:

- МУ-ын Эрүүгийн хууль /2015/
- МУ-ын Эрүүгийн хууль /2002/
- БНМАУ-ын Эрүүгийн хууль /1942/
- БНМАУ-ын Эрүүгийн хууль /1961/
- БНМАУ-ын Эрүүгийн хууль /1986/
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Хүүхдийн эрхийн конвенц

IV. Бусад эх сурвалж:

- Iran, Saudi Arabia, Sudan: End Juvenile Death Penalty. Human Rights Watch /<https://www.hrw.org/news/2010/10/08/iran-saudi-arabia-sudan-end-juvenile-death-penalty/> .
- <https://deathpenaltyinfo.org/news/kazakhstan-signs-global-treaty-to-abolish-death-penalty>
- <https://president.mn/2931/>
- <http://jnfreid.com/cdb/hannah.html>



Abstract

**PRINCIPLES OF HUMANITY
IN CRIMINAL LAW**

B.ARMANBEK

Court Reporter, Secretariat of Bayan-Ulgii Court

In the article is examined essence, the content and the form of the lawful principle of humanism as the principle, which defines concretely the lawful principle of validity. Special attention is paid to the embodiment of this principle in the Mongolian legislation and in the pravoprimenitelnoy activity and

an assessment was made as to whether this was taking place within the framework of modern trends in the development of global criminal law.

Keywords

criminal law, law principles, humanity, principles of humanity, punishment

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ХЯНАЛТ:
ТӨВ БАНКНЫ ШИЙДВЭРИЙГ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН
ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ**

Тэрбишийн МӨНХ-ЭРДЭНЭ /LL.M/¹

Оршил

- I. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн суурь үзэл баримтлал
- II. Төв банк /Монголбанк/-ны шийдвэр, үйл ажиллагаанд Захиргааны хэргийн шүүхээс эрх зүйн хяналт хэрэгжүүлэх нь
- III. ХБНГУ-ын Захиргааны хэргийн дээд шүүхээс Германы Холбооны банкны хараат бус байдлыг дүгнэсэн нь
- IV. Дүгнэлт

¹ /LL.M – University of Vienna/ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн цагийн багш

Lecturer (part-time), School of Law, the National University of Mongolia Judge, Administrative Court of First Instance, Ulaanbaatar



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ХЯНАЛТ: ТӨВ БАНКНЫ ШИЙДВЭРИЙГ ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ*

*Т.МӨНХ-ЭРДЭНЭ /LL.M – University of Vienna/
Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч,
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн цагийн багш*

Нэг. Оршил

Хэдийгээр 1992 оны Үндсэн хуульд Монгол Улсын Төв банк болох Монголбанкны эрх зүйн байдал, чиг үүргийн талаар бие даасан зохицуулалт шууд утгаараа хуульчлагдаагүй боловч Үндсэн хуулийн ерөнхий зарчим, эрх зүйн системчлэлийн үүднээс авч үзвэл Төв банкны эрх зүйн байдал, чиг үүргийг 1996 оны Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар¹ зохицуулсан.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ ...” гээд мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.” гэж Монголбанкны үндсэн зорилтыг тодорхойлж, 5 дугаар зүйлд тус банкны үйл ажиллагааны чиглэлийг хуульчлан тогтоож өгсөн.

* Энэхүү эрдэм шинжилгээний илтгэл нь хувь судлаач Т.Мөнх-Эрдэний судалгааны үр дүн бөгөөд ямар нэг байдлаар Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагын байр суурь, дүгнэлт санал биш, мөн түүнийг төлөөлөхгүй болохыг онцлон тэмдэглэж байна, Т.М

¹ <https://legalinfo.mn/mn/detail/483>, сүүлд 2021.11.16-нд үзсэн.

Дурдвал, 1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах; 2/мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; 3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; 4/банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих; 5/үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих; 6/гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах; 7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; 8/макро зохистой бодлого хэрэгжүүлэх гэсэн үндсэн 8 чиглэл байна.

Дээрх үндсэн чиглэлүүдийн хүрээнд Монголбанкнаас гаргасан аливаа шийдвэр, үйл ажиллагааны аль хэсэг нь эрх зүйт төрийн зарчмын дагуу захиргааны эрх зүйн аспектын үүднээс Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтын хүрээнд хамаарах вэ гэдэг суурь бөгөөд сонирхолтой /зарим талаараа онол-практикийн маргаантай/ эрх зүйн асуудал үүсдэг бөгөөд энэхүү асуудалд уг илтгэлээр бүрэн биш ч, голлох хэсгүүдийг авч үзэж, хариулт өгөхийг зорьсон болно.

Мөн зохиогч нь энэхүү эрдэм шинжилгээний илтгэлээрээ Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагын байр суурийг төлөөлөхгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна.



I. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн суурь үзэл баримтлал

Манай улс нэг талаас эрх зүйт төрийн зарчмыг 1992 оны Үндсэн хуулийн 1 дүгээр 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" хэмээн баталгаажуулсан бол нөгөө талаас олон улсын эрх зүйн эх сурвалжид, тухайлбал 2000 оны Европын Холбооны Үндсэн эрхүүдийн харта²-ийн 41 дүгээр зүйлд бэхжүүлэн заасан "сайн захиргаатай байх эрх" хэрэгжих минимум стандарт, нөхцөлийг мөн хуульчлан тогтоож өгсөн.

Тэрхүү хууль нь Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Захиргааны ерөнхий хууль³ юм. Тодруулбал, Захиргааны ерөнхий хуулийн эцсийн зорилго нь Монгол Улсад хууль тогтоомжид үндэслэсэн шийдвэр гаргадаг, шийдвэр гаргахаасаа өмнө тухайн шийдвэрийн эрх зүйн үйлчлэл шууд чиглэх этгээдийг сонсдог, шийдвэр, үйл ажиллагаа нь бодит нөхцөл байдалд нийцсэн, үр нөлөөтэй байдаг захиргааны байгууллагыг ажиллуулах буюу "сайн захиргаа"-г төлөвшүүлэх явдал гэж үзэж болно.

Энэ хүрээнд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт "хуульд үндэслэх; шуурхай, тасралтгүй

байх; хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх; үр нөлөөтэй байх; зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх; бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах; ашиг сонирхлын зөрчилтэй захиргааны үйл ажиллагаанаас татгалзан гарах, татгалзан гаргах боломжийг хангах; хууль ёсны итгэлийг хамгаалах" зарчмууд хуульчлагдсан болно.

Мөн Захиргааны ерөнхий хуулиар Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад хамаарахгүй захиргааны үйл ажиллагааг тодорхойлсон. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар дараах эрх зүйн харилцаанд Захиргааны ерөнхий хууль үйлчлэхгүй. Үүнд:

1/ хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон хууль тогтоох үйл ажиллагаа;

2/ Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагаа;

3/ Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүхийн гэмт хэрэг, эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа;

4/ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хяналт, нийгмийн хэв журмыг сахиулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

5/ онц болон дайны байдал зарласан үед зэвсэгт хүчин ашиглах, цэрэг хөдөлгөх;

6/ тагнуул, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон төрийн гадаад бодлогыг шууд хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа;

7/ Монгол Улсын Их Хурлын улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэр.

² https://www.europarl.europa.eu/charter/pdf/text_de.pdf, сүүлд 2021.11.16-нд үзсэн.

41 дүгээр зүйл. Сайн захиргаатай байх эрх Хүн бүр өөрийн асуудлыг Европын Холбооны байгууллага, нэгжүүдээр хараат бусаар, шударгаар, боломжийн хугацаанд шийдвэрлүүлэх эрхтэй.

(2) Энэ эрхэд дараах агуулга онцгой хамаарна:
- өөрт нь сөрөг нөлөөлөл учруулах аливаа арга хэмжээ авахаас өмнө хүн бүрийг сонсох;
- нууцлал, мэргэжлийн болон бизнесийн нууцад холбогдолтой хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх замаар хүн бүр өөрт хамааралтай материалтай танилцах, мэдээлэл авах эрх;
- захиргааны шийдвэр үндэслэлтэй байх, үндэслэлийг тайлбарлах үүрэг.

³ <https://legalinfo.mn/mn/detail/11259>, сүүлд 2021.11.16-нд үзсэн.



Тайлбар: “Улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор” гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас гаргасан төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлсон шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор, Улсын Их Хурлын тухайн шийдвэрээс салгаж болохгүй Засгийн газрын шийдвэрийг ойлгоно.

8/ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх ажиллагаа.

9/ Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тус тус хамаарна.

Түүнчлэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн⁴ 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Захиргааны ерөнхий хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй.” гэж заасан.

Дээрх хуулийн хэм хэмжээнүүдээс авч үзвэл, Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал нь Төв банк буюу Монголбанкны шийдвэр, үйл ажиллагааг Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад байлгахад чиглэсэн болохыг ойлгож болно.

Гэхдээ Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтын хамрах хүрээ, хязгаар нь Монголбанкны бүхий л шийдвэр, үйл ажиллагаанд хамааралтайгаар хэрэгжих үү гэдэг нь онолын нарийн үндэслэл бүхий хариулт шаардсан, нөгөөтэйгүүр зарим талаараа шүүхийн практикаар хэвшүүлэн тогтоох боломжтой асуудал гэж тайлбарлавал төдийлөн явцуурсан дүгнэлт болохгүй юм.

⁴ <https://legalinfo.mn/mn/detail/11703>, сүүлд 2021.11.17-нд үзсэн.

II. Төв банк /Монголбанк/-ны шийдвэр, үйл ажиллагаанд Захиргааны хэргийн шүүхээс эрх зүйн хяналт хэрэгжүүлэх нь

Захиргааны ерөнхий хуулиар захиргааны байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэлбэрийг захиргааны акт гаргах, захиргааны хэм хэмжээний акт батлах, захиргааны гэрээ байгуулах үйл ажиллагаа байхаар заасан.⁵

Мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэгт “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.” гэж, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн хэмжээнүүдээс үзэхэд нийтлэг шинж нь аль алинд захиргааны байгууллага байх, нийтийн эрх зүйн хүрээний асуудал байх, гадагш чиглэсэн буюу иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн байх гэсэн шинжүүдийг шаардсан байгааг төвөггүй харж болохоор байна.

Өөрөөр хэлбэл, Монголбанк нь захиргааны байгууллага болох, Монголбанкны гаргасан шийдвэр, үйл

⁵ Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийг үзэх.



ажиллагаа нийтийн эрх зүйн хүрээний асуудал байх, мөн гадагш чиглэсэн байх буюу иргэн, хуулийн этгээдэд шууд эрх зүйн үр дагавар үүсгэхээр тохиолдолд Монголбанкны гаргасан шийдвэр, үйл ажиллагаа Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад хамаарах магадлал үндсэндээ хангагдана гэж үзнэ.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монголбанкыг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.”² дахь хэсэгт “Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.”,³ 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монголбанк Засгийн газраас хараат бус байна.” гэж тус тус зааснаас үзвэл, Монголбанк нь Засгийн газрын харьяаны бус бие даасан байгууллага болох нь шууд ойлгогдож байх бөгөөд энэ агуулгаараа Монголбанк нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад заасан “хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг ...” гэдэгт хамаарах захиргааны байгууллага гэж үзнэ.

Харин Монголбанкны бүхий л шийдвэр, үйл ажиллагаа нь нийтийн эрх зүйн хүрээнд хамаарна гэж үзэх боломжгүй бөгөөд тухайн тохиолдолд шийдвэрт үндэслэсэн хуулийн хэм хэмжээ, харилцааны агуулга зэргээс хамаарч нийтийн, эсхүл хувийн эрх зүйн шинжтэй харилцааг дүгнэх боломжтой бөгөөд хувийн эрх зүйн шинжтэй харилцааг зохицуулсан бол Монголбанкны тухайн

шийдвэр нь Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад хамаарахгүй юм.

Монголбанканд хуулиар тогтоосон үйл ажиллагааны 8 үндсэн чиглэлээс⁶ үзэхэд зарим төрлийн үйл ажиллагааны чиглэл нь бодлогын /политикийн/ шинжтэй буюу эрх зүйн хэмжүүрээр үнэлж дүгнэх боломжгүй үйл ажиллагаа байгааг үгүйсгэж болохгүй. Тухайлбал, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах; мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах; макро зохистой бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд эдийн засаг, мөнгөний бодлогод суурилсан байдаг шинжээрээ эрх зүйн хэмжүүрээр шууд үнэлж, дүгнэх боломжгүй шийдвэр, үйл ажиллагаанд хамаарах магадлал тун өндөр байна.

Тиймээс хэдийгээр Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан Захиргааны ерөнхий хууль үйлчлэхгүй харилцаанд Монголбанкны дээр дурдсан үйл ажиллагааны чиглэлүүд хамаарах агуулга заагдаагүй боловч мөн зүйлийн 3.1.7 дахь заалтыг уг харилцаанд төсөөтэй хэрэглэх боломж захиргааны эрх зүйн онолын хүрээнд хязгаарлагдахгүй гэж үзэх боломжтой.

⁶ Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйл. 1/мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах; 2/мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; 3/Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; 4/банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих; 5/үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих; 6/гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах; 7/банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; 8/макро зохистой бодлого хэрэгжүүлэх.



Учир нь, Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад заасан “Монгол Улсын Их Хурлын улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ...” гэдэг урьдчилсан нөхцөлийг бодлогын шинжтэй шийдвэр, үйл ажиллагаа буюу эрх зүйн хэмжүүрээр шууд үнэлж, дүгнэх боломжгүй шийдвэр, үйл ажиллагаа гэдэгтэй адилтан авч үзэж, тайлбарлан хэрэглэх боломжтой.

Тодруулбал, Монголбанкнаас гаргасан мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах талаарх шийдвэр, мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх талаарх шийдвэр, Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх талаарх шийдвэр, гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах талаарх шийдвэр, макро зохистой бодлого зэрэг нь эрх зүйн хэмжүүрээр дүгнэх боломжгүй бодлогын шинжтэй шийдвэр, үйл ажиллагаа учраас Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад хамаарахгүй байх магадлал туйлын өндөр юм.

Харин түүнээс бусад иргэн, хуулийн этгээдэд шууд эрх зүйн үр дагавар үүсгэсэн, нийтийн эрх зүйн хүрээнд хамаарах шийдвэр, үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад байх учиртай.

Тухайлбал, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, 19¹ дүгээр зүйлд заасан Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих, 19² дугаар зүйлд заасан Хадгаламжийн даатгалын корпорацийн үйл ажиллагаанд хяналт тавих, 20 дугаар зүйлд заасан Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих, 20¹ дүгээр зүйлд заасан Банкинд зээл олгох нийтлэг

журамтай холбоотой үйл ажиллагаа, 25, 25¹, 25², 25³ дугаар зүйлд заасан Монголбанкны хянан шалгагч, хянагчийн шийдвэр үйл ажиллагаа, 28 дугаар зүйлд заасан Монголбанкны Ерөнхийлөгчийн гадагш чиглэсэн эрх зүйн үр дагавар бүхий шийдвэр, үйл ажиллагаа зэрэг нь хамаарна гэж үзэх үндэслэлтэй.

Энэхүү илтгэлд ач холбогдолтой гэж үзэж, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2019 оноос 2021 оны 10 дугаар сар дуустал хугацаанд тус шүүхэд Монголбанк, түүний газар, хэлтэс, нэгжийн эрх бүхий албан тушаалтнууд хариуцагчаар татагдан оролцож, шүүхийн шийдвэр гарсан захиргааны хэргийн тойм судалгааг хийлээ. Тус тойм судалгааг энэ илтгэлийн **Хавсралт** хэсгээс харна уу.

Судалгаанаас үзэхэд үндсэндээ бүх тохиолдолд Монголбанкны хянан шалгагч, улсын байцаагч нарт холбогдох тэдгээрийн гаргасан шийтгэлийн хуудастай холбогдуулан арилжааны банк буюу хуулийн этгээдүүдээс ирүүлсэн нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэсэн байна.

Дээрхээс дүгнэхэд Захиргааны хэргийн шүүх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу өөрийн харьяалан шийдвэрлэх хэргийн харьяаллын дагуу маргааныг хянан шийдвэрлэсэн байна.

III. ХБНГУ-ын Захиргааны хэргийн дээд шүүхээс Германы Холбооны банкны хараат бус байдлыг дүгнэсэн нь

Илтгэлийн энэ хэсэгт манай улстай эрх зүйн нэг бүлд хамаарах бөгөөд манай улсын хувьд эрх зүйн рецепцийг олон тоогоор хийсэн гэдэг утгаар нь



Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын Захиргааны хэргийн дээд шүүх дээр өрнөж байсан нэгэн кэйсээс жишээ болгон авч үзлээ.

Энэхүү кэйс нь ХБНГУ-ын Захиргааны хэргийн дээд шүүхээр 1973 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр эцэслэн шийдвэрлэгдсэн⁷ бөгөөд энэхүү эрх зүйн маргааны гол зүйл нь “Банкны заавал байлгах нөөцийн талаарх Германы Холбооны банк /Deutsche Bundesbank/-ны заавар” захиргааны акт болох эсэх, мөн энэхүү зааврыг Холбооны банк батлах эрх хэмжээтэй эсэх, хэрэв тийм бол энэхүү зааврыг батлах эрх хэмжээ нь Холбооны Үндсэн хуульд нийцсэн эсэх гэсэн гурван томоохон эрх зүйн асуудал байсан.

Маргааны үйл баримтаас товч танилцуулахад:

Германы Холбооны банкны 1962 оны 9 дүгээр сарын 3-ны болон 1963 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн заавраар 1965 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл урт хугацаатай зээл олгох үйлчилгээ явуулдаг зээлийн үйлчилгээний байгууллагуудын ностро-дансны үлдэгдлийг банкны заавал байлгах нөөцөд хамруулах үүрэггүй буюу заавал байлгах нөөцөөс чөлөөлөх зохицуулалтыг Холбооны банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрт зааснаар хийсэн байжээ.

Гэтэл Германы Холбооны банкны Зөвлөлийн 1965 оны 5 дугаар 06-ны өдрийн Тогтоолоор энэхүү зааварт өөрчлөлт оруулж, урт хугацаатай зээл олгох үйлчилгээ эрхэлдэг зээлийн үйлчилгээний тодорхой байгууллагуудыг банкны заавал байлгах нөөцийн үүргээс

чөлөөлөх болон тэдний ностро-дансны үлдэгдлийг заавал байлгах нөөцөд хамруулах шийдвэрийг Холбооны банк гаргах боломжтой байхаар зохицуулжээ.

Энэхүү шийдвэрийн үйлчлэлд олон тооны банкууд хамарсан бөгөөд тэдгээрээс 4 этгээд нь Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Тэд маргахдаа “Холбооны банк ийм зохицуулалт хийх эрх хэмжээ байхгүй, Холбооны банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг энэхүү заавар зөрчсөн, хэрвээ энэ заалтаар эрх олгосон гэж үзвэл энэхүү заалт нь Холбооны Үндсэн хуулийг зөрчсөн байна” гэх зэрэг үндэслэлийг дэвшүүлсэн байдаг.

Германын захиргааны хэргийн шүүхүүд дүгнэхдээ:

Зээлийн үйлчилгээ явуулдаг байгууллагад заавал байлгах нөөц хүлээлгэх үүргийн харилцаа нь ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “нийтийн эрх зүйн харилцаа” мөн гэж дүгнэсэн.

Учир нь, уг харилцаанд захирах-захирагдах ёсны шинж агуулагдаж байхаас гадна нэг талын захирамжилсан шинжтэй арга хэмжээ болно. Мөн энэ харилцаа нь үндсэн хуулийн эрх зүйн харилцааны бус, харин захиргааны эрх зүйн харилцааны агуулгыг илэрхийлнэ гэж дүгнэсэн.

Өөрөөр хэлбэл, энэхүү маргаан нь Захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх эрх зүйн маргаан болно гэж үзсэн.

Харин нэхэмжлэлийн шаардлагууд үндэслэлгүй гэж үзсэн. Тодруулбал, Германы Холбооны банк Холбооны банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн

⁷ <https://research.wolterskluwer-online.de/document/f196e5ab-3545-4c9a-8f75-73a0ad2fef83> энэ линкээр орж герман хэл дээр танилцах боломжтой. Сүүлд 2021.12.06-ны өдөр хандсан.



1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийн дагуу урт хугацаатай зээл олгох үйлчилгээ явуулдаг зээлийн үйлчилгээний байгууллагуудыг банкны заавал байлгах нөөцийн үүргээс чөлөөлөх болон тэдний ностро-дансыг заавал байлгах нөөцөд хамруулах шийдвэр гаргах эрх хэмжээтэй гэж үзсэн.

Өөрөөр хэлбэл, Холбооны банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь тийм эрх хэмжээг олгосон заалт байна гэж дүгнэжээ.

Түүнчлэн Холбооны банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Холбооны Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэрийг зөрчөөгүй байна гэж үзсэн.

Учир нь, Холбооны Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх өгүүлбэр нь Холбооны Засгийн газар, Холбооны сайд болон Муж улсуудын Засгийн газарт Холбооны хуулиар “журам батлах” эрхийн шилжүүлгийг зөвшөөрсөн зохицуулалт бөгөөд тиймээс энэхүү зохицуулалт нь Холбооны банкны журам, заавар тогтоох асуудалд үйлчлэхгүй гэж дүгнэсэн.

Тиймээс энэ тохиолдолд Холбооны Үндсэн хуулийн 88 дугаар зүйл тусгайлсан зохицуулалт болохоор байна гэж үзсэн.

Холбооны Үндсэн хуулийн 88 дугаар зүйлд “Холбоо нь валют-мөнгөн тэмдэгийн төв банк буюу Холбооны банкыг байгуулна” гэж заасан.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн дээрх заалтаар холбооны хууль тогтоогчид / Бүндэстатг/ ийм банк байгуулах Үндсэн хуулийг үүргийг хүлээлгэсэн гэж үзсэн.

Хэдийгээр Холбооны Үндсэн хуулийн 88 дугаар зүйлд Холбооны банкны үндсэн чиг үүргийг нэн тодорхой байдлаар тусгаж өгөөгүй боловч “валют-мөнгөн тэмдэгийн банк” гэх тодотголын

цаана мөнгөний бодлого хэрэгжүүлэх, мөнгөний хэрэгслээр дамжуулан макро-эдийн засгийг дэмжих, мөнгөний үнэ цэнийг баталгаатай хангах зэрэг чиг үүргийг олгосон гэж тайлбарлах боломжтой /гэхдээ энэ нь нээлттэй/ гэж дүгнэсэн.

Энэ эрх зүйн маргааны цаана хөндөгдсөн бас нэг чухал асуудал нь Холбооны банкны хараат бус байдлын асуудал юм.

Учир нь, дээр дурдсанаар Холбооны Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Холбооны Засгийн газарт журам тогтоох эрхийг хуулиар шилжүүлж болохыг зөвшөөрснөөс бус Холбооны банканд тийм эрхийн шилжүүлэг олгоогүй байгаа нь Холбооны Засгийн газраас Холбооны банкны үйл ажиллагаа хараат бус байх ёстой зарчимд хэрхэн нийцэх, ямар харилцан хамааралтай байх тухай асуудал хөндөгдсөн.

Нэгэнт Холбооны Үндсэн хуулийн холбогдох заалтуудад Холбооны банкны үндсэн чиг үүрэг болон хараат бус байдлын асуудлаар “нэн тодорхой” зааж өгч чадаагүй тул Германы Захиргааны хэргийн дээд шүүх онолын тайлбаруудыг хангалттай хийх шаардлагатай болсон.

Үүнд тус шүүх Лампе, Бёкманн, Уленбрук, Гаугенрийдэр, Фёген зэрэг эрдэмтдийн туурвисан Холбооны банкны хараат бус байдлын зарчмын талаарх онолын үзэл баримтлалуудыг ихээхэн хэмжээгээр эш татан бичсэн байдаг.

Мөн Германы Эзэнт гүрний Төв банкны түүхээс эхлэн түүнээс хойших үеийн Төв банкны эрх зүйн байдлын түүхэн хөгжлийн талаар хүртэл шийдвэртээ оруулсан нь тун ач холбогдолтой болсон байдаг.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Холбооны банкны хараат бус байдлын



талаар тухайлан дүгнэсэн ямар нэг шийдвэр 1973 оны үед гараагүй байгаа болохыг мөн дүгнэж өгсөн.

Дээрх бүгдээс дүгнээд ХБНГУ-ын Захиргааны хэргийн дээд шүүх Холбооны Үндсэн хуулийн 88 дугаар зүйлд Холбооны банкны хараат бус байдлын талаар зохицуулаагүй ч бас үгүйсгээгүй гэж тогтоосон нь эрх зүйн хувьд зарчмын чухал ач холбогдолтой шийдвэр болж түүхэнд үлдсэн байна.

IV. Дүгнэлт

Дээрх эрдэм шинжилгээний илтгэлийн гол санааг нэгтгэн дүгнэвэл:

1. Манай улс нэг талаас эрх зүйт төрийн зарчмыг 1992 оны Үндсэн хуулийн 1 дүгээр 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" хэмээн баталгаажуулсан бол нөгөө талаас олон улсын эрх зүйн эх сурвалжид, тухайлбал 2000 оны Европын Холбооны Үндсэн эрхүүдийн харта-ийн 41 дүгээр зүйлд бэхжүүлэн заасан "сайн захиргаатай байх эрх" хэрэгжих минимум стандарт, нөхцөлийг мөн хуульчлан тогтоож өгсөн.

2. Тэрхүү хууль нь Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Захиргааны ерөнхий хууль юм. Тодруулбал, Захиргааны ерөнхий хуулийн эцсийн зорилго нь Монгол Улсад хууль тогтоомжид үндэслэсэн шийдвэр гаргадаг, шийдвэр гаргахаасаа өмнө тухайн шийдвэрийн эрх зүйн үйлчлэл шууд чиглэх этгээдийг сонсдог, шийдвэр, үйл ажиллагаа нь бодит нөхцөл байдалд нийцсэн, үр нөлөөтэй байдаг захиргааны байгууллагыг ажиллуулах буюу "сайн захиргаа"-г төлөвшүүлэх явдал гэж үзэж болно.

3. Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал нь Төв банк буюу Монголбанкны шийдвэр, үйл ажиллагааг

Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад байлгахад чиглэсэн болохыг ойлгож болно.

4. Монголбанк нь захиргааны байгууллага болох, Монголбанкны гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нийтийн эрх зүйн хүрээний асуудал байх, мөн гадагш чиглэсэн байх буюу иргэн, хуулийн этгээдэд шууд эрх зүйн үр дагавар үүсгэхээр тохиолдолд Монголбанкны гаргасан шийдвэр, үйл ажиллагаа Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад хамаарах магадлал үндсэндээ хангагдана гэж үзнэ.

5. Монголбанканд хуулиар тогтоосон үйл ажиллагааны 8 үндсэн чиглэлээс үзэхэд зарим төрлийн үйл ажиллагааны чиглэл нь бодлогын /политикийн/ шинжтэй буюу эрх зүйн хэмжүүрээр үнэлж дүгнэх боломжгүй үйл ажиллагаа байгааг үгүйсгэж болохгүй. Тухайлбал, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах; мөнгөний бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх; гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах; макро зохистой бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд эдийн засаг, мөнгөний бодлогод суурилсан байдаг шинжээрээ эрх зүйн хэмжүүрээр шууд үнэлж, дүгнэх боломжгүй шийдвэр, үйл ажиллагаанд хамаарах магадлал тун өндөр байна.

6. Харин түүнээс бусад иргэн, хуулийн этгээдэд шууд эрх зүйн үр дагавар үүсгэсэн, нийтийн эрх зүйн хүрээнд хамаарах шийдвэр, үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн хяналтад байх учиртай.

7. Судалгаанаас үзэхэд Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх үндсэндээ бүх тохиолдолд Монголбанкны хянан шалгагч, улсын байцаагч нарт холбогдох



тэдгээрийн гаргасан шийтгэлийн хуудастай холбогдуулан арилжааны банк буюу хуулийн этгээдүүдээс ирүүлсэн нэхэмжлэлээр захиргааны хэрэг үүсгэсэн байна.

Дээрхээс дүгнэхэд Захиргааны хэргийн шүүх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт заасны дагуу өөрийн харьяалан

шийдвэрлэх хэргийн харьяаллын дагуу маргааныг хянан шийдвэрлэсэн байна.

8. ХБНГУ-ын Захиргааны хэргийн дээд шүүхийн 1973 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн шийдвэрээр “Холбооны Үндсэн хуулийн 88 дугаар зүйлд Холбооны банкны хараат бус байдлын талаар шууд зохицуулаагүй ч бас үгүйсгээгүй” гэж тогтоосон нь эрх зүйн хувьд зарчмын чухал ач холбогдолтой шийдвэр болж түүхэнд үлдсэн байна.



Хавсралт

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2019-2021 оны 10 дугаар сар дуустал хугацаанд Монголбанк хариуцагчаар татагдан оролцсон захиргааны хэргийн шийдвэрлэлтийн судалгаа /тойм/

	Нэхэмжлэгч	Хариуцагч	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар	Нэхэмжлэлийн шаардлага
1	Хас банк ХХК	Монголбанкны Хяналт Шалгалтын Газрын тусгай хяналтын албаны хянан шалгагч Б.Мандахнаран	2019-05-08 128/ ШШ2019/0279	Монголбанкны Хяналт Шалгалтын Газрын тусгай хяналтын албаны хянан шалгагч Б.Мандахнарангийн 2018 оны 12 сарын 06-ны өдрийн №0050062 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах
2	Ариг банк ХХК	Монголбанкны Хянан шалгах газрын Хянан шалгах хэлтсийн улсын ахлах байцаагч Б.Галия	2019-06-17 128/ ШШ2019/0377	Монголбанкны Хянан шалгах газрын Хянан шалгах хэлтсийн улсын ахлах байцаагч Б.Галиягийн 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 0050013 дугаар шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгуулах
3	Хаан банк ХХК	Монголбанкны хяналт шалгалтын газрын тусгай хяналтын албаны ахлах хянан шалгагч Г.Даваахүү, хянан шалгагч Б.Халиунаа нар	2019-07-01 128/ ШШ2019/0413	Монголбанкны хяналт шалгалтын газрын тусгай хяналтын албаны ахлах хянан шалгагч Г.Даваахүү, хянан шалгагч Б.Халиунаа нарын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр гаргасан 0050046, 005105 тоот шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгуулах
4	Хас банк ХХК	Монгол банкны хяналт шалгалтын газрын улсын байцаагч Т.Одонтунгалаг	2019-09-26 128/ ШШ2019/0617	Монгол банкны хяналт шалгалтын газрын улсын байцаагч Т.Одонтунгалагийн 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 0050040 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах
5	Чингис хаан банк ХХК	Монголбанкны ахлах хянан хянан шалгагч, улсын байцаагч Ч.Даваажав	2021-01-04 128/ ШШ2021/0012	Монголбанкны ахлах хянан хянан шалгагч, улсын байцаагчийн 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 0050243 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах



6	Чингис хаан банк ХХК	Монголбанкны ахлах хянан хянан шалгагч, улсын байцаагч Ч.Даваажав	2021-01-13 128/ ШШ2021/0035	Монголбанкны ахлах хянан хянан шалгагч, улсын байцаагч Ч.Даваажавын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 0050242 тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах
7	Тээвэр хөгжлийн банк ХХК	Монгол банкны Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн хянан шалгагч, улсын байцаагч Н.Зоригоо	2021-01-28 128/ ШШ2021/0073	Монгол банкны Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн хянан шалгагч, улсын байцаагч Н.Зоригоогийн 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 0050216 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах
8	Тээвэр хөгжлийн банк ХХК	Монголбанкны хянан шалгагч, улсын байцаагч Н.Зоригоо	2021-03-03 128/ ШШ2021/0149	Монголбанкны хянан шалгагч, улсын байцаагч Н.Зоригоогийн 2020.10.08-ны өдрийн 0050217 дугаартай шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах

ШҮҮГЧИД ХҮЛЭЭЛГЭХ САХИЛГЫН ХАРИУЦЛАГЫН ПРОЦЕССЫН ЗАРИМ АСУУДАЛ

Одончимэгийн БАДМААРАГ¹

- I. Удиртгал
- II. Үндэслэл
- III. Дүгнэлт
- IV. Ном зүй

¹ Дотоод хэргийн их сургуулийн магистрант
LL.M. candidate, the University of Internal Affairs



ШҮҮГЧИД ХҮЛЭЭЛГЭХ САХИЛГЫН ХАРИУЦЛАГЫН ПРОЦЕССЫН ЗАРИМ АСУУДАЛ

О.БАДМААРАГ. Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Удиртгал

Бага байхад хөгшин ээжийнхээ үлсэн ярьсан, хий гэсэн болгоныг хийж өслөө. Нэг өдөр хөгшин ээж минь өөрийн хамгийн бага охинтойгоо ярьж байхыг нь хүүхдийн сониучхан зангаар нууцаар чагнатал миний хүү даанч яаавдаа гэж халаглан хоолой зангирч ярих нь тэр. Уг нь миний хүү буруугүй юм л даа. Гай нь таарч найзыг нь зодож байсан согтуу хүмүүсээс найзыгаа өмөөрч чулуу шидсэн нь буруудлаа. Хэрэв тийм үйлдэл хийгээгүй бол миний хүү өнөөдөр алуурчин нэр зүүхгүй байлаа гэсээр гунигтай санаа алдаж байгаа хөгшин ээжийгээ ямар их өрөвдсөн гээч. Тухайн үед манай амьдралын боломж хангалуун байгаагүй болоод ч тэр үү гайгүй сайн өмгөөлөгч авч чадаагүй, тухайн хэргийг өмгөөлөгч гэх нэг хүний нэрийг хэлээд даанч чадваргүй юм, олигтойхон шиг байсан бол хүүгээ арай олон жил сонсохгүй байсан юм. Манайханд даанч хууль, шүүхийн мэдлэгтэй хүн байхгүй юм даа гэхийн сонссон тэр агшин намайг Шүүгч л гэдэг мэргэжилтэй хүн болчих юм бол ахыгаа тэр муухай нэртэй газраас гаргаад, хөгшин ээжийгээ сэтгэл тэнэгэр байлгахын байна гэдэг хүсэн мөрөөдлөөрөө өдийг хүрсэн юм.

Үндэслэл

Энэ асуудлыг судлах болсон үндэслэл нь Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур ойлголтуудын нэг нь Шүүх эрх мэдлийн тухай асуудал бөгөөд харилцан тэнцвэртэйгээр хяналт тавих засаглалын бие даасан хэлбэр мөн гэж үздэг. Үндсэн хуулийн энэхүү үзэл санааны дагуу Шүүх эрх мэдлийн талаарх харилцааг нарийвчлан зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох шүүхийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх нь өнөөгийн шүүхийн шинэтгэлийн асуудлын амин чухал сэдэв болж байгаа юм. Энэ нь шүүхийн үйл ажиллагааны өргөн хүрээг хамрах асуудал мөн бөгөөд түүний дотор шүүх хараат бус байх, хэрэг маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэх, шүүх шударга ёсны баталгаа байх Үндсэн хууль болон шүүхийн тухай хуульд заасан зарчмын хэм хэмжээг амьдралд хэрэгжүүлэх үндсэн асуудлын нэг нь шүүгчид тавигдах ёс зүйн болзол шаардлага, хүлээлгэх хариуцлагын тухай ойлголтыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, онол-практикийн уялдаа холбоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлан тодорхойлох нь ач холбогдолтой байгаа учраас энэхүү сэдвийг сонгон авсан



болно. Шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Шүүхийн тухай хуульд шүүгчид хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалт, сахилгын зөрчил, шийтгэл, хариуцлага хүлээлгэх харьяалал зэрэг үндсэн ойлголтуудыг заан хуульчилсан боловч сахилгын хариуцлага хүлээлгэх процессын хууль зүйн зохицуулалт, онол-арга зүйг цаашид боловсронгуй болгох эрх зүй, нийгмийн бодит шаардлага байгааг үгүйсгэхгүй юм. Иймээс шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх процессын ойлголт, үндэслэл, журам, дараалал, онол-практикийн уялдаа холбоо, цаашид боловсронгуй болгох асуудлыг магистрын судалгааны ажлын хүрээнд судлах зорилгоор энэхүү сэдвийг сонгон авсан болно. Шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх процессын ойлголт, үндэслэл, журам, дараалал, онол-практикийн уялдаа холбоо, цаашид боловсронгуй болгох асуудлыг магистрын судалгааны ажлын хүрээнд судлах нь шүүхийн тухай хууль болон түүнд нийцэн гарсан бусад эрх зүйн актуудын зохицуулалтыг боловсронгуй болгох, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаанд хууль ёсыг хангахад энэхүү сэдвийн ач холбогдол оршино.

Монгол Улсын Үндсэн¹ хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” хэмээх зарчмыг тунхагласан. Энэхүү зарчмын хэрэгжих гол баталгаа нь шүүгчийн хараат бус шүүхийн бие даасан байдлын хэмжүүр, Шүүхийн би даасан байдал хангагдаагүй нөхцөлд шүүгчийн хараат бус байдал алдагдах бөгөөд үүнээс үүдэн иргэдийн үндсэн хуулиар баталгаажсан шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх нь гарцаагүй юм. Манай улсын хувьд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх гол

институц нь Үндсэн хууль болон бусад хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл билээ.

Харин шүүгчийн хараат бус байдлын нөгөө талд нь шүүгчийн хариуцлага буюу шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлж, шүүн таслах ажиллагааг эрхлэх явцдаа шүүгчийн ёс зүйн зөрчил гаргах болон хууль зөрчдөг, хариуцлага хүлээдэггүй дархан эрхтэй этгээд болохгүй байх тэнцвэржүүлэгч механизм оршдог. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын² зарчмуудын оршил хэсэгт шүүхийн тогтолцоо болон шүүгчийн ёс зүй, үнэнч байдалд итгэх нийтийн итгэл нь өнөөгийн ардчилсан нийгмийн амин сүнс болохыг тунхагласан. Тус зарчмын 13 дахь хэсэгт шүүхийн бие даасан болон шүүгчийн ёс зүйтэй байдлыг шүүхийн тогтолцооны үр ашигтай, шударга байдалд итгэх олон нийтийн итгэл хэмээн тайлбарласан. Өөрөөр хэлбэл шүүгчийн хариуцлагын асуудал нь энэ тогтолцооны амин чухал хэсэг болохыг тод томруунаар харуулж байгаа юм. Тийм ч учраас шударга ёсыг тогтоох шүүхийн тогтолцоо нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх замаар биеллээ олдог.

Монгол Улсын шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо буюу шүүгчийн ёс зүйн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд цөөнгүй асуудал тулгамдсан шинжтэй байна. Тухайлбал шүүхийн ёс зүйн хорооны маргаан хянан шийдвэрлэх хүрээнд нотлох баримт бүрдүүлэх, ёс зүйн хорооны ажлын албаны эрх хэмжээ, ёс зүйн хорооны гишүүний хараат бус байдал, шүүгчид хариуцлага хүлээлгэх тогтолцооны хүрээнд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны зохист харьцаа ба ёс зүйн гомдлыг шийдвэрлэх

¹ Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. Уб. 1992. №01

² Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим (2002), түүний тайлбар(2007). Уб. 57 дахь тал.



үе шат, шүүгчийн хариуцлага, түүнтэй холбогдох эрх зүйн орчны хүрээнд ёс зүйн хорооны эрх зүйн байдал болон дүрмийн давхардал ба эрэмбэ зэрэг тулгамдсан шинжтэй асуудлууд байна.

Хүний амь нас, өмч хөрөнгө, эрх чөлөө гурвыг хүний салшгүй эрх, юугаар ч орлуулшгүй үнэтэй ашиг сонирхол гэдэг. Тэгвэл шударга ёсны үйлчилгээг хүргэх замаар хүний энэ амин чухал ашиг сонирхлыг дэнслэх онцгой бүрэн эрх зөвхөн шүүгч хүнд бий. Энэ өндөр нэр хүнд, хариуцлагыг хүлээдэг болохын хувьд шүүгчид олон төрлийн хязгаарлалт, хуулийн болон хэм хэмжээ үйлчилж байна. Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хууль болон шударга ёсонд захирагдаж хуулийн хэрэглэнэ, хуулийг биелүүлнэ гэж хуульчилсан байдаг³. Энэ ч утгаараа одоо хэрэгжиж, батлагдсан хуулийн хүрээнд шүүхийн байгууллага хийгээд шүүгч, шүүх таслах ажиллагааг тасралтгүй явуулж, тухайн хуулийн зүйл заалтад заасан хуулийн хариуцлага, ял оногдуулж байгаа болно. Үүнийг хүн иргэн бүр ойлгож, бүгдэд ил тод, нээлттэй байгаа хуулийн хариуцлага хийгээд хуулийн мэдлэгийг дээшлүүлэх үүднээс нийгэм рүүгээ чиглэсэн сургалт арга хэмжээг тогтмол зохион байгуулах нь маш зөв зүйтэй ажиллагаа болж байна.

Шүүхийн байгууллага болон шүүгч, прокурор, мөрдөгч нь гагцхүү төрийн дээд албан тушаалтнуудын батлан тунхагласан хуулийн хүрээнд хүн, иргэн, хуулийн этгээдэд холбогдох зүйл заалтад заасан түүний санкцад багтах ялын төрөл хэмжээгээр ял оногдуулж байгаа болохоос биш, шүүгч өөртөө таалагдахаар хэрэг маргааныг шийдэж ял оногдуулаад байгаа асуудал огтоос

³ Шүүхийн Ерөнхий зөвлөл. Шүүгчийн ёс зүй-сургалтын гарын авлага. 2018 он.

биш гэдгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэдийг соён гэгээрүүлж байж шүүхийн байгууллагад олон нийтийн итгэх итгэлийг бий болгоход ач холбогдолтой байна. Ерөнхийдөө одоо мөрдөж байгаа хуулиуд нь шүүхийн бие даасан, хараат бус байдалд аюул заналхийлэл учруулахуйц маш олон орхигдуулсан зүйлтэй болон учир дутагдалтай зүйлүүд их байна. Нийгмээрээ шударга шүүх гээчийг хүсэмжилж байгаа бол хуулийн алдаа дутагдалтай зүйл тус бүр дээр нухацтай нүдээ олсон хууль хэрэглээг шинэчлэн баталж байж нийгмийн хүсээд байгаа гэмт хэргүүдэд тохирсон эрүүгийн хариуцлага оногдуулахаар байна. Бид шинэчлэн найруулж байгаа Эрүүгийн хуулиа тодорхой оновчтой байлгаж байж л энэ маргааныг таслан зогсооно.

Шүүгч шүүн таслах ажиллагаанаас бусад орчинд ч гадаад байдал, үг яриа, үйлдэл, харилцаа, хандлагаа цэнэж хувь хүнийхээ хувьд буруу ойлголт төрүүлэх, алдаа дутагдал гаргахаас үргэлж сэргийлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл хэлбэл эмч, инженер, үсчин гэх мэт бусад мэргэжилтний хувьд ажил мэргэжлийн ёс зүй нь зөвхөн ажлын байранд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үед л яригддаг бол шүүгчийн хувьд ажлын бус үед ч мэргэжлийн ёс зүйгээ байнга санан өөртөө зүй зохистой амьдралын хэв маягийг хэвшүүлэх шаардлагатай байдгаараа онцлогтой.

Иймд монгол улсын бүх шүүгч нар нь шүүгчийн албан үүргээс гадуур хувийн амьдралын орон зай хэт өргөн бөгөөд тухайн цаг хугацаанд явагдах олон олон харилцааг нь урьдчилан харж, сэргийлж, нэг бүрчлэн зохицуулах боломжгүй. Ёс зүйтэй, шударга шүүгч байхын тулд зөвхөн хууль дүрэмд захирагдах нь хангалтгүй бөгөөд ёс зүйн зарчим шаардлагуудыг



бичмэл байдлаар хэлбэржсэн эсэхээс үл хамааран өргөн агуулгаар хүлээн авч ажил, амьдралдаа мөрдөх нь зүйтэй. Шүүгч нь олон нийтийн байнгын хяналтад байдаг тул жирийн хүний хувьд бэрхшээлтэй байж болох хувийн эрхийг хязгаарласан хэм хэмжээг өөртөө тогтоох ёстой бөгөөд үүнийг ямар нэг шахалт шаардлагагүйгээр, сайн дураараа өөрөө хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, шүүгч нь шүүхийн өндөр нэр хүндэд нийцүүлэн биеэ авч явбал зохино.

Шүүгч нь шүүхээс гадуурх, нийгмээс тусгаарлахгүй зохих үйл ажиллагаанд оролцож болно. Тиймээс шүүгч нь хуулийн бус сэдвээр бичих, лекц унших, багшлах, ярих, урлаг, спортын болон бусад нийгэм, амралтын үйл ажиллагаанд оролцож болно. Гэхдээ эдгээр үйл ажиллагаа нь шүүгчийн албаны нэр хүндийг унагах, шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд нөлөөлөхгүй байх ёстой. Ингэснээр нийгмээрээ хууль шүүхэд итгэх итгэлцэх бий болох болов уу гэсэн бодолтой байна.

Шударга шүүх, шүүгчийн ёс гэсэн асуудлаар өнөөг хүртэл маргалдаж мэтгэлцсээр л байгаа. Энэ асуудлыг хүн бүр дор бүрнээ ухамсартайгаар, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хүлээцтэй, тууштай байж дээрх асуудлыг зөв зохистой гольдролд оруулахаар байна. Ямар нэг онол практик, эрдэмтэн судлаачид гэхгүйгээр зөвхөн хувь хүн өөрөө бие хүн байх нь чухал гэж иргэн хүний зүгээс харж байна.

Шүүгч, шүүхийн байгууллагад ажиллагсдын үнэнч шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авлигад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр авна гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Шүүхийн хараат бус

байдал нь олон нийтийн итгэл ялангуяа шүүхийн шударга ёсны тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоход чухал ач холбогдолтой бөгөөд ингэснээр хуулийн өмнө хүн бүр тэгш эрхтэй бөгөөд хэн ч хуулиас дээгүүр бус гэдэг зарчмын баталгаа юм. Хууль дээдэлдэг нийгэмд шүүх засаглал нь улс төрийн нөлөөнөөс хараат бус гэдэгт итгэх олон нийтийн итгэлийг олж авах нь чухал байна.

Бие даасан, тал үл харах буюу төвийг сахисан, шударга байдлыг баримтлах зарчим нь шүүгчдээс албан тушаалынхаа нэр төр, шүүхийн шударга, хараат бус байдлыг бүх цаг үед хадгалж байхыг шаарддаг. Бүх цаг үед олон нийтийн хяналт дор байдаг тул шүүгчид энгийн иргэдэд дарамттай санагдаж болох зарим хувийн хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх ёстой боловч энэ нь олон улсын хүний эрхийн стандартуудад нийцэж буй тохиолдолд шүүх засаглалын шударга, хараат бус байдлыг хамгаалах үйлсээр зөвтгөгдөж болох юм.

Ерөнхийдөө үндэсний хууль эрх зүйн хүрээнд “шүүгчийн шударга байдал”, “шүүхийн хараат бус байдал” гэсэн нэр томъёолол ашиглагдаж байгаа боловч шүүгчийн бие даасан байдлын талаар дурдаахгүй байна. Хараат бус байдлыг хангах шаардлага нь шүүх засаглалын байгууллагад төдийгүй шүүгч бүрт хамаарах бөгөөд шүүхийн эрх мэдлийн байгууллагын ажилтнууд засгийн газар, парламент, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд, бусад шүүгч эсвэл гуравдагч этгээдийн шууд болон шууд бус нөлөөллөөс ангид байх байдлыг хангах нь чухал юм. Шүүгчийн бие даасан, хараат бус байх зарчмыг шүүх засаглалтай холбоотой бүхий л хууль тогтоомжид илүү сайн тусгахыг зөвлөж байна.



Тухайн байгууллагын бие даасан эсэх байдалд үнэлгээ өгөхөд тус байгууллагын хөндлөнгөөс бие даасан байдал нь харагдаж, дүгнэгдэх байдал нь чухал бөгөөд гадны нөлөөлөл, хөндлөнгийн оролцоо орсон байж болзошгүй гэх таамаг төдий ялимгүй магадлал нь шүүхийн бие даасан байдлыг бүхэлд нь алдагдуулахад хангалттай байж болно гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хангах баталгааг тодорхой зааж өгсөн байна. Тус хуулийн 27.1-р зүйлд төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, улс төрийн нам, хуулийн этгээд, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах ажиллагааны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг тусгайлан хориглосон байдаг. Үүний зэрэгцээ, хуулинд дээр зөрчилтэй холбогдох шийтгэл оногдуулах талаар заагаагүй нь тус заалтыг ердөө хүсэл эрмэлзэл илэрхийлсэн төдий заалт болгож буй юм. Бусад хууль тогтоомжид өөрөөр заасан бол холбогдох лавлагааг оруулахыг, үгүй бол оногдуулах шийтгэлийн талаар тодорхой тусгахаар байна.

Хуулийн төсөлд гомдол урьдчилан шийдвэрлэх, хөөн хэлэлцэх хугацаа, төрийн аль нэг институтээс хараат бус байх зарчмын заалт эргэлзээтэй байсан тул Шүүхийн хараат бус байдал олон улсын баримт бичиг судалж, хуулийн төслийн ажлын хэсэгт 22 заалтын 13 хэсэг дэх 24 заалтыг шинээр оруулахаар боловсруулсан 30 баг саналыг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05/09 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, мөн Шүүгчийн эрх зүйн байдал, хариуцлагын тухай хуулийн Шүүхийн

сахилгын хороо, шүүгчийн хариуцлагатай холбогдох заалтад хууль хэрэгжсэнээр гарах үр нөлөөний судалгаа, эдийн засгийн тооцоог хийж хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус тус хүргүүлсэн байна.

Шүүхийн тухай хууль боловсруулах ажлын хэсэгт ажлын албанаас тус хуульд оруулахаар хүргэсэн саналын 40 орчим хувь нь төсөлд тусгасан байна. Энэ талаар Хууль зүйн, дотоод хэргийн яамны сайд УИХ-ын чуулганы танхимд Хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг хийх үедээ “Шүүхийн Ёс зүйн хорооны ажлын албанаас ирүүлсэн тусгайлсан саналыг тусгасан.

Шүүхийн Ёс зүйн хороо 2017, 2018, 2019 оны эхний хагас жилд буюу нэг жилд дунджаар давхардсан тоогоор 360 гаруй шүүгчид холбогдох 240 орчим гомдлыг хүлээн авч хянан шалгах ажиллагаа явуулж тэдгээрийн 150 гаруй гомдолд буюу 62.5 хувьд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж 70 гомдолд буюу 27.75 хувьд сахилгын хэрэг үүсгэн шалгаж түүний 68.46 хувь буюу 73 шүүгчид⁴ сахилгын шийтгэл ногдуулжээ.

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар гаргасан гомдлыг шийдвэрлэсний дараа Шүүхийн Ёс зүйн хорооны хүчин төгөлдөр шийдвэрээр нийт гомдлын 5.41 хувь, сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолын 13.33 хувь, сахилгын шийтгэл ногдуулсан магадлалын 21.05 хувь буюу 14 шүүгч сахилгын шийтгэл бодитоор хүлээжээ.

⁴ Монгол Улсын Шүүхийн тайлан (2020) - Улаанбаатар хот 2021 он



Дүгнэлт

Сахилгын хэргийг шалгах хөөн хэлэлцэх хугацааны тухайд шүүгчийн ёс зүйн дүрэмтэй холбоотойгоор сахилгын хэргийг шалгах хөөн хэлэлцэх хугацаа хэт богино байна. Сахилгын шийтгэлийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож байгаа нь буруу гэх зэргээр шүүмжлэл дагуулсаар өдийг хүрчээ. Үүнээс үзэхэд ёс зүйн дүрмийн ач холбогдлыг тодорхойлохдоо сахилгын хэргийг шалгах, хариуцлага ногдуулах тал дээр илүү анхаарал хандуулж буй мэт. Өнөөгийн нөхцөлд шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчид хариуцлага тооцох нэг хэрэгсэл мэт ойлголт нэгэнт бий болжээ. Буруу зүйл хийсэн хүн хариуцлага хүлээх нь зүй ёс боловч ёс зүйн хэм хэмжээ нь төлөвшин тогтох эсэх нь эргэлзээтэй.

Ёс зүйн болон сахилгын зөрчил. Олон Улсын валютын сангийн ерөнхийлөгч Кристин Лагардын 2015 онд Нью-Йорк хотод тавьсан “санхүүгийн байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын талаарх” илтгэл ёс зүйн нийтлэг асуудлуудыг хөндсөнөөрөө анхаарал татсан юм. Тэрээр хэлэхдээ тухайн салбарын ёс зүй, сахилгын хариуцлагыг дээшлүүлэхийн тулд бие хүний үнэнч, шударга, ёс зүйтэй байдлыг урамшуулан дэмжих өөрчлөлтийг хийж нийгмийн соёл болгон төлөвшүүлэх нь нэн чухал хамтын хариуцлага юм. Үүний тулд удирдлагын түвшинд ёс зүйн хэм хэмжээг хөхиүлэн дэмжих нь ёс зүйн сургалт хийхээс илүү үр дүнтэй. Түүнчлэн ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чухал нэг зүйл нь боловсролтой залуу мэргэжилтнүүдийг дан ганц хууль дээдлэх бус нийтийн эрх ашгийг эрхэмлэх үзэлтэй болгох явдал юм. Түүнчлэн ямар ч ажилд хүнийг сонгож авахдаа гурван шалгуурыг харгалзах нь зүйтэй. Үүнд шударга, ёс зүйтэй байх, мэдлэг боловсролтой

байх, эрч хүчтэй байх зэрэг хамаарна. Мэдлэг боловсролтой, эрч хүчтэй байгаад шударга бус, ёс зүйгүй байх юм бол эргээд бүхнийг сүйрүүлэх болно гэдгийг анхааруулжээ. Үүнээс дүгнэхэд мэргэжлийн ёс зүй гэдэг бол ямар мэргэжил гэдгээс үл хамааран үйл ажиллагаандаа баримтлах үнэт зүйл юм.

Энэ талаар Шүүгчдийн Магна Хартад “...18. Сахилгын зарчмаас тусдаа ёс зүйн зарчмууд нь шүүгчийн зан байдлыг чиглүүлэх ёстой...” гэж заасан байдгаас үзэхэд ёс зүйн зарчмыг заавал баримтлах ёстой боловч хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй харин сахилгын зөрчлийг сахилгын зарчмаар тусад нь тодорхойлж, сахилгын хариуцлагыг зааж өгөх шаардлагатай талаар дурдсан байдаг. Үүнээс үзэхэд ёс зүй ба сахилга хариуцлага гэсэн хоёр тусдаа ойлголт байдаг.

Хариуцлагын тухайд шүүгчийн ёс зүйн дүрмийг дан ганц хариуцлага хүлээлгэх хэрэгсэл бус сайн дурын үндсэн дээр дагаж мөрдүүлж ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх соёл болгон төлөвшүүлж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх хэрэгсэл гэж үзэж болох юм. Одоогийн хэрэгжиж байгаа Шүүгчийн ёс зүйн дүрмийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмтэй харьцуулахад зарчмын шинжтэй заалтуудыг хэт ерөнхийлөн заасан байдаг тул үл ойлгогдох байдлыг үүсгэсээр байгаа юм⁵.

Одоогийн хэрэглэж буй Шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.1 дүгээр зүйл. Дүрмийн зорилго нь “Шүүгчийн албаны үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлж, зөрчигдөхөөс

⁵ Мөнх-Эрдэнэ Ц., Шүүгчийн ёс зүй ба сахилга хариуцлага түүнийг боловсронгуй болгох нь. Шүүх эрх мэдэл. УБ. 2020. №4.



урьдчилан сэргийлэх” гэж заасан байдаг. Шүүгчийн хувийн амьдрал болон албаны чиг үүрэг хэрэгжүүлэх хоёрыг нэгтгэн ойлгож Шүүгчийн ёс зүйн дүрмээр зохицуулах нь өрөөсгөл ойлголт юм. Шүүгчдийн Магна Хартад дурдсанаар “...20. Шүүгчид нь албан үүргээс гадуур гаргасан аливаа хууль бус үйлдэл, эс үйлдэхүйдээ хуульд хуульд хариуцлага хүлээнэ...” гэж заасан байдаг тул шүүгч нь хувийн амьдралдаа шүүгчийн ёс зүйн зарчмыг баримтлаагүй нь ёс зүйн хариуцлага хүлээх болон бусад хуульд заасан хариуцлага хүлээх давхардал буюу double jeopardy үүсгэж болохгүй юм. Иймд шүүгчийн ёс зүйн дүрмийг хувийн амьдралдаа баримтлах гэсэн хэсгийг өөрчлөх нь зүйтэй.

Эцэст нь дурдахад Шүүгчийн ёс зүйн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулахыг санал болгож байна. Үүнд:

- Одоогийн дагаж мөрдөж буй ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд заасан 1 дэх хэсэгт заалтыг өөрчилж ёс зүйн зарчмууд буюу үнэт зүйлийг тус бүрд нь бие даасан заалт болгон зааж өгч тодорхойгүй байдлыг арилгах,
- Ёс зүйн зарчмуудыг зөрчих нь сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй байх,
- Сахилгын зарчмуудыг тусгайлан зааж өгөх,
- Гагцхүү сахилгын зөрчилд сахилгын хариуцлага оногдуулах талаар зааж өгөх,
- Тодорхойгүй үг хэллэгийг эргэн харах замаар одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ёс зүйн дүрмийг засан сайжруулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Ёс зүй ба сахилга хариуцлагын ялгаа

заагийг тодорхойлсноор ёс зүйн дүрэм нь илүү боловсронгуй болно. Өөрөөр хэлбэл ёс зүйн дүрмийг дан ганц хариуцлага тооцох хэрэгсэл бус шүүгч, шүүхийн ёс зүйн соёлыг үр ашигтай төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлж олон нийтэд шүүн таслах үйл ажиллагааг ёс зүйн өндөр түвшинд хүргэх ач холбогдолтой. Ёс зүйн соёлыг урт удаан хугацаанд урамшуулан дэмжиж үнэт зүйл болгон төлөвшүүлж харин сахилгын зөрчилд зохих хариуцлагыг хүлээлгэх нь илүү үр дүнтэй.

НОМ ЗҮЙ

I. Монгол эх сурвалж

Монгол Улсын шүүхийн тайлан. 2021 он.

Шударга ёсны хэмжүүр-Мэдээлэл, хууль зүйн онол практикийн сэтгүүл 2021 он.

Шүүх эрх мэдэл - Мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл. 2020 он. №4.

Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, түүний тайлбар.

Шүүгчийн ёс зүй- сургалтын гарын авлага /Шүүхийн Ерөнхий зөвлөл/.

Монгол Улсын Шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн эмхэтгэл. 2017-2019 он.



ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ДУАЛИЗМ

С.ЦЭРЭНДОЛГОР. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Захиргааны эрх зүйн судлаач.

Guido Calabresiⁱⁱ, Spenser Smithⁱⁱⁱ

Бид Жон Голдберг, Бенжамин Зипурский профессоруудын “Гэм хорыг танихуй”ⁱ хэмээх шинэ бүтээл, тус бүтээлд бичсэн Катерин Шарки профессорын шүүмж², шүүмжид өгсөн Голдберг, Зипурский нарын хариу³ зэргийг шимтэн уншлаа. Тэдний харилцан байр суурь гэм хорын эрх зүй “амьд” гэдгийг батлав. Гэвч дажгүй байгаа?

Голдберг, Зипурский /цаашид “ГЗ” гэх/ болон Шарки нарын бичсэнийг анх үзвэл гэм хорын эрх зүйн эрс ялгаатай онол дэвшүүлжээ. ГЗ иргэний нэхэмжлэлийн онолдоо “гэм хор, түүнийг

ⁱ i Харвардын их сургуулийн Хууль зүйн сургуулиас эрхлэн гаргадаг “Harvard Law Review” сэтгүүлийн 135 дугаар цуврал болох 2022 оны Хоёрдугаар сарын №4 дугаарт нийтлэгдсэн өгүүллийг орчуулан хүргэж байна. Хүсвэл та бүхэн англи хэлээрх эхийг <https://harvardlawreview.org/issues/volume-135-issue-4/> хаягаас унших боломжтой.

ⁱⁱ АНУ-ын Хоёрдугаар тойргийн Давж заалдах шатны шүүхийн ахлах шүүгч, Йелийн Хууль зүйн сургуулийн Стерлингийн болон эмерит профессор, мэргэжлийн хичээлийн лекцийн багш

ⁱⁱⁱ АНУ-ын Хууль зүйн яамны Рилл хөтөлбөрийн оролцогч. Энд бичсэн үзэл санаа нь АНУ-ын Хууль зүйн яамны байр суурийг төлөөлөхгүй болно.

JOHN C.P. GOLDBERG & BENJAMIN C. ZIPURSKY, RECOGNIZING WRONGS (2020).

² Catherine M. Sharkey, Modern Tort Law: Preventing Harms, Not Recognizing Wrongs, 134 HARV. L. REV. 1423 (2021) (reviewing GOLDBERG & ZIPURSKY, supra note 1).

³ John C.P. Goldberg & Benjamin C. Zipursky, Thoroughly Modern Tort Theory, 134 HARV. L. REV. F. 184 (2021) (responding to Sharkey, supra note 2).

нөхөн төлүүлэх” онол нэмсэн байна⁴. Тэр нь ч сайн болсон⁵. Харин Шарки ГЗ-ийн онолд “иргэний гэм хорыг яаж тогтоох талаар үндэслэлтэй тайлбар” дутуу байна гэжээ⁶. Шарки “өртөг багатайгаар зайлсхийх” онол⁷-ыг “гол дүр” хэмээгээд энэхүү онол болон гэм хорын эрх зүйн бусад хөдөлгөгч онолууд “амин чухал”, ялангуяа орчин үеийн гэм хорын эрх зүй дэх бүтээгдэхүүний хариуцлага зэрэг асуудлын үүднээс авч үзсэн ч тэр гэж маргажээ⁸.

Бидний зүгээс харин дээрх хоёр “талд”-тийнхүү томъёолмоор байвал аль алинд нь дутуу юм байна гэж үзлээ. Нэг талаас гэм хорын эрх зүй нь гэм хор, түүнийг нөхөн төлүүлэх явдал мөн. Энэ нь гэм хорын хувийн эрх зүйн шинж (англ. *private side*) болно. Шүүхүүд ч ихэнхдээ үүнийг анхаардаг. Нөгөө талаас, гэм хорын эрх зүй нь гэм хор учрахаас урьдчилан сэргийлэх буюу нийгмийн

⁴ GOLDBERG & ZIPURSKY, supra note 1, at 263–64

⁵ See generally Guido Calabresi, Civil Recourse Theory’s Reductionism, 88 IND. L.J. 449 (2013)

⁶ See Sharkey, supra note 2, at 1426–27.

⁷ GUIDO CALABRESI, THE COSTS OF ACCIDENTS 155 (1970) (“Ослоос үүдэн гарах зардлаас хамгийн бага өртгөөр зайлсхийх арга зам эрэлхийлэх нь илүү аюул багатай, хамгийн боломжит замаар орлуулж болохуйц үйл ажиллагааг эрэлхийлэх явдал юм. Энэ нь ослоос үүдсэн анхдагч зардлын хэмжээг хамгийн өртөг багатайгаар бууруулахуйц гарц хайна гэсэн үг”).

⁸ Sharkey, supra note 2, at 1426, 1435–44.



зохицуулалтын хэрэгцээг хангах явдал юм. Энэ нь гэм хорын нийтийн эрх зүйн шинж (англ. *public side*) болно. Үүнийг шүүхүүд хаа нэг авч үздэг ч хууль тогтоох болон захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг нь билээ. Хэрэв та гагцхүү нэг талынх нь байр суурийг дэмжиж буй бол гэм хорын эрх зүйн туйлын ач холбогдлыг ойлгоогүй гэсэн үг.

ГЗ болон Шарки нарын харилцан байр суурь нь *ubi jus ibi remedium*⁹, “гэм хор, түүнийг нөхөн төлүүлэх”¹⁰, “хувийн эрх зүйн” гэм хор ба “нийтийн эрх зүйн” зохицуулалт¹¹, Проссерийн “дуал инструментализм”¹², ГЗ-гийн “дуал конструктивизм”¹³ гэх зэрэг бүхэлдээ дуализмаар дүүрэн байна. Нэрмээс болчих буй заа гэвч, бид өөрсдийн зүгээс хоёрыг нэммээр байгаа: Нэгдүгээрт, гэм хорын эрх зүй *хоёрдмол шинжтэй*. Хэлбэрийн болон агуулгын талаасаа. Гэм хорын эрх зүйг энэ өнцгөөс харвал ГЗ, Шарки нарын онол хоорондоо уялдана. Хоёрдугаарт, гэм хорын эрх зүй *хоёрдмол чиглэлд* хэрэгждэг. Иргэний гэм хорыг хэрхэн тодорхойлох нь ихэнхдээ нийгмийн зохицуулалтын хэрэгцээнд үндэслэх бөгөөд энэ нь “өртөг багатайгаар зайлсхийх” аргаар хариуцлага хүлээлгэх хүсэл зоригоос үүднэ. Гэвч “их”, “бага” гэдгийн хэмжүүр нь нийгмийн үнэт зүйл, үнэлэмжээс хамаарах ба иргэний гэм хорын өнөөгийн чиг хандлагаас хамаарна. Заримдаа дулимаг санагддаг энэ урвуу хамаарал гэм хорын эрх зүйн ирээдүйг тодорхойлж мэдэх юм. Учир нь, гэм хорын эрх зүй нийгмийн зохицуулалтын хэрэгцээнд

үндэслэх нь зайлшгүй билээ.

Шарки номын шүүмжээ Дээд шүүхэд саяхан шийдсэн Air & Liquid Systems Corp.-ийн эсрэг DeVries¹⁴-ийн хэргийн тухай дурдан эхлүүлжээ. Тэрээр “эдийн засгийг тогтоон барихад суурилсан ‘өртөг багатайгаар зайлсхийх’ зарчмыг үндсэн шүүхийн шийдвэрт үндэслэн тусгажээ”¹⁵ гээд “DeVries-ийн хэргийн үндсэн шийдвэр болон тусгай саналын аль аль нь тус үндэслэлийг хүлээн авсан нь учиртай”¹⁶ гэжээ. Кавано шүүгч (Justice Kavanaugh) шүүхийн үндсэн шийдвэртээ ““эх метал” бүтээгдэхүүн нийлүүлэгч нь тухайн бүтээгдэхүүнд асбесто материал нэмэх шаардлагатай тохиолдолд урьдчилан анхааруулах үүрэгтэй, учир нь интеграцчилагдсан бүтээгдэхүүний аюулаас сэргийлэхийг зөвлөх үүрэг нь [асбесто] жижиглэн нийлүүлэгчээс илүү бүтээгдэхүүн нийлүүлэгчид байх нь зүйтэй”¹⁷ гэсэн байна. Горсуч шүүгч (Justice Gorsuch) тусгай саналдаа ““өнөөдрийн хувьд хамгийн байж болохуйц” эрх зүйн хэм хэмжээ бол анхааруулах үүргийг [бүтээгдэхүүний] эрсдэлийг эрх зүй, эдийн засгийн томъёоллоор хэрэглэгчид сэрэмжлүүлж, ойлгуулахад тохирох байр сууринд байгаа буюу ...өртөг багатайгаар зайлсхийгч тал”¹⁸-д ногдуулах юм”

¹⁴ 139 S. Ct. 986 (2019).

¹⁵ Sharkey, *supra* note 2, at 1425.

¹⁶ But see Goldberg & Zipursky, *supra* note 3, at 196 (arguing that Justice Gorsuch does not embrace cheapest cost avoider analysis but instead uses it to “parry” Justice Kavanaugh’s “thrust” (quoting Karl N. Llewellyn, Remarks on the Theory of Appellate Decision and the Rules or Canons About How Statutes Are to Be Construed, 3 VAND. L. REV. 395, 401 (1950))).

¹⁷ DeVries, 139 S. Ct. at 994 (citing CALABRESI, *supra* note 7, at 311–18).

¹⁸ *Id.* at 997 (Gorsuch, J., dissenting). GZ are correct that Justice Gorsuch’s cheapest cost avoider argument is just one of several he gives in support of the traditional common law rule. See Goldberg & Zipursky, *supra* note 3, at 196 (citing DeVries, 139 S. Ct. at 997–99 (Gorsuch, J., dissenting)). At the same time, Justice Gorsuch’s appreciation of the relevant economics went even further than the majority’s:

⁹ See GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 15, 82–110.

¹⁰ See generally *id.* at 25–259.

¹¹ Sharkey, *supra* note 2, at 1445.

¹² GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 210–21 (citing WILLIAM L. PROSSER, HANDBOOK OF THE LAW OF TORTS (1941)).

¹³ *Id.* at 232–59



хэмээн үндсэн шүүхийн шийдвэртэй санал нийлжээ. Гэхдээ Горсуч шүүгч болон тусгай санал гаргасан бусад шүүгч нар үндсэн шүүхийн шийдвэрийн “эх метал” бүтээгдэхүүн нийлүүлэгч, эсхүл асбесто материал нийлүүлэгчийн аль нь хамгийн өртөг багатай зайлсхийгч болох тал дээр санал нийлээгүй байна¹⁹. Гэсэн ч бүрэлдэхүүний олонх болон тусгай санал гаргасан талуудын аль аль нь адил асуулт дэвшүүлжээ: “Гэм хорын болзошгүй эрсдэлийг бууруулахад аль тал нь хамгийн тохирох байр сууринд байна вэ?” Энэхүү хандлагыг Шарки “харьцангуй” эсхүл “туйлын”²⁰ гэж тодорхойлсонд гайхах юмгүй.

ГЗ DeVries-ийн хэрэг ганц Шаркигийн байр суурьтай ч²¹ бус, тэдний байр суурьтай²² мөн зөрчилдөж байна гэжээ. Тэд “DeVries-ийн хэрэгт бүрэлдэхүүний олонх болон тусгай санал гаргасан шүүгчдийн аль алиных нь байр суурь “өртөг багатайгаар зайлсхийх” асуудалд дүн шинжилгээ хийсэн атлаа эрс тэс дүгнэлтэд хүрсэн нь энэхүү үзэл баримтлалд “бодитой” бөгөөд “тодорхой” байдал дутагдаж байгааг харуулж байна”²³ гэжээ. Цаашилбал,

By placing the duty to warn on a product's manufacturer, we force it to internalize the full cost of any injuries caused by inadequate warnings - and in that way ensure it is fully incentivized to provide adequate warnings. By contrast, we dilute the incentive of a manufacturer to warn about the dangers of its products when we require other people to share the duty to warn and its corresponding costs.

DeVries, 139 S. Ct. at 997 (Gorsuch, J., dissenting) (citing STEVEN SHAVELL, *ECONOMIC ANALYSIS OF ACCIDENT LAW* 17 (1987); CALABRESI, *supra* note 7, at 135 & n.1; Italia Societa per Azioni di Navigazione v. Or. Stevedoring Co., 376 U.S. 315, 324 (1964)).

¹⁹ See DeVries, 139 S. Ct. at 996–97 (Gorsuch, J., dissenting).

²⁰ Sharkey, *supra* note 2, at 1424, 1426.

²¹ See Goldberg & Zipursky, *supra* note 3, at 195–96.

²² See *id.* at 196–98.

²³ See *id.* at 195 n.67, 196. This is compounded by Justice Kavanaugh's “hedge,” *id.* at 196 n.68, that the bare-metal “product manufacturer will often be in a better position than the parts manufacturer to warn of the danger from the integrated product,” DeVries,

бүрэлдэхүүний олонхын шийдвэр болон тусгай саналын аль алиных нь эдийн засгийн үндэслэл “дүгнэлтээс цаашгүй”²⁴ гэжээ. Кавано шүүгч, Горсуч шүүгчийн хэн хэн нь үр дагаврыг зөвтгөх буюу тайлбарлах үүднээс ямар ч эдийн засгийн эрх зүйн дүн шинжилгээ хийсэнгүй²⁵. Энэ нь шүүхүүд тийм үндэслэл гаргах чадамжгүй хэмээсэн ГЗ-гийн санааг бэхжүүлж өгөв²⁶.

Зарим шүүгч гэм хорын эрх зүй дэх аюулгүй байдал хийгээд гэм хорын өртгийг бууруулах ёстой гэсэн зарчмыг яаж хэрэгжүүлэх дээр санал нийлэхгүй байгаа нь энэ үзэл баримтлалд бодитой бөгөөд тодорхой байдал дутагдаж байна гэсэн үг бас биш юм (гэм хорын эрх зүйн бусад хандлага, тухайлбал, ёс суртахууны хариуцлагад суурилсан ойлголтуудын хувьд ч ижил.²⁷) Иймд бид дараах өргөжүүлсэн санааг дэвшүүлж байна: Хэрэг нэг бүрд байтугай ер нь дийлэнх хэрэгт зардал-үр ашгийн дүн шинжилгээ хийж, гэм хороос хамгийн бага өртгөөр зайлсхийх аргыг эрэлхийлэх шаардлагатай гэж үзэх нь өрөөсгөл юм. Хэрэв зээ тэгсэн бол ГЗ-гийн зүгээс уг

139 S. Ct. at 994 (emphasis added); see also *id.* at 994 n.2 (“We do not rule out the possibility that, in certain circumstances, the parts manufacturer may also have a duty to warn.”).

²⁴ Goldberg & Zipursky, *supra* note 3, at 195.

²⁵ *Id.* at 196.

²⁶ See, e.g., GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 296–97; Goldberg & Zipursky, *supra* note 3, at 190 n.45. Contrast this position of GZ with that of Robert Bork, who argued for a consumer welfare standard in antitrust in part because he believed it was the only standard that courts were competent to apply. See ROBERT H. BORK, *THE ANTITRUST PARADOX* 72–89 (2d ed. 1993). We believe that both positions, either that courts are competent to do only this kind of analysis, or that courts are not able to do it, are wrong, both in theory and as a representation of what courts actually do.

²⁷ E.g., JULES L. COLEMAN, *RISKS AND WRONGS* (1992); ERNEST J. WEINRIB, *THE IDEA OF PRIVATE LAW* (1995). The same is also true of most law theories, including every theory of statutory interpretation. See, e.g., Tara Leigh Grove, *The Supreme Court, 2019 Term - Comment: Which Textualism?*, 134 HARV. L. REV. 265, 266–67 (2020).



тогтолцооны ТЭЗҮ ч юм уу, зардал²⁸ ч гэж юм уу зүйлд санаа тавих эрхтэй байх сан билээ. Онц асуудал байхгүй байх байсан. Гэтэл хууль дэс дараатай сэтгэдэг. Тухайлбал, динамит тэсэлгээ онц аюултай тул хатуу хариуцлага хүлээлгэнэ²⁹. Харин зөв, буруу жолоодох эсэхээс үл хамаарч машин барих нь тийм нухацтай асуудал биш.

Уурхайн олборлолтын хэрэгт шүүхүүд иргэний нэхэмжлэл, “гэм хор, түүнийг нөхөн төлүүлэх” зэрэгт илүү ач холбогдол өгдөг тухайд ГЗ-гийн зөв. ГЗ-гийн нээлттэй уриалга³⁰ болон гэм хорын эрх зүйг “нэрлэсэн үнээр” нь авч үздэг “практикт суурилсан” хандлагыг³¹ бид чухалд тооцож байна. Түүнчлэн, үнэхээр л шүүхүүд энэ тал дээр илүү цаг зарцуулдагтай санал нийлнэ³² (Гэсэн хэдий ч даатгалд хамрагдсан бол ГЗ-гийн дэвшүүлж буйгаас арай бага хамааралтай байх нь бий³³). Энэ нь гэм хорын хувийн эрх зүйн шинж юм.

²⁸ See CALABRESI, *supra* note 7, at 28 (describing this “tertiary” goal of tort law).

²⁹ See, e.g., *Spano v. Perini Corp.*, 250 N.E.2d 31 (N.Y. 1969).

³⁰ GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 11, 80; Goldberg & Zipursky, *supra* note 3, at 198.

³¹ GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 6, 47; see also *id.* at 5–6, 76–81 (describing their “pragmatic conceptualist” approach).

³² See, e.g., *Desiano v. Warner-Lambert & Co.*, 467 F.3d 85, 94–95 (2d Cir. 2006)

³³ The great torts scholar, Professor Fleming James, Jr., believed that the coming of insurance made the private law arrangement of tort law obsolete and focused his tort theories on the public law aim of holding the best “loss spreader” liable. See Fleming James, Jr., *Accident Liability Reconsidered: The Impact of Liability Insurance*, 57 *YALE L.J.* 549 (1948). For a full discussion of James’s approach to tort law, see Guido Calabresi, *Professor Fleming James Jr (1904–1981)*, in *SCHOLARS OF TORT LAW* 259 (James Goudkamp & Donal Nolan eds., 2019). See also, e.g., Steve Hedley, *Corrective Justice - An Idea Whose Time Has Gone?*, in *LAW IN THEORY AND HISTORY: NEW ESSAYS ON A NEGLECTED DIALOGUE* 305 (Maksymilian Del Mar & Michael Lobban eds., 2016). But see GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 274–76 (attempting to rebut this criticism).

Гэвч нөгөө талаас эрх зүйг бүтээдэг “том” хэргүүд болон бусад шийдвэр, шүүх, хууль тогтоогч, захиргааны албан тушаалтнуудад хамаарахуйц, эрх зүйг хаашаа чиглэж буйг тодорхойлдог түгээмэл хэргүүд гэж байна. Чухам ийм хэргийн шийдвэрүүд л энэ ч төрөл, тэр ч төрөлд хамаарна гэх үндсэн шалтгааныг тодорхойлж байдаг. (Заримаас нь дурдвал, *MacPherson v. Buick Motor Co.*³⁴, *Greenman v. Yuba Power Products, Inc.*³⁵, *Dillon v. Legg*³⁶ зэрэг шийдвэр болно.) Хууль тогтоох, шүүх болон захиргааны байгууллагууд ховор боловч иймэрхүү хэрэг шийдвэрлэдэг. Цаашилбал, нийтлэг эрх зүйн бүлийн шүүхүүд гэм хорын эрх зүйг бүтээх үндэслэл байвал уриалгахан ханддаг нь олон³⁷. Зарим хүн “би үүнийг

³⁴ 111 N.E. 1050 (N.Y. 1916); see *id.* at 1053 (“Precedents drawn from the days of travel by stagecoach do not fit the conditions of travel to-day. The principle that the danger must be imminent does not change, but the things subject to the principle do change. They are whatever the needs of life in a developing civilization require them to be.”).

³⁵ 377 P.2d 897 (Cal. 1963); see *id.* at 901 (“The purpose of such liability is to insure that the costs of injuries resulting from defective products are borne by the manufacturers that put such products on the market rather than by the injured persons who are powerless to protect themselves.”)

³⁶ 441 P.2d 912 (Cal. 1968); see *id.* at 916 (“[D]uty’ is not sacrosanct in itself, but only an expression of the sum total of those considerations of policy which lead the law to say that the particular plaintiff is entitled to protection.” (quoting WILLIAM L. PROSSER, *HANDBOOK OF THE LAW OF TORTS* 333 (3d ed. 1964))).

³⁷ See, e.g., *Lauer v. City of New York*, 733 N.E.2d 184, 187 (N.Y. 2000) (“While the Legislature can create a duty by statute, in most cases duty is defined by the courts, as a matter of policy. Fixing the orbit of duty may be a difficult task. Despite often sympathetic facts in a particular case before them, courts must be mindful of the precedential, and consequential, future effects of their rulings”); *Waters v. N.Y.C. Hous. Auth.*, 505 N.E.2d 922, 923–24 (N.Y. 1987) (“The common law of torts is, at its foundation, a means of apportioning risks and allocating the burden of loss. While moral and logical judgments are significant components of the analysis, we are also bound to consider the larger social consequences of our decisions and to tailor our notion of duty so that the “legal consequences of wrongs are limited to a controllable degree.” (quoting *Tobin v. Grossman*, 249 N.E.2d 419, 424 (N.Y. 1969))).



бүтээсэн” гэж дандаа давтдаг шиг. Энэ нь гэм хорын нийтийн эрх зүйн шинж болно.

Энд бидний гэм хорын эрх зүйн “хоёрдмол шинж” гэж яриад буйн учир оршино. Үргэлж биш боловч зарим тохиолдолд “хувийн эрх зүйн” утгаар нь, зарим тохиолдолд иргэний нэхэмжлэл буюу “гэм хор, түүнийг нөхөн төлүүлэх” утгаар нь авч үзэх хэлбэрийн түвшинг “микро түвшин” гэнэ. Нөгөө талаас мөн зарим тохиолдолд “нийтийн эрх зүйн” утгаар нь, зарим тохиолдолд эрсдэл, алдагдлын хуваарилалт зэрэг төрөл бүрийн арга хэрэгслээр тайлбарладаг агуулгын түвшинг “макро түвшин” гэнэ. Иймд ГЗ болон Шарки нарын гэм хорын эрх зүйд дэвшүүлсэн санаа нь энэхүү хосолмол ойлголтын агуулгад уялдахгүй байх шалтгаан алга гэж бид үзлээ.

Заримдаа шүүгчид хувийн болон нийтийн эрх зүй хоёрыг холбох гэж үздэг л дээ. Ингэхдээ нөхөн төлүүлэх хэмжээний гэм хор байсан эсэх хувийн эрх зүйн чанартай хэрэг шийдэхдээ нийтийн анхаарлыг татах маягаар. Энд бид *Palsgraf v. Long Island Railroad Co.*,³⁸-ийн хэргийг жишээ болгон авсны учир нь ГЗ, Шарки нар тус шийдвэрийг

ялгаатай тайлбарласан байна. ГЗ-гийн зүгээс *Palsgraf*-ийн хэргийн гол сургамж нь гэм хорын эрх зүй дэх “бодитой байдал”-ын урьдчилсан нөхцөл буюу зүй ёсны нэхэмжлэгчийн зарчмыг хөндсөнд оршино³⁹ гэж мэтгэлцжээ. Харин Шаркигийн хувьд *Palsgraf* болон *MacPherson*⁴⁰ гэсэн хоёр өөр хэрэгт хоёуланд нь нэг шүүгч буюу Ерөнхий шүүгч Бенжамин Кардозо шүүхийн шийдвэрийн үндсэн (олонх) хэсгийг бичсэн нь итгэхэд бэрх гэжээ.

Харин бидний зүгээс *Palsgraf*-ийн хэргийг өөрөөр харж байна. ГЗ, Шарки нарын тайлбар гэм хорын эрх зүйг өнөө л гагцхүү хувийн эрх зүйн талаас нь эсхүл нийтийн эрх зүйн талаас нь тодорхойлох гэж оролддог хандлагыг харуулж байна. ГЗ *Palsgraf*-ийн хэргийн холбогдох хэсгийг онцолсон⁴¹. Угаас бүрэлдэхүүний олонхын шийдвэр ч хөдөлшгүй томъёоллоор бичигдсэн тул ойлгож болмоор⁴². Харин Шарки *MacPherson*⁴³-ийн хэргийн олонхын шийдвэрийг бичсэн Кардозо шүүгч *Palsgraf*-ийн хэргийн мөн олонхын шийдвэрийг бичсэн гэхээр итгэхгүй маягтай. *MacPherson*-ийн шийдвэрт Кардозо шүүгч илт инструменталист хандаж “гэм хорын аюул болзошгүй байх ёстой гэдэг зарчим өөрчлөгдөхгүй боловч зарчимд хамааралтай зүйлс өөрчлөгддөг. Хөгжиж байгаа соёл иргэншилд амьдрал ямар хэрэгцээг шаардана, түүний дагуу

³⁸ 162 N.E. 99 (N.Y. 1928). For the uninitiated, GZ provide this helpful summary of the facts of *Palsgraf*: A man leapt onto the open space at the end of a train car as the train was pulling out of the defendant railroad’s station. Two conductors employed by the railroad tried to steady him by pushing and pulling him onto the train. In the process, they dislodged a newspaper-wrapped package he was carrying under his arm. The conductors did not know - and had no reason to know - that the package contained powerful fireworks, which fell onto the tracks, exploding upon impact. The explosion was powerful enough to blow away a chunk of the railway platform and to cause reverberations around the station. As a result, a large metal scale, located on the platform perhaps thirty feet away from the point where the package fell, toppled onto Mrs. *Palsgraf*, a ticketed customer who was waiting for a different train. She sued the railroad for negligence.

GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 199.

³⁹ GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 198–204 (quoting Benjamin C. Zipursky, Rights, Wrongs, and Recourse in the Law of Torts, 51 VAND. L. REV. 1 (1998)).

⁴⁰ Sharkey, *supra* note 2, at 1436 n.46. But see Goldberg & Zipursky, *supra* note 3, at 189 n.36 (noting that if you adopt their theory of *MacPherson*, the two decisions fit together).

⁴¹ GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 200–04.

⁴² See, e.g., *Palsgraf*, 162 N.E. at 100 (“The plaintiff sues in her own right for a wrong personal to her, and not as the vicarious beneficiary of a breach of duty to another.”); *id.* at 101 (“Negligence, like risk, is thus a term of relation.”).

⁴³ See Sharkey, *supra* note 2, at 1436 n.46.



л байдаг⁴⁴ гэжээ. Түүнчлэн, Кардозогийн MacPherson-ийн шийдвэрийн үзэл баримтлал “хамгийн бага өртгөөр зайлсхийх” томъёоллын үндэслэл⁴⁵ болжээ. Гэсэн хэдий ч Palsgraf-ийн шийдвэрт Кардозо гэм хорын улмаас учирсан хохирлыг хамгийн бага өртгөөр зайлсхийх үүрэгтэй бус этгээд болох Палсграфд ногдуулах нь тохиромжтой гэж үзсэн байна.

Ингэхээр Кардозо Palsgraf-ийн шийдвэрт яасан байх нь вэ? Нэгдүгээрт, Кардозо шүүгч “Аугаа гуйвуулагч” байжээ. Урьдчилан харах чадвар, харилцаа хамаарал зэрэг ямар ч утгагүй нэр томъёо, үзэл баримтлал хэрэглэж байгаагаа шүүгч өөрөө мэдэж байсан. Бүх зүйлийг таамаглах боломжтой бөгөөд юуг ч хангалттай таамаглах аргагүй шүү дээ. Мөн бүх хүн хоорондоо харилцан хамааралтай бөгөөд хэнийг нь ч хэт хамааралтай гэж үзэх аргагүй. Хоёрдугаарт, Palsgraf-ийн хэргийг та ойлгож мэдэх ёстойн учир нь хууль зүйн хувьд хүмүүс (манай тохиолдолд Кардозо) тухайн цаг үеийнхээ эрх зүйн тогтолцооны бүтээгдэхүүн бөгөөд мөн шинэ тогтолцоог давхар хөгжүүлж байдаг гэдгийг харуулжээ.

Palsgraf-ийн шийдвэрийн үр дагавар нь манай шүүх урт хугацаандаа тодорхой хэрэгт нийтийн эрх зүйн шинжтэй үр дагавар хүсэмжилж байдаг, түүнчлэн, энэ нь хамгийн бага өртгөөр зайлсхийх арга замыг эрэлхийлэхтэй шууд холбогддогийн тод жишээ болох мэт. Кардозо гурван зүйл дурджээ.

Нэгдүгээрт, хохирлын хэмжээн дээр маргаж байвал бага хэмжээний хохирлыг хүлээн авах чадамжтай этгээд

их хэмжээний хохирлыг мөн сайн хүлцэх магадлалтай⁴⁶. (Хэдий тийм ч онцгой тохиолдол бүхий өөр хэрэгт (ховор боловч) ялгаатай онол шаардаж болзошгүйг санахад илүүдэхгүй.)

Хоёрдугаарт, эрсдэл тооцоолох аргагүй тохиолдолд талууд болон олон нийтийн хүлээлтэд нийцүүлэн шүүгч хамгийн бага өртгөөр зайлсхийх зарчмаар шийдвэрлэнэ гэдэг нь бараг ойлгомжтой⁴⁷.

Гуравдугаарт, нэхэмжлэгчийн байдлыг таамаглах аргагүй бол хохирлыг хүлцэх чадамжтай нэхэмжлэгч мөн эсэх асуудал урган гарах нь мэдээж. Өөр хэрэгт хариуцагч нар “гарамгай” байж болох ч таамаглах аргагүй иймэрхүү хэрэгт чухам нэхэмжлэгч “гэм хороос үүдсэн хохирлыг хамгийн сайн хүлцэгч” байж чадах эсэхийг тодорхойлох боломжгүй. Тиймээс Кардозогийн хувьд энэ асуудлыг давын өмнө шүүхийн шийдэх асуудал хэвээр үлдээжээ. Ингэхдээ үүнийг чиг үүргийн “асуудал”⁴⁸ болгосон. Нью-Йорк мужийн Давж заалдах шатны шүүх ч үүнийг үүргээ гэж үзэн хүлээн авсанд гайхах зүйлгүй⁴⁹.

Тэгсэн атал Кардозо шүүгч яагаад хохирол нөхөн төлөх чадамжгүй Палсграфийн эсрэг шийдвэр гаргав? Хариулахад ер нь бол амархан. Кардозо шүүгч хатуу хариуцлага бус хайхрамжгүй байдал давамгайлсан цаг үед амьдарч байсан. Харин Long Island Railroad компани хайхрамжгүй хандаагүй. Хөдлөн яваа галт тэргэнд салютуудаа оруулаад суухад туслахад хайхрамжгүй хандана гэж байхгүй. “Аугаа гуйвуулагч”

⁴⁶ See Palsgraf, 162 N.E. at 100–01; see also RESTATEMENT (FIRST) OF TORTS § 435 (AM. L. INST. 1934).

⁴⁷ Palsgraf, 162 N.E. at 101.

⁴⁸ Id. at 99–100.

⁴⁹ See, e.g., Lauer v. City of New York, 733 N.E.2d 184, 187 (N.Y. 2000).

⁴⁴ MacPherson v. Buick Motor Co., 111 N.E. 1050, 1053 (N.Y. 1916) (emphasis added).

⁴⁵ Sharkey, supra note 2, at 1437 (citing MacPherson, 111 N.E. at 1051–52).



Кардозо харин хувийн эрх зүйн аливаа зарчмыг хөндөхгүйгээр нийтийн эрх зүйн санаархлаа тус хэрэгт ашиглахад тулд Палсграфийг “хайхрамжгүй хандсан” гэж үзжээ. Нэгэнт төмөр замын компани хайхрамжгүй хандаагүй тул золгүй Палсграфд компаниас нөхөн төлбөр нэхэмжлэх эрх тэр үед байгаагүй төдийгүй одоо ч байхгүй билээ.

Palsgraf-ийн хэрэг бол энэхүү нийтийн болон хувийн эрх зүйн динамикийн хамгийн тод жишээ юм. Холбогдох шинэ, хуучин өөр олон жишээ бий. Шууд, илт гэм хор учруулчихаад байхад хүртэл гэм буруу заавал шаарддаг нийтийн эрх зүйн утилитар зарчмыг үндэслэл болгосон Барон Брамвеллийн шийдсэн *Holmes v. Mather*⁵⁰-ийн хэргийг авч үзье. 19 дүгээр зууны өнөө цуутай “хамгийн бага өртгөөр зайлсхийх” зарчмыг дэвшүүлэхээс өмнө Брамвелл яг Кордозогийн *Palsgraf*-ийн хэргийг шийдсэнтэй адилхан шийдсэн юм. Үйлчлэгчийнхээ хайхрамжгүй байдлын улмаас шүүхэд хариуцагчаар дуудагдсан эзний хэрэг байтал хариуцагчийг шууд гэм хор учруулагч мөн гэж шүүгч үзжээ. Нэхэмжлэгч *Holmes*-ийн эсрэг ялагдах нь ойлгомжтой байсан агаад үүгээрээ нийтийн эрх зүйн шинэ зарчим бий болгоход төгс тохирсон хэрэг байжээ⁵¹.

Мөн “бие махбодод гэм хор учруулж болзошгүй шууд эрсдэл” нь Ажил олгогчийн хариуцлагын тухай Холбооны хуулийн дагуу хайхрамжгүйгээр сэтгэл санааны дарамт учруулснаас нөхөн төлбөр авах цаг хугацааны урьдчилсан нөхцөл болохгүй гэж шийдсэн Калабresi шүүгчийн *Nelson v. Metro-North Commuter*

⁵⁰ See, e.g., *Lauer v. City of New York*, 733 N.E.2d 184, 187 (N.Y. 2000).

⁵¹ See *id.* *Holmes* is perhaps best known for Baron Bramwell’s instrumentalist words: “For the convenience of mankind in carrying on the affairs of life, people as they go along roads must expect, or put up with, such mischief as reasonable care on the part of others cannot avoid.” *Id.* at 267.

*Railroad*⁵²-ийн хэргийг авч үзэж болно. Гэсэн атлаа дараа нь хуульд “шууд” хэмээсэн байгаа тул нэхэмжлэгчид бие махбодод нь гэм хор учруулж болзошгүй аливаа “шууд” эрсдэл учраагүй⁵³ гэжээ.

Holmes, Nelson, Palsgraf-ийн хэргүүд бол бүгдээрээ шүүгч тухайн цаг үеийн хувийн эрх зүйн үр дагаврыг нь шийдвэрлэх замаар нийтийн эрх зүйд хамааруулах гэж үзсэний жишээ болно. Үүгээрээ тэд хувийн болон нийтийн эрх зүйн хэрэгцээнд үндэслэн хооронд нь холбох гэж үзжээ. Нөгөө талаас, шүүгч заримдаа өөрийн болон ах дүү нарынхаа “барьсан”⁵⁴ шатны оройд гараад хуулийг өөрчлөх боломж бүхий макро түвшинд очсон байх нь бий. Тэгээд буцаад микро түвшинд очно.

Эцэст нь, гэм хорын эрх зүйн “урвуу хамаарал”-ыг бид дурдахгүй өнгөрч боломгүй нь. Өмнө дурдсанчлан, иргэний гэм хорыг хэрхэн тогтоох нь нийгмийн зохицуулалтын хэрэгцээ болон хамгийн бага өртгөөр зайлсхийх замаар хариуцлага хүлээлгэх хүсэл зоригоос хамаарч тодорхойлогдон тайлбарлагдах өргөн утгатай ойлголт юм. Гэсэн хэдий ч “их”, “бага” өртөг гэсэн хэмжүүр нь тухайн цаг үед тогтсон иргэний гэм хорын ойлголттой уялдаж нийгмийн үнэлэмж, үнэт зүйлээс урган гарна. Энэ утгаараа гэм хорын эрх зүй нь хоёрдмол чиглэлд хэрэгждэг⁵⁵.

⁵² 235 F.3d 101 (2d Cir. 2000).

⁵³ See *id.* at 107–13; see also *id.* at 114 (Jacobs, J., concurring).

⁵⁴ We use this term deliberately. See GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 232–59 (explaining their “dual constructivist” approach). We agree with GZ that judges “construct” wrongs “using precedents and principles embedded in the law as [their] principal guide.” *Id.* at 258. Where we differ with GZ is in our recognition that a judge, in an appropriate case, often does reach “a decision to deem certain kinds of injurious conduct tortious” based “primarily on the social benefit that stands to be achieved by imposing liability for such conduct,” *id.* at 239, and does so both properly and manifestly.

⁵⁵ See GUIDO CALABRESI, *THE FUTURE OF LAW*



ГЗ-гийн урлагийн галерейн зүйрлэл энэ санааг дэвшүүлэхэд дөхөм болов:

Гэм хорын эрх зүйг бүтээхдээ шүүгч ялимгүй хохирол учруулсан багавтар хэмжээний гэм хорын цуглуулгаас (урлагийн бүтээлийн цуглуулга гэдэгтэй зүйрлэж байна – орч.) эхэлж, цагийн явцад тэрхүү цуглуулгаа нэмж баяжуулсаар иржээ. Тус цуглуулга нь “сонгодог” бөгөөд чухал шинэ бүтээлээс бүрдэнэ. Ижил төрлийн урлагийн бүтээлүүдийг тухайлсан зохион байгуулалттай ерөөнд төрөлжүүлэн өрсөн байдаг шиг (нэр хүндэд учруулсан гэм хор, эд хөрөнгөд учруулсан гэм хор, бусадтай харилцах чадварт нь хөндлөнгөөс оролцож учруулсан гэм хор гм). Тэгээд үе үе гэм хорын тэрхүү байшинд гэм хорын шинэ төрөл, хэмжээгээр дүүрэн шинэ өрөө нэмэгдэнэ. Гэм хорын эрх зүй бол [тэгэхээр] гэм хорын төрлөөр дүүрч бий болсон урлагийн галерей юм⁵⁶.

Яг тийм. Тэгээд куратор (урлагийн галерейн зохион байгуулагчийг куратор гэдэг бөгөөд шүүгчийг куратортай зүйрлэж байна – орч.) нь нийгмийн үнэлэмж, үнэт зүйлд уялдуулан үзэсгэлэнгийн гол бүтээлүүдийг сонгоно. Иргэний гэм хорын “галерей” тэгэхээр энэ утгаараа бидний үнэт зүйлийн цуглуулга-сан юм.

Тухайлбал, гэм хорын эрх зүй дэх үлэмж хэмжээний хариуцлага

(англ. *punitive damages*)-ыг авч үзье⁵⁷. (Жишгийн эрх зүйн бүлийн орнуудын иргэний болон гэм хорын эрх зүйд хэрэглэдэг тус хариуцлагын төрөл нь гэм буруутай этгээдийг дахин хууль бус үйлдэл гаргахаас сэргийлж маш өндөр дүнгээр хариуцлага ногдуулдаг байна. Энэ хариуцлагыг маш ховор тохиолдолд ногдуулдаг тул хариуцагчийн хөрөнгө чинээ болон дахин гэм хор учруулж болзошгүй зэрэг шинжийг харгалзан үздэг – орч.) Үлэмж хэмжээний (буюу илүү нарийн нэмэлт нөхөн олговор) хариуцлага нь гэм буруутай үйлдэлд хүлээлгэх хариуцлага, түүний нийгмийн өртөгтэй тэнцэхүйц хариуцлагыг ихэсгэх сэдэл төрүүлж мэдэх юм⁵⁸. Түүнчлэн, тухайн тодорхой тохиолдолд хариуцлага ногдуулахын оронд өмчийг нь авч үзэх хандлагыг төрүүлснээр хууль ёсны эрх шилжүүлэх явдлыг улам төвөгтэй болгох сэдэл бий болгохыг үгүйсгэхгүй⁵⁹. Ямартай ч тодорхой төрлийн гэм хор учруулсан үйлдэлд үлэмж хэмжээний хариуцлага ногдуулснаар хүмүүс цаг хугацаа өнгөрөх тусам гэм хор учруулбал

⁵⁷ For GZ's and Sharkey's most recent takes on punitive damages, see *id.* at 168–74 (citing John C.P. Goldberg, *Tort Law for Federalists (and the Rest of Us): Private Law in Disguise*, 28 HARV. J.L. & PUB. POL'Y 3 (2004); Benjamin C. Zipursky, *A Theory of Punitive Damages*, 84 TEX. L. REV. 105 (2005); Benjamin C. Zipursky, *Punitive Damages After Philip Morris USA v. Williams*, 44 CT. REV. 134 (2007–2008); Benjamin C. Zipursky, *Palsgraf, Punitive Damages, and Preemption*, 125 HARV. L. REV. 1757 (2012)); and Sharkey, *supra* note 2, at 1448–54.

⁵⁸ See generally Keith N. Hylton, *Punitive Damages and the Economic Theory of Penalties*, 87 GEO. L.J. 421 (1998); A. Mitchell Polinsky & Steven Shavell, *Punitive Damages: An Economic Analysis*, 111 HARV. L. REV. 869 (1998); Catherine M. Sharkey, *Punitive Damages as Societal Damages*, 113 YALE L.J. 347 (2003). See also, e.g., *Ciraolo v. City of New York*, 216 F.3d 236, 242 (2d Cir. 2000) (Calabresi, J., concurring).

⁵⁹ See CALABRESI, *supra* note 55, at 120–21, 125; Guido Calabresi, *A Broader View of the Cathedral: The Significance of the Liability Rule, Correcting a Misapprehension*, 77 LAW & CONTEMP. PROBS. 1 (2014); Guido Calabresi & A. Douglas Melamed, *Property Rules, Liability Rules, and Inalienability: One View of the Cathedral*, 85 HARV. L. REV. 1089, 1124–27 (1972).

AND ECONOMICS 158 (2016) (“Torts . . . affects our values, and it does so with respect to things as crucial as safety, the environment, the duty to look after each other, and life itself.”). The effect of law on values is by no means limited to the domain of torts. See *id.* at 157–58 (giving as examples the effects of law on attitudes toward race, same-sex marriage, and abortion, and crediting the critical legal studies movement for this insight).

⁵⁶ GOLDBERG & ZIPURSKY, *supra* note 1, at 237–38; see also *id.* at 263 (“Our ‘gallery’ metaphor aims to capture the thought that, even though the various torts do not express a single substantive moral principle, they are not merely an ad hoc collection either.”).



үр дагавар нь илүү гарзтай гэж үзэж, гэм хор учруулахгүй байх нь хавь илүү гэсэн итгэл үнэмшилтэй болох боломжтой юм. Цаашилбал гэм хорын бусад хариуцлага төдийгүй гэм хорын тогтолцоог хэрэгжүүлэх зардлаас тусдаа ойлголт болно. Тодруулбал, энэ хариуцлага нь бусад “энгийн” гэм хорын хэргүүд болон гэм хорын хор уршгийг нөхөн төлүүлэх талаарх иргэдийн хүлээлтээс хамааран тодорхой зарим гэм хорын үйлдлийг арай өндөр зардлаар тооцно гэсэн үг юм. Энэ нь эргээд “бага өртгөөр ийм төрлийн зардлаас зайлсхийх” сонирхолтой этгээдүүдэд нөлөөлнө.

Гэм хорын эрх зүйгээр илт мэдэгдэхүйц хүрээ хязгаар тогтоосон сэтгэл санааны хохирол мөн дээрхтэй адилхан⁶⁰. Сэтгэл санааны гэм хорыг ер нь барагдуулдаггүй. Яагаад юм бол? Ийм гэм хор учруулсан этгээд нь бага өртгөөр зайлсхийх сонирхолтой болохоор уу?⁶¹ Хэрэв тийм бол хохирол барагдуулснаар далайцыг нь ихэсгэнэ гэж үздэгтэй холбоотой болов уу. Тодруулбал, нийгмийн зүгээс сэтгэл санааны хохирлыг хэдий чинээ нөхөн төлнө, төдий чинээ сэтгэл санааны хохиролд өртлөө гэж “мэдэгдэх” хүмүүс олон болно⁶². Мэдээж сэтгэл санааны хохирлыг бодит бус гэж хэлэх гээгүй юм шүү. Бодитой байлгүй яах вэ! Тэр тусмаа ямар нэгэн байдлаар тодорхойлон таньж анхаарал хандуулах учиртай. Гэвч эрх зүйн үндэслэлтэйгээр сэтгэл санааны гэм хорыг яаж тодорхойлох талаарх асуудлыг шийдвэрлэхдээ нийгэмд мөн ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг бодолцох нь зүйтэй. Тухайлбал, дотны хүнээ алуулсныг хараад мэдэрсэн сэтгэл санааны гэм хорыг

нийгэм авч хэлэлцэхийг хүсэхгүй байж мэднэ. Харин их хэмжээний түгжрэл зэрэг бид бүгдийн мэдэрдэг бухимдлын асуудлын хувьд нөхөн төлбөр авах эрхийг үгүйсгэх замаар нийгмийн зүгээс бууруулахыг эрмэлзэж мэднэ. Нөхөн төлбөр нь зардалд нөлөөлдөг бөгөөд энэ нь эргээд нөхөн төлбөр авах эрхэд нөлөөлдөг.

Ийнхүү гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах миний эрх буюу хувийн эрх зүйн шинж; нийгмийн зүгээс гэм хор гэж үзсэн үйлдэлд л нөхөн төлбөр авах буюу нийтийн эрх зүйн шинж гэсэн хоёр шинжийг давхар агуулснаараа гэм хорын эрх зүй бол маш сонирхолтой салбар эрх зүй билээ. Энэ утгаараа ГЗ болон Шарки нарын аль алиных нь үзэл санаа үнэ цэнтэй юм!

⁶⁰ See 2 DAN B. DOBBS, PAUL T. HAYDEN & ELLEN M. BUBBLICK, THE LAW OF TORTS § 381, at 534, § 383, at 538–45 (2d ed. 2011)

⁶¹ See GUIDO CALABRESI, IDEALS, BELIEFS, ATTITUDES, AND THE LAW: PRIVATE LAW PERSPECTIVES ON A PUBLIC LAW PROBLEM 72–76 (1985).

⁶² See id. at 77–79.

